Монголын Зэвсэгт хүчний мал эмнэлгийн албанд өөрийн гэсэн бахархалт ул мөрөө үлдээсэн хүний нэг бол 1937-1946 оны хоорондох богинохон зурвас үед жагсаалын цэргээс бага дарга, хороо, бригад, дивизийн мал эмнэлгийн албаны дарга хүртэл албан тушаал хашиж байсан, Халх голын дайн, Аугаа эх орны дайн, 1945 оны Чөлөөлөх дайнуудад оролцож явсан, ахмад дайчин бэлтгэл ахмад Ц.Бадарч юм. Энэ онд түүний хорвоод мэндэлсний 100 жилийн ой тохиож байгаа билээ.

Түүх өгүүлбэл тэрээр 1917 онд хуучнаар Дөрвөд Далай ханы хошуу буюу одоогийн Увс аймгийн Сагил сумын нутагт Боршоон гол хэмээх газар ядуу ард, малчин Цодогоогийн хоёрдугаар хүү болон мэндэлжээ. Ц.Бадарч нь 11 нас хүртлээ эцэг эхийн гар дээр өсөн хүмүүжсэн бөгөөд 1928-1931 он хүртэл Төгсбуйянтын хүрээний дэргэдэх

бага сургууль, 1934 онд дунд сургууль төгссөн. Тэрээр 1937 оны 9 дүгээр сарын 27-нд 20 настайдаа Монгол Ардын Хувьсгалт Цэргийн албанд татагдаж, Улаанбаатар хотод байрлах 1 дүгээр морьт дивизийн Холбоо сумангийн Агаарын постын тасагт жагсаалын цэргээр цэргийн алба хааж эхэлсэн бөгөөд Бөхөг-Түргэнд нисэх онгоцны газрын харилцааны курс (1938.5.1-1938.7.11), Даланзатгайтын 28 дугаар тусгай морьт



хороонд холбоо сумангийн агаарын тоотын тасгийн даргаар (бага дарга) ажиллаж байжээ. Тэр үед Халхын голын дайн эхэлсэн бөгөөд тэрээр дайны утаан дунд цэрэг-эрийн хатуужил олсон юм.

Дайн манай ялалтаар дуусч “Халх гол 1939” медалиар энгэрээ чимсэн бага дарга Ц.Бадарч тухайн үед цэргийн академи, их дээд сургуульд суралцах хуваарийн дагуу шалгалт өгч тэнцсэн учир эх орныхоо даалгавраар ЗХУ-д цэргийн мал эмнэлгийн академид суралцахаар 6 цэргийн алба хаагчийн хамт алс холын Москва хотыг 1939 оны намар зорьсон билээ. ЗХУ-ын Мал эмнэлгийн академийн 1 дүгээр курсийг тэрээр онц дүнтэй төгссөн учир Бүх цэргийн жанжны тушаалаар аж ахуйн албаны дэслэгч цолоор шагнагдаж байв¹.

Дэслэгч Ц.Бадарч орос хэлийг сайтар эзэмшиж, мал эмнэлгийн цэргийн эрдэмд шамдан суралцаж байх үед Аугаа их эх орны дайн эхэлж, дайсны гол хүч Москваруу давшиж байсан хүнд хэцүү үе буюу 1941 оны 11 дүгээр сараас академийн курсантууд(сонсогч)-орос цэргүүдтэй Москвагийн хамгаалалтад оролцож, хамгаалалтын бүх хүнд ажлыг бууны сумны шуурган дунд өдөр, шөнөгүй зориг, тэвчээртэй, нойр, хоолгүй туулж байжээ.

Энэ тухай дурсахдаа: «Хүн амьдарч байгаа орчиндоо бэрх үе тохиолдоход хаана ч, үндэс угсаа, зүс царай, хэл соёл хичнээн ялгаатай ч шударга үйлст хэнийг ч гэсэн нэгтгэдэг. 1941 оны өвөл Москвад цас ихтэй, хүйтэн, бэхлэлт-нуувчинд дулаан хувцас хунар дутмаг, түгшүүрийн дохио тасрахгүй, бууны сумны исргэрэх шуугиан хэвийн нөхцөл, хүнс, хоол голдуу консерв, орос цэргүүд улаан тамхи, хатсан талхныхаа хэлтэрхийг ч бага гэхгүй хуваана, эх орон нутгаас ямар ч мэдээлэл байхгүй мөн ч хүйтэн байсан даа... Орос цэрэг-эрчүүл зориг хатуужилтай, хязгааргүй эх оронч, туйлын нөхөрсөг, хүнлэг, тусархаг чанарууд нь надад онцгой сэтгэгдэл үлдээсэн.

Тэдэнтэйгээ дайн дуустал хамт тулалдана, ялалтыг үзнэ гэсэн сэтгэл шулуудсан билээ. Гэтэл академийг Узбекистаны Самарканд хот руу нүүлгэн, бидний хэдэн монгол курсант (сонсогч)-дыг шилжүүлэн суралцуулах тушаал ирсэн учир цэргийн ёсоор үе тэнгийнхээ орос цэргүүдтэйгээ халуунаар тэврэлдэн дараа уулзахын ерөөл өргөн салцгаасан юм. Энэ бол миний туулсан амьдралд хамгийн гунигтай мөч болж үлдсэндээ... хэмээн өгүүлсэн байдаг². 1943-1944 онд Москва хотод шилжин байрлаж тус академийг

¹БХТА. Ахмад Ц.Бадарчийн хувийн хэрэг дугаар №165.

²Бэлтгэл ахмад Ц.Бадарчийн хувийн тэмдэглэлээс

амжилттай төгсөж, малын эмчийн дипломоо гардан авч, цэргийн дээд боловсролтой офицер болж, эх орондоо эргэн ирэх үед Бүх цэргийн жанжны 1944 оны 6 дугаар сарын 1-ны өдрийн 081 тоот тушаалаар түүнийг ахмад цолоор шагнасан юм.

Тэрээр 7 дугаар морьт дивизийн 20 дугаар хорооны мал эмнэлгийн албаны даргаар (1944.5.24-1946.2) томилогдон ажилласан юм. Ахмад Ц.Бадарч 28 настайдаа Монгол Ардын Хувьсгалт Цэргийн морьт хороонд мал эмнэлгийн албаны даргын албан тушаал хашиж, “хорооны цэрэг-байлдагчдын хүнсний эрүүл ахуй, агт морьдын тарга хүч, сүрэг бүрэн мэнд, өвс усыг нь тохируулах ажлыг эрхлэх болсон”...

1945 онд Японы эсрэг явуулсан Чөлөөлөх дайнд Монгол, Зөвлөлтийн морьт механикжуулсан бүлгийн бүрэлдэхүүнд Хурандаа Г.Доржийн командалсан 7 дугаар морьт дивиз үүрэг гүйцэтгэсэн юм¹. 20 дугаар морьт хорооны мал эмнэлгийн дарга ахмад Ц.Бадарч давших байлдааны ажиллагааны үеэр хорооны толгойн сэргийлэхэд томилогдон тусгай үүрэг гүйцэтгэж... булаг шанд худаг дээр очиж, нүүдлийн лабораторийн шуурхай шинжилгээ хийж, ууж ундаалж болох зөвшөөрөл өгч хоноглох газрыг тогтоон сонгодог... морьд, цэргүүд ус үзээд ихэд баярладаг байв... хэмээн дурсамжиндаа өгүүлсэн байдаг.

Тус дивиз Дарьганга, Байшинтын районоос Долоннуур, Жэхэ хотын чиглэлд 1000 гаруй км давшиж, Цахарын усгүй элсэн цөл, Хянганы уул нуруудыг давж олон арван гол мөрнүүдийг гатлан дайсны цэргийн эсэргүүцлийг няцаан хоногт 80-90 км хурдтайгаар давшсаар олон хот тосгоныг чөлөөлөлцөж, өмнөө тавьсан байлдааны үүргээ нэр төртэй гүйцэтгэсэн билээ²... тус дивизийн бие бүрэлдэхүүн 1945 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 16:00 цагт Жэхэ хотоос 7 дугаар морьт дивиз нутгийн зүг марш үйлдэж, дивизийн бие бүрэлдэхүүн байнгын байрлал болох Байшинтад 1945 оны 10 дугаар сарын 11-ны өдөр хүрэлцэн очсон билээ³.

Түүний гавьяа зүтгэлийг төр засгаас өндрөөр үнэлэн Японы эзэрхэг түрэмгийчүүдийг бут цохин устгах ариун шударга байлдаанд баатарлаг зориг гаргаж гарамгай гавьяа байгуулсан учир «Алтан гадас» одон, «Бид ялав» медаль, ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн тэргүүлэгчдийн зарилгаар «За победу над Японией» медальболон бусад ойн медалиудаар тус тус шагнасан юм.

1945 онд ахмад Ц.Бадарчхорооныхоо цэргийн эмнэлгийн сувилагч Г.Гэлэгтэй⁴ гэр бүлболж хувь заягаа нэгтгэсэн байна. Чөлөөлөх дайнд хоёр ахмад дайчинхамт явсан бөгөөд эхнэр сувилагч Г.Гэлэг нь бие давхар байсан тул замын дундаас ар талруу татагдсан юм. Тэд долоон хүүхэдтэй, өнөр сайхан айл болсон бөгөөд өнөөдөр ач гучтэдний үр хүүхдүүд нь төрөл бүрийн мэргэжилтэй болцгоож эх орныхоо хөгжил дэвшилд өөр өөрсдийн хувь нэмрийг оруулсаар байна.

Дэлхийн II дайны дараагаар Монгол Ардын Хувьсгалт Цэрэг,тайван цагийн байдалд шилжсэнтэй холбогдуулан 1946 оны 2 дугаар сараас морин бригадын

¹Монгол цэргийн түүхийн товчоо.УБ., 1996. С.368.

²Шагдар.Х, Гантулга.Ж.Эх орныхоо төлөө өргөсөн алтан амь. УБ., 2014.

³БХТА. Сх-1. д.4 хн.112 х.56-59.

⁴Зоригтбаатар С. Соёмбо сонин // Хэвлийдээ үртэй фронтод морджээ. 1995 №38.

25 дугаар морьт хороонд мал эмнэлгийн даргаар ажиллаж байсан ахмад Ц.Бадарчийг 1946 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн Сайд нарын зөвлөлийн тогтоолоор Улсын хоршоодын төв холбоонд түр малын их эмчээр томилон ажилуулсанбөгөөд тэрээр удалгүй Бүх цэргийн жанжны тушаалаар 6 дугаар морьт дивизийн мал эмнэлгийн дарга (1946.10.15-1947.10.23), 9 дүгээр тусгай морьт хорооны эмнэлгийн албаны дарга, 5 дугаар морьт дивизийн мал эмнэлгийн дарга (1948.6.26.-1949.5.21) ажиллаж байгаад бэлтгэл офицероор (ахмад цолтой) халагдаж, Мал аж ахуйн яамны мэдэлд шилжиж 1977 он хүртэл мэргэжлийнхээ дагуу улс эх орондоо хөдөлмөрлөж, Монгол цэрэг эрийн ид хавыг энхцагийн бүтээн байгуулалтын үед ч нэр төртэй дуурсгаж байсан хувьсгалт тэмцлийн ахмад дайчдын нэгэн төлөөлөл билээ.

Приложение 2

Договор о дружбе и взаимопомощи между СССР и МНР от 27.02.1946

В связи с окончанием десятилетнего срока действия Протокола о взаимопомощи, заключенного между Союзом Советских Социалистических Республик и Монгольской Народной Республикой, Президиум Верховного Совета СССР и Президиум Малого Хурала Монгольской Народной Республики решили превратить нижеприведенный Протокол от 12 марта 1936 года в Договор о дружбе и взаимопомощи со сроком действия на десять лет:

«Правительства Союза Советских Социалистических Республик и Монгольской Народной Республики, исходя из отношений неизменной дружбы, существующей между их странами со времени освобождения территории Монгольской Народной Республики в 1921 году при поддержке Красной Армии от белогвардейских отрядов, находившихся в связи с военными силами, вторгшимися на территорию Союза Советских Социалистических Республик, руководимые желанием поддержать дело мира на Дальнем Востоке и содействовать дальнейшему укреплению существующих между ними дружественных отношений, решили оформить в виде настоящего Протокола существующее между ними с 27-го ноября 1934 года джентльменское соглашение, предусматривающее взаимную поддержку всеми мерами в деле предотвращения и предупреждения угрозы военного нападения, а также оказание друг другу помощи и поддержки в случае нападения какой-нибудь третьей стороны на Союз Советских Социалистических Республик или Монгольскую Народную Республику, для каковой цели и подписать настоящий Протокол.

СТАТЬЯ ПЕРВАЯ.

В случае угрозы нападения на территорию Союза Советских Социалистических Республик или Монгольской Народной Республики со стороны третьего государства Правительства Союза Советских Социалистических Республик и Монгольской Народной Республики обязуются немедленно обсудить совместно создавшееся положение и принять все те

меры, которые могли бы понадобиться для ограждения безопасности их территорий.

СТАТЬЯ ВТОРАЯ.

Правительства Союза Советских Социалистических Республик и Монгольской Народной Республики обязуются в случае военного нападения на одну из Договаривающихся Сторон оказать друг другу всяческую, в том числе и военную помощь.

СТАТЬЯ ТРЕТЬЯ

Правительства Союза Советских Социалистических Республик и Монгольской Народной Республики считают само собой разумеющимся, что войска одной из Сторон, находящиеся по взаимному соглашению на территории другой Стороны, в порядке выполнения обязательств, изложенных в статьях первой и второй, будут выведены с соответствующей территории незамедлительно по миновании в том надобности, подобно тому, как это имело место в 1925 году в отношении вывода советских войск с территории Монгольской Народной Республики».

Настоящий Договор вступает в силу с момента его ратификации, которая должна быть произведена в возможно короткий срок. Обмен ратификационными грамотами будет произведен в Улан-Баторе.

Если ни одна из Высоких Договаривающихся Сторон не сделает за год до истечения срока действия настоящего Договора заявления о своем желании денонсировать Договор, он останется в силе на последующий десятилетний срок.

Составлено в Москве 27 февраля 1946 года, что соответствует 27 дню второй луны 36 года монгольского летоисчисления, в двух экземплярах, каждый на русском и монгольском языках, причем оба текста имеют одинаковую силу.

**По уполномочию
Президиума
Верховного Совета
Союза ССР**

В. МОЛОТОВ

**По уполномочию
Президиума
Малого Хурала
Монгольской
Народной Республики
ЧОЙБАЛСАН**

*Ведомости Верховного Совета СССР
за апрель 1946 г. № 13(422). С. 2.*

ФОТОДОКУМЕНТЫ

Монгольская делегация во главе с маршалом Х. Чойбалсаном на Западном фронте.



Делегация МНР во главе с Председателем Президиума Малого Хурала МНР Г. Бумцэндом на Калининском фронте в декабре 1942 г.





Монгольская делегация во главе с секретарем ЦК МНРП Ч. Сурэнжавом на Северо-Западном фронте в декабре 1942 г.





Делегация МНР во главе с командующим добровольными кавалерийскими отрядами народной самообороны Ч. Мижидом на Волховском фронте в декабре 1942 г.





Делегация МНР во главе с генеральным секретарем ЦК МНРП Ю. Цэдэнбалом на Западном фронте в марте-апреле 1943 г.





Делегация во главе с зам. Главкома МНРА Ж. Лхагвасуруном на Центральном фронте в марте-апреле 1943 г.





**Монголия во Второй мировой войне
(1939–1945 гг.)**

Коллективная монография

Издательство «Оттиск».

Лицензия ЛР № 066064 от 10.08.1998.

Подписано в печать 07.11.2017 г.

Формат 60x84 1/32.

Отпечатано в типографии «Оттиск»

Гарнитура Тип Таймс.

Печать офсетная. Бумага офсетная.

Усл. печ. л. 10,8. Уч.-изд. л. 13,02.

Тираж 500 экз. Заказ № 0109.

664025, г. Иркутск, ул. 5-й Армии, 26.

Тел./ факс: (3952) 34-32-34, 241-242.

E-mail: ottisk@irkmail.ru

www.ottisk-irk.ru

МОНГОЛЫН МОРЬТ ЦЭРЭГ ДЭЛХИЙН II ДАЙНД

ХОЁРДУГААР ХЭСЭГ

МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ ЦЭРГИЙН МОРЬТ ДИВИЗУУД 1939 ОНЫ ХАЛХЫН ГОЛЫН ДАЙНД

Шаарийбуу

2.1. Монгол ардын хувьсгалт цэргийн 5 дугаар морьт дивиз Халхын голын дайнд

Бүх Цэргийн Зөвлөлийн 1921 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн “**Зүүн хязгаарын цэргийн отрядыг морьт бригад болгон өөрчлөх тухай**” 10 тоот тушаалаар 2 дугаар морьт бригад (5 ба 7 дугаар морьт хороо)-ыг байгуулсан нь тус улсын байнгын цэргийн түүхэн дэх ууган нэгтгэл ангийн нэг буюу хожим маршал Х.Чойбалсангийн нэрэмжит 5 дугаар морьт дивизийн үндэс суурь болсон түүхтэй ажээ. Уг тушаалд заасны дагуу Ардын Засгийн Газар, Цэргийн яамнаас зүүн хязгаарыг тохинуулах цэргийг дайчлан захирах сайдаар Дарьгангын Наранбулагт сууж байсан Гомбо-Идшин гүнг Цэргийн яамны эрхэлсэн түшмэлээр томилон Ардын Засгийн хэрэгт хүчин зүтгэхийг хүссэн захидал бичгийг илгээсэн ба мөн Ардын Засгийн Газарт захирагдсан Дугар бэйс, Балжинням нарын отрядыг нэгтгэн 2 дугаар тусгай морьт бригадыг шинээр байгуулж, даргаар Н.Дугаржав, 1 дүгээр хорооны дарга И.Нутугаевыг бригадын даргын туслахаар тус тус томилсны зэрэгцээ зохих төлөвлөгөө ёсоор бригад бүрт хоёр хороо, хороо бүрт дөрвөн суман, суман бүрт салаа байх”¹-аар зохион байгуулсан нь хязгаарын цэргийн тухайд авч хэрэгжүүлсэн анхны арга хэмжээ байжээ.

Энэ хугацаанд Ардын Засгийн Газар, Цэргийн Зөвлөлийн тогтоол, шийдвэрийн дагуу зүүн хязгаарыг сэргийлэн сахих гол үүрэгтэй 5 дугаар морьт хорооны бүтэц, зохион байгуулалтыг тухайн үеийн цэрэг, улс төрийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлагад нийцүүлэн дараах байдлаар хэд хэдэн удаа өөрчлөн шинэчилсэн байна. Үүнд: **1921-1923 онд** 2 дугаар морьт бригадын бүрэлдэхүүнд багтаж байгаад “Ардын Засгийн Газар, Цэргийн Зөвлөлийн 1923 оны 3 дугаар сарын шийдвэрээр 2 дугаар морьт бригадыг татан буулгахад “**5 дугаар морьт хороо**”-г хэвээр үлдээж, Зүүн хязгаарын сайдын яаманд захируулсан байна. Тус хороог нь баатар Нанзадаар захируулжээ. Хорооны зохион байгуулалтын өөрчлөлт нь 4 сумангаас бүрдэл болж зохиогдсон бөгөөд 4 сумангийн 1 нь хүнд ба хөнгөн пулемётын суман байжээ. 1 суманд 4 салаатай, салаанд 30 орчим хүнтэй, салаанд хагас салаа буюу тасгуудыг бий болгосон ба суманд суртлыг сургагч, улс төрийн удирдагчдыг шинээр нэмэгдүүлэх болсон байна. Тус хорооны 2 суман нь төв дээрээ буюу одоогийн Чойбалсан аймгийн Чойбалсан сумын нутаг “Ламын хийд” гэдэг газар байрлаж байсан бол нөгөө хоёр суман нь

¹ “Бүх цэргийн зөвлөл” /Баримтын эмхтгэл/ (хянан нягталсан: С.Ганболд, эмхэтгэгчид: С.Ганболд, Д.Гомбосүрэн, Н.Хишигт) УБ., 2010. т. 17.

“Хөх нуур”, “Үнэст” гэдэг газруудаар байрласан ба түүнчлэн салбарласан салаа тасгууд, хязгаарын харуулууд сууж байжээ”¹.

1923-1927 онд Засгийн газрын тогтоол ба Цэргийн Зөвлөлийн тушаал шийдвэрийн дагуу “Зүүн хязгаарын сайдын яам ба 5 дугаар морьт хороог татан буулгаж, оронд нь **“5 дугаар морьт тусгай дивизион”**-ыг 2 сэлэмт сумангаар байгуулж, дивизионы даргаар Нэрэнгийн Дашийн биеийг Цэргийн Зөвлөлийн тушаалаар томилон захируулсан байна. Энэхүү дивизион нь 1927 оны намар хүртэл байжээ”².

1927-1932 онд “Засгийн газрын тогтоол ба Цэргийн Зөвлөлийн шийдвэрийн дагуу 5 дугаар морьт тусгай дивизионыг **“5 дугаар морьт тусгай хороо”** болгон өөрчлөн байгуулсан бөгөөд тус хорооны зохион байгуулалт нь сэлэмт суман-3, пулемёт-1, ажил команд, хүн ба малын эмнэлэг, агаарын мэдээний тасаг гэсэн салбаруудаар зохион байгуулагдаж байжээ”³.

5 дугаар морьт дивизийг байгуулсан нь, түүний бүтэц, зохион байгуулалтын бэхжилт, байлдааны бэлтгэлийн өсөлт. 1930-аад оны эхэн үе бол Монголын цэрэг, улс төрийн гадаад, дотоод байдал нэн хурцадсан, тогтворгүй байдал үүссэн түүхэн цаг үе байв. Энэ үест гадаад талдаа Японы халдан түрэмгийлэх цэрэг, дайны бодлого, үйл ажиллагаа улам бүр өргөжин тэлж, улс орны тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдалд ноцтой хор хохирол учруулах болсон байна.

Улс орныг батлан хамгаалах хүчнийг нэмэгдүүлэх шаардлагаас үндэслэж 5 дугаар морьт тусгай хороог өөрчлөн өргөтгөж, оронд нь **“5 дугаар морьт дивиз”**-ийг зохион байгуулжээ.

5 дугаар морьт дивизийг 1932 онд 5 ба 7 дугаар морьт хороод, их бууны хороо, дивизийн бага дарга нарын сургууль, холбооны тусгай суман, ажил команд, хүн ба мал эмнэлэг зэрэг анги салбаруудаар зохион байгуулжээ. Үүнд 7 дугаар морьт хороо нь нутгийн хороо байжээ. Дивизийн удирдлага нь дивизийн дарга бөгөөд комиссар, дивизийн штаб, дивизийн улс төрийн хэлтэс, дивизийн бэлтгэл зэрэг байжээ. Үүнээс гадна Хувьсгалт Цэргийн Зөвлөл (ХЦЗ)-өөс дайны цагийн байдалтай уялдуулан хязгаарын цэргийн анги, морьт хороодын удирдлага, зохион байгуулалтын өөрчлөлтийг шинэчилж, дараах байдлаар тогтоожээ. Үүнд “ХЦЗ-ийн 1932 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 61 тоот тушаалаар тус бүр хоёр морьт дивиз бүхий морьт корпусууд байгуулав.

➤ **1 дүгээр морьт корпус:** Улаанбаатарын 1 дүгээр морьт дивиз (1, 2 дугаар морьт хороо, 1 дүгээр их бууны хороо, холбооны тусгай суман), шинээр байгуулсан Архангайн 10 дугаар морьт дивиз (Цэцэрлэгийн 17 дугаар морьт хороо, Улиастайн 8 дугаар нутгийн морьт хороо, Лүн уулын 6 дугаар нутгийн морьт хороо, 10 дугаар их бууны хороо)

➤ **2 дугаар морьт корпус:** Баянтүмэний 5 дугаар морьт дивиз (Гурванбаяны 5 дугаар морьт хороо, дивизийн сургууль, холбооны тусгай

¹БХТА. сx-1, д-3, хн. 462. хуудас 4.

²БХТА. сx-1, д-3, хн. 462. хуудас 5.

³БХТА. сx-1, д-3, хн. 462. хуудас 5.

суман), Тамсагбулагийн 6 дугаар морьт дивиз (Тамсагийн 15 дугаар морьт хороо, дивизийн сургууль, холбооны тусгай суман)”¹ тус тус багтан захирагдах болсон байна. Ингэснээр МАХЦ нь үндсэн төрлийн цэрэг болох морьт цэргийн хороо, дивиз, корпусын зохион байгуулалтанд орж, түүний бүрэлдэхүүнд хуягт танк, их буу, нисэх хүчин, холбоо зэрэг техникийн цэргийн анги шинээр бий болж, байнгын цэргийг орон нутгийн цэрэгтэй хосолсон цэргийн тогтолцоо үүсэн бүрэлдсэн төдийгүй улс орон, ард түмнийг найдвартай батлан хамгаалах хүчин болох үндэс суурь тавигдсан байна.

Бүх цэргийн зөвлөлийн 1930 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 58 тоот тушаалаар аймаг дахь нутгийн цэргийн анги, салбаруудыг татан буулгаж, байнгын цэргийн зохион байгуулалтыг өргөжүүлэв. БНМАУ-ын хувьсгалт цэргийн зөвлөлийн 1932 оны 3 дугаар сарын 12-ны 16 тоот тушаалаар хоёрдугаар морьт корпусын орон тоог баталж, тус корпусыг Баянтүмэнд төвлөрүүлэн байрлуулжээ... 1930-аад оны байдлаар 4, 5, 11 дүгээр тусгай морьт хороод хил хязгаарыг сэргийлэн хамгаалж байсан бол 1931-1932 онуудад 4, 5, 7, 10 дугаар дивиз, хэд хэдэн тусгай хороо, сумангууд чухал чиглэлд байрлан эх орныхоо хил хязгаарыг хамгаалж байжээ”² хэмээн үнэлсэн нь чухамдаа дайн самууны аюул нүүрлэсэн хүнд бэрх цагт төр засаг, цэргийн удирдлагаас гаргасан тогтоол, шийдвэрийн хүрээнд 5 дугаар морьт дивизийн нийт бие бүрэлдэхүүний гүйцэтгэсэн үүрэг, түүхэн гавьяаг нотлон харуулсан хэрэг билээ.

Шинээр зохион байгуулагдсан 5 дугаар морьт дивиз нь зэвсэглэл, аж ахуйн хангалтын хувьд “Дивизийн байлдааны зэвсэглэл: байлдагч, бага дарга нарт винтов, сэлэм, баг, гар гранат, дарга нар нь наган, сэлэм, дуран зэрэг зэвсгээр зэвсэглэсэн бөгөөд бусад техникийн зэвсэглэл нь хөнгөн пулемёт, хүнд пулемёт /максим/ 76 мм-ийн хээрийн ба уулын их буу, харилцаа холбооны зэвсэглэл нь УНАФ ба УНАИ гэдэг аппаратууд КОФ ба номер нэг гэдэг коммутаторууд, агаарын мэдээ зэрэг зэвсэглэлүүдтэй байжээ. Аж ахуйн хангалт нь төлөв гэр ба майханд дарга байлдагчид нь сууж байсан ба харин байшин барилгын талаар зөвхөн 13 дугаар морьт хорооны цэргүүдийн казармаг ба сургагч нарын байшин зэрэг хэдхэн барилгуудтай байсан бөгөөд 1934 оноос 13 дугаар морьт хорооноос бусад ангиуд нь дивизийн штаб ба цэргүүдийн казармаг, гал зуух, дарга нарын байшин, складын зэрэг барилгуудыг барьж эхэлсэн байна.

5 дугаар морьт дивизийн удирдлага, нийт бие бүрэлдэхүүний дотор байлдааны болон улс төрийн бэлтгэл, сургуулийг дээшлүүлэх олон талт үүрэгт ажил төлөвлөгөө ёсоор тогтвортой явагдаж, зохих үр дүнд хүрч байсан нь “5 дугаар морьт дивиз нь 1932 оны зун цаг хээрийн маневрын байлдааны сургуулийг анхдугаар удаа хийж, Хэнтийн 7 дугаар морьт дивизтэй Баянтүмэн хотоос баруун тийш 200 орчим км газарт Бат хаан, Долоон даваа, Сүмбэрийн бүрд зэрэг газруудад тулгаран байлдаж хээрийн сургуулийн үүргийг амжилттай гүйцэтгэсэн бөгөөд маневрын сургуулийн

¹“Монгол цэргийн түүхийн товчоон” (1911 оноос 1990-ээд он) УБ., Дэд дэвтэр. 1996. т. 222

²“Монгол Ардын арми 50 жил”. УБ., 1971. т. 95.

төгсгөлд цэргийн удирдлагаас 5 дугаар морьт дивиз сайн байлдаж тоглосон гэдэг үнэлэлтийг авсан байна...Байлдааны бэлтгэл сургуулиар морин ба явган жагсаалуудын төрөл бүрийн хувиралтууд, төрөл бүрийн буунуудын буудлага, байлдааны тактикийн сургуулиуд, биеийн тамир зэрэг сургуулиудаар хувьсгалт цэргийн байлдах байлдааны эрдмийг бүрэн судалж байсан ба мөн улс төрийн сургуулиар Монгол, Зөвлөлт, олон улсын хоорондын байдал, нам, засгийн тогтоол, бодлогуудыг судалж байжээ. Ерөнхий эрдмийн талаар үндэсний хэл бичиг, тоо бодлого, дэлхийн байдал зэрэг цэргийн олон төрлийн эрдмүүдийг судалж байсан нь эх орноо батлан хамгаалах, гадаад ба дотоодын дайснуудыг үзэн ядах үзлээр хүмүүжүүлж байна”¹ гэснээс тодорхой ажээ.

5 дугаар морьт дивиз 1939 оны Халхын голын дайнд ХХ зууны эхэн үеийн Монголын түүхэнд томоохон нөлөө үзүүлсэн цэрэг, улс төрийн үйл явдлын нэг бол 1939 оны Халхын голын дайн юм.

МАХЦ-ийн анги, нэгтгэлийн зохион байгуулалтыг өөрчлөх, шинэчлэн зохион байгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлсний дотор 1936 оны 7 дугаар сард БНМАУ-ын Ардын хувьсгалын 15 жилийн ойгоор Улсын Бага Хурал (УБХ)-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор 5 дугаар морьт дивизийг маршал Х.Чойбалсангийн нэрэмжит болгон алдаршуулсан түүхтэй. Тус дивизийг маршал Х.Чойбалсангийн нэрэмжит болгосон нь дивизийн бүх дарга, улс төрийн тушаалтан, байлдагч, түрүүч нараас эх орноо батлан хамгаалах, байлдааны ба улс төрийн бэлтгэлийг дээшлүүлэх, цэргийн сахилга журмыг бэхжүүлэх, тэдний урам зориг, улс төрийн идэвхийг нэмэгдүүлэхэд сэтгэл зүйн хувьд ихээхэн чухал нөлөө үзүүлжээ.

Халхын голын дайны эхэн үед “МАХЦ-ийн бие бүрэлдэхүүн 17 мянга орчим хүнтэй, Тамсагбулагт 6 дугаар морьт дивиз, Матадад 8 мд, Баянтүмэнд 5 мд, Байшинтад 7 мд, Улаанбаатарт 1мд болон хуягт бригад зэрэг ангиуд байрлаж байв”². Түүний дотор 5 дугаар морьт дивизийн бүрэлдэхүүнд “13, 14 мх, хуягт, их бууны дивизион бүхий бие бүрэлдэхүүн”³ багтаж байсан ажээ. Харин Халхын голын дайны үед МАХЦ-ийн 5 мд-ийн зохион байгуулалт, хүн хүчийг нэмэгдүүлэх болсны дотор “...5 дугаар морьт дивизийн бүрэлдэхүүнд хуягт дивизион шинээр байгуулж, 15 дугаар морьт хороог (1938.07.10)6 дугаар морьт дивизид шилжүүлжээ. Морьт дивизүүдийн их бууны хороог дивизион болгов... МАХЦ-ийн морьт нэгтгэл, ангиуд (1939.03.02-ны байдлаар) буюу 5 мд-ийн хүн хүчийг дивизийн удирлага-117, холбооны суман-74, 13 морьт хороо-621, 14 морьт хороо-631, 5 их бууны дивизион-340, 5 хуягт дивизион-173, бүгд-1956”⁴ хүнтэй болгон өөрчилж, бусад зохион байгуулалтыг хэвээр үлдээсэн байна.

Эдүгээ Халхын голын дайны түүх судлалд МАХЦ-ийн 5 дугаар морьт дивизийн гүйцэтгэсэн үүрэг, байр суурийг төдий л өргөн дэлгэр, тусгайлан судлан шинжилсэн нь хараахан үгүй юм. Иймд уг асуудлыг түүх архивын баримт, дурдатгал, дурсамжинд тулгуурлан судалж, түүхэн бодит үнэнийг нээн

¹БХТА. сx-1, д-3, хн. 462. хуудас 8-9.

²Ганболд С. “Наймдугаар морьт дивиз Халхын голын дайнд”. УБ., 1995. т.15.

³Ганболд С. “Наймдугаар морьт дивиз Халхын голын дайнд”. УБ., 1995. т.43.

⁴Гомбосүрэн Д. “Монгол улсын Зэвсэгт хүчний байгуулалтын түүх” (ХХ зуун) Судалгааны бүтээл. Нэмж засварласан хоёр дахь удаагийн хэвлэл. УБ., 2012. т. 141-142.

илрүүлж, судалгааны эргэлтэнд оруулах нь тус 5 дугаар морьт дивиз төдийгүй Халхын голын дайнд оролцсон МАХЦ-ийн түүх судлалыг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой билээ.

Түүхэн баримтаас үзвэл, Халхын голын дайны эхний жилээс эхлэн дайн, байлдааны үүрэг, тушаал хүлээж, тухайн газар оронд цэрэг, зэвсгийн хүчээр дайсан этгээдийн эсрэг амжилттай үүрэг гүйцэтгэсэн МАХЦ-ийн анги, нэгтгэлийн нэг бол 5 дугаар морьт дивиз юм. Энэ тухай Батлан хамгаалахын төв архив (БХТА)-ын сан хөмрөгт хадгалагдаж буй. “5 дугаар морьт дивизийн түүх” хэмээх сурвалж бичгийн чанартай нэгэн бүтээлд “Японы империализмууд нь 1935 ба 1936 оны эхээр тус улсын дорнод хязгаарт Халхын сүмийн орчим хилийн будлианыг гаргасан ба БНМАУ-ын хил хязгаарыг цөмрөн орж зөрчсөн учир Засгийн газар ба Цэргийн дээд командлалын тушаалаар тус 5 дугаар морьт дивиз нь байлдааны бэлэн байдалд орж, 1936 оны 1 дүгээр сард Чойбалсан аймгийн Чойбалсан сумын нутаг Хар нуурын зүгт дивизийн тэргүүний ангийг дивизийн дарга хошууч генерал Ч.Доржпаламаар командлуулан явуулсанд дээрх Хар нуурын орчим японы зэвсэглэсэн 3 машин цэрэгтэй ширүүн тулалдааныг хийж, японуудыг өөрийн улсын дархан хил хязгаараас хөөн зайлуулж, японы зэвсэг ба алагдагчдын хүүрүүдийг олзолсон байна. Энэ тулалдаанд нам, засгаас тавьсан үүргийг эх орныхоо өмнө онц гарамгай биелүүлсэн учир пулемёт салааны дарга Содномдаржаа нарын зэрэг 3 тооны хүмүүс улсын дээд шагнал, одон тэмдгээр шагнагдсан байна”¹ гэж тэмдэглэжээ.

Японы нисэх онгоцууд 1939 оны 6 дугаар сар гарсаар Баянтүмэн хотыг хэд хэдэн удаа бөмбөгдөв. 5 мд ч үйл ажиллагаагаа дайны байдалд зохицуулан явуулж, байлдаанд орох бэлтгэл хийж байв. Фронт дээрх цагийн байдал хүндэрч, дайсны хүч нэмэгдэж байсан 6 дугаар сард Зөвлөлт, Монголын командлал фронт руу нэгтгэл, ангиудыг нэмж татсан билээ. Энэ үед 5 дугаар морьт дивиз Бүх цэргийн жанжны тушаалаар Баянтүмэн хотоос хөдөлж Буйр нуурын орчимд хилийн зүгээс дайсныг нэвтрүүлэхгүй барьж байх үүрэгтэйгээр хориглолтод шилжсэн юм....Бүх цэргийн жанжны тушаалаар 5 дугаар морьт дивиз 1939 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Баянтүмэн хотоос хөдөлж Хонгор хулстайд очиж улсын хилийг хориглон хамгаалах үүрэг хүлээн авчээ (мөн энэ үед 8 мд Матадаас хөдөлсөн) Тэндээс 7 дугаар сарын 11-ний өдөр Буйр нуурын баруун ба баруун хойд талаар улсын хилийг хориглон хамгаалах тушаал авч хөдлөн 14-нд заагдсан районд очжээ”². Энэ үеэс эхлэн 5 дугаар морьт дивиз Халхын голын дайны жилүүдэд МАХЦ-ийн бусад бие бүрэлдэхүүний нэгэн адил байлдааны үүрэг, даалгавар гүйцэтгэж, улс орны хил хязгаарыг батлан хамгаалах, дайсны халдлага довтолгоог тууштай эсэргүүцэн тэмцэхэд өөрсдийн хувь нэмрийг бодитой оруулж эхэлсэн байна.

МАХЦ-ийн 5 дугаар морьт дивиз тогтоосон цагт заасан районд гарч хориглолтонд шилжээд байтал мөн оны 7 дугаар сарын 11-ний өдөр Хонгор хулстайгаас Хөх ус, Адаг Дулаан, Алаг морьт, Бадам Ишийн худаг, Булан дэрсний чиглэлд маршрут үйлдэж, Булан дэрс, Баян нуурын районд хүч хуралдуулах тушаал хүлээн авчээ. Улмаар Булан дэрсний заагт дөнгөж очоод

¹БХТА. сx-1, д-3, хн-462. хуудас 9.

²Ганболд С. “Наймдугаар морьт дивиз Халхын голын дайнд”. УБ., 1995. т.43-44.

байхад Бүх цэргийн жанжны орлогч Ж.Лхагвасүрэн тус дивиз дээр хүрэлцэн ирж, 5 дугаар морьт дивизийн даргаар байлдааны ангийн штабын дарга, хошууч Г.Дорж, дивизийн штабын даргаар Н.Сандуйжав нарыг маршал Х.Чойбалсангийн тушаалаар томилсныг мэдэгдэж, МАХЦ-ийн 5 дугаар морьт дивиз нь Армийн 1 дүгээр бүлгийн командлагчийн бэлтгэл хүчний бүрэлдэхүүнд орж, Булан дэрс, Улаан худаг, Адаг Дулааны заагт хориглолтонд шилжиж, Буйр нуурын хойд талаар ороон Халх гол дахь Монгол, Зөвлөлтийн цэргийн гол хүчний ар тал Тамсагбулагийн чиглэлээр хийж болзошгүй Японы дайралтыг няцаах, цаашид байлдааны ямар ч үүрэг даалгавар биелүүлэхэд бэлэн байдлыг хангах үүрэг хүлээсэн байна. Ингээд тушаал ёсоор 5 дугаар морьт дивизийн 13 дугаар морьт хорооны 1 дүгээр суманг Булан дэрсэнд, 2 дугаар суманг Улаан худаг, Адаг Дулааны хооронд, 3 дугаар суманг Улаан худгийн өмнө талд тус тус хориглон байрлуулж, 14 дүгээр морьт хороог их буу, хуягт дивизионы хамт дивизийн даргын хөдөлгөөнтэй бэлтгэл хүчинд авсан байна. Халхын голын дайны ажиллагаа ид үргэлжилсэн шийдвэрлэх цаг мөчид 5 дугаар морьт дивизийн удирдлага, нийт бие бүрэлдэхүүн өөрт оногдсон эр цэргийн үүрэг, тушаалыг нэр төртэй биелүүлэхийн төлөө бүхий л нөөц боломжийг шавхан дайчилж байсны үр дүнд дайсан этгээдийн халдлагыг тухай бүр таслан зогсоож байжээ.

5 мд-ийн байлдааны түүхэнд холбогдох нэг чухал зүйл бол Халхын голын дайны дунд үеэр 8 мд-д хүч нэмэгдүүлэн очсон 14 мх-ны байлдааны ажиллагаа байдаг.

Халхын голын дайны түүхийн асуудлаар бичсэн ном, материалуудад буй ганц нэг өгүүлэл, дурсамжийг эс тооцвол тус хорооны гүйцэтгэсэн үүргийн талаар товч төдий дурдаж 8 мд-д хүч нэмэгдүүлэн очсон гэхээс өөр тодорхой зүйл бараг тааралддаггүй билээ. Дээрх материалуудад тус хорооны гүйцэтгэсэн үүргийг тэр бүр бүрэн дүүрэн гаргаж чадаагүй хоорондоо зөрөөтэй, ташаа бичигдсэн зүйл багагүй байдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Ер нь ч тэгээд Халхын голын дайнд МАХЦ-ийн 6, 8 мд оролцож байлдсан гэж өнөөг хүртэл өргөн дэлгэр сурталчилж ирснээс 14 мх болон 5 мд, байлдаанд шууд биш ч гэсэн ямар нэг хэмжээгээр оролцсон бусад нэгтгэл, ангийн талаар тодорхой судалж, гүйцэтгэсэн үүргийг нь үнэлж ирсэнгүй.

Тэгэхээр 14 мх Халхын голын дайнд чухам хэдий үеэс эхлэн оролцож ямар үүрэг гүйцэтгэв гэдэг асуулт зүй ёсоор гарч ирэх нь мэдээж. Зэвсэгт хүчний төв архивт байгаа материалууд болон бусад холбогдох ном, өгүүлэл, ахмад дайчдын дурсамжийг судалж үзсэний үндсэн дээр тус хорооны талаар бага зэрэг тодруулах оролдлого хийв.

Халхын голын дайн эхлэхэд бүрэлдэхүүндээ 13, 14 мх, хуягт, их бууны дивизион бүхий 5 мд Баянтүмэн хотод байрлаж байв. Японы нисэх онгоцууд 6 дугаар сар гарсаар Баянтүмэн хотыг хэд хэдэн удаа бөмбөгдөв. 5 мд ч үйл ажиллагаагаа дайны байдалд зохицуулан явуулж байлдаанд орох бэлтгэл хийж байв. Фронт дээрх цагийн байдал хүндэрч дайсны хүч нэмэгдэж байсан 6 дугаар сард Зөвлөлт, Монголын командлал фронт руу нэгтгэл, ангиудыг нэмж татсан билээ. Энэ үед 5 мд Бүх цэргийн жанжны тушаалаар Баянтүмэн хотоос хөдөлж Буйр нуурын орчимд хилийн зүгээс дайсныг нэвтрүүлэхгүй барьж байх

үүрэгтэйгээр хориглолтод шилжсэн юм. Зөвлөлт, Монголын цэргийн командлал 7 дугаар сарын сүүлээс эхлэн ерөнхий давшилтад бэлтгэн анги, салбаруудыг нөхөн хангаж шинээр ирсэн ангиудыг фронт руу татан хүч хуралдуулж эхлэв. Энэ үед 8 мд нэлээд хэдэн удаагийн байлдаанд орж хүн хүчний хувьд ч багагүй хорогдсон, тэгээд ч давшилтын гол чиглэл болох “Өмнөд” бүлгийн баруун жигүүрийг халхлах үүрэг хүлээсэн тул түүнд хүч нэмэгдүүлж 5 мд-ээс 14 мх-г өгсөн байна.

Халхын голын дайнд тус хороог удирдаж явсан Л.Гомбожав дурдатгалдаа “...5 мд 1939 оны 6 дугаар сарын 28-нд Баянтүмэн хотоос хөдөлж Буйр нуурт очин хориглосон. Манай хороо 7 дугаар сарын 8-нд Буйр нуураас фронт руу хөдөлж 11-ний өдөр Хамар даваанд очин 8 мд-ийн мэдэлд орж 7 дугаар сарын 28-ны өдөр анхныхаа байлдаанд орсон юм. 8 дугаар сарын 4, 5-ны үед болон 12-ны өдөр дайсантай ширүүн байлдаж 17-ны өдөр Хулд уулыг дайснаас чөлөөлсөн”¹ тухай бичсэн байдаг.

Мөн тус хорооны тухай өгүүлсэн зарим нэг бүтээлд “5 мд 1939 оны 6 дугаар сарын 24-нд Баянтүмэнээс маршаар хөдлөн 29-ны өдөр Буйр нуурт очин хориглосон бөгөөд 14 мх нь их бууны батарей ба хуягтын салаагаар хүч нэмэгдүүлэн 7 дугаар сарын 8-нд фронт руу хөдөлж 14-ний өдөр Хамар даваанд хүч хуралдуулан 8 мд-ийн мэдэлд очсон. Мөн сарын 22, 24-ний өдрүүдэд дайсантай байлдаж ялалт байгуулж байсан ба 27-ны өдөр дайсантай байлдаж Хулд уулыг эзэлсэн” тухай өгүүлсэн байдаг².

Мөн 5 мд-ийг 5 дугаар сарын 28-нд Баянтүмэнээс гарч Буйр нуур руу явсан бөгөөд 14 мх нь 7 дугаар сарын 25-нд фронт руу хөдлөн 8 дугаар сарын 5-нд Хэрээ уулыг чөлөөлөх, 10-ны үеэр Гэр чулууны районд, 19-20-ны үеэр Эрс уулыг дайснаас чөлөөлөх байлдаан хийж байсан³ гэх баримт ч байдаг.

Ийнхүү цаг хугацааны хувьд хоорондоо зөрүүтэй дээрх баримтууд нь тус хорооны Халхын голын дайнд гүйцэтгэсэн үүргийг тодруулахад бэрхшээл учруулж байгаа юм. Зэвсэгт хүчний төв архивт 14 мх-ны байлдааны ажиллагааны талаар тодорхой өгүүлсэн баримт материал ховор ч зарим нэг холбогдох материалыг нягтлан үзвэл бодит байдал дээр өгүүлснээс өөр байдаг.

Бүх цэргийн жанжны тушаалаар 5 мд 1939 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Баянтүмэн хотоос хөдөлж Хонгор хулстайд очиж улсын хилийг хориглон хамгаалах үүрэг хүлээн авчээ /мөн энэ үед 8 мд Матадаас хөдөлсөн. Тэндээс 7 дугаар сарын 11-ний өдөр Буйр нуурын баруун ба баруун хойд талаар улсын хилийг хориглон хамгаалах тушаал авч хөдлөн 14-нд заагдсан районд очжээ⁴.

Халхын голын дайны дундуур МАХЦ-ийн хээрийн штабаас 1939 оны 8 дугаар сарын 14-нд гаргасан 26 тоот тушаалаар 5 мд-ийн 14 мх-г батарей ба 7 хуягт машин бүхий хуягт сумангийн хамт 8 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн 8 мд-ийн мэдэлд шилжүүлжээ. Мөн өдрийн оройноос эхлэн 14 мх-г морин гарам 2-оос хойд зүг 10 км-ийн районд 8 мд-ийн байлдааны байрын баруун гарт, хуягт суманг Хэрээ уулаас баруун хойш 6 км-т байрлуулж хүнд пулемёт бүхий нэг

¹БХТА, сх.4, д.2, хн.97, хуудас 1-6

²Жамсранжав Ш. “Мөнх найрамдлын их ялалт”. УБ., 1969. т.151-153, “Халх голын байлдаанд оролцсон ахмад дайчдын дурдатгал”. УБ., 1981, т.33-40, “Эх орны төлөө”. 1939.07.16.№21.

³“Улаан одон”. 1939.08.10. №92

⁴БХТА, сх.1, д.3, хн.462. х.33

салааг Эрс уулын овоон дээр ба хүнд пулемётын салаа бүхий нэгэн суман, танк эсэргүүцэх их буу, хуягт салаануудыг Хулд уулын овоон дээр тус тус байрлуулах, эл хүчээр дивизийн баруун гарыг хангахыг¹ даалгасан байна.

Бүх цэргийн жанжны орлогч Ж.Лхагвасүрэн, Жанжин штабын дарга Ж.Цэрэн нарын нэр дээр 5 мд-ийн штабаас 8 дугаар сарын 15-нд явуулсан нэгэн бичигт "...8 дугаар сарын 11-нд 14 дүгээр хороог наймын даргын мэдэлд /8 мд-ийн/ шилжүүлсүгэй хэмээсэн тушаал ирсэн бөгөөд гэтэл танай газраас манай комиссарт тэр өдөр тушаалыг өгч уул тушаалыг хүчингүй болгосон. Гэтэл маргааш өглөө нь ...сургагчид утсаар тушаал ирж тэр тушаалын ёсоор 14 хороог батарей ба 7 хуягтаар хүч нэмэгдүүлэн явуулсан болно"² гэжээ. Мөн 5 мд-ийн комиссар дивизионы комиссар Г.Тогтохоос Улс төрийн газрын даргад 8 дугаар сарын 15-нд явуулсан илтгэлдээ "...өөрийн 4 дүгээр хороог хүч нэмэгдүүлэн 12-нд явуулсан болно"³ гэсэн байдаг.

Дээрх баримтуудаас харахад 14 морьт хороо наймдугаар сарын 12-ны өдөр Буйр нуурын районоос дээд командлалын тушаалын дагуу фронт руу хөдөлжээ. Улмаар Халхын голын районд 8 дугаар сарын 14-ний өдөр хүрэлцэн ирж МАХЦ-ийн хээрийн штабаас гаргасан тушаалын дагуу мөн өдрийн оройгоос эхлэн 8 мд-ийн мэдэлд очиж баруун жигүүрт нь байрлан, хориглолтод шилжсэн нь тодорхой. Тэгэхлээр тус хороог 7 дугаар сараас эхлэн байлдаанд орсон гэдэг нь өөр баримтаар нотлогдохгүй байгаа тул 8 дугаар сарын 14-нөөс эхлэн фронтод ирж байлдааны ажиллагаанд оролцож эхэлсэн гэж үзэх нь зүйтэй юм. 1946 онд бичсэн маршал Х.Чойбалсангийн нэрэмжит 5 мд-ийн түүхэнд ч 14 мх-г их бууны батарей, хуягтын салаагаар хүч нэмэгдүүлэн 8 дугаар сарын 12-ны өдөр хөдөлж 8 мд-ийн харьяанд орон байлдсан гэж өгүүлсэн байдаг⁴.

Халхын голын дайнд 14 морьт хороо нь: хорооны дарга дэслэгч Л.Гомбожав, хорооны штабын дарга ахлах дэслэгч А.Даваа, хорооны комиссарыг орлож намын товчооны дарга, улс төрийн бага удирдагч Ц.Цэрэндорж /хорооны комиссар Рэнцэн нь 8 дугаар сарын 8-нд шүүхэд шилжсэн байна, байлдааны ангийн дарга Балдан, тагнуул ангийн дарга Лувсандорж, 1 дүгээр сумангийн дарга Дамдинжав, 2 дугаар сумангийн дарга Содном, 3 дугаар сумангийн дарга Лувсандорж, 4 дүгээр сумангийн дарга Пунцаг, пулемёт сумангийн дарга Л.Гончигжамц, танк эсэргүүцэх салааны дарга Пүрэвдорж, тус хороонд хүч нэмэгдүүлсэн их бууны батарейн дарга Дармаа, хуягт сумангийн дарга Содов нарын удирдах бүрэлдэхүүнтэй оролцжээ. Тус хороо нь түр цэрэг 156-г авч хүн хүчний хувьд 700 гаруй цэрэг, даргатай, 765 агт морьд, 76 мм-ийн 4 их буу, 45 мм-ийн танк эсэргүүцэх их буу 3, 37 мм-ийн агаарын пулемёт 5, хөнгөн хуягт 2, дунд хуягт 5, 30 гаруй хүнд, хөнгөн пулемёт бүхий хүч бүрэлдэхүүнтэй байлдаанд оролцсон байна⁵.

14 морьт хороо 8 дугаар сарын 20-ны их давшилт хүртэл дээр заагдсан районд байрлаж байгаад давшилт эхлэхэд 8 мд-ийн бэлтгэлд үлджээ⁶. Тус хороо

¹БХТА. сх.4, д.2, хн.32, хуудас 65.

²БХТА. сх.4, д.2, хн.36, хуудас 33.

³БХТА. сх.4, д.2, хн.36, хуудас 41.

⁴БХТА. сх.1, д.3, хн.462, хуудас 33.

⁵БХТА. сх.4, д.2, хн.39, хуудас 13.

⁶"Халх гол: түүхэн үнэний эрэлд". УБ., 1993. т.83.

фронтод ирснээс хойш 8 дугаар сарын дундуур дайсны томоохон хүчтэй 4 удаа байлдаж¹, 9 удаа бага, жижиг хүчтэй байлдан устгаж байсан² тухай зарим нэг мэдээ байдаг хэдий ч одоогоор зөвхөн 2 удаагийн байлдааных нь талаар л архивын баримт олддоод байна.

Наймдугаар сарын 24-ний өдөр 23 мх танкийн ротын дэмжлэгтэй Хулд уулын зүг давшин байлдаж чөлөөлсөн юм. Энэ байлдаанд 14 мх нь 23 мх-той хүч хавсран байлдсан байж болох бөгөөд энэ өдөр Х.Лхагвасүрэн, У.Найдан нар амь үрэгдэж³, салааны дарга М.Нямжав, цэрэг П.Дамдинсүрэн нарын 5 хүн шархадсан байна⁴. Гэвч харамсалтай нь дээрх алагдаж, шархадсан дарга, цэргүүд дайсны суманд бус өөрийн онгоцны пулемётын галд өртөж хохирол үзжээ.

БНМАУ-ын нутаг дэвсгэр 8 дугаар сарын 31 гэхэд Японы халдан довтолгочдоос бүрэн цэвэрлэгдэж Зөвлөлт, Монголын ангиуд улсын хилийн дагуу хориглолтод шилжсэн билээ. Японы тал 9 дүгээр сар гарсаар манай улсын хилийг их бага хүчээр зөрчиж 8 морьт дивизийн байрлалаар үе үе халдан довтолж эхэлсэн юм. Энэ үед 9 дүгээр сарын 5-нд 14 морьт хороо нь дайсны эсрэг хүчтэй байлджээ. Энэ өдрийн байлдаанд цэрэг Чойжилын Лувсандаш дайсны 14 цэргийг, их бууны батарейны бага дарга Доржийн Равсал дайсны 20 шахам хүнийг устган өөрөө хүнд шархадсан байна. Мөн цэрэг Очирын Базарваань, Чүлтэмийн Сундуй нар эрэлхэг зоригтой байлдаж, цэрэг Ойдовын Шарав, Жамъянгийн Самбуу нар энэ байлдаанд холбоочны үүргийг сайн биелүүлсний учир Байлдааны гавьяаны улаан тугийн одонгоор шагнуулж байжээ⁵.

Тус хорооны ахмад дайчдын дурдатгалууд болон Халхын голын дайны талаар бичсэн ном бүтээлд 14 морьт хорооны явуулсан байлдааны ажиллагааны тухай зарим нэг зүйлийг онцлон дурдсан байдаг юм. Тус хорооны штабын дарга байсан А.Даваагийн дурсамжид "... Дивизийн штабаас /8 мд-ийн/ хорооны дарга Гомбожавыг хүнд пулемёт бүхий салаа цэрэгтэй Баргын Жанжин сүмийн чиглэлд тагнуулын үүрэг гүйцэтгүүлэхээр явуулсан нь замдаа Японы эзэлсэн Дархан уулын орчим дайсны хүрээнд орж хүн ба морьдоо шархдуулан буудалцаж буцаж ирснийг нэг суман хүчтэй болгон Гомбожаваар удирдуулан Хулд уулын районд хориглосон дайсны хүчийг барьж байх үүрэгтэйгээр явуулсан"⁶ гэж бичсэн байдаг. Мөн цааш нь Дархан уулыг эзлэн авахын төлөө дайсны их буу бүхий морьт хороо цэрэгтэй байлдаж устгасан тухайгаа дурсан бичсэн байдаг нь чухам хэзээ болсон тулалдааныг өгүүлсэн нь тодорхой бус байна. Мөн "...Япончууд 14 мх-ны хамгаалж байсан Шар толгой, Улаан давааны орчмоор хүч нэмэгдүүлсэн хоёр суман цэргээр довтолсон тул дайсныг няцаах ширүүн байлдаанд оржээ. Хорооны дарга Гомбожав байлдааны ажиллагааг удирдан Содном даргатай 2 дугаар сумангаа хүч нэмэгдүүлэн Хулд уулын баруун талын Шар толгойн орчимд Японы тоогоор илүү хүчинтэй хагас өдрийн

¹БХТА. сх.16, д.4, хн.97, хуудас 1-6.

²"Улаан одон". 1939.08.10. №92.

³БХТА. сх.16, д.4, хн.109, хуудас 16.

⁴БХТА. сх.16, д.4, хн.40, хуудас 3-8.

⁵БХТА. сх.16, д.4, хн.24, хуудас 36.

⁶БХТА. сх.16, д.4, хн.97, хуудас 21-22.

турш байлдсан байна. Энэ байлдаанд Япончуудын бараг салаа шахам цэргийг бутцохин устгаж үлдэгдэл нь ухран зугтжээ. Энэ хүч тэнцвэргүй байлдаанд 2 дугаар сумангийн дэслэгч Хасарваанийн салааны туслах бага дарга Дорж дайсны эсрэг хориглон байлдаж байгаад зүүн гараа хуга буудуулан, нэг нүдээ сохлуулсан боловч Японы цэргийн эсрэг эх орныхоо алхам газрын төлөө зоригтой байлдаж өөрийнх нь сум дууссан тул дайсанд алагдсан өөрийн 7 байлдагчийн буу, сумыг авч хэрэглэн 20 гаруй дайсныг устгаж дайсны довтолгоог няцаан баатарлаг гавьяа байгуулжээ. Тэрээр ганцаараа тулалдан дайсанд цохилт өгсөөр байгаад өөрийн ар талаас нэмэгдэл хүч хүрэлцэн ирэхэд хорооны дарга Гомбожав, комиссар Цэрэндорж нарт эх оронч баатрын ёсоор сэтгэгдлээ хэлээд нас баржээ”¹ гэж бага дарга Дорж болон түүний нөхдийн байгуулсан баатарлаг гавьяаны тухай өгүүлсэн зүйл ч байдаг. Харин энэ байлдааныг 7 дугаар сарын 24-нд болсоноор бичсэн байх ба өөр нэг номонд “... 7 дугаар сарын 14-нд бага дарга Дорж өөрийн тасгийн 9 байлдагчийн хамт Шар толгой, Улаан давааны орчмоор довтолсон дайсны хүч нэмэгдүүлсэн суманг хорооны гол хүч хүрэлцэн очтол тогтоон барьж байлдах тушаал авч байлдан тасгийнх нь цэргүүд алагдан өөрөө хэдэн удаа шархдаж ганцаар үлдсэн ба хорооны гол хүч хүрэлцэн ирж дайсныг хөөн зайлуулсан бөгөөд бага дарга Дорж эрэлхэгээр байлдаж нас барсан”² тухай бичсэн байдаг.

Энд тэмдэглэн хэлэхэд 7 дугаар сард 14 морьт хороо нь фронтод ирээгүй байсан нь тодорхой бөгөөд 8 дугаар сарын сүүлч болон 9 дүгээр сарын эхэн үед болсон аль нэгэн байлдааны тухай дээр өгүүлжээ.

Харин хэдэн сарын хэдний өдрийн байлдаанд дээр дурдсан бага дарга Дорж тэргүүтэй чухам хэн гэдэг цэргүүд амь үрэгдсэн тухай бүртгэл болон байлдааны үеийн хорогдлын мэдээ байхгүй байгаа юм. Дээр дурдсан хоёр баримтын нэгэнд нь “Бага дарга Дорж өөрийн 9 байлдагчийн хамт тушаал авч явж байлдсан” гэх, нөгөө баримтад буй “...дайсанд алагдсан 7 байлдагчийнхаа буу сумыг авч байлдсан” гэж дурдсаныг “...цэрэг Ойдовын Шарав, Жамъянгийн Самбуу нар нь 9 дүгээр сарын 5-ны өдрийн байлдаанд холбоочны үүргийг сайнаар биелүүлсний учир”³ Улаан тугийн одонгоор шагнуулахаар тодорхойлсон архивын баримттай харьцуулж үзвэл бага дарга Дорж тасгийнхаа хоёр цэргийг ар талтай холбоо бариулахаар явуулж өөрсдөө баатарлагаар байлдан амь үрэгдсэн, хорооны гол хүч хүрэлцэн ирж дайсныг бутцохисон энэ байлдаан нь 9 дүгээр сарын 5-ны өдөр болсон байж болох юм. Халхын голын дайнд онц гарамгай байлдсаны учир 14 морьт хорооноос одонгоор шагнуулагсдын бүртгэл, тодорхойлолтоос үзвэл энэ өдрийн байлдаан нь тус хорооны хувьд дайсантай хийсэн томоохон байлдаан байжээ.

5 морьт дивизийн комиссар байсан Г.Тогтох өөрийн дурсамжид “...14 дүгээр хорооноос 2 дугаар сумангийн салааны дарга Найдан, хүнд пулемётын наводчик Нямаа, Шарав, байлдагч Норовсамбуу, Арилдий, Равжил, тасгийн дарга Дорж нарын 30 гаруй дарга, байлдагчид эх орныхоо төлөө эрэлхэг цогтой тулалдаж амь эрсдсэний гадна их буу, хуягт, пулемёт зэрэг зарим зэвсэг

¹“Халх голын байлдаанд оролцсон ахмад дайчдын дурдатгал”. УБ., 1981. Т.33-40.

²Жамсранжав Ш. “Мөнх найрамдлын их ялалт”. УБ., 1969. т.151-153.

³БХТА. сх.16, д.4, хн.24. хуудас 36.

техникээ эвдүүлэн... 50 гаруй агт морьдын” хохирол үзсэн тухай дурдсан байдаг. Харин одоогоор тус хорооноос Халхын голын дайнд нийтдээ 12 хүн амь үрэгдэж, шархадсаныг архивын баримтаар тогтоогоод байна. Мөн 2 хүн амь үрэгдэж, 15 хүн шархадсан гэх баримт ч байдаг¹.

Маршал Х.Чойбалсан Халхын голын дайны шувтаргаар фронт дээр ирж 8 морьт дивизийн байлдааны ажиллагаатай танилцахдаа тус хорооны үйл ажиллагааг өндөр үнэлж,агаарын салааны дарга дэслэгч Гончигжамц, танк эсэргүүцэх салааны дарга дэслэгч Пүрэвдорж, салааны дарга бага дэслэгч Гэндэн нарын 5 хүнд алдар цол нэмэгдүүлэн шагнажээ².

Төр засгаас 14 морьт хорооны Халхын голын дайнд гүйцэтгэсэн үүргийг өндөр үнэлж хуягт сумангийн дарга Содов, тасгийн дарга Г.Найдан, улс төрийн удирдагч Д.Нямбуу, цэрэг Д.Галсан, Ч.Сундуй, Ш.Хойши, тасгийн дарга Д.Равжил нарын 20 гаруй цэрэг, дарга нарыг төрийн дээд шагнал болох Улаан тугийн болон Алтан гадас одонгоор шагнасан байна.

Ийнхүү 14 морьт хороо нь командлалын даалгаврыг амжилттай биелүүлж манай эх оронд халдан довтолсон Японы түрэмгийлэгчдийг бутцохисон ялалтад өөрийн зохих хувь нэмрийг оруулсан байна.

Эцэст нь тэмдэглэхэд 5 морьт дивизийн 14 морьт хорооны гүйцэтгэсэн үүргийг цаашид улам гүнзгийрүүлэн судалж тодруулах нь Халхын голын дайны түүхийг баяжуулан түүхэн үнэнийг сэргээж олон түмний хүртээл болгоход чухал ач холбогдолтой болох билээ.

Монгол-Зөвлөлтийн хамтарсан хүчний ажиллагаа улам бүр өргөжин тэлэхийн хэрээр 8 дугаар сард ерөнхий давшилтыг эхлүүлснээр Халхын голын дайны ялалтын санаачлагыг гартаа оруулан, японы түрэмгийлэгчдэд эцсийн шийдвэрлэх цохилтыг өгсөн билээ. Энэ хугацаанд 5 морьт дивизийн бие бүрэлдэхүүн байлдааны үүрэг, даалгаврыг цаг ямагт алдалгүй биелүүлсээр ирсэн бөгөөд “Халхын голын дайнд онц гарамгай байлдсан ба байлдааны үүргийг онцоор биелүүлсэн учир нэгтгэлийн дарга Дорж, холбоо сумангийн байлдагч Лувсанбалдан тэргүүтэй хорь гаруй тооны байлдагч, бага дарга, дарга, улс төрийн ажилтан нар улсын дээд шагнал одон тэмдгээр шагнагдсан байна. Халхын голд японы самурай нар Зөвлөлт-Монголын армиудад бут цохигдсоноор Халхын голын дайн төгссөн учир тус нэгтгэл (5 мд) нь цэргийн дээд командлалын тушаалаар 1939 оны 10 дугаар сарын 16-ны өдөр буцах маршид орж, мөн сарын 22-ны өдөр Баянтүмэн хотноо хүрэлцэн ирж байрлажээ”³.

Өмнө өгүүлснийг дүгнэвэл, Халхын голын дайны шийдвэрлэх ялалтыг хангахад МАХЦ, түүний дотор 5 дугаар морьт дивизийн удирдлага, бие бүрэлдэхүүн тухайн үеийн нам засаг, цэргийн дээд удирдлагын тушаал, шийдвэрийг нэр төртэй биелүүлж, үнэтэй хувь нэмэр оруулжээ. Түүнчлэн 5 дугаар морьт дивиз нь байлдааны туршлага, сургамжийг ихэд хуримтлуулж, хожим явагдсан цэрэг, дайны ажиллагаа (1945 оны Чөлөөлөх дайн)-нд тууштай нэвтрүүлж, амжилт ялалтаа бэхжүүлэх үндэс суурь тавьсан аж. Эцэст нь

¹БХТА. сх.16, д.4, хн.28. хуудас 8.

²БХТА. сх.4, д.2, хн.32. хуудас 119.

³БХТА. сх-1, д-3, хн-462. хуудас 11.

тэмдэглэхэд, Халхын голын дайнд оролцсон МАХЦ-ийн удирдлага, нийт бие бүрэлдэхүүний дотроос 5 дугаар морьт дивизийн гүйцэтгэсэн үүрэг, байр суурийг сурвалж, судалгааны бүтээлүүдэд түшиглэн нэхэн тодруулах, улам бүр шинэчлэн баяжуулах, судалгаа, шинжилгээний эргэлтэнд оруулах зэрэг хэрэгцээ шаардлага нь цэргийн түүх судлалын тулгамдсан асуудлын нэг хэвээр байгаа болно.

2.2. Монгол ардын хувьсгалт цэргийн 6 дугаар морьт дивиз Халхын голын дайнд.

6 дугаар дивиз үүсэн байгуулагдсан нь. 1927-1932 онд Монгол улсын талаарх Япон, Хятад зэрэг орны баримтлах бодлогод эзлэн түрэмгийлэх хандлага идэвхжиж байгааг харгалзан улс орныг батлан хамгаалахын тулд Ардын цэргийн хүчийг зузаатгах, хил хязгаарыг сахин хамгаалах ажлыг улам эрчимжүүлэх, цэргийн дотор явуулах сургалт, хүмүүжлийн ажлыг сайжруулах талаар Ардын засгийн газраас нэлээд арга хэмжээ авчээ.

Япон улс цэргийн зардлаа эрс нэмэгдүүлэн дайнд эрчимтэй бэлтгэж Хятадын гоминданы эрх баригчид болон явцуу эрх ашиг хөөцөлдөгч зарим урвагчдын туслалцаатайгаар Хятадын нутагт цөмрөн орж, зүүн хойд Хятадыг бүхэлд нь эзэлжээ. Тэд Манжуур, Хятадын зүүн хойд хэсгийг эзлэн авсныхаа дараа БНМАУ-ын хилийн орчим төмөр зам тавьж, засмал замыг сайжруулан засварлаж, цэргийн байр, зэвсэг, галт хэрэглэлийн агуулах, онгоцны буудал барьж эхэлжээ. Квантуны армийн штабаас зохион байгуулсан тагнуулын бүлэг манай улсын хил хязгаарт нэвтрэн орж, газрын зураг авах, хилийн тэмдэг, пайзыг устгах, худаг ус эрж хайх зэргээр тагнан турших, өдөөн хатгах үйл ажиллагаагаа идэвхжүүлж байлаа.

Улс орны дорнод хилийн байдал түгшүүртэй байгаад дүгнэлт хийж БНМАУ-ын Хувьсгалт цэргийн зөвлөл 1932 оны 3 дугаар сарын 12-ны 16 тоот тушаалаар дорнодын 2 дугаар морьт корпусын орон тоог баталж Баянтүмэнд байгуулжээ. Энэ корпусын бүрэлдэхүүнд 6 дугаар морьт дивиз орж Тамсагбулагт байгуулагдсан юм.

Гэвч 6 дугаар морьт дивизийн үүсэл хөгжил, дайчин замнал нь түүнээс өмнөх үетэй, улс орны дорнод хил, түүний амгалан тайван байдал, ард иргэдийн аж амьдралтай салшгүй холбоотой юм.

1921 онд өрнөсөн ардын хувьсгалын үед зүүн хязгаарыг цагаантны үлдэгдлээс чөлөөлөхөөр ардын журамт цэргийн хороо партизан Бумцэндийн удирдлагаар хөдөлжээ. Хүнд пулемёт, винтов, ширмэн бөмбөг, жад сэлмээр зэвсэглэсэн 200 хүнтэй энэ хороо 1921 оны 7 дугаар сарын 17-нд Санбэйсийн өргөө суурин /Баянтүмэн хот/-г чөлөөлж Егүзэрийн хийдэд төвлөрч байсан Найданжав вангийн 400 орчим цэргийг 8 дугаар сарын сүүлчээс эхлэн Арын хамбын хүрээ, Алтан очирын хийд, Бор-Өндрийн говь хүртэл дамжуулан хөөж сүүлчийн үлдэгдлийг Тээгийн сүмээс зүүн тийш Цагаан уул хэмээх газар бут цохижээ.

Бумцэндийн удирдсан хороо Тамсагбулагийг чиглэн явсан цагаантны үлдэгдлийг нэхэн хөөж бут цохиод хил хязгаарыг сахин хамгаалах үүрэг гүйцэтгэж байгаад 1921 онд Матадын төвийн орчим Билүүтийн ацат гэдэг газар

өвөлжжээ. Энэ хороог суурь болгон Тамсагбулагт цоохор цэргийн анги байгуулагдсан байна. Хожим нь 1925 онд цэргийн зөвлөлийн шийдвэрээр энэ ангийг 15 дугаар морьт тусгай суман болгон байгуулж даргаар нь Чойбалсан аймгийн Халхын гол сумын харьяат Шархүүг тохоон томилжээ. Эл 15 дугаар морьт тусгай суман сэлэмт салаа гурав, пулемёт салаа нэгтэйгээр зүүн хязгаарыг сэргийлэн хамгаалах үүргийг хүлээж байв.

1928 онд тус суман морьт хороо болон өргөжин зохион байгуулагдав. Хороо нь сэлэмт суман хоёр, их бууны батарей нэг, пулемёт суман нэгтэй байсан бөгөөд Сүмбэр харуулыг хүлээн авч 1932 он хүртэл хил хязгаарыг хамгаалах үүрэг хүлээж байжээ. Үүний зэрэгцээ цэргийн сургууль дадлагыг цуцалтгүй хийж ард олны дотор нам, засгийн бодлогыг тайлбарлан таниулах, цэргийн насны залуучуудыг сурган хүмүүжүүлэхэд зохих хувь нэмэр оруулжээ. Энэ хороо нь 6 дугаар морьт дивизийн анхны үүсэл байсан юм.

МАХЦ-ийн 6 дугаар морин дивизийн орон тоо, зохион байгуулалт. МАХЦ-ийн 6 дугаар морьт дивиз 1932 оны 8 дугаар сард байгуулагдан анхны даргаар нь партизан Мөнхцэрэнгийн Гомбо томилогджээ.

Дивизийн тайван цагийн орон тоог Цэргийн яамны сайд 1932 оны 7 дугаар сарын 30-ны өдөр баталсан байна. Үүний дагуу тус дивиз 15, 10 дугаар морьт хороо, их бууны хороо, бага даргын сургууль, холбооны суман гэсэн ангиудтай анх байгуулагджээ. Энэ орон тоогоор дивизийн удирдлага, штаб, улс төрийн хэлтэс, хүн ба мал эмнэлэг зэрэгт бүгд 53 хүн, бага даргын сургуульд 121 хүн, 15 дугаар хороонд 526 хүн, 10-р хороонд 568 хүн холбооны суманд 76 хүн байхаар тусгагджээ¹. 1934 онд Бүх цэргийн зөвлөлийн шийдвэрээр 6 дугаар морьт дивизийн 15 дугаар морьт хороог Баянтүмэний 5 дугаар морьт дивизийн бүрэлдэхүүнд шилжүүлж, түүний оронд 17 дугаар морьт хороог байгуулжээ². Энэ нь тухайн үед хил хязгаарын байдал хурцадсантай холбогдуулж шинэ анги нэгтгэл байгуулахдаа хуучин анги нэгтгэлүүдийн байршил, бие бүрэлдэхүүн, удирдлагын дадлага туршлагыг харгалзан үзсэнтэй холбоотой.

6 дугаар морьт дивиз байгуулагдсаны дараахан түүний бүрэлдэхүүнд орж байсан Егүзэрийн хийдийн Эрдэнэцагааны 10 дугаар морьт хороог тусгай хороо болгон шилжүүлж түүний оронд 16 дугаар хороог шинээр байгуулсан байна. 6 дугаар морьт дивиз үүсэн байгуулагдсан үеэсээ эхлэн улс орны хил хязгаарыг сахин хамгаалах үүргээ нэр төртэй биелүүлж төр засаг, ард түмэндээ өндөр үнэлэгдэх гавьяат үйлс олныг бүтээжээ.

Дивизийн анги салбарууд 1937 он хүртэл Бадам-Иш, Алаг морьт, Адаг дулаан, Ар шавар, Баянхоолой, Галбартаа, Завсарын булаг зэрэг 10 гаруй газарт харуул гаргаж нийтдээ 850 орчим километр зурваст улсын хилийг сэргийлж хамгаалах чухал үүргийг нэр төртэй биелүүлж Японы түрэмгийлэгчдээс улсын хил рүү их, бага янз бүрийн хүчээр олон удаа довтолсныг тухай бүрт нь няцааж байжээ. Тухайлбал 1935 оны 1 дүгээр сард Халхын сүмийн районоор, 1935 оны 3, 4 дүгээр сард Булан дэрс, Ар шавартай, Адаг дулааны харуулаар улсын хил зөрчсөн Японы булаан эзлэгчдэд хатуу цохилт өгч байлаа.

¹БХТА, сх. 1. хн 920. Х.1-11

² Монгол цэргийн түүхийн товчоон. Дэд дэвтэр т.259.

1935 оны 1 дүгээр сарын 24-нд Япон-манжийн цэргийн 17 хүнтэй зэвсэгт баг манай улсын хилийг нэвтэрч Халхын сүмийн харуулыг чиглэн ирэхэд 6 дугаар морьт дивизийн морьт хорооны штабын дарга Д.Дондов, Халхын сүмийн харуулын дарга Г.Янжив эрэлхэг зориг гарган тулалдаж амь насаа алдсан юм. Мөн 1936 оны 1 дүгээр сард Булан дэрсний харуулын чиглэлээс өдөөн хатгалга явуулсан Японы 10 гаруй цэргийн эсрэг 6 дугаар дивизийн харуулын дарга Ш.Гонгор эрэлхэг тулалдаж гавьяа байгуулсан учир “Улсын баатар” цолоор шагнагджээ.

1932 оноос хойш Халхын голын байлдаан хүртэл 6 дугаар морьт дивизийн орон тоо зохион байгуулалт, харьяа ангиудын нэр, дугаар хэд хэдэн удаа өөрчлөгдсөн байна. 6 дугаар морьт дивизийн үндсэн хүч болох морьт хороодын дугаар цаг үеийн байдлаас шалтгаалан өөрчлөгдсөөр байсныг дараах баримтаас мэдэж болно. Үүнд:

10 дугаар морьт хороо (1932-1938),

15 дугаар морьт хороо (1932-1934, 1938 оноос дахин),

16 дугаар морьт хороо (1934-1936),

17 дугаар морьт хороо 1935 оноос 6 дугаар морьт дивизийн бүрэлдэхүүнд багтаж байжээ. Үүнээс гадна дивизийг анх байгуулах үед бүрэлдэхүүнд нь байсан их бууны хороог 1937 онд татан буулгаж, хоёр батарей бүхий их бууны дивизион болгосон байна. Мөн 1934 онд дивизийн бүрэлдэхүүнд моторт хороо байгуулсныг хүч хэрэгслийн байдлыг харгалзан хожим нь хуягт дивизион болгон өөрчилжээ. Энэ бүхэн бол байлдааны техник, зэвсэглэлийн боломж, зэвсэгт хүчнийг хүн, зэвсэг техникээр нөхөн хангах бололцооноос урган гарсан өөрчлөлтүүд байсан юм.

Эх орны зүүн хил хязгаарыг хамгаалах үүргээ нэр төртэй биелүүлсэн учир 1934 онд Ардын хувьсгалын 13 жилийн ойн баяраар 6 дугаар морьт дивизийг “их жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит” болгон алдаршуулсан юм.

1930-аад оны үед хууль ёсыг завхруулж, цэргийн удирдлага, анги, нэгтгэлийн дарга нарыг хилс хэрэгт хэлмэгдүүлсэн хар аюул 6 дугаар морьт дивизийг нэгэн адил нөмөрчээ. Дивиз 1932 онд байгуулагдсанаас хойш Халхын голын дайныг хүртэлх 7 жилийн дотор дивизийн даргаар 9 хүн ажилласны 7 нь хилс хэргээр баривчлагдан “улс төрийн талаар найдваргүй этгээд” гэгч шалтгаанаар цэргийн албанаас зайлуулагдсан байна.

Халхын голын районд хилийн хамгаалалтыг чангатгах шаардлагатай болсныг харгалзан Бүх цэргийн жанжны тушаалаар 1939 оны 1 дүгээр сард Тамсагбулагийн 6 дугаар дивизээс шигшмэл суманг томилон Халхын гол дахь Сүмбэрийн цагаан нуурын заставт илгээжээ. Энэ суман 15, 17 дугаар морьт хороодоос тус бүр нэг сэлэмт салаа, 15 дугаар хорооны хүнд пулемётын салаа, 17 дугаар хорооны хуягтын салаа зэргээс бүрдэж байсан юм. Шигшмэл суман дарга Дашийн Шарав, улс төрийн удирдагч Данзангийн Махцэнд нарын удирдлагаар хилчин дайчидтай хүч хавсран Номонхан, Бүрд-Овоо, Хайлаастын голын чиглэлээр довтолсон японы түрэмгийлэгчдэд хатуу цохилт өгсөн байна.

1939 оны 4, 5 дугаар сард Японы цэргийн нисэх онгоц тус улсын дорнод хязгаарын агаарын хилийг зөрчиж, Халхын гол, Тамсагбулагийн хавиар тагнуул хийх нь олшров. Япон-Манжго-гийн цэргийн отрядууд хилийн шугамыг давж

тагнуул хийх, хил хамгаалж байгаа харуулын байрлалыг довтлох зэргээр өдөөн хатгах явдлаа илтэд үргэлжлүүлэв.

Тэд 5 дугаар сарын 11-нд их буу, нисэх онгоцоор дэмжүүлсэн 200 шахам морьт цэргийн хүчээр Халхын голд цөмрөн орж байлдааны ажиллагаа өдөөжээ. Дайсны анхны цохилтыг П.Чогдон даргатай хилийн 7 дугаар заставын дайчид, Тамсагбулагийн 6 дугаар дивизээс томилогдсон шигшмэл сумангийн хамт няцаав.

5 дугаар сарын 14-ны өглөө Японы цэргийн отряд баргын морьт хорооны хамтаар /13 машин явган цэрэг, 600 орчим морьт цэрэг/ улсын хил даван хилийн манааны пост байрласан “Давхарт манхан”-ыг чиглэн иржээ¹. Улсын хилээс дотогш 3 км орчимд явган цэрэг нь машинтайгаа үлдэж, морьт хороо нь цааш хөдөлгөөнөө үргэлжлүүлжээ. Хилийн манааны пост дайсны морьт цэргийн аяны толгойн хаалтыг өнгөрүүлж, гол хүчний цувааны эхний хэсгийг өнгөрмөгц гэнэтийн гал нээж тэднийг эмх журамгүй болгон сандралд оруулжээ. Дайсан резервт үлдээсэн явган цэргээ байлдаанд оруулж хилийн манааны постыг хэд хэдэн удаа атаклан, бүслэн авахад хилчид тэдний байлдааны журмын эмзэг хэсгээр сөрөг атак хийж бүслэлтээс гарчээ. Гэвч дайсан Хайлаастын голын зүүн эрэг дэх Дунгар овоог злэн авчээ².

Мөн 5 дугаар сарын 15-нд Японы 5 нисэх онгоц Улсын хил нэвтрэн хилийн цэргийн 7 дугаар заставын байрлалыг бөмбөгдөв. Энэ үед манай 2 хүний амь үрэгдэж, 20 шахам хүн шархаджээ.

Ийм байдал цаашид шатлан өргөжих хандлагатай болж улсын хилийн орчим Номонхан, Бүрд-Овоо, Хайлаастын голын чиглэлд Японы тал 40 гаруй хуягт танк, олон зуун морьт цэрэг хуралдуулав. Манай цэргийн командлал цагийн байдлын энэ өөрчлөлтийг үнэлэн үзээд хилийн цэргийн 7 дугаар застав болон шигшмэл сумангийн хүчээр дайсны дээрх анги, салбаруудыг Халхын голын орчимд түр тогтоон барьж, 6 дугаар морьт дивизийг байлдаанд орох нөхцөлийг хангах шийдвэр гаргажээ. Энэ үүргийг хүлээж авсан хилчид шигшмэл сумангийн хамтаар Халхын голын зүүн эрэгт гарч, Хайлаастын голын шавар намаг, замын бартаанд саатаж явсан дайсны хүчинд жижиг бүлгээр шөнийн цагт гэнэтийн дайралт хийх замаар 5 дугаар сарын 21 хүртэл тэднийг саатуулжээ.

Цэргийн явдлын яамны сайд, Бүх цэргийн жанжин маршал Х.Чойбалсан 6 дугаар морьт дивизийг Тамсагбулагаас Халхын гол руу байлдааны маршаар хөдөлгөх тушаал өгчээ³. Энэ үед манай нутагт байрлаж байсан зөвлөлтийн 57 дугаар онцгой корпусын командлал ч зохих арга хэмжээ авсан юм. Корпусын командлал бүр 3 дугаар сарын эхээр 11 дүгээр танкийн бригадын мотобуудлагын батальоныг хуягтын рот, их бууны батарей, сапёрын ротоор хүч нэмэгдүүлэн ахлах дэслэгч А.Б.Быковын удирдлагаар Тамсагбулагт илгээгээд байсан юм. 1939 оны 5 дугаар сарын 17-нд дээр дурдсан нэгтгэл ангиуд Тамсагбулагаас Халхын голын район руу маршаар хөдөлжээ.

Байлдааны марш үйлдэх тухай тушаал хүлээж авсан 6 дугаар морьт дивизийн дарга хошууч Ч.Шаарийбуу, сургагч Л.В.Васильев, комиссар

¹МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд. 1-р дэвтэр. 1921-1940. УБ., 1966. 333 дахь тал.

²МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд. 1-р дэвтэр. 1921-1940 УБ., 1966. 333 дахь тал.

³БХТА. 6 дугаар дивизийн түүх. сх 1, ТЗ-1.

Д.Пэлжээ, улс төрийн сургагч Амусов, штабын сургагч М.И.Малов нарын хамт маршийн төлөвлөгөө боловсруулах ажилд оров. Дивизийн байнгын байрлал хүрэлцэн очих районоос үлэмж алслагдсан хийгээд анги салбаруудын уналга хөсгийн байдал, бие бүрэлдэхүүний хээрийн дадлага, хороо, сумангийн удирдлагын мэдлэг чадвар, зам маршрутын байдлыг сайтар судлан үзээд дайсны зүгээс маршийн явцад үзүүлж болох нөлөөллийг харгалзан дараах шийдвэрийг гаргасан байна. Үүнд, Тамсагбулаг Шимийн шорвог нуур, Шим овоо, Баянбүрд, Сүмбэрийн цагаан нуурын маршрутаар 130 километр замыг 1 өнжилттэйгээр туулна. Дивизийн аяны цувааны байгууламж нь 17 дугаар морьт хороо, их буу, хуягтын дивизион, дивизийн штаб, тусгай салбарууд, 15 дугаар морьт хороо, ар талын цуваанаас бүрдэж байв. Дивизийн ангиудын хооронд 3-5 километрийн зайтай, харин ар талын цуваа дотроо хоёр цувраа болон хөдөлгөөн үйлдэхээр зохион байгуулжээ. Хороо, ангиуд, ар талын цуваа бүр өөрийн баруун, зүүн гарт 3-5 хүний бүрэлдэхүүнтэй сэргийлэх, гол хүчний цуваанаас агаар, газрын дайралтын дохио хүлээж авах пост томилон аяны хамгаалалтын үүрэг гүйцэтгүүлсэн байна. Хөдөлгөөний хурдыг төлөвлөхдөө тухайн үед мөрдөж байсан байлдааны дүрмийн шаардлага, газар орны нөхцөлд үндсэндээ тохируулсан байна. Тэгэхдээ “БНМАУ-ын морьт улаан цэргийн байлдааны дүрэм” /1935/-ийн III ангийн 141, 147 дугаар зүйлүүдэд “...морин цэрэг нэг хоногийн дотор 40-70 км хүртэл явж болох ... шөнийн цаг буюу муу замтай газар явахдаа 1 цагт 4-5 км хүртэл явж болно” гэснийг баримталжээ.

Дивизийн дарга Ч.Шаарийбуу маршийн төлөвлөгөөг сургагч нарын шууд оролцоотойгоор боловсруулан гаргаад морьт хороод, их буу, хуягтын дивизион зэрэг ангиудын удирдах бүрэлдэхүүнд марш үйлдэх байлдааны үүрэг тавьж, түргэн жагсаалын дохио өгснөөр 6 дугаар морьт дивиз Халхын голын чиглэлд хөдөлгөөн үйлдэхэд бэлэн болжээ.

Тамсагбулагийн төвд офицеруудын гэр бүл, дивизийн ар тал, эмнэлгийн зарим ажилтан үлдэж хороо, дивизион, сумангуудын бие бүрэлдэхүүн байлдааны зэвсэг хэрэглэлээ авч алсын аянд гарсан юм. Зөвлөлтийн ажилчин, тариачны улаан армийн Жанжин штабын орлогч дарга корпус командлан захирагч Смородинов 1939 оны 5 дугаар сарын дунд үеийн Халхын голын районы цагийн байдлын талаар 57 дугаар онцгой корпусын дарга дивиз командлан захирагч Фекленкотой утсаар ярьсныг үзэхэд МАХЦ-ийн 6 дугаар морьт дивиз Тамсагбулагаас 5 дугаар сарын 17-ны 14.30 цагт гарчээ¹.

Дашрамд дурдахад 6 дугаар морьт дивизийг цаашид ашиглах явдлыг энэ үеэс эхлэн 57 дугаар корпусын удирдлага шийдэх болсон нь ярианы агуулгаас харагдаж байна.

1939 оны 5 дугаар сарын сүүлчээр явуулсан байлдааны ажиллагаа. 6 дугаар морьт дивиз Тамсагбулагаас хөдөлж 1939 оны 5 дугаар сарын 19 гэхэд Хамар давааны баруун өмнөд этгээдэд хүчээ хуралдуулаад байв². Энэ үед Халхын голын орчимд Японы нэлээд тооны цэрэг улсын хил зөрчиж 15-20 километрийн гүнд нэвтрэн Хайлаастын голын өмнөд эрэгт орших Дунгар овоог эзлэн авахаар санаархаж байлаа. Гэвч өмнө өгүүлснээр П.Чогдон даргатай

¹ЦГАСА. Ф. 37977. ОП. 1. Д. 38. Л. 18

²РГВА. Ф 25871, ОП 29. Д.491.

хилчид 5 дугаар сарын 21 хүртэл дайсанд идэвхтэй ажиллагаа явуулах боломж олгоогүй юм. 6 дугаар морьт дивизийг Хамар даваанд хүч хуралдуулах үед Японы тал 23 дугаар дивизийн бүрэлдэхүүнээс 318 хүнтэй 23 дугаар тагнуулын хороо, 64 дүгээр явган хорооны 1 дүгээр батальон, түргэн буудагч их бууны батарей, 150 хүнтэй манжийн морьт цэрэг орсон, нийтдээ 1000 гаруй хүнтэй отрядыг Номонхан, Бүрд-Овоо, Хайлаастын голын орчимд илгээгээд байсан юм¹.

Дивизийн удирдлага дайсны хүч бүрэлдэхүүн, байрлал, ажиллагааны шинж байдлыг тогтоох зорилгоор 5 дугаар сарын 27 хүртэл хүч нэмэгдүүлсэн сумангаас морьт хороо хүртлэх хүчээр Хөх өндрийн овоо, Номонхан, Цагаан овоо, Хайлаастын голын орчимд байлдан тагнах үүрэг гүйцэтгэж байв. 6 дугаар морьт дивиз энэ үеэс эхлэн бүрэн бүрэлдэхүүнээрээ Халхын голын дайныг дуустал байлдааны янз бүрийн үүрэг гүйцэтгэж байв. Байлдааны ажиллагаа явагдсан район нь цэрэг-газар зүйн дор дурдсан онцлогтой байлаа. Тухайлбал, Халхын гол, түүний орчимын өндөрлөгүүд нь ой модгүй нүцгэн газар, элсэн манхан, голын хөндий, намаг шавар бүхий голын бургас зэрэг төрөл бүрийн гадаргуутай бөгөөд тэгэхдээ тактикийн сайн нөлөө үзүүлэх хэдхэн зааг бүхий нутаг. Гэвч газар орон дээр баримжаа авах зүйл ховор, байр зүйн зураг авагдаагүй, голоос өөр усны эх булаггүй, энгийн хүн ам суурьшдаггүй газар байв. Газрын хөрсний байдал бүхэлдээ хар шороон хөрс бүхий тэгш тал байсан нь зам тавих, автотээврийн хэрэгслийг замгүй газраар нэвтрэх явдлыг хөнгөвчилсөн юм.

1939 онд явуулсан газар орны судалгаагаар Халхын гол нь 40-130 м өргөн, гүн нь гарамны орчимдоо 0,4-1,5 м, гарамгүй газартаа ихэвчлэн 2 метр, зарим хэсэгтээ түүнээс ч илүү, урсгалын хурд 0,3 м/сек, голын ёроол хайргатай, голын хөндий өргөн бөгөөд зарим хэсэгтээ намагтай, Хайлаастын голын цутгалангаас урагш өндөр өвстэй болохыг тогтоожээ.

Халхын голын баруун тал нь 30 градусаас дээш налуу бүхий эгц эрэгтэй бөгөөд тэнд Хамар даваа, түүнээс хойш 20 орчим километр Баянцагааны нуруу оршино. Голын зүүн эргийн газар орон цөлөрхөг, олон тооны элсэрхэг өндөрлөгүүдтэй тул танк, хуягт машин туулахад тун бэрхшээлтэй байв.

Голын зүүн талаас цутгасан Хайлаастын гол нь байлдааны ажиллагааны районыг хойд ба урд хоёр хэсэгт хуваах бөгөөд Хайлаастын гол нь хэмжээгээр багавтар боловч фронтын шугамд эгц шурган орсон хөндий тохойд нь цэрэг далдлах, нууцаар маневрлах явдалд таатай боломжийг бүрдүүлж байжээ.

Байлдааны ажиллагааны район нь Монгол орны төв хэсгээс үлэмж алслагдсаны зэрэгцээ төмөр замын хамгийн ойр өртөө гэхэд 750 км зайтай байсан нь цэргийн хүчийг богино хугацаанд хуралдуулах, шаардлагатай материал хэрэгслээр хангахад ихээхэн хүндрэл учруулж байв.

Гэтэл Японы тал цэргийн хүчээ хуралдуулаад байсан хэсэг нь Манжуурын төмөр замаас 80 км, Дорнод Хятадын төмөр замын өртөөнөөс 150 км зайтай бөгөөд Халхын голын зүүн эргийн ноёлох өндөрлөгүүд нь хяналт явуулах, их бууны галыг засварлах, нууц далдуур маневрлах өргөн бололцоо олгож байлаа.

¹Батбаяр Ц. Халхын гол түүх ба орчин үе. УБ., 1989.

Ийм онцлог бүхий бөгөөд олон янзын гадаргутаг газар орны энэ хэсэгт зүг чигээ алдах, төөрөх, будилах явдал олонтаа гарч байсан боловч 6 дугаар морьт дивизийн анги, салбарууд дайсны хүч бүрэлдэхүүн, байрлалыг тагнан илрүүлэх үүргээ сайн биелүүлж байв.

Дивизийн ангиуд Халхын голын орчимд хүч хуралдуулсаны дараа Зөвлөлтийн армийн 57 дугаар онцгой корпусын дарга 5 дугаар сарын 23-нд 6 дугаар морьт дивизийн гурван морьт сумангаар Дунгар овоо, Номонхан, Бүрд овооны чиглэлд байлдан тагналт явуулахаар шийдвэрлэжээ¹. Иймд дивизийн дарга Ч.Шаарийбуу 15, 17 дугаар хорооноос тус бүр нэг морьт суман, дивизийн бага даргын сургуулийн суманг дайсны байршил, бүлэглэл, тоо, бүрэлдэхүүнийг тогтоох үүрэг өгч томилон гаргажээ.

15 дугаар морьт хорооны Д.Ням-Осор даргатай суманг 45 мм-ийн танк эсэргүүцэх буу, пулемёт сумангийн нэг салаагаар хүч нэмэгдүүлж Хөх-Өндөрийн овооны чиглэлд тагнуул үйлдэхдээ Халхын голын зүүн эрэгт дайсны тагнуул мөн хөдөлгөөн үйлдэж байгааг илрүүлжээ. Дайсны тагнуулын энэ бүлгийг хорооны сумангууд Халхын гол гатлах үед атаклан няцаасан байна.

17 дугаар морьт хорооны Ядамсүрэн даргатай морьт суман танк эсэргүүцэх буу, пулемёт сумангийн салаагаар хүч нэмэгдүүлэн тагнуулын үүрэг гүйцэтгэхдээ Халхын голыг гатлан Талын манхны орчимд очиж “Нэргүй өндөрлөг”-ийн орчимд байсан дайсны 100 орчим цэргийг илрүүлэн нэлээд хохирол учруулжээ.

Мөн өдөр Лхагважав даргатай бага даргын сургуулийн суман Халхын голыг гатлан Хайлааст манхны чиглэлд тагнуулд гарч дайсны танк, их буу бүхий морьт ба явган цэргийн ихээхэн хүч Хайлаастын голын ойролцоох өндөрлөгүүдийг эзэлснийг илрүүлжээ. Энэ өдрөөс өмнө бага даргын сургуулийн суман тагнуулын үүргийг салаа, тасгаараа гүйцэтгэж дайсны жижиг бүлэглэл, тагнуултай дөрвөн удаа тулгарч няцааж байжээ.

Тагнуулын үүрэг гүйцэтгэсэн дээрх сумангуудын мэдээг дивизийн штаб нэгтгэн, Монгол-Зөвлөлтийн цэргийн командлалын тагнуулын мэдээтэй харьцуулан үзээд “дайсны тал ихээхэн хүчээр шинэ ажиллагаанд бэлтгэж байна” гэсэн дүгнэлтэд хүрсэн байна. Иймд Халхын голын зүүн эрэгт гарч хориглолтод шилжихээр шийдвэрлэжээ.

Японы тал 1939 оны 5 дугаар сарын дундуур БНМАУ-ын хилийн дотор явуулсан ажиллагаагаа өргөтгөхийн тулд 23 дугаар дивизийн 64 дүгээр хорооны дарга хурандаа Ямагатагаар толгойлуулсан томоохон хүчийг илгээхээр шийджээ. 23 дугаар дивизийн командлагч Комацубарагийн 5 дугаар сарын 21-ний өдрийн тушаалаар дээрх бүлэглэлд 64 дүгээр явган хорооны 1 ба 3 дугаар батальон, дэд хурандаа Азума даргатай тагнуулын отряд, ахмад Коно даргатай мото рот, 8 дугаар морьт хороо, баргын 1 ба 7 дугаар морьт хороо, уулын их бууны батарей, түргэн буудагч их бууны батарей багтаж байв.

Энэ хүчний эсрэг МАХЦ-ийн 6 дугаар морьт дивиз, зөвлөлтийн армийн ахлах дэслэгч Быковын отрядын хоёр рот Халхын голын зүүн эрэгт хориглон байлдсан бөгөөд нийтдээ явган цэрэг 668, морин цэрэг 866, их буу 20, хуягт 39, пулемёт 58 байжээ.

¹ЦГАСА. Ф. 32113. ОП. 1. Д.3. Л.8

Хоёр талын хүч, хэрэгслийн харьцааг авч үзвэл Япон-Манжийн тал амьд хүчээр 3 дахин, пулемётоор 1,3 дахин их байсан нь тэдэнд хүчээр давамгайлах боломж олгож байв. Харин Монгол-Зөвлөлтийн тал их буугаар ялимгүй давуу, хуягт машинаар 5-6 дахин илүү байсан нь энэ байлдаанд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. 5 дугаар сарын 26-нд дивизийн командлагч Комацубара Ганжуур сумд байрласан Ямагатагийн штабт хүрэлцэн ирж цагийн байдалтай нарийвчлан танилцаад Халхын голын зүүн эрэг дэх Зөвлөлт-Монголын цэргийг бут цохихоор 28-нд давших тухай тушаал өгөөд тэр оройдоо Хайлаар буцжээ.

Хурандаа Ямагата энэ үүргийг хүлээн аваад 5 дугаар сарын 27-нд давшилтын төлөвлөгөө боловсруулж дууссан байна. Энэ төлөвлөгөөнд зааснаар Японы тал Зөвлөлт-Монголын цэргийн хориглолтыг фронтоос нь хүчтэй довтолж самгардуулж, хоёр жигүүрээс ороон бүслэн авахаар тооцоолжээ. Энэ үед Зөвлөлт-Монголын цэргийн зарим анги, салбарууд Халхын голыг гатлан зүүн эрэгт гарч хориглолтын зурвасаа эзлээд байв. МАХЦ-ийн 6 дугаар морьт дивиз Хайлаастын голын хойд эрэгт Нуурын овооноос зүүн тийш 6 километр 20 орчим километр өргөн фронт дээр хориглолтын зурвас эзлэв. Дивизийн баруун гарт Зөвлөлтийн цэргийн ахлах дэслэгч Быковын отрядын 3 дугаар рот Нуурын овооноос хойш 13 километр орших өндөрлөгт, зүүн гарт мөн отрядын 2 дугаар суман морин гарамаас зүүн тийш 7 километр хоригложээ. Быковын отрядын бусад салбар нь 76 мм-ийн их бууны батарей, 11 дүгээр танкийн бригадын сапёрын 1 дүгээр рот Халхын голын баруун эрэгт гармын орчимд байрласан байлаа.

6 дугаар морьт дивизийн 17 дугаар морьт хороо нь Быковын отрядын 3 дугаар ротын зүүн гарт 8 километр өргөн фронт дээр байрласан ба түүний зүүн гарт 4 километр зайтайгаар 15 дугаар морьт хороо хориглолтод шилжжээ. Дивизийн их бууны дивизион хориглолтын өвөр эгнээнээс 3 километр орчим гүнд галт байр эзэлсэн байв. Дивизийн резервт хуягт дивизион томилогдож дивизийн командын байрнаас зүүн тийш байрлав. Дивизийн командын байр Хайлаастын голын эрэгт нэргүй өндөрлөгт байрлаж түүнийг хамгаалах үүргийг бага даргын сургуулийн суман хариуцаж байжээ.

Зөвлөлт-Монголын цэргийн байлдааны ажиллагааг Улаан армийн 57 дугаар онцгой корпусын оперативын бүлгийн ахлагч хурандаа Иванков удирдах үүрэгтэй байсан юм.

5 дугаар сарын 28-ны өглөөний 4 цагийн орчим Японы тал 40 орчим онгоцоор зөвлөлтийн сапёрын ротын дөнгөж барьж дуусаад байсан Халхын голын гарамыг үр дүнгүй бөмбөгдөөд, давшилтаа эхэлжээ.

Тэгэхдээ Японы тал өөрийн баруун гарт үндсэн хүчээ төвлөрүүлж 15 дугаар морьт хороо, зөвлөлтийн 2 дугаар ротын хориглолтын чиглэлд гол цохилтоо хийхээр төлөвлөсөн байв. Энэ үүргийг Азума ба Коногийн отряд гүйцэтгэх ёстой байжээ. Японы 64 дүгээр хорооны нэг батальон танкаар дэмжүүлэн 15 дугаар морьт хорооны хориглолтын фронт талаас, баргын 8 дугаар морьт хороо, 17 дугаар морьт хорооны хориглолтын фронт ба хажуу үзүүрээс цохилт хийхээр давшив. Тэр анхны давшилтыг 15, 17 дугаар морьт хороодын удирдлага бие даан няцаасны дараа япончууд хүчээ шинээр бүлэглэж дахин дайрав.

Давшилт эхэлмэгц Зөвлөлтийн 2 дугаар ротын хажуу үзүүрээр тойрч түүний ар талд гарсан Азума ба Коно нарын отряд 6 дугаар морьт дивизийн зүүн гараар ороож бүслэх аюул бий болгожээ.

Энэ аюулыг мэдэрсэн дивизийн дарга Ч.Шаарийбуу сургагч Васильевын хамтаар бага даргын сургуулийн суманг биечлэн удирдаж дивизийн ар талаас бүслэхийг оролдсон японы бүлэглэлийн эсрэг хүч тэнцвэргүй тулаанд оржээ.

Уг суман сэлэмт салаа гурав, пулемёт салаа нэг, нийтдээ 150 орчим хүнтэй байсан бөгөөд 5 дугаар сарын 28-ны байлдаан эхлэхэд дивизийн командын байрыг хамгаалан түүнээс 1 километр орчим зайд байрлаж байв. Өглөөнөөс үд хүртэл сумангийн байлдааны журмын дотор шууд байрласан дивизийн дарга, сургагч нар дайсны хэд хэдэн удаагийн атакийг няцаах ажиллагааг зохион байгуулж байгаад байдал түр тогтворжих үеэр командын байр руугаа буцацгаасан боловч Шаарийбуу дивизийн командын байрандаа хүрч амжилгүй амь эрстсэн байна. Тэднийг буцсаны дараа сургуулийн суман байрлалаа хамгаалан тулалдаж дивизийг бүслэн, ар талаас нь довтолсон эсрэг талын давуу хүчинд түрэгдэн бие бүрэлдэхүүний олонх нь алагдаж шархдан хүнд байдалд орсон ажээ. Гэсэн хэдий ч сургуулийн суман байлдаанаа үргэлжлүүлсээр 28-ны орой голын гарамд хүрч дивизийн бусад ангитай нийлсэн байна.

Гэхдээ 5 дугаар сарын 28-ны байлдаанд дивизийн бага даргын сургуулийн сумангийн гүйцэтгэсэн үүрэг Халхын голын дайны түүхэнд тун ч бүрхэг үлджээ. Ямар боловч Япон-Манжийн цэрэг Халхын голын гармыг чиглэн 6 дугаар морьт дивизийн ар талд гарч анги, салбаруудын ухрах замыг таслахыг оролдоход дивизийн бага даргын сургуулийн суман үлэмж эсэргүүцэл үзүүлж тогтоон барьж байлаа. Улмаар дивиз дайсанд бүслэгдэлгүй үлдэж, Халхын голын гарам тийш ухрах зам бүрэн таслагдаагүй явдалд бага даргын сургуулийн сумангийн дайчдын эрэлхэг зориг, тэсвэр хатуужил онцгой нөлөө үзүүлсэн нь тодорхой юм.

Энэ өдрийн байлдаанд дивизийн морьт хороод хүчээр давуу эсрэг талын давшилтыг хэд дахин няцаасан боловч арга буюу хүчинд түрэгдэн байрлалаа орхин ухрахад хүрчээ. Дивизийн штабын даргын үүрэг гүйцэтгэж байсан Ж.Осор энэ үед их бууны дивизионыг удирдан, Хайлаастайн голыг уруудан дивизийн ар талаас бүслэхийг оролдсон японы хүчийг саатуулан тогтоожээ. Хуягт дивизион дивизийн комиссар Д.Пэлжээгийн удирдлагаар фронтын өмнөөс болон ар талаас давшиж байсан японы тал руу 6 удаа сөрөг атак хийж тухай бүрдээ хориглолтын тогтвортой байдлыг хангахад чухал нөлөө үзүүлжээ.

Япончууд хүч хэрэгслийн давуу байдлаа ашиглан дахин давтан атаклаж байсан тул 17 дугаар морьт хороо хүчинд түрэгдэн Хайлаастын голын өмнөд эрэгт гарч, харин 15 дугаар морьт хорооны сумангууд 2 хэсэг болж таслагдан гэдрэг ухарч шинэ заагт хориглож эхлэв. 15 дугаар хорооны нэг хэсэг дивизион командын байрыг чиглэн давшсан эсрэг талын хүчийг нэвтрүүлэхгүй барьж, нөгөө хэсэг нь 17 дугаар морьт хорооны хамт Хайлаастын голын өмнөд эрэгт гарчээ. Энэ үед дивизийн хориглолтын өвөр эгнээ анхны байрлалаасаа 2-3 километр хойшилсон байв.

Дивизийн хориглолтын тогтвортой байдалд аюул учирсаныг ухаарсан их бууны дивизионы дарга Д.Дамба өөрийн санаачлагаар зоригтой шийдвэр гарган өөрийн ангиа батарей, батарейгаар салган морьт хороод болон сургуулийн сумангийн байлдааны ажиллагааг галаараа дэмжих үүрэг өгчээ. Энэ мөчид голын гармыг хамгаалж байсан Зөвлөлтийн армийн их бууны батарейны дарга ахлах дэслэгч Ю.Б.Бахтин бие даан шийдвэр гаргаж батарейгаа голын зүүн эрэгт ил галт байр эзлүүлэн, сургуулийн сумангийн эсрэг хүчтэй довтолж байсан Японы тойрох отрядад гал нээж эхлэв.

Дэслэгч Е.Төрхүүгийн удирдсан батарей фронтын төв хэсгээр давшсан дайсны моторт болон явган ангиуд дээр ширүүн гал явуулсан нь морьт хороодын хориглолтыг тогтвортой болгож, эсрэг талын давшилтыг зогсооход хүргэжээ. Үүнийг ашиглан морьт хороод голын гармын ойролцоо гарч шинэ заагт бэхжжээ.

Улаан армийн 36 дугаар мотобуудлагын дивизийн хошууч И.М.Ремизовын удирдсан 149 дүгээр мотобуудлагын хорооны тэргүүний салбарууд 5 дугаар сарын 28-ны орой 19 цагийн орчим байлдааны талбарт маршаар ирж явдлаас шууд хүч задлан байлдаанд орсон нь МАХЦ-ийн 6 дугаар морьт дивизийн хориглолтыг улам найдвартай болгосон юм.

Ремизовын хороо ийнхүү Улаанбаатараас Халхын гол хүртэл 1000 гаруй километр замыг 11 хоног туулж ирээд их бууны дэмжлэггүйгээр шууд байлдаанд орсон тул тэр өдөртөө онцын амжилт олоогүй боловч Азумагийн отряд болон бусад салбаруудыг гол хүчнээс нь салган бүсэлжээ.

Монгол-Зөвлөлтийн цэрэг 29-ний үүрээр их бууны дэмжлэгтэйгээр давшилтанд шилжив. Энэ давшилтад улаан армийн 175 дугаар их бууны хорооны салбарууд чухал үүрэг гүйцэтгэж 6 дугаар морьт дивиз, 149 дүгээр мотобуудлагын хорооны байлдааны ажиллагааг галаараа дэмжив.

6 дугаар дивизийн морьт хороод 29-ний өдрийн давшилтад фронтын жигүүрт ажиллахдаа дайсны хажуу үзүүрээр тойрон бүслээд морин атакаар дайсныг бут цохин устгажээ.

5 дугаар сарын 30-ны үдээс хойш гэхэд 6 дугаар дивизийн ангиуд М.П.Яковлевын командалсан танкийн 11 дүгээр бригадын пулемётчид, их буучид, И.М.Ремизовын командалсан мотобуудлагын хорооны дайчид, А.С.Рыбкины удирдсан их буучдын хамтаар дайсны галын цэгүүдийг дарж, сөрөг атакиг няцаан, үлэмж хэсгийг устган, үлдсэн хэсгийг нь хилийн цаана хөөн гаргажээ.

Японы талын бичсэнээр 5 дугаар сарын 28-ны шөнө Азума шөнийн атаканд бэлтгэж байсан үед Монгол-Зөвлөлтийн цэрэг их буу, танкаар дэмжүүлэн давшиж хүнд хохирол учруулжээ. Энэ үед Азумагийн отрядаас 20 орчим хүн алагдаж, 70 гаруй хүн шархаджээ. 5 дугаар сарын 29-ны өглөөний байлдаанд отрядын бүх цэргийн хагасаас илүү нь амь үрэгдэж цаашид байлдааны үүрэг гүйцэтгэх найдваргүй болжээ. Үдээс хойш 6 дугаар морьт дивиз, зөвлөлтийн 149 дүгээр мотобуудлагын хорооны салбаруудтай хамтран Азумагийн отрядын үлдэгдлийг бут цохисон байна¹.

¹Батбаяр Ц. Халхын гол: түүх ба орчин үе. УБ., 1989. т.55

5 дугаар сарын 30, 31-ний өдрүүдэд 6 дугаар дивизийн ангиуд Хайлаастын голын хойт эрэгт хориглолтод шилжив. 5 дугаар сарын сүүлчээр болсон энэ байлдаанд 6 дугаар морьт дивизийн олон арван дарга, цэрэг баатарлагаар тулалдаж амь үрэгдсэн хэдий ч өөрийн өмнөх үүргээ нэр төртэй биелүүлсэн юм.

Дивизийн их бууны батарейны улс төрийн удирдагч Л.Гэлэгбаатар, хуягт дивизионы сумангийн дарга Н.Хорлоо, жолооч Д.Хаянхярваа, пулемёт сумангийн улс төрийн удирдагч Ч.Жүгдэрнамжил, хорооны дарга Л.Дандар, их эмч Л.Шаравдорж, пулемёт сумангийн дарга Д.Баадай, Лувсанжамбаа, танк эсэргүүцэх бууны дарга Дорж, салааны дарга Ж.Зундуй, Ориг, бага дарга Жамба, Маналжав, С.Жанжаа нарын зэрэг эрэлхэг баатарлагаар зориг гаргасан хүмүүс олон арав байна.

5 дугаар сарын сүүлчээр болсон энэ ширүүн байлдаанд япончууд олон зуун хүнээ алуулж, Азума болон Коногийн тойрох отряд бүрмөсөн устгагджээ. Энэ өдрүүдэд Монгол-Зөвлөлтийн талаас 130 гаруй хүн алагдаж шархадсан гэсэн мэдээ байдаг. Харин 6 дугаар морьт дивизийн хохирлын талаар одоог хүртэл нэлээд будилаантай зүйлс байсаар байна. Байлдаанд оролцогсдын өгүүлж байгаагаар зөвхөн дивизийн бага даргын сургуулийн сумангаас энэ өдрүүдэд 70 гаруй хүн алагдаж шархадсан бололтой. Гэтэл дивизийн хохирлын тухай архивт тодорхой зүйл байхгүй бөгөөд дивизийн байлдааны ангийн дарга Ж.Осор, комиссар Д.Пэлжээ нарын үгээр бол 5 дугаар сарын байлдаанд дивизийн хэмжээгээр 20 орчим хүн алагдаж шархадсан юм шиг. Энэ мэт будилаантай зүйл нэг биш байна.

Хэдийгээр 5 дугаар сарын байлдаан Монгол-Зөвлөлтийн цэргийн ялалтаар төгссөн боловч командлалын үйл ажиллагаанд хэд хэдэн дутагдал, доголдол байсан нь тодорхой байна. Энэ нь юуны өмнө байлдааны ажиллагааг төлөвлөж зохион байгуулах, удирдах асуудалд холбогдож байна. Халхын голын зүүн эрэгт хориглолтод шилжих шийдвэр гаргахдаа Быковын отрядын буудлагын ротуудыг хориглолтын төв хэсэгт байрлуулахын оронд морьт хороодыг томилсон нь жигүүрүүдийг хамгаалахад хүндрэл учруулж, дивизийн ангиудыг бүслэгдэх аюулд хүргэжээ. Үүний зэрэгцээ дивизийн ангиуд 20 километр орчим фронт дээр ганц эгнээгээр байрласан ба хүчтэй бэлтгэл хүч /резерв/ үгүй байв. Дивизийн штаб тагнуул зохион байгуулах талаар учир дутагдалтай хандсанаас японы отряд саадгүй урагшлан голын гарамд ойртож, дивизийн ангиудын ар талд гарах бололцоо олгосон байна.

Анги салбаруудын завсар үзүүрийг халхлах хүч, хэрэгслийг томилоогүйн улмаас дайсан этгээд сул задгай завсар үзүүрийг ашиглан байлдааны журмын элементүүдийн зүг бүрээс довтолох аюултай байдал бий болгожээ.

Байлдааны ажиллагаа нэгэнт эхэлсэн үед дивизийн дарга, штаб анги, салбаруудыг удирдах талаар ихээхэн доголдол гаргажээ. Дивизийн дарга, сургагч нар дивизийн командын байраа орхиж сургуулийн сумангийн байлдааны ажиллагааг биечлэн удирдаж байсан тул анги, салбарууд үндсэндээ нэгдсэн удирдлагагүй болж, өөр өөрсдийн дарга нарын санаачлагаар бие даасан ажиллагаа явуулсанаар анги салбаруудын харилцан ажиллагаа алдагдаж, нэгдмэл зохион байгуулалтгүй болсон байна. Дивизийн комиссар Д.Пэлжээ, штабын даргын үүрэг гүйцэтгэж байсан Ж.Осор нар ч командын байрыг орхин

хуягтын ба их бууны дивизионд очсон нь дивизийн ангиудыг нэгдсэн удирдлагаар хангах, нэг бодлогоор байлдааныг явуулахад сөрөг нөлөө үзүүлжээ. Энэ бүхнээс шалтгаалан байлдааны ажиллагаа бүхэлдээ сунжирч, шинэ заагт ухрах үед тактикийн уялдаа алдагдан олон арван цэрэг дайчдын амь нас үрэгдсэн бололтой.

Дивиз командлан захирагч Г.К.Жуковоос байлдааны цагийн байдлын талаар ЗСБНХУ-ын Батлан хамгаалах ардын комиссарт 1939 оны 5 дугаар сарын 30-нд өгсөн мэдээндээ дээрх дутагдлыг тодорхой зааж засаж залруулах зохих арга хэмжээ авсан тухай материал Зөвлөлтийн армийн төв архивт хадгалагдан үлджээ¹.

1939 оны 6, 7 дугаар сард явуулсан байлдааны ажиллагаа. Японы тал 5 дугаар сарын байлдаанд ихээхэн хохирол хүлээж улсын хилийн цаана ухарч гараад бут цохигдсон ангиудынхаа үлдэгдлийг журамлан зохион байгуулж эхэлжээ.

Монгол-Зөвлөлтийн цэргийн командлал тагнуулын мэдээнд үндэслэн “дайсны тал нутгийн гүнээс анги, нэгтгэлүүдийг шинээр татан авчиртлаа идэвхтэй ажиллагаа явуулах чадваргүй” гэж дүгнээд 6 дугаар морьт дивиз болон байлдааны районд хүрэлцэн ирээд байсан Зөвлөлтийн цэргийн ангиудыг Халхын голын баруун эрэгт хориглолтод шилжих, бие бүрэлдэхүүн, зэвсэг техникээр нөхөн хангалт хийх үүрэг өгчээ.

Энэ үед ЗХУ-ын Батлан хамгаалах ардын комиссарын тушаалаар 57 дугаар буудлагын корпусын штаб байрлаад байсан Тамсагбулагт дивиз командлан захирагч Г.К.Жуков хүрэлцэн иржээ. Тэрээр Тамсагбулагт хүрэлцэн ирмэгц байлдааны ажиллагааны районд ирээд байсан 6 дугаар морьт дивиз болон Зөвлөлтийн 57 дугаар корпусын хүчээр Японы цэргийн түрэмгийлэлийг няцаах боломжгүй гэж үзээд Зөвлөлтийн цэргийн хүчийг нэмэгдүүлэх хүсэлт тавьжээ. ЗХУ-ын Батлан хамгаалах ардын комиссар маршал К.Е.Ворошилов хүсэлтийг хүлээн авч, корпусын командлагчаар дивиз командлан захирагч Г.К.Жуковыг томилсон байна.

1939 оны 6 дугаар сараас эхлэн 6 дугаар морьт дивизийг байлдаанд ашиглах талаар өөр байр суурь илэрч эхлэв. Дивизийн ангиуд Халхын голын баруун эрэгт Гурван нуурын районд хүч хуралдуулж, бие бүрэлдэхүүн, зэвсэг техникийн хувьд байлдааны цагийн орон тоогоор нөхөн хангагдав.

5 дугаар сарын байлдаанд амь үрэгдсэн дивизийн дарга Ч.Шаарийбууны оронд 17 дугаар хорооны дарга дэслэгч Л.Дандар дивизийг командлах болов. Бүх цэргийн жанжны тушаалаар дивизийн штабын даргаар М.Цэрэндаш, 17 дугаар хорооны даргаар С.Чойндонгаваа нарыг тус тус томилон 200 гаруй цэрэг, бага дарга нарыг 6 дугаар дивизийн ангиудад илгээжээ.

Японы командлал Манжуур, Солонгос, Умард Хятадын нутгуудаас нисэх онгоцны ангиудыг Халхын голын районд татан авчирч томоохон ажиллагаанд бэлтгэж эхлэв. Тэд 5 дугаар сарын байлдаанд хүлээсэн хохирлоо нөхөн хангаж, материал хэрэгсэл, зэвсэг техник, шинэ ангиудыг байлдааны ажиллагааны районд татан ирүүлэхийн хамт нисэх хүчний ажиллагаагаа эрчимжүүлэв.

¹ЦГАСА. Ф. 37977. ОП. 1. Д.37. Л.109-115.

Япончууд манай цэргийн байрлал, Хамар давааны районыг бөмбөгдөж, агаарт тулалдах явдал бараг өдөр бүр үргэлжлэх болжээ.

Халхын голын районд Японы нисэх хүчний эсрэг Зөвлөлтийн сөнөөгч онгоцны 22 дугаар хороо, хурдан бөмбөгдөгч онгоцны 70 дугаар хороо, бөмбөгдөгч онгоцны 150 дугаар хороо тулалдаж байв. 6 дугаар морьт дивизийн ангиуд 1939 оны 6 дугаар сард дайсны агаарын дайралтад хэд хэдэн удаа өртсөн боловч онцын хохирол үзсэнгүй. 6 дугаар сарын туршид дивизийн морьт хороодын салаа, сумангууд хэд хэдэн удаа хил зөрчсөн дайсны тагнуул хорлон сүйтгэх жижиг бүлэгт цохилт өгч байжээ.

57 дугаар онцгой корпусын командлагчаар томилогдсон Г.К.Жуков Халхын голын зүүн эрэгт 5 дугаар сард болсон байлдааны дүнг анхааралтай судлан шинжлээд юуны өмнө корпусын командын байрыг Тамсагбулагаас Хамар даваанд шилжүүлэн байрлуулах, түүнчлэн байлдааны ажиллагааны районоос алсад байрлаж байсан корпусын бүх анги, нэгтгэлийг Халхын голын чиглэлд хөдөлгөх тушаал өгчээ. 1939 оны 6 дугаар сарын эхээр Өндөрхаанаас дорно зүг Зөвлөлтийн 11 дүгээр танкийн бригад, 7, 8, 9 дүгээр мото хуягт бригад, 36 дугаар буудлагын дивизийн 24 дүгээр хороо хөдөлгөөнөө эхэлсэн юм.

Японы тал ойрмог хугацаанд томоохон хэмжээний ажиллагаанд бэлтгэж буй нь илэрхий байсан тул Монгол, Зөвлөлтийн ангиудыг байлдааны районд богино хугацаанд татан авчрах, тэдний байлдааны үүргийг нарийн уялдуулан зохицуулах шаардлагатай байв. Иймд маршал Х.Чойбалсан, МАХЦ-ийн Улс төрийн газрын дарга, корпусын комиссар Ж.Лхагвасүрэн нар 6 дугаар сарын 20-ны үеэр Халхын голд хүрэлцэн очжээ.

Тэд Монгол, Зөвлөлтийн цэргийн ангиудаар орж командлалын бодлого, шийдвэрийн талаар тайлбарлан, дайчдын санал сэтгэгдлийн байдалтай танилцаж байв. Халхын голын баруун эрэгт Гурван нуурын районд байрласан 6 дугаар дивизийн штабт маршал Х.Чойбалсан, корпусын комиссар Ж.Лхагвасүрэн нар хүрэлцэн ирж 5 дугаар сард Хайлаастын голын районд гарамгай байлдсан дарга, цэргүүдэд төрийн дээд шагнал одон медаль гардуулсан байна¹. Шагнагдсан хүмүүсийн дотор дивизийн дарга Л.Дандар, комиссар Д.Пэлжээ, пулемётын наводчик Ц.Олзвой, улс төрийн удирдагч Жүгдэрнамжил, танк эсэргүүцэх бууны дарга Дорж нарын олон арван дайчид байв.

1939 оны 5 дугаар сарын байлдаанд амь үрэгдсэн дайчдын шарилыг цуглуулах ажлыг дивизийн анги, салбарууд 6 дугаар сарын эхээр гүйцэтгэсэн дуусгасан бөгөөд тэр үед дивизийн дарга Ч.Шаарийбуу, батарейн улс төрийн удирдагч Гэлэгбаатар нарын шарилыг олж хөдөөлүүлжээ.

1939 оны 7 дугаар сард явуулсан байлдааны ажиллагаа. Японы цэргийн командлал 1939 оны 5, 6 дугаар сард Халхын голын зүүн эрэгт болон агаарт үлэмж хохирол хүлээснийхээ дараа 6 дугаар сарын турш томоохон тулалдааны бэлтгэл хийж байв. Тэгэхдээ Квантуны армийн штаб Баянцагааны чиглэлд давшихаар чиглэл сонгож, Халхын голын зүүн районд цэргийн хүч хуралдуулахаар байлдааны төлөвлөгөө боловсруулах ажлыг шуурхайлан

¹Халхын голын байлдаанд оролцсон ахмад дайчдын дурдатгал, УБ., 1981. т.12-13

гүйцэтгэж 6 дугаар сарын 19-нд боловсруулж дуусгаад командлагч Уэда-гийн шийдвэрээр генерал Ясуокагаар удирдуулсан цохилтын бүлэглэл байгуулжээ.

Дээрх төлөвлөгөөний дагуу хошууч генерал Кобаяши-гийн отряд Монгол, Зөвлөлтийн цэргийн хориглолтын зүүн гараар тойрон Халхын голыг гаталж, Баянцагааны нурууг эзлэн, цаашид фронтын төв хэсгээр давших генерал Ясуокогийн бүлэглэлтэй харилцан ажиллагаатайгаар Халхын голын зүүн эрэгт байгаа Монгол-Зөвлөлтийн анги, нэгтгэлүүдийг бүслэн авч устгах зорилт тавьжээ.

Энэ зорилтыг биелүүлэхийн тулд Японы цэргийн командлал Халхын голын фронтод 23 дугаар явган дивизийг бүхэлд нь /энэ нь 64, 71, 72 дугаар хороодтой/, 7 дугаар явган дивизийн 26 дугаар хороо, 23 дугаар хорооны хагас, 3, 4 дүгээр танкийн хороод, Хянганы морьт дивизийн гурван хороо, баргын 1, 2, 8 дугаар морьт хороод, хүнд их бууны 7 дугаар хороо, зенитийн хоёр дивизион, их бууны хэд хэдэн батарей зэргийг хуралдуулаад байв. 7 дугаар сарын эхээр Халхын голын район дахь Японы цэргийн тоо 38000, янз бүрийн калибрийн их буу 310, танк 135, хуягт 10, нисэх онгоц 225-д хүрсэн байлаа¹.

Энэ үед Халхын голын фронт дахь Монгол-Зөвлөлтийн цэрэг Халхын голоос зүүн тийш 5-6 километр газар өргөнөөрөө 20 километр, гүнээрээ 10 километр зурваст хориглож байжээ. Тэр районд байрлаж байгаа хүч хэрэгсэл нь Хайлаастын голын өмнөд эрэгт Зөвлөлтийн 11 дүгээр танкийн бригадын буудлага-пулемётын батальон, түүний зүүн гарт голын хойд эрэгт 149 дүгээр буудлагын хороо, 9 дүгээр мото хуягт бригад байлаа. Халхын голын зүүн эрэгт нийт 1500 орчим цэрэг, 31 их буу, 53 пулемёт байршуулсан байсан бөгөөд цохилтын гол нударга нь БА-10 маркийн 98 хуягт машин байв. Зөвлөлтийн цэргийн зүүн жигүүрийг халхлах үүрэг Халхын голын баруун эрэгт байрласан МАХЦ-ийн 6 мд-д ноогдсон юм.

Халхын голын дайны түүхэнд “Баянцагааны тулалдаан” гэж нэрлэгдсэн 7 дугаар сарын эхэн үеийн үйл явдалд 6 дугаар морьт дивизийн гүйцэтгэсэн үүргийг тодруулахын тулд уг үйл явдал хэрхэн эхэлж цаашид өрнөснийг тодорхой авч үзэх нь зүйтэй.

Японы цэргийн командлалын төлөвлөснөөр 71, 72, 26 дугаар явган хороодыг их буугаар хүч нэмэгдүүлэн хошууч генерал Кобаяшийн командын дор Яньху нуураас зүүн тийших районд хуралдуулж 7 дугаар сарын 3-ны шөнө Баянцагааны чиглэлд давшилтад шилжүүлэх ёстой байв. Кобаяшийн отряд Баянцагааны орчмоор Халхын голыг гаталж Монгол-Зөвлөлтийн ангиудын ухрах замыг таслахын тулд хойноос нь урагш цохих зорилготой байжээ. 26 дугаар явган хороо отрядын задгай үзүүрт давшиж Монгол-Зөвлөлтийн бүлэглэлийн резервийг саатуулан барих үүрэг хүлээжээ. Кобаяшийн отрядын гол гатлах ажиллагааг инженерийн 23 дугаар хороо хангах ёстой байв.

Дэслэгч генерал Ясуокагийн удирдсан бүлэглэлд 64 дүгээр явган хороо, 28 дугаар явган хорооны хэсэг, 3, 4 дүгээр танкийн хороод, Хянганы морьт дивизийн хороод багтаж байсан бөгөөд энэ бүлэглэл жигүүрээр хөдөлгөөн үйлдэж байгаа Коябишийн отрядын гол гатлах ажиллагааг галаар ханган,

¹М.Новиков. “Победа на Халхин голе”. Москва. 1971 г. Стр 49.

Халхын голын зүүн эрэгт хориглосон Зөвлөлтийн ангиудын завсар үзүүрээр тойрч 7 дугаар сарын 2-нд шийдвэртэй давшилтанд шилжих үүрэг авчээ.

Энэхүү бодлого төлөвлөгөөг нь тааварласан манай командлал өөрийн бүлэглэлийн жигүүрүүдийг халхлахаар морьт дивизийг хөдөлгөв.

6 дугаар морьт дивиз 6 дугаар сарын 29-нд шөнийн маршаар хөдөлж, Бурхант хошууны чиглэлээр Халхын голыг гаталж, Хорго манхны районыг эзлэн авч, хүч нэмэгдүүлсэн тагнуулыг Яньху нуур, Жанжин сүмийн чиглэлд ажиллуулах үүрэг авчээ.

Дивизийн дарга Л.Дандарын шийдвэрээр 15 дугаар морьт хороог ахмад Ш.Дарамжаваар удирдуулан тэргүүний отрядад томилов. Дивизийн гол хүч тэргүүний отрядын замаар хөдөлгөөн үйлдэж үүр цайхын өмнө тушаалд заасан районыг эзлэн авчээ.

7 дугаар сарын 1-нд Монгол Зөвлөлтийн цэргийн командлал 15 дугаар морьт хороог их бууны батарей, хуягтын салаагаар хүч нэмэгдүүлэн Бурхант хошууны чигт марш үйлдэж Халхын голын зүүн эргийн дагуу хориглолтод шилжих үүрэг өгөв.

15 дугаар морьт хорооны хориглолтын өмнөөс японы гурван рот хэртэй хүч давшиж эхлэхэд их бууны батарей дайсанд гал нээж хүчтэй цохилт өгч байв. Энэ байлдааны эхэнд япончууд үлэмж хохирол үзэж рот орчим хүчээ алдсан боловч резерв хүчээ байлдаанд оруулж 15 дугаар хорооны салбаруудыг хүчээр түрэн голын баруун эрэгт гаргажээ.

Ахмад Ш.Дарамжавын командалсан 15 дугаар морьт хороо япончуудыг гол гатлах үеэс эхлэн бүтэн өдрийн турш байлдаж тэднийг тогтоон барьсаар байв. Хорооны байлдааны ажиллагааг ахмад Д.Дамбын удирдсан их бууны дивизион галаараа дэмжиж эсрэг талын олон тооны явган цэрэг, хүнд хөнгөн пулемёт, танк эсэргүүцэх хэрэгслийг устгажээ.

7 дугаар сарын 3-нд Япончууд Баянцагааны нурууг эзлэхээр Халхын голыг гаталсан учир корпус командлан захирагч Г.К.Жуковын тушаалаар 11 дүгээр танкийн бригад, 7 дугаар хуягт бригад, 24 дүгээр мотобуудлагын хороо Хамар даваанаас Баянцагааны чиглэлд байлдаанд орохоор хөдлөв.

М.П.Яковлевын захирсан 11 дүгээр танкийн бригадын гурван батальон дайсныг гурван талаас нь нэгэн зэрэг атаклан оржээ. Үүнд 1 дүгээр танкийн батальон Баянцагааны нурууны баруун хойд талаас дайсны ар тал руу, 3 дугаар танкийн батальон 6 дугаар морьт дивизийн хуягт дивизионы хамт баруун талаас нь атаклаж, 2 дугаар танкийн батальон 8 дугаар морьт дивизийн хуягт дивизионы хамтаар дайсныг өмнө талаас нь тогтоон барьж байв.

Дивизийн дарга Л.Дандарын шийдвэрээр хуягт дивизионы давшилтыг хөгжүүлэхээр ахмад С.Чойндонгаваагийн захирсан 17 дугаар морьт хороог байлдаанд оруулав. Хорооны давшилт дайсны их бууны хүчтэй галын улмаас түр саатаж, хуягт дивизионы 3 хуягт жагсаалаас гарчээ. Үдээс хойш Улаан армийн хурандаа Федюнинскийн захирсан мотобуудлагын 24 дүгээр хороо хүрэлцэн ирж, дайсны баруун хойд талаас нь давшин атаклаж, зүүн өмнө зүгт түрж эхлэв. Харин японы 71, 72 дугаар хороод гол гаталсныхаа дараа бүлгийн командлагч Кобаяшийн шийдвэрээр 100 орчим их бууны галын дэмжлэгийн дор давшсан авч амжилт олсонгүй. Энэ байдлыг нүдээр үзсэн 23 дугаар дивизийн

командлагч Камацубара голын баруун эрэг дэх цэргээ бут ниргэгдэхээс өмнө яаралтай ухрах тушаал өгсөн гэж Японы судлаачид тэмдэглэсэн байна.

Энэ үед Баянцагааны өндөрлөгийн өмнө талаас давшсан хурандаа А.Л.Лесовойн командалсан 7 дугаар хуягт бригадын ажиллагаа МАХЦ-ийн 6 дугаар морьт дивизийн амжилтыг бататгав. Баянцагааны байлдаан 7 дугаар сарын 4-ний өдөр үргэлжилжээ. Монгол-Зөвлөлтийн танк, хуягт, морьт цэргийн хүчтэй дайралтад өртсөн японы цэрэг ухарч, Халхын голыг гатлах ажиллагаа Камацубара-гийн тушаасан дэс дараалалаас гадуур эмх замбараагүй болжээ. Тухайлбал 7 дугаар сарын 4-ний өглөө гэхэд 71 дүгээр хорооны зарим хэсэг, 23 дугаар дивизийн штаб хүнд хохирол амсч Халхын голын зүүн эрэгт буцаж гарчээ. 72 дугаар хорооны үлдэгдэл 7 дугаар сарын 4-ний шөнө гүүр рүү ухарч ирээд 5-ны үүрээр гол гарч дууссан байна. 26 дугаар хороо Халхын голоор хамгийн сүүлд ухран гарахдаа 1 дүгээр батальоноо алджээ. Энэ хороог гол гарсны дараа Халхын голд тавьсан гүүрийг дэлбэлсэн ба ийнхүү Халхын голын баруун эрэгт гарч Баянцагааны нуруунд хийсэн Японы цэргийн байлдааны ажиллагаа тэдний ялагдлаар төгсжээ. Энэ тулалдаанд Японы тал 8000 хүнээ алдсан тухай судлаачид тэмдэглэн үлдээжээ.

Баянцагааны тулалдаанд 6 дугаар морьт дивизийн 15 дугаар хорооны дарга ахмад Ш.Дарамжав, их бууны дивизионы дарга ахмад Д.Дамба, комиссар Д.Сэрээсэн, пулемёт сумангийн дарга Ширзана, улс төрийн удирдагч Ц.Лувсаншарав, батарейн дарга Ё.Төрхүү, Дамдин, хуягтын дарга Н.Дэлгэр нар анги салбараа сайн зохион байгуулж удирдсан байна.

Баянцагааны тулалдаанаас хойш 8 дугаар сарын 20-ны их давшилт хүртэлх хугацаанд фронт дээр болсон үйл явдал манай болон Зөвлөлтийн түүхчдийн бүтээл, туурвил, архивын материалд харьцангуй бага тусгагджээ.

6 дугаар морьт дивиз Баянцагааны тулалдааны дараа резервт гарч тагнуулын үүрэг гүйцэтгэв. Монгол-Зөвлөлтийн командлалаас дивизийн тагнах зурвасыг тодорхойлон өгч дайсны хориглолтын систем, амьд хүч, их бууны галт байрууд, танкийн байрлал ба резервийг илрүүлэх тухай үүрэг даалгаврыг удаа дараа өгч байжээ. Үүргийн дагуу дивизийн штабаас хороо, ангиудад хуваарь, төлөвлөгөө гарган өгч дайсныг тагнах чиг, зурвасыг зааж, дайсны гүнд ажиллах тагнуулын хүч хэрэгслийг хүртэл тодотгон өгч байв. Дивизийн тагнах зурвасын дотор хориглосон дайсныг үндсэндээ бүтэн сар гаруй хугацаанд тагнан туршиж байнгын хяналт явуулж байсны дээр хоёр удаа байлдан тагнах ажиллагаа явуулсан нь дайсныг бүрэн илрүүлэх үндэс болж өгчөө. Үүний дүнд дайсны хориглолтын өвөр эгнээ, ротын тулгуурт байрууд, галын цэг, резерв, их бууны галт байр, танкийн хүч хуралдуулах районыг илрүүлэн дээд штабт мэдээлжээ.

7 дугаар сарын 24-ний өдөр Хорго өндөрлөг, Гөлөгт манхны районд хориглосон дайсны хүч хэрэгслийг тодотгохоор байлдан тагналт явуулжээ. Энэ ажиллагаанд 15 дугаар морьт хороо нэг сумангүйгээр Хорго өндөрлөгийн чиглэлд, 17 дугаар морьт хороо Гөлөгт манхны чиглэлд, 15 дугаар хорооны дэслэгч Гомбосүрэнгийн суман Гөлөгт манхны баруун хойд талаар хориглосон дайсны чиглэлд тагнуул явуулах үүрэгтэйгээр оролцов.

Байлдан тагнах ажиллагаа сумангуудын эрс шийдэмгий, гэнэтийн давшилтаар эхэлжээ. Давшилт дайсны хувьд үнэхээр гэнэтийн болсон учир тэд

эхний үед илт самгардан эмх замбараагүй гал нээж эхэлснээ удалгүй их буугаар буудаж давшилтыг зогсоохыг оролджээ. Энэ байлдаанд 15 дугаар хорооны дэслэгч М.Экейгийн суман дайсны хориглолтын өвөр эгнээ хүртэл давшин ширүүн тулалдаанд оржээ. Дайсны өвөр эгнээн дэх цэргийн санал сэтгэгдэл алдран зарим хэсэг нь ухарч зугтаж эхэлсэн боловч тэд нэмэгдэл хүч татан ирүүлж их бууны галыг нэмэгдүүлжээ. Тэгснээр хүчний харьцаа өөрчлөгдөн дайсны тал давуутай болсон энэ тулалдаанд дэслэгч М.Экей баатрын ёсоор амь үрэгджээ. Мөн 17 дугаар хорооны штабын дарга П.Шагдарсүрэн, салааны туслах М.Нинзайдорж нарын дайчид шархаджээ.

6 дугаар морьт дивизийн цэрэг, дарга нэлээд хүн энэхүү байлдан тагнах ажиллагааны явцад алагдаж шархадсан боловч Гөлөгт манхны районд баргын цэргийн 28 дугаар хороо, их бууны батарей, танкийн салаа хориглож байгааг тогтоож чаджээ.

6 дугаар морьт дивиз 8 дугаар сарын их давшилтад оролцсон нь. Японы цэргийн командлал 1939 оны 5, 7 дугаар сард Монгол, Зөвлөлтийн цэрэгт илт цохигдсоныхоо дараа давших ажиллагаагаа түр зогсоож хориглолтод шилжив. Юуны өмнө тэд эзлэн авсан газартаа бат бэх хориглолтын систем байгуулж дараагийн томоохон ажиллагааны түшиц газар болгон хадгалах, цаашилбал энэ районд өвөлжих, урин дулаан цаг болохыг хүлээхээр төлөвлөж байв.

23 дугаар дивизийн командлагч Камацубарагийн 7 дугаар сарын 25-нд гаргасан тушаалын дагуу бэхлэлтийн барилга байгууламж барих ажлыг 2 шаттай явуулж эхлэв. Японы цэргийн хориглолтын систем нь хойд талд Хуруу өндөрлөг, өмнөд талд Ногоон өндөрлөг хүрч байсан бөгөөд энэхүү хориглолтын өвөр эгнээнд явган цэргийн 9 рот, хээрийн их бууны 8 батарейг хүнд их бууны 2 батарей байрлуулан гол хүчээ Номонхан, Бүрд-Овоо, Жанжин сүмийн чиглэлд төвлөрүүлжээ.

8 дугаар сарын эхээр Квантуны арми 2 дугаар дивизийн хүчийг бэхжүүлэх хэд хэдэн арга хэмжээ авсны дотор Хасэбэгийн командалсан хилийн цэргийн гарнизон, 7 дугаар явган дивиз зэргийг шинээр татан авчирчээ. 8 дугаар сарын 4-нд Японы дээд командлал Халхын голын районд байлдааны ажиллагаа явуулах үүрэгтэй 6 дугаар армийг байгуулах шийдвэр гаргаж, тус армийн командлагчаар Огису Риппог, штабын даргаар Фузимото Тэцукумаг томилжээ.

6 дугаар армийн бүрэлдэхүүнд 23, 7 дугаар явган дивизүүд бүхлээрээ, их бууны долоон хороо, танкийн хоёр хороо болон олон тооны хангалтын ангиуд багтаж байв. Энэ нь нийтдээ 55 мянган хүн, 300 гаруй их буу, 135 танк юм. Энэ районд 6 дугаар армиас гадна Манжуурын холимог явган бригад, хилийн 8 дугаар гарнизон, хүнд артиллерийн гурван хороо, баргын гурван морьт хороо, 1 дүгээр явган дивизийн танк эсэргүүцэх бүх батарей, Порт-Артурын бэхлэлтийн хүнд артиллерийн анги, Хятад- Японоос ирүүлсэн 350 орчим нисэх онгоцыг хүч хуралдуулж амжжээ. Энэ районд нийтдээ дайсны 75 мянган хүн бүхий бүлэглэл, 500 гаруй их буу, 182 танк, 350 орчим нисэх онгоц төвлөрүүлжээ¹.

Японы цэргийн командлал Халхын голын зүүн эргээс 5-8 километр зайтай хориглолтын систем байгуулж, голын зүүн талын элсэн манхан, толгодуудаар

¹Зөвлөлт эх орны дайны түүх, 1941-1945 он. I боть, т.240

бэхлэлтийн зангилаа хийж, баруун жигүүр нь Их элст районд Хулд уул хүрч 60 шахам километр урт, 15-20 километр гүн зурвасыг эзлээд байв. Бэхлэлтийн зангилгаануудыг харилцах шуудуугаар холбож, Элсэн, Ногоон, Ремизовын болон “Хуруу” өндөрлөгүүдэд бат бэх мод, шороон галын цэгүүд байгуулж, өргөст торон цайз болгожээ.

Монгол Улсын нутагт цөмрөн орж бэхжин суусан Японы цэргийг бут цохиж газар нутгаа чөлөөлөх их давшилтын төлөвлөгөөг Монгол-Зөвлөлтийн цэргийн командлал 7 дугаар сарын сүүлээр боловсруулж дууссан байна. 1939 оны 5, 6 дугаар сард явуулсан байлдаан, ялангуяа Баянцагааны тулалдаан нь дайсны шатлан өргөжүүлж байгаа түрэмгийлэлийг няцаахад тийм ч хангалттай хүч байгаагүйг харуулсан тул Халхын голын районд 7 дугаар сард шинээр буудлагын болон механикжуулсан анги, нэгтгэлүүдийг татан авчирав.

Өвөр Байгалын цэргийн тойргийн бүрэлдэхүүнээс 6 дугаар танкийн бригад, 5 дугаар пулемёт-буудлагын бригад, Уралын болон Сибирийн цэргийн тойргийн 82, 57 дугаар буудлагын дивиз хүрэлцэн ирж өмнөх байлдааны хүнд бэрхийг туулсан цэргийн ангиудыг халж, хохирлоо нөхөн сэлбэх бололцоо олгожээ.

Тийнхүү Халхын голын районд байрлаж байсан 57 дугаар онцгой корпусын бүрэлдэхүүнд буудлагын хоёр, мотобуудлагын нэг дивиз, танкийн хоёр бригад, мотохуягт гурван бригад, пулемёт-буудлагын болон агаарын десантын бригадууд багтаж байв. Эдгээр бүрэлдэхүүн болоод ерөөс Халхын голын район дахь үйл явдлын өрнөлт нь Зөвлөлтийн цэрэгт зохион байгуулалтын өөрчлөлт зайлшгүй болсныг харуулав.

Иймд ЗХУ-ын Батлан хамгаалах ардын комиссарын 7 дугаар сарын 19-ний тушаалаар 57 дугаар онцгой корпусыг армийн бүлэг болгон өөрчлөн байгуулав.

Монгол ардын хувьсгалт цэргийг ерөнхийд нь бүх цэргийн жанжин маршал Х.Чойбалсан удирдаж байсан бөгөөд байлдааны ажиллагааны район дахь анги нэгтгэлүүдийн ажиллагааг бүх цэргийн жанжны орлогч, Улс төрийн газрын дарга корпусын комиссар Ж.Лхагвасүрэн, Жанжин штабын дарга дивиз командлан захирагч Ж.Цэрэн, байлдааны хэлтсийн дарга хурандаа Г.Эрэндoo, армийн их бууны газрын дарга хурандаа Б.Цог, нисэх хүчний командлагч бригад командлан захирагч М.Зайсанов нарын бүрэлдэхүүнтэй шуурхай бүлэг зохицуулж байв¹.

8 дугаар сарын дундуур командлалын тушаалаар Хорго өндөрлөгийн районд хориглож байсан 6 дугаар морьт дивизийн 15 дугаар хорооны хориглолтын хэсгийг Улаан армийн 601 дүгээр буудлагын хороонд шилжүүлж, 15 дугаар хороо дивизийн бусад ангиудын хамт Гөлөгт манхны чиглэлд хүч хуралдуулжээ. 8 дугаар сарын дундуур Монгол-Зөвлөлтийн цэргүүд Халхын голын зүүн эргээс 2-6 км зайтай хориглолтын байр зээлж байв. Монгол-Зөвлөлтийн цэргийн бүлэглэлийн зүүн жигүүрийг халхлах үүрэг МАХЦ-ийн 6 дугаар морьт дивизэд оногдсон юм.

Армийн 1 дүгээр бүлгийн үндсэн хүч Халхын голын баруун эрэгт хүч хуралдуулсан бөгөөд бүрэлдэхүүндээ 57 мянган хүн, 634 их буу, 498 танк, 385 хуягт, 515 нисэх онгоц багтааж байв. Энэ бүлэглэл дайснаас хүн хүчний хувьд

¹Халхын голын байлдаан. УБ., 1979. т.13.

их биш боловч их буу, пулемётоор бараг 2 дахин, танк ба хуягт машинаар 6 дахин илүү байсан нь шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн юм.

Шийдвэрлэх давшилтын төлөвлөгөө ёсоор армийн 1 дүгээр бүлгийн цэргийг 3 групп болгон хуваажээ. Монгол-Зөвлөлтийн цэргийн зүүн жигүүрийг халхалж байсан 6 дугаар морьт дивиз умард группт багтаж байсан бөгөөд энэ группт Зөвлөлтийн 82 дугаар буудлагын дивизийн 601 дүгээр хороо, 7 дугаар мотохуягт бригад, 11 дүгээр танкийн бригадын хоёр батальон, 87 дугаар танк эсэргүүцэх дивизион оролцож байв. Тус групп Нэргүй нуурын чиглэлд давшиж Номонхан, Бүрд-Овооноос баруун хойш 4 километрт орших элсэн манхнуудыг эзлэн авч цаашдаа төвийн группийн 36 дугаар мотобуудлагын дивизтэй харилцан ажиллаж Хайлаастын голын хойд эрэгт дайсныг бүслэн авч устгах үүрэгтэй байв. Командлалын өгсөн энэ үүргийг биелүүлэх гол хүч нь 7 дугаар мотохуягт бригад болон 601 дүгээр буудлагын хороо байв. Эдгээр нэгтгэл, ангийн жигүүрийг хамгаалан давших үүрэг 6 дугаар морьт дивизэд тулгарав.

1939 оны 8 дугаар сарын 17-нд корпус командлан захирагч Г.К.Жуков, Улс төрийн газрын дарга корпусын комиссар Ж.Лхагвасүрэн нар 6 дугаар морьт дивизийн штабт хүрэлцэн ирж байлдааны тушаал өгөв. Тэд давших чиг, эзлэх район, гол цохилтын чигийг газар орон дээр тодотгожээ. 6 дугаар морьт дивизийн дарга Л.Дандар цагийн байдлыг үнэлэн үзээд 15 дугаар хороог Зөвлөлтийн цэргийн буудлагын ротоор хүч нэмэгдүүлэн Гөлөгт манхны урд талаар ороож гэнэтийн атакаар манхны урд хэсгийг эзлэн цаашид давшилтаа хөгжүүлэн улсын хилийн шугамд гарах, 17 дугаар хороог Зөвлөлтийн цэргийн танкийн ротоор хүч нэмэгдүүлэн Гөлөгт манхны баруун ба баруун хойд талаар давшин дайсныг устган мөн улсын хилийн шугамд гарах байлдааны үүрэг өгөв.

Энэхүү байлдааны ажиллагаанд дивизийн удирдлага Монгол-Зөвлөлтийн цэргийн командлалын шууд оролцоотойгоор нягт нямбай бэлтгэв. Даших байлдааны явцад морьт цэрэг, танк, мотобуучидтай харилцан ажиллах явдалд онцгой анхаарал хандуулан тэдний ажиллагааг сайтар уялдуулан зохицуулсан төлөвлөгөөг давшилтын бэлтгэлийн үед боловсруулжээ. Мөн холбоо, удирдлагыг зохион байгуулах талаас их анхаарал тавьжээ. Дивизийн удирдлага тагнуулыг зохион байгуулах, дайсны хүч бүрэлдэхүүн, хориглолтын өвөр эгнээ, галын цэг бүрийг нарийн тодорхойлоход хүч анхаарлаа төвлөрүүлсэн нь цаашдын ажиллагаанд чухал хувь нэмэр болсон юм.

Давшилт эхэлмэгц дивизийн штабын зарим офицеруудыг хороо, ангиудад илгээж шуурхай мэдээллээр хангах, байлдааны ажиллагааг удирдахад нь туслалцуулсан нь дивизийн өмнө тавигдсан үүргийг нэгэн бодлогоор гүйцэтгэхэд дөхөмтэй нөлөө үзүүлсэн байна.

8 дугаар сарын их давшилтад гүйцэтгэсэн байлдааны үүрэг. 1939 оны 8 дугаар сарын 20-ны үүрээр Монгол-Зөвлөлтийн цэргийн ангиудын үндсэн хүч Халхын голын зүүн эрэгт хүч задлах заагт гараад байв. Өглөөний 5 цаг 45 минутанд Монгол-Зөвлөлийн 600 шахам их буу дайсны агаарын зенитийн их буу, артиллерийн салбаруудын галт байр, бусад галын цэгүүдэд нэгэн зэрэг хүчтэй гал нээжээ. Мөн 150 гаруй бөмбөгдөгч онгоц, 100 гаруй сөнөөгч онгоцоор дайсны хориглолтын өвөр эгнээ резерв, хуягт танкийн ангиудад цохилт өгч эхлэв.

Нисэх онгоцны бөмбөгдөлт, их бууны бэлтгэл 4 цаг шахам үргэлжилсний дараагаар Монгол-Зөвлөлтийн дайчид 8 цаг 45 минутаас 80 километр өргөн фронтоор дайсны тал бүрээс нэгэн зэрэг давшилтад шилжив.

Умард группын 7 дугаар мотохуягт бригад болон 601 дүгээр буудлагын хороо дайсны тэргүүний байрлалыг эзлэн аваад хүчтэй бэхэлсэн Хуруу өндөрлөгт дөхөж очив. Дайсны эсэргүүцэл ширүүсч дээрх анги, нэгтгэлийн дайчид зууралдсан хүнд тулаан хийх төлөвтэй болжээ. Энэ нь Умард группын давшилтыг удаашруулж, дайсныг бүслэх явдлыг тасалдуулахад хүргэх аюултай байв. Энэ үед Л.Дандарын командалсан 6 дугаар морьт дивизийн ангиуд Зөвлөлтийн цэргийн танк, буудлагын салбаруудаар хүч нэмэгдүүлэн их бууны галын дэмжлэгийн дор амжилттай давшин Гөлөгт манхны район дахь Хянганы хоёр морьт хороонд хүчтэй цохилт өгч улсын хилийн заагт гарав. Ингэснээр дайсны дээрх хүч Хуруу өндөрлөгийн чиглэлд маневрлан өөрийн хүчиндээ туслах бололцоог тасалдуулжээ.

8 дугаар сарын 21 гэхэд 6 дугаар дивизийн аниуд Хянганы морьт хороог устгаж, их буу 4, танк эсэргүүцэх буу 3-ыг олзолж хүнс, галт хэрэгслийн томоохон агуулахыг эзлэн авсан юм.

Хуруу өндөрлөгийн орчимд дайсны эсэргүүцэл нэмэгдсэн энэ шийдвэрлэх үед 1 дүгээр армийн бүлгийн командлалын нөөцөд байсан 9 дүгээр мото хуягт бригадыг 6 дугаар танкийн бригадын нэг батальоны хамтаар Халхын голыг гатлан Хуруу өндөрлөгийн зүүн талаар ороон бүслэлтийн цагирагийг битүүлэх үүрэг өгчээ. Г.К.Жуковын энэ тушаал давшилтын дөнгөж хоёр дахь өдөр бүх резервийнхээ ихэнх хэсгийг байлдаанд оруулсан эрсдэлтэй боловч тун зоригтой шийдвэр байсан юм. Үүний зэрэгцээ дайсныг хоёр талаас нь ороон авч бүслэхэд танкийн ба мотохуягт бригадуудыг жигүүрийн хүч болгон бие даалган ажиллуулсан нь хожим чухал туршлага болсон билээ.

8 дугаар сарын 21-ний өглөө байлдаанд орсон резерв-9 дүгээр мотохуягт бригад 6 дугаар танкийн бригадын 4 дүгээр батальоны хамт Хуруу өндөрлөг дэх дайсны зүүн хойд талаар тойрон гарч улсын хилийн шугамд хүрэн 24-ний өглөө бүслэлтийн цагирагийг битүүлэв.

Харин Хуруу өндөрлөгт бэхжин хүчтэй эсэргүүцэл үзүүлсээр буй дайсныг устгахын тулд резервт байсан сүүлчийн хүч 212 дугаар агаарын десантын бригадыг байлдаанд оруулснаар 23-ны орой 21 цагийн орчим гэхэд энэ өндөрлөгийг Зөвлөлтийн цэрэг эзлэн авсан байв.

Дайсны бүлэглэлийг бүслэн устгах явцад бүслэлтийн гадаад фронтыг байгуулсан явдал цэргийн урлагт цоо шинэ үзэгдэл байсан бөгөөд бүслэлтийг гаднаас цөмлөх оролдлогыг няцааж, бүслэгдсэн дайсныг зохион байгуулалттай устгах бололцоо олгосон юм.

Бүслэлтийн гадаад фронт дээр 80 дугаар хороо, 8, 9 дүгээр мотохуягт бригад, 11 дүгээр танкийн бригадын буудлага-пулемётын батальон, 212 дугаар агаарын десантын бригад болон МАХЦ-ын 6 дугаар морьт дивиз байрлаж байв.

8 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн Монгол-Зөвлөлтийн цэргийн командлал бүслэгдсэн дайсныг хэсэгчлэн устгах ажиллагаанд шилжсэн бөгөөд энэ ажиллагаа 27-ны орой хүртэл үргэлжлэв.

28-ны өдөр их давшилтын сүүлчийн үе эхэлж Монгол-Зөвлөлтийн цэрэг дайсны сүлчийн түшиц газар болон үлдсэн Ремизовын өндөрлөг дэхь япончуудыг устгаж эхэлсэн байна.

6 дугаар морьт дивиз бүслэгдсэн дайсныг устгах ажиллагаа явагдаж байсан дээрх өдрүүдэд хүч нэмэгдүүлсэн тагнуул томилон хилийн заагаар ажиллуулж бүслэлтээс гарч зугтсан дайсныг устгаж байв.

Ийм нэгэн ажиллагаанд 17 дугаар хорооны тагнуулын тасгийн дарга Цэрэндаш эрэлхэг гавьяа байгуулан дайны дараа одонгоор шагнагдаж байжээ.

6 дугаар морьт дивизийн ангиуд Гөлөгт манханд хориглосон дайсныг богино хугацаанд өндөр хурдтай гэнэтийн атакаар устгасан явдал нь умард группийн анги нэгтгэлүүдийн түргэн маневрлаж дайсныг бүслэн устгах нөхцөл боломжийг хангасан учир армийн бүлгийн командлагчаас тус дивизийн нийт дайчдад талархал илэрхийлсэн тушаал гаргаж байжээ¹.

Ийнхүү 6 мд Халхын голын дайнд эхний өдрөөс оролцож дайныг ялалтаар өндөрлөсөн бөгөөд тус дивиз Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнуулж, дивизийн дарга Л.Дандар БНМАУ-ын гарамгай баатар цолоор шагнуулсан юм.

Энэ нь тус дивизийн Халхын голын дайнд гүйцэтгэсэн үүргийг өндөр үнэлсэн үнэлэлт байв.

2.3. Монгол ардын хувьсгалт цэргийн 8 дугаар морьт дивиз Халхын голын дайнд.

МАХЦ-ийн түүхэнд “Матадын найм” хэмээн алдаршсан 8 дугаар морьт дивиз (Чанагш 8 мд гэнэ) анх байгуулагдсан цаг үе нь манай орны гадаад байдал түгшүүртэй болж улс орныг батлан хамгаалах талаар дэс дараатай олон чухал арга хэмжээ авах шаардлага тулгарч байсан түүхийн эгзэгтэй үе байв.

1936 оны 1 дүгээр сарын 20-23-нд МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн хурал болж “Улс орныг батлан хамгаалах тухай” асуудал хэлэлцжээ. Уг хурлаас “...Тус улс орныг батлан хамгаалах явдлыг бэхжүүлэхийн төлөөнөө цэргийн тоо хэмжээг олшруулах ба зохион байгуулалтыг өөрчлөх буюу шинэчлэн гүйцэтгэх хийгээд техникжүүлэх... МАХЦ-ийн ангиудыг шинээр нэмж байгуулах”² шийдвэр гаргаж “Ар жаргалантад 8 мд-ийг ийнхүү байгуулахаар төлөвлөсөн нь зүйтэй гэж” үзэж баталсан байна.

Энэ шийдвэрийн дагуу Цэргийн Явдлын Яам /ЦЯЯ/-ны сайд бөгөөд Бүх цэргийн жанжнаас “Ар жаргалант хэмээх газрын орчим 8 мд-ийг байгуулах тухай” маш нууц 5 тоот тушаалыг 1936 оны 2 дугаар сарын 11-нд гаргажээ³.

Уг тушаалаар хязгаарын 18 ба 35 морьт хороодыг улсын дотоодыг хамгаалах ангиуд халж, улсын хил хамгаалах явдлыг хүлээн авсны дараагаар 1936 оны орон тооны ёсоор 8 мд-ийг Ар жаргалантын /Дорнод аймгийн Матад сумын нутаг/ орчим газар байгуулах, түүний бүрэлдэхүүнд орох ангиуд болох 18 дугаар тусгай морьт хороог 22 дугаар хороо, 35 дугаар тусгай морьт хороог 23 дугаар хороо, 17 дугаар хороог /6 мд-ийн/ 24 дүгээр хороо, 6 мд-ийн штаб, их

¹“Халхын гол хагас зууны тэртээ” баримт бичгийн эмхтгэл.

²МАХН-ын тогтоол, шийдвэр, баримт бичгүүд. II боть. 1929-1940.УБ., 1984. Т.494-495

³БХТА, сх.1, д.1, хн.299, х.51-52

бууны хороо, хуягт суман, холбооны сумангуудыг 8 дугаар дивизийн хэмээн нэрлэж байгуулахаар заажээ.

Тус дивизийн бүрэлдэхүүнд шинээр орсон 18 мх нь 3 дугаар сарын 1-ний наана, 35 мх нь 3 дугаар сарын 15-ны наана Ар жаргалантын орчим газар хүрэлцэн ирэх, 6 дугаар их бууны хороог моторт батарейгүйгээр 3 дугаар сарын 15-ны өдөр хөдөлгөн Ар жаргалант руу явуулах, бусад ангиудыг тусгай тушаалаар байгуулахаар заасан байна.

Ар жаргалантад ангиудыг шилжүүлэх бэлтгэл ажлыг 18 мх-ны дарга Д.Дашцэрэнд даалган түүнийг 8 мд-ийн даргаар томилжээ. Дивизийн штабын дарга ба бэлтгэлийн даргыг 6 мд-ээс томилон 2 дугаар сарын 15-ны өдөр 8 мд-д шилжүүлэхийг даалгасан байна. Тушаалын хавсралт ёсоор 18 мх нь 67 км газрыг хоёр өдрийн дотор, 35 мх нь 279 км газрыг 11 өдөрт, 6 дугаар их бууны хороо нь 180 км газрыг 8 өдөрт туулан Ар жаргалантад ирэх ёстой байв¹.

Энэ тушаал гарсны маргааш нь буюу 1936 оны 2 дугаар сарын 12-нд ЦЯЯ-ны сайдын 16 тоот тушаалаар 8 мд-ийн удирдлагыг дахин шинээр томилсон байна. Үүнд: Ерөнхий сургуулийн захирал бөгөөд комиссар Б.Гончигшаравыг 8 мд-ийн дарга бөгөөд комиссараар, 6 мд-ийн штабын дарга М.Гомбыг дивизийн штабын даргаар, мөн дивизийн улс төрийн хэлтсийн дарга Готовыг дивизийн улс төрийн хэлтсийн даргаар, 16 дугаар хорооны ажлын туслах Бямбыг дивизийн бэлтгэлийн даргаар, мөн бусад хороодын дарга, комиссар нарыг тус тус томилжээ². Харин үүний урьдах тушаалаар томилогдсон дарга нарыг өөрчлөх болсон шалтгаан нь тодорхой бус, энэхүү тушаал гарснаар дээрх тушаалыг хүчингүй болгосон бололтой.

Энэ үед буюу 1936 оны 1, 2 дугаар саруудад Япон, Манжийн түрэмгийлэгчид манай улсын хилд 600 хүртэл тооны цэргийн хүчээр халдан довтолж дахин их хүчээр дайрахаар бэлтгэж байв. Тухайн ийм нөхцөл байдалд 8 мд-ийг шинээр эмхлэн байгуулах завдал болоогүй ажээ.

Буй болсон цагийн байдлыг харгалзан дорнод хязгаарын ангиудад хүч нэмэгдүүлэх зорилгоор 1936 оны 2 дугаар сарын 28-нд ЦЯЯ-ны сайдын “Моторжуулсан отряд байгуулах тухай” 12 тоот тушаал гарав. Моторжуулсан отрядыг Улаанбаатарын цэргийн ангиудаас бүрдүүлэн 2 дугаар сарын 29-нд хөдөлгөн 3 дугаар сарын 3-ны өдөр Баянтүмэн хотноо хүрэлцэн очоод улмаар Матад сумын хавьд очих, 8 мд-ийн бүрэлдэхүүнд орсон 18 мх-г Бяруутаас 2 дугаар сарын 29-нд гарган 3 хоногийн дотор Матад суманд хоёр ээлжийн байлдааны сум хэрэглэлтэйгээр очихыг тушаажээ.

1936 оны гуравдугаар сарын 29-нөөс 4 дүгээр сарын 1-ний өдрүүдэд Япон, Манжийн 200-1000 хүртэл тооны цэрэг танк, нисэх онгоцоор дэмжүүлэн Булан дэрс, Адаг дулааны харуулаар довтлов. Энэ дайралтуудыг Адаг дулааны харуулын ба Тамсагийн 6 мд, Улаанбаатараас хүч нэмэгдүүлэн ирсэн отряд, Зөвлөлтийн цэргийн зарим анги, салбарын хамт няцаан дайсныг хилийн цаана гартал үлдэн хөөв. Энэ байлдаанд баатарлаг зориг гаргаж байлдсаны учир 100 гаруй дарга, цэргүүд одон болон байлдааны хүндэт зэвсэг, үнэ бүхий зүйлээр

¹БХТА, сх.1, д.1, хн.299, х.55

²БХТА, сх.1, д.1, хн.299, х.71

шагнагдсанаас 8 мд-ийн дарга Б.Гончигшарав, штабын дарга М.Гомбо нар Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнуулжээ¹.

Манай дорнод хязгаарт 1936 оны эхээр болсон дээрх байлдаануудад хожим нь 8 мд-ийн бүрэлдэхүүнд орсон зарим анги салбарууд ямар нэгэн хэмжээгээр оролцсон юм.

Энэ хугацаанд 8 мд-ийн удирдлага, штаб болон ангиудын дийлэнхийг нь Тамсагийн 6 мд-ээс бүрдүүлэхээр төлөвлөж байсан нь бодит байдал дээр хэрэгжих бололцоогүй байснаас 1936 оны 6 дугаар сар хүртэл 8 мд-ийг зохион байгуулах ажил үнэн хэрэгтээ хийгдээгүй байна. Учир нь 1936 оны 2 дугаар сараас Японы зэвсэгт халдлага улам өргөжсөн тул хязгаарын болон МАХЦ-ийн ангиудын байлдах чадварыг алдагдуулахгүйгээр байлдааны бэлэн байдалтай байлгах шаардлага зүй ёсоор тавигдсан бөгөөд шинээр ангиудыг зохион байгуулж өөрчлөх нь цаг хугацаа алдах байв. Мөн бүрэн бүрэлдэхүүнтэй байгаа 6 мд-ийг тараах нь тухайн үед ашиггүй байсан нь мэдээж юм.

Иймээс 8 мд-ийн бүрэлдэхүүнд орохоор томилогдсон ангиуд нь өөрсдийн харьяалалдаа хэвээр үлдэж оногдсон үүргээ гүйцэтгэж байв. Харин 18 мх нь 1936 оны 2 дугаар сарын 24-нд Бяруутаас хөдөлж 3 хоногийн дотор Матадад ирж байрласан² боловч дээрх байлдаануудад оролцоогүй байна.

Япон, Манжийн цэрэг 1936 оны 4 дүгээр сараас хойш манай хил хязгаарт халдан довтлох нь түр намжив. Энэ нь манай улсад халдан довтлох санаархлаа бүрмөсөн орхисон хэрэг биш бөгөөд Японы тал цэрэг зэвсгийн хүчээ зузаатгах, нөгөө талаар ЗХУ, БНМАУ-ын хооронд байгуулсан харилцан туслалцах протокол гэрээ зэрэг улс төрийн бодлогын нөлөөлөл, тухайн үеийн олон улсын байдал болон бусад олон талын хүчин зүйлийг харгалзан үзсэнтэй холбоотой юм.

Энэ түр амсхийлтийг ашиглаж манай улс батлан хамгаалах хүч чадлаа бэхжүүлэх талаар их анхаарал тавьж МАХЦ-ийн ангиудын орон тоог нөхөн хангаж, цэргийн ангиудыг шинээр байгуулах ажлыг эхлэв.

Энэ үед буюу 1936 оны 6 дугаар сарын 13-ны өдөр ЦЯЯ-ны сайд, Бүх цэргийн жанжнаас “8 мд-ийг шинээр байгуулах ба 6 дугаар дивизийг хаана байгуулах тухай”³ маш нууц 18 тоот тушаал гаргасан байна. Уг тушаалын 2 дугаар зүйлд “8 мд-ийг Матад суманд байгуулах тухай заасан ба түүний бүтэц, орон тоог тодорхойлохдоо:

1. 18 мх. Үүнийг одоо 22 мх хэмээн нэрлэнэ.
2. 20 мх. Үүнийг одоо 23 мх хэмээн нэрлэнэ.
3. 8 дугаар моторт хороо.
4. 8 дугаар дивизийн холбоо суман /үүнийг шинээр байгуулна/.
5. Дивизийн удирдлага /үүнийг шинээр байгуулна/.

Дивизийг зохион байгуулж дуусах хугацаа нь 6 дугаар сарын 20-ны өдөр. Холбоо суманг байгуулж дуусах явдлыг 7 дугаар сарын 15-ны өдөр тус тус гүйцэтгэсүгэй”³ гэжээ. Мөн тушаалаар 6 мд-ийн штабын дарга /үүний урьд 8 мд-ийн штабын даргаар томилогдсон/ хурандаа М.Гомбыг 8 мд-ийн даргаар түр,

¹Новиков В.М. Победа на Халхин голе. М.,1971. Стр 365

²БХТА, сх.1, д.3,хн.475. х.375

³БХТА, сх.1, д.1, хн.300, х.591-592

Ерөнхий сургуулийн штабын дарга хурандаа Д.Цолмонг 8 мд-ийн штабын даргаар түр томилсон байна.

Ийнхүү дивизийг шинээр эмхлэн зохион байгуулснаар 8 мд нь хурандаа М.Гончигжав, хорооны комиссар Ч.Баянмөнх нарын захирсан Бяруутын 18 мх, Хэнтийн 7 мд-ийн хурандаа Ж.Мижиддорж, дивизионы комиссар Гомбо нарын захирсан 20 мх, хурандаа Д.Дашцэрэн, дивизионы комиссар Б.Лхамжав нарын захирсан моторт хороо, ахлах дэслэгч Жадамба даргатай холбооны суман, ахлах дэслэгч Лувсанжамба даргатай бага даргын сургууль, гуравдугаар удирдагч Гомбосүрэнгийн удирдсан хөгжим ангиар бүрэлдэн 1936 оны 6 дугаар сард Дорнод аймгийн Матад сумын нутаг Хадан хөвийн баруун хойд талбай дээр байгуулагдсан түүхтэй.

Хүснэгт 2.1

8 мд-ийн байлдааны цагийн орон тоо, зэвсэглэл

Он	Бие бүрэлдэхүүн	Зэвсэглэл								
		Винтов	Автомат	Хөнгөн пулемёт	Хүнд пулемёт	50 мм-ийн миномёт	120 мм-ийн миномёт	45 мм-ийн их буу	76 мм-ийн их буу	Хуягт
1936	2671	25								
1939	2619	22		56	46			2*	15	10
1941	3745	12		66	32			6	8	27
1945	4169	19	32	101	36			12	12	29
		16	3	107	36	27	4	9	12	22
		20								
		44								

Тус дивиз зохион байгуулагдсан тэр жилдээ цэргийн байр, дарга нарын орон сууц, агуулах, агтны жүчээ зэргийг өөрсдийн хүчээр барьж босгон аж ахуй зохион байгуулалтын асар их ажил хийв. Бүх цэргийн жанжны 1936 оны намар явагдсан шалгалтаар 8 мд амжилттай шалгагдаж МАХЦ-ийн хэмжээнд 1 дүгээр байр эзлэн, Засгийн газраас алтан үсэгтэй хүндэт үнэмлэх, улаан тугаар шагнуулсан байна. Мөн хорооны комиссар Ч.Баянмөнх, улс төрийн удирдагч Чимиддорж нарын олон арван хүн одон тэмдгээр шагнуулжээ.

Өрлөг жанжин /маршал/ Г.Дэмид, түүний хамтран зүтгэгчдийн боловсруулсан “техникжсэн морьт цэрэг” байгуулах төлөвлөгөөний дагуу байгуулсан морьт дивизийн нэг нь 8 мд байсан юм. Ийм нэгтгэл нь тухайн цагийн байлдаан явуулах арга, монгол цэргийн хүч бололцоонд тохирсон, бие дааж маневрлах чадвартай, галын хүч сайтай нэгж байв.

1937 оны сүүлчээр Х.Чойбалсан цэргийн удирдлагыг гартаа авсныхаа дараа өмнөх зохион байгуулалтыг өөрчлөхдөө морьт дивизүүдийн моторт болон их бууны хороог татан буулгаж оронд нь хуягт болон их бууны дивизионыг байгуулж, дивизийг хоёр морьт хороотой болгожээ.

*37 мм-ийн пулемёт

Ийм өөрчлөлт, зохион байгуулалт нь Халхын голын дайнд олигтой үр дүн өгөөгүйг тэмдэглэвэл зохино. Харин Халхын голын дайны дараа 1940 оноос эхлэн морьт дивизүүдийг 3 морьт хороотой болгоход 10 мд-ийн 34 мх-г 8 мд-ийн бүрэлдэхүүнд нэмж оруулсан байна.

1939 оны 5 дугаар сарын 28-29-нд Японы цэрэг манай хилийг ихээхэн хүчээр цөмрөн орж 6 мд-ийн ангиудтай цус асгаруулсан ширүүн байлдаан хийсэн билээ.

Тус дивизийн дарга, цэргүүд Халхын голд Японы халдан түрэмгийлэгчидтэй 6 мд-ийн хийж буй байлдаан, түүний ялалт амжилтын талаар байнга мэдээлэлтэй байж, байлдаанд орж тулалдах хүсэлтээ хороо, дивизийн удирдлагадаа илэрхийлж байсан бөгөөд маршал Х.Чойбалсанг 1939 оны 6 дугаар сарын 14-нд тус дивиз дээр ирж дарга, цэргүүдтэй уулзахад ч "... манай эх оронд довтолсон япончуудыг цохиулахаар 5 дугаар сарын 28-нд биднийг явуулаагүйд бид үнэхээрийн гомдож байна. Бид өөрийн эх орныг хамгаалахыг хүсэх тул биднийг хил дээр явуулахыг хүсч байна"¹ гэж санал хүсэлтээ илэрхийлж байв. Тус дивиз 1939 оны 6 дугаар сарын 25-нд Бүх цэргийн жанжнаас тушаал авч 25-наас 26-нд шилжих шөнө Матадаас хөдөлсөн нь тодорхой байдаг.

Бүх цэргийн жанжны шифрээр өгсөн байлдааны тушаалаар 8 мд Матадаас гарч Ар булаг дахь дайсны хүчийг устгаад Буйр нуурын баруун талд Булан дэрс, Улаан худгийн районд очиж тэр чиглэлээр дайсныг нэвтрүүлэхгүй хориглон халхлах үүрэг хүлээсэн байна. Тушаал хүлээн аваад явах маршрутаа гаргаж галт хэрэглэл 5 ээлж, хүнс 5 хоногоор авч дарга, цэрэг нэг бүрийн хувийн бэлтгэлийг хангуулан хороо, ангиуд цуглаан хийх зэргээр богино хугацааны дотор байлдааны зохих хангалтуудыг хийж гүйцэтгэжээ.

Тус дивизийн фронт руу хөдөлсөн хүн хүч бүрэлдэхүүн нь:

- дивизийн бүх хүний тоо	1591
- бүх даргалах бүрэлдэхүүн нь	371
- Үүнээс: захиран командлах дарга	291*
улс төрийн тушаалтан	40
аж ахуй, эмнэлэгийн тушаалтан	40
- Жагсаалын цэрэг	1220
- агт морь	1723
- ажлын тэмээ	198
- 76 мм-ийн их буу	8
- дунд ба хөнгөн хуягт	18
- төрөл бүрийн автомашин	60
- тачанк болон ажлын хөсөг тэрэг	215 байв ² .

Дивизийг Матадаас хөдлөхөд шөнө, өдрийн турш бороо үргэлжлэн орж байсан учир нойтон шавартай зам нь хүнд ачаатай хөсөг тэрэг, их буу хөллөсөн морь, тэмээ бүхий цувааны хурд саарах, хоол хүнс, аргал түлш норох зэрэг бэрхшээлтэй учирч байв.

¹Ардын хувьсгалт цэргийн 20 жил. УБ., 1941. т.47

*Бага дарга нарыг оруулаад

²БХТА, сх. 16, д.4, хн.68, х.88

Адагдулаан, Буландэрсний орчимд дайсны нисэх онгоцууд дивизийн цувааг удаа дараа өдөр, шөнийн цагаар дайрч бөмбөгдөж байсан бөгөөд Адагдулаанд дайсны 2 нисэх онгоцыг 23 мх-ны агаарын салааны бууны дарга Хорлоогийн Амгалан, Сүрэнгийн Чүлтэм нар анх удаа сөнөөжээ¹.

Тус дивиз маршаар явж байх үедээ Арбулагийн орчим буй дайсны хэсэг хүчийг устгуулахаар 22 мх-ныхоо хагасыг явуулсан байдаг. Хорооны дарга ахмад Р.Бадарчид дайсны хүчийг устгаад Буландэрсний орчим дивизтэйгээ эргэн нийлэх тушаал өгч Адагдулаанаас явуулжээ. Тус хороо дивизийн даргаас өгсөн эл тушаалыг амжилттай биелүүлж дайсны 30-аад хүнийг устган 26 морь, олон тооны буу, сэлэм, сум хэрэглэлийг 4 барга цэргийн хамт олзлон авчирсан байна. Энэ тухай тус хорооны комиссар байсан Е.Цэдэн-Иш, дивизийн дарга агсан Д.Нянтайсүрэн нарын дурдатгалд л товч дурдсанаас өөр тодорхой баримт хараахан олдоогүй байна.

Маршийн 3 дахь өдрөө 8 мд заагдсан газар Буйр нуурт хүрч хориглолтын бэлтгэл хийж гурав хоножээ. Тэндээсээ дээд командлалын тушаалаар Сүмбэрийн Цагаан нуурын чиглэлд 140 гаруй км газар марш үйлдэж Баруун, Зүүн Хан уул, Хэрээ уулын хавьд очихоор 7 дугаар сарын 1-нд хөдлөв. Өдөр шөнөгүй явсаар 2-ны өдөр Хан уул, Хэрээ уулын орчимд ирээд байтал командлалын дараагийн тушаал ирж Хамар давааны чиглэлд буцаж дахин марш хийжээ².

Маршаар явж байхад тохиолдсон эмгэнэлтэй бөгөөд өнөөг хүртэл тодорхой ярьж ирээгүй нэг үйл явдал бол улаан таван хошуутай гэгдэх нисэх онгоцнууд дивизийг бөмбөгдөж хүн хүч, эд материалын их хохирол үзсэн явдал юм. Энэ үйл явдлын талаар Халхын голын дайнд Бүх цэргийн жанжны орлогчоор ажилласан Ж.Лхагвасүрэн агсан өөрийн дурдатгал номд "... манай фронтын баруун жигүүрийг хангах 8 мд хүрэх газраа 10-аад км ойртож явтал дайсны нисэх онгоцны дайрагч хороо довтолж 82 хүний амь хохироожээ...очиж шалгавал...дайсны онгоцны дайралтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг дивизийн удирдлага аваагүйгээс ийм аюул учирчээ. Энэ хэрэг явдал Хэрээ уулын баруун хойно болсон юм"³ гэж бичсэн байдаг.

Ийнхүү 8 мд дайсны нисэх онгоцонд бөмбөгдүүлсэн гэх ойлголт ном, сонин хэвлэлд цухас төдий дурдагдсаар өнөө үеийг хүрч ирсэн юм. Гэтэл уг үйл явдлыг нүдээр үзсэн тус дивизийн ахмад дайчдын дурдатгалд Хэрээ уулын хавьд далавчин дээрээ тод улаан өнгийн таван хошуутай нисэх онгоцнуудад бөмбөгдүүлсэн тухай олонтаа дурдсан байдаг⁴.

Энэ болсон явдлын талаар дивизийн дарга агсан Д.Нянтайсүрэн 1969 онд бичсэн дурдатгалдаа арай дэлгэрэнгүй дурдсан байдаг юм. Тэрээр "...орлогч жанжин Ц.Лувсандоной 6 дугаар сарын 23-нд ирж танай дивиз 25 гэхэд Хэрээ уулын районд очсон бай гэсэн ба тэр шөнөдөө маршлан 25-ны шөнө агт морьдоо нэлээн сульдаан явж хүрлээ. 26-ны өглөө 10 цагийн орчим орлогч жанжин Лувсандоной ... Зөвлөлтийн нэг

¹БХЯ-ны ЭШХ-ийн фондод буй ахмад дайчдын дурдатгалууд

²БХТА, сх.1, д.3,хн.475, х.85

³Монголын Ардын Армийн 50 жил. УБ., 1971, т.37

⁴Монголын Ардын Армийн 50 жил. УБ., 1971, т.674

бригад командлагч, хоёр хошууч, манай яамны бололтой хоёр дарга бүгд ийм 6 хүмүүс суудлын хоёр машинаар ирлээ. Зөвлөх Петросянц бид хоёр Буйр нуураас маршаар ирсэн байдал, ирээд хийж байгаа ажлаа илтгэлээ. Тэгтэл дэслэгч жанжин миний яриаг таслан одоохон дивизээ түргэн дохиогоор хөдөлгөж Сүмбэрийн овоо чиглүүлэн замд оруулаад нэмэгдэл тодорхой үүргээ надаас ав. Бид эндээ байна гэж хэлээд өөрсдөө юм идэх гэж байгаа бололтой байв. Зөвлөх бид хоёр газрын зураг дэлгэж штабын дарга З.Дашдорж, сургагч Исаев нартай хамтран Сүмбэрийн Цагаан овоог эрж олсон чинь буцаад л хойшоо Хамар давааг чиглэн явах болжээ. Ингээд дивизийг зэргэлдээ 2 маршрутаар ... маршлахаар тушаал өгсөн ба дивизийг бүхэлд нь штабын дарга, сургагч нарт хариуцуулан хөдөлгөж өгөөд комиссар О.Дандгай, мөн зөвлөх Чернико, Петросянц бид дэслэгч жанжин дээр иртэл зургаа гарга гэлээ.

Дайсны ажиллагаа ширүүн байна. Танай дивиз Сүмбэрийн харуул, Хамар давааны районд очиж түр байрлах ба тэр орчмоор Халхын гол гарч байлдааны үүрэг гүйцэтгэхэд бэлэн бай гэж тушаасныг бид зурагт оруулж авав. Яг тэр үед нисэх онгоцны чихэнд чийртэй дуу гарлаа. Чагнавал бидний байгаагаас хойгуур хэд хэдэн онгоцны дуу бүүр ч тод болов. Гэтэл бөмбөг тэсрэх нь улам хүчтэй сонсогдлоо. Манай цувааг л бөмбөгдөж байх шиг байна. Би явах уу гэтэл ... яв гэлээ.

Зөвлөх бид маш түргэн явж Дугаржавын хороон дээр очлоо. Хороо тарчихсан тэнд ямар нэг аюулгүй байв. Гэтэл нэг дарга 22-ын тэнд л сүйд болох шиг боллоо гэхээр нь тэр зүг яваад очтол баахан бужигнаж үймэрсэн хүн тааралдав. Юу болов, дарга чинь хаана байна? гэж асуух зуур дарга, цэргүүд ам амандаа 3 дугаар суманг онгоц бөмбөгдөөд явсан гэх зэргээр хариулахыг хагас дутуу сонсонгуут айж бачимдсандаа яах учраа мэдсэнгүй нэг мэдэхнээ тэр аюул нөмөрсөн газар яваад хүрчихсэн байж билээ. Гэтэл тэнд дивизийн комиссар, штабын дарга, мөн хорооны дарга Р.Бадарч, комиссар Е.Цэдэн-Иш, штабын дарга П.Жамбал нар очсон ба эмнэлэгийн хүмүүс ч эрвийх дэрвийхээрээ ажиллаж харагдав.

Бөмбөгдүүлсний учрыг сонсоход улаан таван хошуутай 9 онгоц явахаар нь манайх юм гэж байтал гэнэт бөмбөгдөж сүйд хийлээ гэж байв. ...Хорооны штабын гаргасан мэдээгээр 3 дугаар сумангийн дарга Дашчойжил алагдаж бусад алагдаж, шархадсан хүн 60 шахам болжээ гэж байв. Мөн алагдаж шархадсан агт тэмээ, идэшний үхэр нэлээд байв”¹ гэсэн байдаг.

Ингэхээр дээр дурдсан Хэрээ уулын хавьд бөмбөгдүүлэн хохирол үзсэн явдал 6 дугаар сарын 26-нд болоогүй нь тодорхой. Улаан таван хошуутай онгоцнуудад бөмбөгдүүлэн, ялангуяа 22 мх их хохирол үзсэн гэх энэ үйл явдал чухам хэдийд болов? гэдгийг нягтлан судлах шаардлага одоо хэр байсаар байна. Тэрхүү үйл явдлын дараа орлогч жанжин Ц.Лувсандоной эх орноосоо урваж 8 мд-ийг зориуд бөмбөгдүүлсэн гэх үг яриа гарч тэрээр “эсэргүү, урвагч” нэр зүүж удалгүй баригдсан ажээ.

¹БХТА, сх.16, д.4, хн.98. х.77-78

Архивт буй зарим нэгэн баримтанд "...7 дугаар сарын 2-нд Японы 50 гаруй онгоц ирж бөмбөгдсөн"¹, мөн "... 7 дугаар сарын 3-нд Хан уулаас хойш 5-6 км явж байтал дайсны 12 тооны бөмбөгдөгч онгоц дайралт хийж 22 дугаар хороо ба ар тал, агт малыг бөмбөгдөж нэлээд хохирлыг учруулсан"²гэх зэргээр Хэрээ уулын хавьд бөмбөгдүүлсэн явдлыг цаг хугацааны хувьд зөрүүтэйгээр тэмдэглэн бичсэн байна. Тэрчлэн Оросын Холбооны Улс /ОХУ/-ын архивт 7 дугаар сарын 3-ны өдөр 8 мд-ийг дайсны 15 бөмбөгдөгч, 10 хүртэл тооны сөнөөгч онгоц дайрч бөмбөгдсөний улмаас 23 хүний амь үрэгдэж, 52 хүн шархдан, 229 агт морь, 82 үхэр, тэмээ алагдаж, шархадсан³ гэх баримт ч байдаг.

Гэтэл Халхын голын дайнд тус дивизээс нас барсан, шархадсан хүмүүсийн бүртгэлийг шүүж үзвэл "7 дугаар сарын 2-нд маршаар явж агаад бөмбөгт өртсөн"⁴гэсэн тайлбар олонтаа тааралдах бөгөөд тус дивизийн хүн хүчний хувьд учирсан хамгийн анхны бөгөөд их хэмжээний хохирол нь энэ өдөр байдаг. Үүнээс үзвэл тус дивиз 7 дугаар сарын 2-ны өдөр Хэрээ уулын орчимд бөмбөгдүүлж дээрх харамсалтай үйл явдал болсон гэж үзэж болох юм.

Энэ бөмбөгдөлтөд дивизийн штабаас 3 хүн, холбоо сумангиас 6 хүн, химийн салаанаас 1 хүн шархдаж, 22 мх-ноос 14 хүн амь үрэгдэн, 38 хүн шархдаж, 23 мх-ноос 3 хүн амь үрэгдэн, их бууны дивизионоос 4 хүн амь үрэгдэж 17 хүн шархдан, бүгд 21 хүн амь үрэгдэж 65 хүн шархдан нийтдээ 90 шахам хүний хохирол үзсэн байна⁵. Энэхүү бөмбөгдөлтөд 22 мх, их бууны дивизион, дивизийн ар тал илүүтэй өртөж багагүй хэмжээний агт мал, зэвсэг, эд хогшлын хохирол учирчээ.

Тэгэхээр 8 мд-ийн Хэрээ уулын орчимд бөмбөгдсөн улаан таван хошуутай онгоцнууд нь манайх уу, дайсных уу гэдэг нь одоо болтол таамаг хэвээрээ үлдэн, дайсны онгоц биднийг залилан мэхэлж бөмбөгдсөн, энэ бол Лувсандоной эсэргүүгийн хийсэн ажил гэж тухайн үедээ цэрэг, дарга нарт ухуулж ирсэн байна.

Гэвч өнөөгийн цаг үеийн нөхцөл байдалд Халхын голын дайны түүхийн зарим нэг асуудлыг бодитойгоор авч үзэх, түүний дотор энэ үйл явдлын үнэн учрыг ил гаргаж тавих шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа юм. Түүхэн үнэнийг сэргээх талаар сүүлийн үед Монгол, Орос, Японы түүхч, судлаачид багагүй ажлыг хамтран хийж байгаа билээ.

Ер нь ч Японы нисэх онгоцууд өөрийн таних тэмдгийг өөрчилж улаан таван хошуу тэмдэгтэйгээр фронтын шугамыг даван 8 мд-ийг бөмбөгдсөн гэх үндэслэл тун бага бөгөөд өнөө болтол ийм баримт Японы талд ч, манай талд ч гарч ирээгүй юм. Харин орос сургагч гэж Зөвлөлтийн цэргийн хувцас өмссөн хорлон сүйтгэгч нар фронтын шугам давж ирэн хорлон сүйтгэх ажиллагаа явуулж байсан баримт бол байдаг⁶.

¹БХТА, сх.1, т.3,хн.475, х.35

²БХТА, сх.1, т.3,хн.475, х.6

³РГВА, ф. 32113, оп.1, д.672. стр 127

⁴БХТА, сх.16, д.4,хн.65, х.17

⁵БХТА, сх.16, д.4,хн.65, х.17

⁶БХТА, ф.16, т.4,хн.2. х.11

Зөвлөлтийн нисэх онгоц андуурч бөмбөгдсөн гэх архивын нотлох баримт одоогоор гарч ирээгүй ч уг үйл явдлыг нүдээрээ үзсэн ахмад дайчид яахын аргагүй улаан таван хошуутай онгоцнууд байсан гэж ярьдаг ба үүнийгээ тэр бүр ил гаргаж хэлж ирсэнгүй нь тухайн цаг үеийн байдал ямар байсантай холбоотой нь мэдээж. Харин сэтгэлийнхээ мухарт Зөвлөлтийн онгоц биднийг бөмбөгдсөн юм биш биз гэсэн эргэлзэх бодолтойгоор нэлээд нь ертөнцийн мөнх бусыг үзжээ.

Тэр үед фронтод Зөвлөлтийн олон тооны нисгэгч нар, нисэхийн ангиуд шинээр ирээд байсан үе байв. Магадгүй шинэ нисгэгчид фронтод дөнгөж ирсэн 8 мд-ийг дайсны морин цэрэгтэй андуурсан, 8 мд ч нисэх хүчинтэй харилцан ажиллах дохио тэмдгийг мэдээгүй, мэдэж байсан ч фронтын бараг ар талд байрлаж байсан болохоор улаан таван хошуутай онгоцыг өөрсдийнх байна гээд дохио тэмдэг өгөлгүй тайвширснаас бөмбөгдүүлсэн байж болох билээ. Тухайн үедээ туслан хамгаалах үүрэг хүлээсэн Зөвлөлтийн улаан армийн нисэх хүчин Монголын морьт дивизийг эндүүрч бөмбөгдсөн гэж албан ёсоор зарлах нь Монгол, Зөвлөлтийн ах дүүгийн найрамдал, цэргийн хамтын ажиллагаа, цаашилбал социализмын нэр хүндэд харшлана гэж үзэж мөн тэр үеийн удирдах албан тушаалын зарим нэг хүмүүсийн нэр хүндийг хамгаалахын үүднээс уг үйл явдлыг нууж дарагдуулан, хэрэв ярихад хүрвэл дайсан заль мэх хэрэглэн бөмбөгдсөн гэж ярьж, бичдэг болсон гэхэд үгүйсгэх аргагүй. Тэгээд ч энэ үйл явдлын бодит үнэнийг олон түмнээс нууж хаацайлахын үүднээс орлогч жанжин агсан Ц.Лувсандонойг золиосолж хэлмэгдүүлсэн ч байж болох талтай.

Тэр үед /1939 оны 7 дугаар сард/ фронтын бүлгийн командлалаас Батлан Хамгаалах Ардын Комиссарт явуулсан мэдээ болон Армийн 1 дүгээр бүлгийн ангиудын бэлтгэл, байлдааны ажиллагааны явцыг шалгасан актад "... нисэх ангийн, ялангуяа СБ /хурдан бөмбөгдөгч онгоц-зох/ онгоцны ангийн газрын цэрэгтэй барих холбоо маш муу байна. СБ онгоцны бригадад газрын цэргийн байрлалын зураг ч алга..."¹, "... манай нисэх хүчний байлдааны ажиллагаа нь газрын цэргийн ажиллагаанаас тасархай байна..."² гэсэн дүгнэлт өгсөн нь дээр дурдсан Хэрээ уулын хавьд болсон үйл явдалтай ямар нэгэн хэмжээгээр холбоотой байж ч болох юм.

Хэрээ уулын орчмоос 8 мд хөдлөн командлалын тушаал ёсоор 7 дугаар сарын 3-нд Сүмбэрийн Цагаан нуурт ирж хүч хуралдуулав. Энэ өдрөөс эхлэн тус дивизийн хуягт дивизион болон 23 мх-ны зарим сэлэмт сумангууд байлдааны ажиллагаанд оролцож эхэлсэн юм.

Баянцагааны чиглэлээр дайсны довтолгоон ширүүсч цагийн байдал ноцтой хүндэрч байсан үед 8 мд фронтод ирээд Зөвлөлт, Монголын цэргийн баруун жигүүрт хүч хуралдуулаад байв.

8 мд 7 дугаар сарын 6-ны өдөр бүрэн бүрэлдэхүүнээрээ анхныхаа байлдаанд оров. Энэ өдөр тус дивиз дайсны байрлал руу Зөвлөлтийн 603

¹ БХЯ-ны ЭШХ-ийн фондод буй "Халх гол-хагас зуунтэртээг шинээрхарахад" /баримт бичгийн эмхтгэл/номын эх. УБ., 1989. т.155

² БХЯ-ны ЭШХ-ийн фондод буй "Халх гол-хагас зуунтэртээг шинээрхарахад" /баримт бичгийн эмхтгэл/номын эх. УБ., 1989. т.172

дугаар буудлагын хорооны нэг батальоны хамт давшиж дайсны хоёр салаа орчим амьд хүчийг устган 1 хүнд, 3 хөнгөн пулемёт олзлов. Долооны өдөр дахин давших байлдаан явуулж дайсны явган цэргийн суман хүртэл хүч, их буугаар хүч нэмэгдүүлсэн 2 салаа орчим хүчний эсэргүүцлийг няцаажээ. Орой нь 19 цагийн орчимд дайсны 2 суман хээрийн хүч дивизийн байлдааны журмын зүүн жигүүрийг тойрч гарахаар оролдоход цэргүүд сандралд орсноор эмх журамгүй ухран Номон хан, Бүрд овооноос баруун тийш 8 км-т Элсний районд ирж бэхжисэн байна¹. Наймны өдөр тус дивиз командлалын тушаалаар эхлэх байрандаа ирж бэхжив.

Японы цэргийн довтолгоон улам ширүүсэн Зөвлөлт, Монголын цэргүүд Халхын голын зүүн эрэгт өдөр, шөнөгүй цус асгаруулан байлдаж байлаа. Дайсан шөнийн цагаар хүртэл гэнэтийн атакуудыг удаа дараа хийж байв. 7 дугаар сарын 13-ны өдрийг хүртэл 8 мд дайсны удаа дараагийн давшилтыг няцаахын зэрэгцээ, завсар, үзүүрээр нэвтрэхийг оролдсон дайсантай хориглох байлдаан явуулан байрлалаа хамгаалсаар байв.

8 мд-ийг Халхын голын зүүн эрэгт гарсны дараа командлалаас дайсны түшиц газар болох Нуурын овоог эзлэн авах тушаалыг дивизийн дарга хурандаа Г.Эрэндоод өгчээ. Морьт хороод 7 дугаар сарын 19-ны орой их бууны галын дэмжлэгийн дор дайсны зүг давшиж эхлэв. Давшилтын үр дүнд Халхын голын зүүн эргийн элсэн манханд хориглож байсан Баргын морин цэргийн хороо, явган цэргийн суманг 22 мх, хязгаарын 7 дугаар заставын хамт давшин ухрааж буу зэвсэг, амьд хүч нэлээдийг олзлов². Мөн 23 мх ч бага зэрэг урагшлав. 20-ны өглөө их бууны галын бэлтгэл хийсний дараа 23 мх Нуурын овооны зүг давшиж хэд хэдэн удаа дайралт хийсэн боловч амжилт олсонгүй. Тэр шөнөдөө хүч сэлбэж байлдааны журмаа өөрчлөн 21-ний өглөө фронтын их бууны галын дэмжлэгтэй дайралт хийж ширүүн байлдсаны эцэст Нуурын овоо болон түүний орчмын өндөрлөгүүдийг эзлэн авч командлалын тушаалыг биелүүлэв. Тактикийн хувьд ихээхэн ашигтай, чухал түшиц газар Нуурын овоог эзлэн авсанаар дайсны хориглолтын урд зах, зүүн үзүүр нь тодорхой болов. 23 мх энэхүү өндөрлөгийг дайсанд алдахгүйн тулд 20 гаруй хоног хориглон хамгаалсан юм. Сүүлийн өдрүүдэд нь дайсны бүслэлтэд орж ар талаасаа таслагдан хүнд байдалд орсон боловч Зөвлөлтийн ангийн тусламжаар бүслэлтээс гарчээ.

Долдугаар сарын сүүлийн хагаст болсон удаа дараагийн байлдаануудад тус дивизийн олон арван дарга, цэрэг эрэлхэг зоригтой байлдаж шалгарч байснаас 22 мх-ны хүнд пулемётын наводчик Намжилсүрэн дайсны нэг явган суман цэргийг устгахад онц гарамгай байлдан³, 23 мх-ны бууны дарга Х.Амгалан Японы нэг нисэх онгоцыг сөнөөсний гадна мөн хорооны дарга Ч.Дугаржав штабынхаа 20 орчим цэрэг, дарга нарыг удирдан дайсан руу довтолж 83 цэрэг, офицерыг буулган авч байв.

¹РГВА, ф.32113, оп.1, д.672, стр. 459

²БХТА, сх.16, д.4, хн.61. х.63

³Улаан од. 1964.08.20.№100.

Бүх цэргийн жанжин Х.Чойбалсан 7 дугаар сарын дундуур тус дивиз дээр ирж дарга, цэргүүдтэй уулзан дивизийн байлдааны ажиллагаатай танилцсан юм. Тэрээр 8 мд-ийн байлдааны үйл ажиллагааг өндөр үнэлж онц гарамгай байлдаж буй хорооны дарга Ч.Дугаржав, пулемётчин Зана, салааны дарга В.Шарав нарын хүмүүсийн байлдааны амжилтыг сайшааж Улаан тугийн одонгоор шагнуулах хүсэлтээ Улсын Бага Хуралд оруулна гээд тэдгээр дарга, цэргүүдийг “Эх оронч” улс гэж үнэлж байжээ.

Армийн 1 дүгээр бүлгийн командлал дайсны бүлэглэлийг устгах давшилтын ажиллагааг 8 дугаар сарын 20-нд буюу дайснаас 4 хоногийн өмнө эхлэхээр шийдвэрлэжээ. Операцийг хэрэгжүүлэхийн тулд “Өмнөд”, “Хойд”, “Төв” гэсэн 3 бүлгийг зохион байгуулав. “Өмнөд” бүлгийн бүрэлдэхүүнд 8 мд болон хуягт салаа, их бууны батарейгаар хүч нэмэгдүүлсэн 5 мд-ийн 14 мх орсон юм. 8 мд, түүнд хүч нэмэгдүүлж өгсөн 14 мх-нд “Өмнөд” бүлгийн баруун жигүүрийг хамгаалж Манжийн морин ангиудыг хилээс хөөн гаргах, Хулд уулын овоо, Эрс уулын хоорондох заагийг эзлэн аваад тогтоон барьж байх үүрэг тавигдав.

Долдугаар сарын сүүлээр болсон байлдааны дараа Армийн 1 дүгээр бүлгийн командлагч Г.К.Жуков, Бүх цэргийн жанжны орлогч, Улс төрийн газрын дарга, корпусын комиссар Ж.Лхагвасүрэн нар тус дивиз дээр ирж байдалтай танилцан дайсныг урагш ахиулахгүй барьж дайралтыг няцаан өдөр бүр “амьд хэл” барьж байх үүрэг өгчээ.

Наймдугаар сарын 7-ны өдөр тус дивизийн удирдлагад Армийн 1 дүгээр бүлгийн командлалаас урагш дайралт хийж хэд хэдэн нэргүй манхануудыг эзлэн авч дайсны хориглолтын галын систем, их буу, пулемётын галын цэг, зангилаанууд болон дайсны хүч хэрэгслийг илрүүлэх зорилгоор байлдан тагнах ажиллагаа явуулахыг тушаав. Зөвлөлтийн их бууны 3 батарей, өөрийн их бууны дивизионы хүчээр богино хугацаанд галын бэлтгэл хийж 8-ны өглөө дивиз давшилтанд оров. Хүчтэй хориглосон дайсны галтай тулгарч амжилт багатай байсан боловч шаргуу байлдсаны дүнд зарим газраар дайсны хориглолтыг сэтлэн 22 мх өөрийнхөө өмнө байсан Японы явган цэргийн бүлэглэлийг шахан ухруулж Нуурын овооноос зүүн хойш 10 км-т буй Элсэн толгодыг эзлэв. Энэ өдрийн байлдаанд 22 мх-ноос 1 хүн шархдаж, 23 мх-ноос 12 хүн шархдан, 2 хүн алагдсан байна¹.

Наймнаас есөнд шилжих шөнө 22 мх Японы 64 ях-ны жижиг бүлгүүдийг шахан ухрааж Элсэн толгодын өмнөд хэсгийг эзлэн авчээ. Ийнхүү 8 мд-ийн хороод байлдан тагнах ажиллагааны үр дүнд дайсны хориглолтын систем, галын цэгүүдийг илрүүлэн командлалын тушаалыг биелүүлэв. Удалгүй фронтын штабаас давшилтыг зогсоох тушаал ирж эзэлж авсан заагууд дээрээ бэхжин хориглов.

Энэ байлдаанд багагүй хохирол үзсэн дайсан манайд алдсан зарим түшиц газраа эргүүлэн авах зорилгоор хэд хэдэн удаа тус дивизийн байрлал руу довтлов. Тухайлбал, “...8 дугаар сарын 10-ны шөнө 22 ба 23 дугаар хорооны баруун, зүүн гараар дайсны хэсэг морин цэрэг хүнд, хөнгөн пулемётын хамтаар ар талаар ирж манай их бууны батарей ба хүч нэмэгдүүлсэн ангийн

¹БХТА, сх. 16, д. 4, хн. 37. х. 138

их бууны батарейнуудыг дайрсан байна. Үүний улмаас 3 цэрэг шархдан, хэд хэдэн морьд алагдаж, шархаджээ¹.

Мөн 13-ны өдөр дайсан томоохон хүчээр довтлов. Үүрээр дайсны жижиг бүлгүүд 22 мх-ны ар талд гарахыг оролдсон боловч тэднийг ухрааж нэг бүлгийг нь устгажээ. Удалгүй Японы тал их бууны 3 батарей, 3 хуягт машинаар дэмжүүлэн явган цэргийн хоёр батальон хүртэл хүчээр 22 мх-ны хориглолтын хэсэг рүү довтлов. Фронтын командлалаас 8 мд-д хүч нэмэгдүүлж Зөвлөлтийн 293 дугаар буудлагын хорооноос хоёр рот, Т-27 танкийн ротыг өгч, мөн 575 дугаар артиллерийн хорооны нэг дивизион галын дэмжлэг үзүүлсэн байна. Энэхүү хүнд ширүүн байлдаан бүтэн өдөр үргэлжилж орой гэхэд дайсан хүчээр түрэн Их элсэн толгодыг эзлэн авч 22 мх 4 км орчим ухран хуучин байрлалдаа ирж хориглосноор байлдаан зогсов². Дайсан дахиж давшсангүй. Харин 8 дугаар сарын 15-ны орой, 16-ны үүрээр жижиг хэмжээний бүлгүүдээр, өдөр нь их буугаар дэмжүүлсэн батальон хүртэл хүчээр дахин давших оролдлого хийсэн боловч манай галын хүчинд няцаагдсан байна. Тус дивизээс 13-ны өдрийн байлдаанд 5 хүн алагдаж, 20 хүн шархдан, 10 хүн ор сураггүй алга болсноос зөвхөн 22 мх-ноос 2 хүн алагдан, 15 хүн шархдаж, 9 хүн ор сураггүй болж, 45 мм-ийн танк эсэргүүцэх их буу, хүнд, хөнгөн пулемёт, винтов, сэлэм зэрэг нэлээд хэмжээний байлдааны эд хогшил, сум галт хэрэгсэл үрэгджээ³.

Армийн 1 дүгээр бүлгийн командлал ерөнхий давшилтын бэлтгэлийг хангагдсан гэж үзэн жигүүрийн цохилтын бүлэглэлийн цэргийн хүчийг хуралдуулах, тэдгээрийг дашилт эхлэх газарт шилжүүлэх ажлыг зөвхөн 8 дугаар сарын 19-20-ны шөнө хийв. Энэ шөнө 8 мд хориглон хамгаалж байсан байраа Зөвлөлтийн 57 дугаар буудлагын дивизэд шилжүүлэн өгч “Дархан уул, Цагаан овооны районд хүч хуралдуулан 14 мх, 6 дугаар танкийн бригадын буудлагын рот, хоёр хуягт дивизион, их бууны батарейгаар хүч нэмэгдүүлэн Эрс улаан, Хулд уулыг эзлэн бат барьж Хан ширээ, Жанжин сүмийн чиглэлд тагнуулыг хүчтэй явуулах”⁴ командлалын тушаалыг хүлээн авсан байна. Шөнөдөө багтаж байраа шилжүүлэн өгөөд 20-ны үүрээр заасан районыг эзлэн авав.

Дивизийн давших чиглэл болох Эрс ба Хулд уулын заагаар Манжуурын холимог явган бригад, их бууны дивизион, танк эсэргүүцэх ангиуд, мөн Хулд уулын районд “3000 шахам явган цэрэг, морин цэргийн 2 суман, 2 их буу, 10 хуягт, 60 танк бүхий хүч хориглож байгаа нь тагнуулын мэдээгээр илэрсэн” байна⁵. Зөвлөлт, Монголын цэргийн их бууны галын бэлтгэл 8 дугаар сарын 20-ны өглөөний 5 цаг 45 минутанд эхэлж 150 бөмбөгдөгч, сөнөөгч онгоцоор дайсанд цохилт өгч эхлэв. Нисэх онгоц, их бууны гэнэтийн хүчтэй цохилт нь үр дүнгээ өгч дайсны тал бүтэн хагас цагийн турш хариу гал нээж чадсангүй. Энэ хүчтэй цохилт нь манай цэрэг, дарга нарын санаа сэтгэлийг өндөр өргөв.

¹БХТА, сх.16, д.4,хн.37. х.107

²РГВА, ф.32113, оп.1, д.259. 57

³БХТА, сх.16, д.4,хн.37. х.111-112

⁴БХЯ-ны ЭШХ-ийн фондод буй “Халх гол-хагас зуунтэртээг шинээрхарахад” /баримт бичгийн эмхтгэл/номын эх. УБ., 1989.

⁵БХТА, сх.16, д.4,хн.39. х.93

Өглөөний 9 цагт бүх фронтоор Зөвлөлт, Монголын цэрэг шийдвэрлэх давшилтанд оров. Давшилтын эхний өдөр “Өмнөд” бүлгийн цэрэг их амжилт олсон бөгөөд 8 мд дайсны хориглосон ангиудтай амжилттай байлдан өмнөө байсан Баргын морин болон явган цэргийн ангиудыг түрж Эрс ба Хулд уулын заагийг эзлэн авч улсын хилд хүрэв. Энэ өдөр 23 мх эрчимтэй давшилтаар өмнөө байсан явган батальон орчим хүчийг байлдан ухруулсаар Эрс уулыг эзлэн авав. Давшилтын 2 дахь өдөр 22 мх Хулд овооны зүг давшин байлдаж километр хагас хэртэй зайнд ойртон очив. Манай тал болон дайсны зүгээс 22-ны өдөр идэвхитэй ажиллагаа явагдсангүй. Тус дивиз 24-ны өдөр танкийн ротын дэмжлэгтэй хориглосон дайсныг байлдан ухруулсаар Хулд уулын овоог эзлэн авч БНМАУ-ын нутаг дэвсгэрээс дайсныг хөөн гаргав. Энэ өдрийн байлдаанд дайсны штабын баримт бичгүүд, 4 миномёт олзлон авч, манай талаас нэг цэрэг алагджээ¹. Тус дивиз давшиж эзэлсэн газраа бэхжин хориглож дайсны хэсэг бүлэг дайралтыг няцааж цохисоор байв.

Зөвлөлт, Монголын цэрэг 8 дугаар сарын 23 гэхэд Японы цэргийг бүрэн бүсэлж дуусав. 8 мд Эрс ба Хулд уулын овоо, түүнээс баруун хойш хилийн дагуу баруун жигүүрийг Халхынлан, түүний өмнө Манжийн цэргийн холимог бригадын үлдэгдэл хориглосон хэвээр байв. Дайсан 8 дугаар сарын 24-27-нд бүслэгдсэн бүлэглэлийнхээ үлдэгдлийг дотор ба гаднаас нь чөлөөлөх гэсэн оролдлогуудыг хүчтэй хийв. Японы цэрэг 25-ны өдөр “Өмнөд” бүлгийн хэсгээр бүслэлтийг сэтлэхийнтулд шинэ хүчээр хэд хэдэн удаа сөрөг атак хийж Зөвлөлтийн 80 дугаар буудлагын хорооны өмнө зүг хэдэн зуун метр газар ухрааж амжив. Мөн 8 мд-ийн байрлалаар дайсан “Өмнөд” бүлгийн жигүүр ба ар талд гарах зорилгоор сөрөг давшилт явуулахыг оролдов. Наймдугаар сарын 26-нд шилжих шөнө 23 мх давшиж буй дайсанд хүчтэй цохилт өгч улмаар Эрс уулын районд байсан Манжийн цэргийн ангийг устгаснаар дайсан бүрэн сарнин бутрав. Фронтын хэмжээгээр 8 дугаар сарын 24 гэхэд дайсны эсэргүүцлийн 3 том зангилаа үлдсэн байв. Армийн 1 дүгээр бүлгийн командлалаас 8 дугаар сарын 27-ны өдөр бүслэгдсэн дайсныг бүрмөсөн устгах тушаалыг бүлгийн цэрэгт өгөв. Уг тушаалаар 8 мд нь 14 мх, хуягт дивизионтойгоор Эрс улаан, Хулд уулын овооноос баруун хойш 8 км-т улсын хилийн хэсэгт хориглож, дайсныг БНМАУ-ын нутаг дэвсгэрт нэвтрүүлэхгүй байж нэвтэрсэн тохиолдолд устгах, улсын хилд хүч нэмэгдүүлсэн салаагаар бүрдсэн 5 застав гаргаж Хулд уулын өндөрлөгт морьт суман тавих² үүрэг хүлээсэн байна.

Халхын голын дайны түүх бичлэгт 8 дугаар сарын 31-нийг хүртэлх хугацаанд болсон үйл явдлуудыг голчлон авч үзэж энэ үеэр л Халхын гол дахь дайны ажиллагаа дууссан мэтээр тусгаж ирсэн байдаг. Харин 9 дүгээр сард 8 мд болон хилийн заставууд оролцсон их бага хэмжээний байлдааны ажиллагааг орхигдуулж зарим байлдааныг гуйвуулан үзэх хандлага гарч байсан юм. Тухайлбал, 22 мх-ны Нөмрөгийн голд хийсэн байлдааныг олон жилийн турш зөвхөн нэг талыг барин үнэлэлт өгч бодит байдлыг үгүйсгэсээр ирсэн юм.

¹БХТА, сх.16, д.4,хн.12. х.2

²БХЯ-ны ЭШХ-ийн фондод буй “Халх гол-хагас зуунтэртээг шинээрхарахад” /баримт бичгийн эмхтгэл/номын эх. УБ., 1989. т.237

Армийн 1 дүгээр бүлгийн командлагчийн 8 дугаар сарын 27-нд өгсөн тушаал ёсоор Зөвлөлт, Монголын цэрэг 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөргөлдөөний районд улсын хилийн дагуу хориглолтод шилжиж өөрийн байрлалыг бэхжүүлэх ажилд эрчимтэй оржээ. Хэдийгээр бут цохигдсон ч гэсэн дайсан хүчтэй хэвээр байв. Ялангуяа Эрс овоо, Номонхаан, Бүрд овооны хоорондох хилийн хэсгийг онцгой бэхлэх хэрэгтэй байв.

Бүх цэргийн жанжин маршал Х.Чойбалсан 9 дүгээр сарын эхээр фронт дээр ирж тус дивизийн дарга, цэргүүдтэй 2 дахь удаагаа уулзав. Тэрээр “8 мд нь эх орныхоо өмнө өөрийнхөө үүргийг хангалттайгаар биелүүлж чадаж байна. Ийм учраас тус 8 мд-ийг улсын гавьяаны дээд шагналаар шагнуулах хүсэлтийг миний зүгээс тавина. Иймийн тулд өнөөдрөөс хойш тус нэгтгэлийг одон тэмдэгт 8 дугаар дивиз гэж нэрлэе”¹ хэмээн тус дивизийн гүйцэтгэсэн үүргийг өндөр үнэлж байв.

Мөн тус дивизийн дарга хошууч Д.Нянтайсүрэнд хурандаа цол, дивизийн комиссар ахлах улс төрийн удирдагч О.Дандгайд хорооны комиссар цол /нэг шат алгасан/ шагнасан байна. Үүний зэрэгцээ их бууны штабын дарга дэслэгч Чойдог, 22 мх-ны пулемёт сумангийн дарга дэслэгч Пүрэв, зэвсгийн дарга дархач Дэлгэр, улс төрийн удирдагч Содномдаржаа, 23 мх-ны сумангийн дарга дэслэгч Г.Санжмятав, салааны дарга бага дэслэгч Лувсандамба, ахлах номын багш Ломбодорж нарын 45 хүнд алдар цол нэмэгдүүлэн шагнажээ².

Халхын голын дайны түүхэнд саяхныг хүртэл цагаан толбо болон дарагдаж байсан нэг зүйл бол Нөмрөгийн гол, Мана уулын районд болсон 8 мд-ийн 22 мх-ны нэгэн өдрийн байлдааны ажиллагаа юм.

Есдүгээр сарын 11-ний өдрийн байлдаанд 22 мх ухарснаас болж Мана уулыг дайсанд алдсан гэдэг нэр зүүн тус хороо болон дивизийн байлдааны амжилт, гүйцэтгэсэн үүргийг нь үгүйсгэх хандлага газар авсан юм. Сүүлийн жилүүдэд Мана уулын районд болсон энэ байлдааны талаар түүхч, судлаач, сэтгүүлчид болон тус хорооны ахмад дайчдын бичсэн материалууд сонин хэвлэлд олонтаа хэвлэгдсэн ба уулзалт ярилцлага ч хэд хэд зохион байгуулсан байна. Гэвч энэ байлдааны талаар одоог хүртэл буруу зөрүү ойлголт байсаар байгаа тул бодит байдал ямар байсныг дэлгэрэнгүй авч үзэх нь зүйтэй юм.

Зөвлөлт, Монголын цэрэг 1939 оны 8 дугаар сарын 20-нд шийдвэрлэх давшилт хийж, Японы цэргийн үндсэн бүлэглэлийг Халхын голын зүүн талд бүслэн устгаж, улсын хилийг сэргээх үед Япончууд өөр чиглэлээр тухайлбал, Нөмрөгийн голын Мана уулын районд цэргийн үлэмжхэн хүчийг 8 дугаар сарын 26-наас эхлэн хуралдуулан байлдааны ажиллагаанд бэлтгэж байв.

Армийн 1 дүгээр бүлгийн штабын дарга, бригад командлан захирагч М.А.Богдановоос Нөмрөгийн Мана уулын районыг Япончууд эзлэн авсан шалтгааны талаар Гадаад Хэргийн Ардын Комиссар В.Молотовт бичихдээ “Энэ районыг эзлэн авахдаа Японы командлалын тавьсан оперативын зорилго нь БНМАУ-ын хилийг Япончуудын оперативын чухал байр болох Халуун рашааны төмөр зам, Халуун рашааны хээрийн зам, Хан ширээ, Жанжин сүм, Хайлаараас

¹БХТА, сх.1, д.15, хн.475, х.9

²БХТА, сх.1, д.15, хн.32, х.117-119

холдуулж Нөмрөгийн голын зүүн эргээр байгаа томоохон өндөрлөгүүдээр өөрийгөө халхлахад оршиж байв”¹ гэжээ.

Энэ үед Мана уулын районд Япон, Баргын тусгай батальон, морьт суман, их бууны батарей тус тус хориглож байв. Энэ бүлэглэлийг устгуулахаар 1939 оны 8 дугаар сарын 31-нд Зөвлөлтийн 8 дугаар мотохуягт бригадын хүч нэмэгдүүлсэн буудлагын батальоноос бүрдсэн 300 орчим хүнтэй отрядыг хошууч Коневор удирдуулан явуулжээ. Коневийн отряд Нөмрөгийн районд ирж хязгаарын цэргийн 5 дугаар заставтай хамтран байлдааны ажиллагаа явуулсан боловч хүч хомсдон Мана уулын баруун бэлд хориглолтод шилжин дайсны хүчийг тогтоон барьж байв.

Армийн 1 дүгээр бүлгийн командлалаас Мана ууланд бугшсан дайсныг устгах, тэнд буй Коневын отрядыг солихын тулд дахин шинээр отряд зохион байгуулан Нөмрөгийн гол руу явуулахаар шийдвэрлэжээ. Армийн 1 дүгээр бүлгийн командлагчийн 1939 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн 00136 тоот тушаалаар Улаан армийн 5 дугаар буудлага-пулемётын бригадын даргын орлогч хошууч Таранецийг уг отрядын даргаар томилж отрядыг МАХЦ-ийн 22 мх, 8 мд-ийн хуягт суман, их бууны батарей, Улаан армийн 8 дугаар мотохуягт бригадын буудлагын нэг рот, 6 дугаар танкийн бригадын БТ-7 танкийн нэг салааны бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулжээ ². Харин уул отрядын бүрэлдэхүүнд орох буудлагын рот, хуягт суман, танкийн салаа, радио станц зэргийг хошууч Коневын отрядаас гаргахаар заасан байна. Шинээр зохион байгуулсан отрядыг 9 дүгээр сарын 7-ны 20 цагт 8 мд-ийн байрлалын районоос хөдөлж 8-ны өдрийн 16 цагт Нөмрөгийн голын баруун талд буй 1100 тоот өндөрлөгийн районд хүчээ хуралдуулан 8-9-нд шилжих шөнө солих ажлыг зохион байгуулахыг тушаажээ. Үнэн хэрэгтээ энэ шинэ томилогдсон отряд гэдэг нь 22 мх, түүнд хавсаргасан их бууны батарей бүхий 400 гаруй хүнтэй хүч байсан юм. Ингээд 22 мх, Хулд уулын орчмоос маршаар хөдлөн явж 120 км орчим зам туулан 10-ны үүрээр заагдсан газар очиж Коневын отрядыг сольжээ. Тус хороог очсоны дараа хошууч Конев өөрийн отрядаа буцаасан байна.

Мана уулын районд 22 мх-г ирэхэд 2 талын хүчний харьцаа тэнцвэргүй байдалтай байв. Японы тал 3000 гаруй хүн, 12 их буутай, Монгол, Зөвлөлтийн тал 450 гаруй хүн, 4 их буутай байлаа.

Япончууд 9 дүгээр сарын эхээр харуулын тусгай 3 дугаар отрядын дэд хурандаа Фукано даргатай 16 дугаар тусгай батальон, 1 дүгээр явган хороон дээр суурилсан хурандаа Мицудзо Готогийн тусгай отряд, хошууч Якэй Мацумото даргатай харуулын 15 дугаар тусгай батальон зэрэг ангийг Мана ууланд татан ирүүлсэн байв. Эдгээр ангиудыг хошууч генерал С.Миядзавад захируулжээ. 1939 оны 9 дүгээр сарын 11-ний өглөөнөөс цаг агаар улам хүйтрэн баруун хойноос ширүүн салхи үлээж цас бударч байв. Энэ өдрийн өглөө Японы тал их бууны гал болон 2 морин сумангаар дэмжүүлсэн 2 явган батальон хүртэл хүчээр 22 мх руу давшиж байлдаан эхэлжээ. Энэ байлдаан өглөөний 6 цаг 50

¹ БХЯ-ны ЭШХ-ийн фондод буй “Халх гол-хагас зуунтэртээг шинээр харахад” /баримт бичгийн эмхтгэл/ номын эх. УБ., 1989. т.556

² Российской Государственной Военной Архив /РГВА/. ф.32113, оп.1, ед.хр.3. 99

минутанд эхлэн 22 мх-ны хориглолтыг 2 жигүүрээр нь бүсэлж эхэлсэн байна. 22 мх-ны хориглолтын баруун жигүүрт түүний 4 дүгээр суман, дунд нь 3 дугаар суман, зүүн жигүүрт нь Улаан армийн буудлагын рот, нийтдээ 200 орчим хүнтэй хүч хориглож байсан юм.

Дайсны цэрэг 22 мх-ны байрлалд зарим газраар нэвтэрч гардан байлдаан хүртэл болов. 22 мх дайсны давуу хүчинд түрэгдэн аргагүйн эрхэнд ухарсан байна. Ингэж ухрахдаа 4 их буугаа авч чадалгүй орхисон ажээ. Японы тал нийтдээ 800-900 орчим хүнтэй хүчээр довтолж энэ байлдаан 11 цаг 25 минутийн орчим дууссан бөгөөд Япончууд ч давшилтаа зогсоожээ.

Энэ байлдаанд 22 мх-ны 3, 4 дүгээр суман болон тэдгээрт хавсаргасан пулемёт салаа, их бууны батарейнаас 19 хүн амь үрэгдэж, 7 хүн шархдан, Зөвлөлтийн буудлагын ротоос 7 хүн амь үрэгдэж, 10 хүн шархаджээ¹.

Ингэж энэ өдрийн байлдаанд 22 мх дайсны давуу хүчинд, түрэгдэн ухарснаас болж Мана уулыг Японд алдсан гэдэг яриа гарах болсон юм.

Энэ байлдаанд дайсны давуу хүчний давшилтыг зогсоох, улмаар няцаах боломж 22 мх-нд байсангүй. Тэгээд ч бүслэгдэх аюул тулгарсан тул хүн хүчээ хадгалж хамгаалах зорилгоор хорооны дарга ахмад Р.Бадарч ухрах тушаал өгсөнөөр 22 мх Нөмрөгийн голын баруун эрэгт хориглолтод шилжсэн байна. Тухайн үед дайсны давшилтыг ямар ч аргаар болов няцааж, зогсооно гэдэг нь эцсийн эцэст бүх хүнийхээ амь насыг хөнөөлгөнө гэсэн хэрэг бөгөөд ингэх нь ямар ч утга учиргүй хэрэг байв.

Цагийн байдлын ийм нөхцөлд хороог бүслэгдэх аюулаас гаргах, газар орны ашигтай байрлал эзлэх зорилгоор ухрах шийдвэр гаргасан нь тухайн үед зөв байсан бөгөөд тэр үеийн байлдааны захирагч Поздняков бичихдээ: “Энэ нөхцөлд бүх төрлийн зэвсгийн галаар дайсанд хохирол учруулж хорооны үндсэн хүчийг Нөмрөгийн голын баруун эрэгт зохион байгуулалттай гаргах нь тактикийн хувьд зөв байсан”² гэсэн нь дээрхийг давхар нотолж байна. Харин хорооны удирдлага давуу хүчээр давшиж байгаа дайсанд бүх төрлийн галаар хүчтэй эсэргүүцэл үзүүлж салбаруудыг дэс дараатай ухраах ажиллагааг удирдах, хяналт тавихад сул анхаарсан, их бууны батарейг хориглолтын өвөр эгнээнд ойрхон, намгийн цаана гаргаж байрлуулсан, ухрах үед бууны морьдыг ар талаас авч амжаагүй явдал батарейг дайсны галын дороос авах бололцоогүй болгожээ.

Ингэж 1939 оны 9 дүгээр сард Нөмрөгийн голын орчим болсон байлдааныг буруутгах шалтгаан болгож тус дивизийн ялангуяа 22 мх-ны гүйцэтгэсэн үүргийг бараг үгүйсгэн мартахад хүрсэн нь нэг хүнийг тахин шүтэж, хэт үзэл сурталжиж байсан өнгөрсөн үеийн алдаа юм. 22 мх-ны байлдааны ажиллагааг олон нийтэд үнэн байдлаар ойлгуулж,цэргийн түүхэнд зохих байрыг нь эзлүүлэх явдал түүхэн үнэнийг сэргээх, залуу үеийг цэрэг эх оронч үзлээр хүмүүжүүлэх, цэрэг, ард түмний холбоог бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Ийнхүү 8 мд-ийн 22 мх-ны дайчид 1939 оны 9 дүгээр сарын 11-нд Халхын голын дайны сүүлчийн хүч тэнцвэргүй байлдаанд орж түүхэнд эерэг, сөрөг дурсагдах болсон түүхтэй.

¹РГВА, ф.32113, оп.1, д.281. 135

²РГВА, ф.32113, оп.1, д. 672. 12

ГУРАВДУГААР ХЭСЭГ

МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ ЦЭРГИЙН МОРЬТ ДИВИЗҮҮД ДЭЛХИЙН II ДАЙНЫ ТӨГСГӨЛ БОЛОХ 1945 ОНЫ ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНД

3.1. Монгол ардын хувьсгалт цэргийн 5 дугаар морьт дивиз Чөлөөлөх дайнд.

1939 оны Халхын голын дайн Монгол-Зөвлөлтийн цэргийн хамтарсан хүчний ялалтаар төгссөн боловч дайны аюул занал бүрэн арилсангүй, дэлхийн II дайнаар шатлан үргэлжилж, дэлхий дахиныг хамарсан гамшигт үйл явц болон хувирсан юм.

1939-1945 оны хооронд үргэлжилсэн дэлхийн II дайнд Герман болон түүний холбоотны эсрэг ЗХУ тэргүүтэй холбоотон улсууд шийдвэрлэх үүрэгтэй оролцож 1945 оны 5 дугаар сарын 9-нд түүхт ялалтыг байгуулж Европ дахь дайныг дуусгасан юм. Гэсэн хэдий ч дэлхийн II дайныг дуусгахад Алс Дорнодод Гитлерийн Германы гол холбоотон болох Японы милитаристууд түрэмгийлэл үйлдсэн хэвээр байсан юм. Японы түрэмгийлэл ил, далд янз бүрийн арга хэлбэрээр улам бүр өргөжин, эзлэн түрэмгийлэх бодлого, зорилгоо хэрэгжүүлэхийн тулд цэрэг, дайны бэлтгэлийг шаргуу хийж байсан ажээ.

Японы түрэмгий дайны аюул занал бодитой оршин байсны зэрэгцээ 1945 оны 8 дугаар сарын байдлаар "...1 сая гаруй цэрэг, 1800 нисэх онгоц, 1155 танк, 5360 их буу...дивиз 31, явган бригад 9, танкийн бригад 2, тусгай бригад 1, нисэх хүчний арми 2, тэдгээр нь 1, 3, 17 дугаар фронт, 1 тусгай армийн зохион байгуулалтанд хуваагдсан...Японы цэргийн командлалын мэдэлд 8 явган, 7 морьт дивиз, 14 явган ба морин бригад бүхий Манж-го, Өвөрмонгол, Суй Юан мужийн цэрэг..."¹ гэх зэргээр Монгол-Зөвлөлтийн хилийн ойролцоо цэргийн хүч, хэрэгслийг үлэмж их хэмжээгээр хуралдуулах болсон нь Монгол-Зөвлөлтийн цэргийн хамтарсан хүчийг дахин нэгтгэж, Алс дорнодод үүссэн дайны гал голомтыг нэн даруй устган, дэлхийн дайныг түргэн хугацаанд дуусгах цэрэг, улс төрийн зайлшгүй шаардлагыг буй болгосон юм. Иймд 1945 оны Чөлөөлөх дайнд оролцсон Монгол-Зөвлөлтийн цэргийн хамтарсан хүчний тухайн үеийн нөхцөл байдал хийгээд цэрэг, улс төрийн бодлого, зорилтын талаар товч боловч авч үзэх нь чухал юм.

Дэлхийн II дайны төгсгөлд Монгол-Зөвлөлтийн цэрэг хамтарсан хүчээр Японы эсрэг дахин хүч нэгтгэн тэмцэх болсон нь тус хоёр улсын үндэсний эрх ашиг, тусгаар тогтнолын асуудалтай нягт холбогдохоос гадна дэлхий дахинд энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах гол зорилгод чиглэж байв. Ийм бодит нөхцөл байдлын дунд буюу 1945 оны 2 дугаар сард холбоотон гүрнүүдийн Ялтын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу ЗХУ 1945 оны 8 дугаар сарын 9-нд Японд дайн зарлав. БНМАУ-ын Бага хурал, Засгийн газраас 1945 оны 8 дугаар сарын 10-нд Японд дайн зарлах тухай тунхаглах бичиг гаргаж "Эдүгээ хэдэн зуун жилийн турш өөртөө бүрэн эрх чөлөөтэй тусгаар тогтнохын төлөө зорьж ирсэн санаа сэтгэлийг дагуулан Монгол овогтон нэгэн гэр улс болж айл зэргэлдээ ардчилсан улсуудтай найртай сайхнаар оршин суухыг хүсэж

¹ Монгол Ардын армийн 50 жил. УБ., 1971. т. 196

ирснийг үндэслэж...нийтийн дайсныг түргэнээр бүрмөсөн цохиж устгах гэсэн ардчилсан улсууд ба эрх чөлөөг эрхэмлэгч дэлхийн ард түмний нэгэн санаа зорилгоор бахархан зоригжиж нэгдсэн үндэстний үйлсэд өөрийн тус нэмрийг оруулахын тулд нэгдсэн үндэстний талд оролцон Япон улстай байлдах ариун дайныг эрхэмсгээр зарлан”¹ тунхаглажээ.

Энэхүү цэрэг дайны зорилтыг биелүүлэхийн тулд тухайн үеийн МАХЦ-ийн удирдлагаас онцгой анхаарч хүн хүч зэвсэг хэрэгслийн нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсний дотор 1945 оны 9 сарын 4-ний өдрийн байдлаар 5 дугаар дивизийн бие бүрэлдэхүүн, зэвсэглэл техникийг дараах байдлаар зохион байгуулсан байна. Үүнд:

**МАА-ийн цэргийн бүлэглэлийн анги, нэгтгэлүүдийн
бие бүрэлдэхүүний зэвсэглэл техникийн байдал²
(1945 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн байдлаар)**

Анги нэгтгэлийн нэр		5 дугаар морьт дивиз				
Хүн хүчний төрөл	Жагсаалт	Орон тоогоор	Дансаар	Бэлэн байгаа	Замд яваа	Үлдсэн
Бие бүрэлдэхүүн	Офицер	352	328	254	59	15
	Түрүүч	1200	1124	759	331	34
	Байлдагч	2612	2648	1960	529	159
	Бүгд	4164	4100	2973	919	208
Морьдын тоо		4221	3806	3175	571	60
Винтов		3044	3119	2215	434	470
ПТР		57	42	38	4	-
Пулемёт	Автомат	323	317	317	-	-
	Гар пулемёт	107	107	100	7	-
	Суурьт	-	36	36	-	-
	Кр. кал	3	3	-	3	-
	Зенитийн	9	9	-	9	-
Миномёт	PM-50	27	27	-	-	27
	BM-82	-	18	18	-	-
	PM-120	4	4	4	-	-
Артиллер	37 мм калибрь	-	12	-	12	-
	45 мм. калибрь	9	9	8	1	-
	76 мм. калибрь	12	12	8	4	-
	107 мм. калибрь	-	4	-	4	-
Байлдаан машины	Хөнгөн	10	10	-	10	-
	Дунд	12	12	-	12	-
Автомашин		96	84	-	84	-
Хөнгөн танк		-	-	-	-	-
Холбооны станц		18	7	1	7	-

Монгол-Зөвлөлтийн цэргийн хамтарсан хүч Японы эсрэг дайнд эргэлт буцалтгүй оролцох болсноор 1945 оны Чөлөөлөх дайны ажиллагаа эхэлсэн

¹ МАХЦ-ийн түүхэнд холбогдох баримт бичгүүд. 1921-1945 он. УБ., 1974. Т. 589-590

² БХТА. Сх.1 Д.4 Хн 203 хуудас 14

бөгөөд БНМАУ-ын Зэвсэгт хүчин, бүрэлдэхүүнд нь багтаж хамтран байлдсан Өвөрбайгалын фронт давшилтынхаа гол цохилтыг БНМАУ-ын Тамсагбулагийн районоос гвардын танкийн 6 дугаар арми, ерөнхий цэргийн 39, 17, 53 дугаар армийн хүчээр Халуун рашааны бэхлэгдсэн районы өмнө талаар Чаньчунь, Мүгдэний чиглэлээр хийж, түргэн хөдөлгөөнтэй ангиудын хүчээр Их Хянганыг давж цаашид бусад фронт, армитай харилцан ажиллагаатайгаар Квантуны армийг Манжуурын төв хэсэгт бүслэн бутцохих үүрэгтэй байв. Маршал Р.Я.Малиновский, давшилтын баруун гарын цохилтыг Долоннуур, Чуулалт хаалганы чиглэлд хийж, Өвөрбайгалын фронтын баруун жигүүрийг хангахыг Монгол-Зөвлөлтийн цэргийн морьт механикжуулсан группэд даалгажээ. Монгол-Зөвлөлтийн морьт механикжуулсан бүлэг нь фронтын гол цохилтын бүлэглэлээс 200 км зайтай, тусгай чиглэлүүдээр давшиж дайсны зүгээс учруулж болзошгүй эсрэг цохилтыг сэрэмжлэн, хятадын Панзьян хот, Далай нуурын заагт гарч, улмаар Чуулалт хаалган, Долоннуур, Жэхэгийн чигт давшилтаа өндөр хурдтай үргэлжлүүлэх ёстой байв. Группын давших зурвасын өргөн 200-250 км, ойрын үүргийн гүн нь 400 км байв. Тус группын баруун гарт анги нэгтгэлгүй, зүүн гарт дэслэгч генерал А.И.Даниловын командалсан зөвлөлтийн 17 дугаар арми, Егүзэрийн хийдийн районоос Дабаньшаний чигт давших байв.

Монгол-Зөвлөлтийн морьт механикжуулсан бүлгийн командлал өмнөө тавигдсан байлдааны үүргийг биелүүлэхдээ өөрийн хүч, хэрэгслээ хоёр хэсэг болгосон ба нэгдэх нь Дарьганга, Байшинтын районоос Долоннуур, Жэхэгийн чиглэлд 950 гаруй км, хоёр дахь нь Сайншандаас Чуулалт хаалган хүртэл 500 гаруй км зайд давшин байлдахаар шийдвэрлэжээ”¹.

Өвөрбайгалын фронтын Цэргийн зөвлөлийн 1945 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн шийдвэрээр тус фронтын бүрэлдэхүүнд хурандаа генерал И.А.Плиевийн удирдлагад Монгол-Зөвлөлтийн цэргийн морьт механикжуулсан бүлэг байгуулав. Ингэснээр Өвөрбайгалын фронт ерөнхий цэргийн 17, 36, 39, 53 дугаар арми, гвардын танкийн 6 дугаар арми, агаарын цэргийн 12 дугаар арми болон Монгол-Зөвлөлтийн морьт механикжуулсан бүлгээс бүрдэх болжээ. Тэдгээрийн дотор Баянтүмэний 5 дугаар морьт дивиз багтаж байв.

Харин МАХЦ-ийн бүрэлдэхүүнд томоохон хүчийг бүрдүүлсэн Баянтүмэний 5 дугаар морьт дивизийн удирдлагын бүрэлдэхүүнд дивизийн дарга, хошууч генерал Ч.Доржпалам, улс төрийн орлогч, дэд хурандаа С.Лувсанлхүндэв, штабын дарга, хошууч Н.Дугаржав нар томилогдсон бөгөөд тус дивиз нь 13 дугаар морьт хороо (дарга нь БНМАУ-ын баатар, дэд хурандаа Л.Дандар), 14 дүгээр морьт хороо (дарга нь ахмад П.Жамбал), 28 дугаар морьт хороо (дарга нь хошууч Ж.Ринчин), их бууны дивизион (дарга нь хошууч С.Гомбожав), хуягт дивизион (дарга нь ахмад Л.Чүлтэм) болон бусад тусгай салбаруудаас бүрдэж байв². Зарим ахмад дайчдын дуртгалд өгүүлснээр “...онгоц эсэргүүцэх агаарын бууны ба инженерийн ангиуд, холбоо, авто тээвэр, бага даргын сургууль зэрэг үндсэн анги, салбаруудтай байв”³.

¹ Монгол Ардын армийн 50 жил. УБ., 1971. т. 201-202

²Ганболд С. 5 дугаар морьт дивиз Чөлөөлөх дайнд “Соёмбо” сонин.2005. VII. 1-7. №27

³1945 оны дайнд оролцогчдын дуртгал. УБ., 1975. Тал 140.

“Дэлхийн II дайны нэг голомт болж байсан Японы цэргийг бут цохиж Өвөрмонголын ард түмнийг чөлөөлөх дайнд бэлтгэх ажил МАХЦ-ийн хувьд 1945 оны 5 дугаар сарын дунд үеэс эхэлжээ. Тэгэхдээ юуны өмнө МАХЦ-ийн анги, нэгтгэлүүдийг зэвсэг, техник, галт хэрэгсэл, агт морьдоор хангах ажлыг 1945 оны 5 дугаар сарын эцсээр үндсэнд нь гүйцэтгэж, 6 дугаар сарын эхээр армийн анги, нэгтгэлийг хоёр чиглэлд хувааж Замын-Үүд, Байшинтын районд хүч хуралдуулсан байна. Тамсагийн 6 дугаар морьт дивиз, Баянтүмэний 5 дугаар морьт дивиз, Матадын 8 дугаар морьт дивиз, Байшинтын 7 дугаар морьт дивиз, холбооны тусгай хороо зэрэг нэгтгэл, ангиуд 350-400 км газар марш үйлдэж Сүхбаатар аймгийн Дарьганга, Онгон, Хонгор сумын хүч хуралдуулах районд 7 дугаар сарын 19-20-нд очжээ. Дорноговь аймгийн Замын-Үүдийн хүч хуралдуулах районд 7 дугаар мотохуягт бригад, их бууны тусгай хороо болон бусад анги, салбарын хүчийг хуралдуулжээ”¹.

“Бүх цэргийн жанжин, маршал Х.Чойбалсан 1945 оны 6 дугаар сарын 23-нд тус дивизийг хүч хуралдуулах район руу марш хийхэд бэлтгэх тушаал өгсөн ажээ. Тус дивиз 7 дугаар сарын 3-наас эхлэн дайчилгаагаар татагдсан түр болон шинэ цэрэг 200 орчмыг хүлээн авч нөхөн хангалт хийв. Үүний дараа 5 дугаар морьт дивиз 7 дугаар сарын 5-ны өдрийн 20 цагт Чойбалсан хотоос хөдөлж, 355 км марш үйлдэн 20-ны өдөр Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутаг Молцог хийдийн районд иржээ”².

Баянтүмэний 5 дугаар морьт дивизийн хүн, хүчний тухай тус дивизийн дарга, хошууч генерал Ч.Доржпаламын илтгэлд дурдсанаас үзвэл:

- “...Дивизийн хүний орон тоогоор 3951 байхаас 2563 байсан нь даруй 1388 хүнээр дутаж байлаа;

- Агт морьд 4040 байхаас 3079, дутуу 961 байлаа;

- 07.03-ны өдрөөс эхлэн хүн хүлээн авч, 5, 6, 7-ны өдөр түр 480, шинэ цэрэг 10-ыг хүлээн авсан...”³ гэжээ. Эндээс үзэхэд, тус дивизийн хүн, хүчний бүрэлдэхүүнд нөхөн хангалт хийх зайлшгүй шаардлага тулгарсан хэвээр байсан нь “...Тус дивиз 7 дугаар сарын 3-наас эхлэн дайчилгаагаар татагдсан түр болон шинэ цэрэг 200 орчмыг хүлээн авч нөхөн хангалт хийв...Хүч хуралдуулах районд ирсэн 5 дугаар морьт дивиз түр цэрэг 400-г нөхөн хангалтаар авсан байна.

Энэ хугацаанд бие бүрэлдэхүүний байлдааны бэлтгэлийг дээшлүүлэх талаар багагүй ажил хийж, сум, галт хэрэгсэл, хүнс хувцасны нөхөн хангалт хийжээ”⁴ гэснээс тодорхой байна.

Рубины илтгэлд дурдсанаар: “Морьт дивизүүд хүч хуралдуулах район руу хэвийн нөхцөлд марш үйлдэн маршийн дундаж ачааллыг өдөрт 30-35 км-ээс хэтрүүлэхгүйгээр хөдөлгөөн үйлдэж байсан нь маршийн сахилгыг хатуу чанд мөрдөх боломж олгосны дээр хүн хүчний болон уналгыг зүдрээхгүйгээр хөдөлгөөний графикайн тооцоолсон хугацаанд багтаж заасан районд хүрэх бололцоо олгосон байна”⁵.

¹ Монгол цэргийн түүхийн товчоон. II дэвтэр.УБ., 1996. Т.363

² Ганболд С. 5 дугаар морьт дивиз Чөлөөлөх дайнд “Соёмбо” сонин.2005. VII. 1-7. №27

³ БХТА. сх-1, д-4, хн-109, х.16.

⁴ Ганболд С. 5 дугаар морьт дивиз Чөлөөлөх дайнд “Соёмбо” сонин.2005. VII. 1-7. №27

⁵ Российско-Монгольское военное сотрудничество (1911-1946). Сборник документов Часть II. Москва-Улан-Удэ., 2008. Тал 185.

Тухайлбал 5 дугаар морьт дивиз гэхэд нийт 355 км-ийн маршрут бүхий замыг туулж заасан районд ирэхэд 344 цаг зарцуулсан ба түүний дотор явдал дунд нийтдээ 78 цагийн амралт хийж, марш үйлдэхэд цэвэр 266 цаг зарцуулан, өдөрт 7-8 цагийн хөдөлгөөн үйлдэж байжээ¹.

Анги, нэгтгэлийн захирагч нарт тухайн маршийг сургалтыг зорилготой зохион байгуулах үүргийг өгсний дээр цэргийн маршийн бэлтгэлийн зарим дутагдлыг маршийн явцад арилгах, штабуудын зүгээс марш зохион байгуулах болон өгсөн тушаалын гүйцэтгэлийг газар дээр нь хийх тооцоотой ажилласан байна. Эсрэг этгээдийн зүгээс шөнийн цагаар болон агаараас халдлага үйлдсэн нөхцөлд анги, салбарыг удирдах дадлага чадвараа маршийн явцад боловсруулахыг нийт офицерын бүрэлдэхүүнд үүрэг болгосон байна”².

5 дугаар морьт дивизийн удирдлагаас байлдааны ба улс төрийн бэлтгэл, бие бүрэлдэхүүний нөхөн хангалтыг анхнаас нь зохих ёсоор бүрдүүлсэн нь байлдаанд тавигдсан шинэ зорилго, зорилтыг амжилттай биелүүлэх, үүрэг гүйцэтгэх чадварыг улам бүр нэмэгдүүлж байв. Тухайлбал, тус дивизийн дарга, хошууч генерал Ч.Доржпаламын дуртгалд “1945 оны 5 дугаар сарын сүүлээс 6 дугаар сарын 10 хүртэл Бүх зэвсэгт хүчний жанжны хаврын шалгалт болж, маршал Х.Чойбалсан, өөрийн орлогч дэслэгч генерал Ю.Цэдэнбал, дэслэгч генерал Ж.Лхагвасүрэн нар болон Жанжин штаб, Улс төрийн газрын шалгалтын комиссын хамт дивизийн хороо, ангиудын байлдааны ба улс төрийн бэлтгэлийг 10 гаруй хоногийн турш шалгасан билээ. Энэ шалгалтаар манай дивизийн 13, 14 дүгээр морьт хороо, их бууны хороо, хуягт дивизион, холбооны суман, зенитийн ба сапёрын сумангууд улс төр, байлдааны бэлтгэлийн бүх төрлийн хичээлүүдэд сайн дүнтэй шалгагдсан юм. Ялангуяа 13 ба 14 дүгээр морьт хороод галын бэлтгэлийн хичээлүүдэд бусдаасаа илүү сайн байсан. 28 дугаар морьт хороо бүх талаар дүүрэн хангалттай гэдэг өндөр үнэлэлт авсан юм³.

1945 оны 8 дугаар сарын эхээр группын командлагч, хурандаа генерал И.А.Плиев, манай 5 дугаар морьт дивизийг бүх ар талын хөсөг тээврийн хамт жагсаан шалгаад парадаар явуулж үзэв. Дараа нь...Танай энэ нэгтгэл чинь сайн дивиз байна. Байлдааны үүрэг гүйцэтгэж чадах дивиз байна гэж үнэлсэн юм. Мөн зарим их буу, хөсгийн хөдөлгөөний тоноглол тохироогүй урт, богино байгааг тааруулж тохируулах хэрэгтэй гэж үүрэг өгсөн билээ. Энэ үед дивиз 4 мянга шахам хүнтэй болоод байв...”⁴ гэж өгүүлсэн нь түүний бодит баримт юм.

Байлдааны ажиллагааны ерөнхий төлөвлөгөө ёсоор Монгол-Зөвлөлтийн морьт механикжуулсан группын удирдлага анги, нэгтгэлүүдийн хурдан хөдөлгөөнтэй цохилтын их хүч бүхий бүлгийг урьдчилан давшуулж гол цохилтоо Долоннуур, Жэхэгийн чигт хийж, тэдгээрийг эзлэн авч улмаар Бээжингийн чиглэлд давшилтаа өрнүүлэхээр шийдвэрлэжээ. Дайсныг гэнэдүүлэх зорилгоор давшилтыг их бууны галын бэлтгэлгүй эхэлж, шөнийн цагт урагш эрчимтэй хөдөлгөөнөөр дайрч дайсны хил хамгаалалтын ангийг гэнэтийн түргэн цохилтоор устгахаар шийдвэрлэсэн байна.

¹ Мөн тэнд. Тал 185.

² Мөн тэнд. Тал 185.

³ 1945 оны дайнд оролцогчдын дуртгал”. УБ., 1975. Тал 122.

⁴ Мөн тэнд. Тал 124.

5 дугаар морьт дивизийн байлдаанд тавигдсан шинэ үүрэг зорилго нь юуны өмнө Монгол-Зөвлөлтийн цэргийн бусад анги, нэгтгэлүүдийн дэмжлэг, харилцан ажиллагаа, давшилтын чиглэлийг хэрхэн тодорхойлохоос шууд хамаарч байв. Өөрөөр хэлбэл, “Бүлгийн командлал тавигдсан үүргийг биелүүлэхийн тулд хүч хэрэгслээ хоёр хэсэг болгож, үндсэн цохилтыг Дарьгангаас Долоннуур, Жэхэгийн чиглэлд хийж, 950 гаруй км давших, туслах цохилтыг баруун жигүүрээр Замын Үүдээс Хаалганы чиглэлд хийж 500 гаруй км зайд давшин байлдахаар төлөвлөсөн байна.

Энэ шийдвэрийн дагуу хошууч генерал Ч.Доржпаламаар удирдуулсан 5 дугаар морьт дивиз Долоннуур, Жэхэгийн чиглэлд бусад морьт механикжуулсан бүлгийн ангиудын нэгэн адил доорх чиглэлд хүч хуралдуулсан байна. Энэ үед “Морьт механикжуулсан бүлэг нь нийтдээ 43.000 орчим хүнтэй байсны бараг тал нь буюу 21.384 нь монгол цэрэг байв. Дайнд орохоор хүч хуралдуулсан МАХЦ-ийн ангиуд нь 23 мянга гаруй агт морь, 32 танк, 152 хуягт машин, 700 гаруй хүнд, хөнгөн пулемёт, 200 гаруй их буу, минометтой байв”¹.

5 дугаар морьт дивизийн давшилтын замд хүнд бэрх саад, бэрхшээл олонтоо тохиолдсоны нэг нь Хятадын цагаан хэрмийн нэг хаалга болсон Губейкоу хотын өмнүүр эргээ халин үерлэн урссан Чаохэ голыг гатлахаас аргагүйд хүрсэн явдал байв. Хожим тэрхүү үйл явдлын талаар 5 дугаар морьт дивизийн дарга, хошууч генерал Ч.Доржпалам “Манай дивиз дараагийн үүргийг биелүүлэхээр бусад ангиуд ба 6 дугаар морьт дивизийн зарим ангиудтай хамтран Миюнь хотыг эзлэн авахаар цааш хөдлөн явж, 22 цагийн үед Чаохэ голын захад хүрэлцэн очив. Тэр гол маш их үерлэсэн байв. Гүүрэн дээгүүр нь ус урсаж гүүр хаа байгаа нь мэдэгдэхгүй болжээ. Үертэй их голыг шөнийн харанхуйд мориор гарахад олон хүнийг усанд алдаж магадгүй байлаа. Энэ байдлыг би орлогч жанжин Ж.Лхагвасүрэнд илтгэж маргааш өглөө болгоод голыг гатлах хүсэлт тавьсанд зөвшөөрөв. Наймдугаар сарын 22-ны үүр цайхын хамт голыг шууд мориор гаталж зарим газар нь морь хөл алдаж байсан боловч гарз хохирол үзээгүй юм”² гэж дурсан өгүүлсэн буй. Ийнхүү 5 дугаар морьт дивизийн удирдлага, бие бүрэлдэхүүн сайтар зохион байгуулагдсан бэлтгэл хийгээд монгол цэргийн эр зориг, авхаалж самбаа, хүлэг морьдынхоо хүч чадал, тэсвэр хатуужлын үр дүнд байгалийн ямар ч саад бэрхшээлийг амжилттай даван туулж байсан нь амжилт, ялалтын хүчийг улам бүр нэмэгдүүлсээр байжээ. Долоннуур-Жэхэгийн чиглэлийн дайсны сүүлчийн томоохон түшиц газар нь Губэйкоу хот байлаа. Губэйкоу бол Монгол Улсын хилээс 1010-т км орших хойд Хятадын төмөр замын зангилаа бөгөөд тэнд Японы эзэн хааны 8 дугаар корпусын штабын дарга дэд хурандаа Очигийн командалсан 31, 35 дугаар тусгай отряд, 76 мм-ийн их бууны 11 дүгээр батарей, 45 мм-ийн танк эсэргүүцэх бууны батарей, миномётын батарей бүхий томоохон хүч байжээ. “МАХЦ-ийн 5 дугаар морьт дивиз байгалийн саад бэрхшээлийг амжилттай даван туулж, 8 дугаар сарын 21-ний өдрийн 13 цагийн орчим Губэйкоу хотод ойртон очив. 5 дугаар морьт дивиз, 6 дугаар морьт дивизтэй харилцан ажиллаж, уг хотыг эзлэн

¹ Ганболд С. МАХЦ Чөлөөлөх дайнд оролцсон нь “Монгол ба Орос Дэлхийн хоёрдугаар дайны жилүүдэд” эрдэм шинжилгээний өгүүллийн эмхэтгэл. УБ., 2011. т. 62-63

² 1945 оны дайнд оролцогчдын дуртгал. УБ., 1975. тал 122

авч Японы 1300 гаруй цэрэг офицер, 76 мм-ийн их бууны батарея, танк эсэргүүцэх 45 мм-ийн их бууны батарея, хүнд пулемёт 65, хөнгөн пулемёт 44, ротын миномёт 16, винтов 3700, бусад зэвсэг хэрэгсэл галт хэрэгслийн агуулахыг олзлон авсан”¹ нь 1945 оны Чөлөөлөх дайнд байлдаанд тавигдсан үүргээ нэр төртэй биелүүлсэн хэрэг байв.

Губейкоу хотын комендантаар 5 дугаар морьт дивизийн 13 морьт хорооны дарга, Монгол Улсын гарамгай баатар, хурандаа Л.Дандарыг томилсны дараа бүлгийн командлагчийн тушаалаар МАХЦ-ийн 5 дугаар морьт дивиз, 6 дугаар морьт дивиз, бусад анги, салбарын хамт Миюнь хотыг эзлэн авахаар төлөвлөжээ. Чээхо голыг гатлан 8 дугаар сарын 22-нд уг хотод ойртон орсон боловч фронт командлагчийн тушаалаар байлдааны ажиллагааг зогсоожээ. Ийнхүү Долоннуур-Жэхэгийн чиглэлд давшсан 5 дугаар морьт дивиз болон МАХЦ-ийн бусад анги, нэгтгэл 1000 гаруй км хүнд бэрх замыг 9-10 хоногийн дотор эрэлхэгээр даван туулж, эх орон, ард түмнийхээ өмнө хүлээсэн байлдааны үүргээ нэр төртэй биелүүлсэн байна.

Энэ хугацаанд тус дивиз нь бие бүрэлдэхүүн, зэвсэглэлийн хувьд багагүй хохирол амсаж байсан нь дараах баримтаас тодорхой байна. Тухайлбал, 5 дугаар дивизийн штабын 1945 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн мэдээнд дурдсанаар:

5 дугаар дивизийн штабаас

1945 оны 9 дүгээр сарын 1

Жанжин штабын 2 хэлтсийн туслах Хоролсүрэнд эдүгээ тус дивизээс 8 дугаар сарын 7-ноос 9 дүгээр сарын 1 хүртэл мэдээнд байлдааны үеийн дундуур хорогдсон ба хаяж гээгдүүлэн хорогдсон бүх зүйлүүдийг тодорхойлбоос:

1. *Хүний талаар:* алагдсан хүн 3, шархадсан хүн 2, бүгд 5

Хөсөг тэрэгний талаар: хоёр дугуйтай тэрэг 1, дөрвөн дугуйтай тэрэг 3, санитарын тэрэг 1 тус тус эвдэрч жагсаалаас гарсан.

Зэвсгийн талаар: винтов 7, жад 15, замаг 3, автомат 1, нагаан 5, сум ширхэгээр 1916 гранат 21, тагнуулын хянах дуран 1 эдгээр зүйлүүд бүгд замдаа орхигдож хаягдсан болно.

Агт морины талаар: эцэж ядарсан 980, хөл нуруугүй болсон 470, замдаа хаягдсан 241 болно.

2. Дайснаас олзолж авсан зүйлийг тусгай хүснэгтээр хавсаргаж хүргүүлэв.

Хүлээн авч хянан гүйцэтгэхийг эрсүгэй

Штабын дарга хошууч

Сиянямбуу

4 дүгээр хэлтсийн дарга

Ахлах дэслэгч

Сааралдай²

1945 оны 9 дүгээр сарын 2-нд Японы Засгийн газар үг дуугүй бууж өгөх гэрээнд гарын үсэг зурснаар Монгол-Зөвлөлтийн цэргийн хамтарсан хүчний ялалт албан ёсоор баталгаажин, 1945 оны Чөлөөлөх дайн дуусгавар болсон билээ.

¹ Монгол Ардын армийн 50 жил. УБ., 1971. т. 260

² БХТА. Ф1, Д4, Хн 123 хуудас 1



1945 оны 9 дүгээр сард морьт механикжсан бүлгийн командлагч, БНМАУ-ын ерөнхий сайд, маршал Х.Чойбалсан, түүний орлогч Ж.Лхагвасүрэн нар Губэйкоу сууринд түр байрлаж байсан хошууч генерал Ч.Доржпалам даргатай 5 дугаар морьт дивиз дээр хүрэлцэн ирж, Чөлөөлөх дайнд тус дивизийн гүйцэтгэсэн байлдааны үүргийг өндрөөр үнэлж, байлдаанд шалгарсан

тэргүүний анги, нэгтгэлд олгодог дурсгалын тугийг гардуулсан бөгөөд мөн оны 9 дүгээр сарын 15-ны өдөр 5 дугаар морьт дивиз Губэйкоу суурингаас эх орны зүг хүлгийн жолоогоо залж, байнгын байрлалдаа 10 дугаар сарын 5-ны өдөр хүрэлцэн ирснээр 5 дугаар морьт дивиз Чөлөөлөх дайнд оролцсон 3 сар гаруй хугацаанд 2800 гаруй км марш үйлдэж байлдааны үүргийг амжилттай биелүүлсэн юм.

1945 оны Чөлөөлөх дайны шийдвэрлэх ялалтанд 5 дугаар морьт дивизийн удирдлага, бие бүрэлдэхүүн эхнээс нь дуустал эрэлхэгээр тэмцэн оролцож, улс орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолыг бататган бэхжүүлэх үйлсэд баатарлаг гавьяа байгуулсан дивизийн дарга, хошууч генерал Ч.Доржпалам, улс төрийн хэлтсийн дарга С.Лувсанлхүндэв болон сумангийн дарга ахлах дэслэгч Лувсандорж, намын товчооны дарга Цэнд-Аюуш, байлдагч Долгордулам нарын 314 цэрэг, офицер төрийн дээд шагнал одон, медалиар тус тус шагнагдсан байна. Шагнагдсан хүмүүсийн жагсаалтыг архивын баримтаас түүвэрлэн авч нэгтгэн үзүүлэв.

БНМАУ-ЫН БАГА ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН 1945 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 26-НЫ ӨДРИЙН 79 ДҮГЭЭР ХУРЛЫН ТОГТООЛ¹

Японы эзэрхэг түрэмгий нарыг эсэргүүцсэн байлдаанд амжилт гаргаж, гавьяа байгуулагсадыг сайшаан шагнах тухай.

Японы эзэрхэг түрэмгийчүүдийг бутцохин устгах ариун шударга байлдаанд үнэнхүү эх оронч их зүтгэлийг гаргаж, шалгарсан Монгол Ардын Хувьсгалт Цэргийн байлдагч, түрүүч, офицер, генералуудыг тус улсын одон, медалиудаар сайшаан шагнах тухай, БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Улаан тугийн одонгоор		
1.	5 дугаар морьт дивизийн дарга хошууч генерал	Чойровын Доржпалам
2.	5 дугаар морьт дивизийн улс төрийн орлогч дэд хурандаа	Сэрээтэрийн Лувсанлхүндэв
3.	5 дугаар морьт дивизийн 1 дүгээр хэлтсийн дарга ахмад	Магнайн Чимэд
4.	5 дугаар морьт дивизийн 14 дүгээр хорооны дарга хошууч	Пагмын Жамбал
5.	5 дугаар морьт дивизийн 28 дугаар хорооны дарга дэд хурандаа	Жамбалын Рэнцэн

¹ БХТА, сx-1, д-5, хн-46. хуудас 187

6.	5 дугаар морьт дивизийн 14 дүгээр хорооны улс төрийн орлогч ахмад	Нацагийн Хаянхярваа
7.	5 дугаар морьт дивизийн их буюгийн дивизионы дарга хошууч	Сүхбаатарын Гомбожав
8.	5 дугаар дивизийн комендантын цэрэг	Дэлгэрийн Дашзэвэг
9.	5 дугаар дивизийн бага дарга бага түрүүч	Лувсандоржийн Зэвэг
10.	5 дугаар дивизийн бага дарга бага түрүүч	Сэдэдийн Даваа
11.	5 дугаар дивизийн цэрэг	Цэдэвийн Цоодол
12.	5 дугаар дивизийн наводчик	Гарьдын Чанцал
13.	5 дугаар дивизийн цэрэг	Мятавын Мажиг
Алтан гадас одонгоор		
1.	5 дугаар дивизийн госпиталийн жагсаалын дарга ахлагч	Нямын Пэрэнлэй
2.	5 дугаар морьт дивизийн цэрэг	Цэрэнгийн Найдандорж
3.	5 дугаар дивизийн прокурор ахмад	Маамын Гомбосүрэн
4.	5 дугаар дивизийн шүүхийн дарга ахмад	Даваагийн Цэвэгжав
5.	5 дугаар дивизийн штабын дарга хошууч	Навааны Дугаржав
6.	5 дугаар дивизийн холбооны офицер дэслэгч	Надмидын Долгор
7.	5 дугаар дивизийн 13 дугаар хорооны дарга дэд хурандаа	Лодонгийн Дандар
8.	5 дугаар дивизийн 13 дугаар хорооны улс төрийн орлогч хошууч	Донойн Сэрээсэн
9.	5 дугаар дивизийн 28 дугаар хорооны улс төрийн орлогч хошууч	Дамбын Пүрэвдорж
10.	5 дугаар дивизийн арын албаны дарга Аж ахуйн албаны хошууч	Санжийн Бадамсүрэн
11.	5 дугаар дивизийн холбооны сумангийн цэрэг	Дашийн Лувсандорж
12.	5 дугаар дивизийн сургуулийн сумангийн бага дарга ахлах түрүүч	Гомбын Шижээ
13.	5 дугаар дивизийн бага номын багш	Чогсомжавын Зундуй
14.	5 дугаар дивизийн цэрэг	Сономцэрэнгийн Пүрэв
15.	5 дугаар дивизийн цэрэг	Содовын Лувсандаш
16.	5 дугаар дивизийн сапёрын сумангийн цэрэг	Шаравын Санжжав
17.	5 дугаар дивизийн тасгийн дарга	Цэвээнжавын Хаймчиг
18.	5 дугаар дивизийн цэрэг	Банзрагчийн Ханд
Байлдааны хүндэт медалиар		
1.	5 дугаар дивизийн холбооны дарга ахлах дэслэгч	Норжингийн Цэрэндорж
2.	5 дугаар дивизийн холбооны сумангийн дарга ахлах дэслэгч	Дамдингийн Лувсанбалдан
3.	5 дугаар дивизийн комендантын цэрэг	Чойжилын Дашхүү
4.	5 дугаар морьт дивизийн машины	Логоны Сандуйжав

	жолооч	
Хөдөлмөрийн хүндэт медалиар		
1.	5 дугаар дивизийн цэрэг бичээч	Жамсрандоржийн Гомбожав
2.	5 дугаар дивизийн машины жолооч	Яндагийн Дашдондог
3.	5 дугаар дивизийн кино механик бага дэслэгч	Охины Соном
4.	5 дугаар дивизийн хувцасны тасгийн дарга дэслэгч	Авирын Санжаасүрэн

1945 оны Чөлөөлөх дайнд оролцсон 5 дугаар морьт дивизийн байлдааны ажиллагаа нь МАХЦ-ийн байлдах чадвар, байлдааны бэлэн байдлыг дээшлүүлэхэд нэгэн адил чухал үүрэг гүйцэтгэсэн төдийгүй морьт цэргийн бүтэц, зохион байгуулалт, харилцан ажиллагааны өөрчлөлт болон байлдааны туршлага, сургамжийг хуримтлуулахад үнэтэй хувь нэмэр оруулсан билээ.

3.2. Монгол ардын хувьсгалт цэргийн 6 дугаар морьт дивиз Чөлөөлөх дайнд.

Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит, Байлдааны гавьяаны улаан тугийн одонт Тамсагбулагийн 6 дугаар морьт дивиз нь 1922 оноос эхлэн эх орныхоо зүүн хил хязгаарыг хамгаалж, 1936 оны Адагдулааны байлдаан, 1939 оны Халхын голын дайнд оролцсон арвин баялаг дайчин уламжлалтай нэгтгэл юм.

Хурандаа М.Цэдэндаш даргатай (улс төрийн хэлтсийн дарга дэд хурандаа Чадраабал, штабын дарга хошууч Д.Намсрай) тус дивиз 1945.06.25-ны өдөр маршийн үүрэг гүйцэтгэх тушаал хүлээн авч, Тамсагбулагаас зүүн тийш 125 км зайтай Баянцагаанд байрлаж байсан дэд хурандаа С.Чойндонгаваа даргатай 1 мх-г татаж ирүүлэв. Маршийн бэлтгэлийг хангахын хамт маршаар явах маршрутыг судлах зорилгоор тусгай бүлгийг 27-ны өдөр томилон гаргажээ. Ингээд 6 мд 7 дугаар сарын 4-ний өдөр Тамсагбулагаас маршаар хөдөлж, 19-ний өдөр хүч хуралдуулах район болох Сүхбаатар аймгийн Онгон сумын нутаг Хатавчийн хийд хэмээх газар ирсэн байна.

Хүч хуралдуулах районд ирсэн 6 мд байлдааны цагийн шинэ орон тоо хүлээн авч, үүний дагуу шинэ болон түр цэргүүдийг Онгон, Дарьганга сумын нутагт болон улсын хил давсан хойноо ч хүлээн авч нөхөн хангалт хийжээ.

Монгол, Зөвлөлтийн морьт механикжуулсан бүлгийн командлагчийн тушаалаар 7 дугаар сарын 25-наас Долоннуур, Жэхэгийн чиглэлд давших ангиудыг шилжүүлэн бүлэглэхэд 6 мд Онгон сумын районоос Хонгор сумын районд очиж байрлав. Энд байх хугацаанд шинэ болон түр цэргүүдээр буудлага болон бусад төрлийн дадлага хийлгэж, сум галт хэрэгсэл, хүнс, хувцасны нөхөн хангалт хийж байлдаанд бэлэн болжээ.

Хүч хуралдуулах районд байрласан ангиуд 8 дугаар сарын 6-7-нд шилжих шөнө хөдөлж, улсын хилийн ойролцоо Цагаан овоо, Хашинт уул, Богд уулын районд эхлэх байранд гарахад 6 мд Богд уулын орчимд байрлав. Нэгтгэл, ангийн дарга нар 8 дугаар сарын 8-ны өдөр улсын хил нэвтрэх газрыг судалж тагнасан байна. Орой нь тус дивизэд дайнд орох болсонтой холбогдуулан нам,

эвлэлийн гишүүдийн болон цэргийн алба хаагчдын хурал болж, байлдааны үүргээ нэр төртэй биелүүлэхээ илэрхийлсэн байна.

1945 оны чөлөөлөх дайнд МАХЦ-ийн 5, 6, 7, 8 дугаар морьт дивиз, хэд хэдэн морьт тусгай хороо, 7 дугаар механикжуулсан хуягт бригад, танкийн тусгай хороо, их буугийн тусгай хороо, холбооны тусгай хороо, холбооны тусгай хороо, нисэх холимог дивиз, хими инженерийн тусгай салбар, авто тээврийн тусгай хороо, батальон зэрэг гол анги нэгтгэл, хилийн цэргийн хэд хэдэн отряд, застав, ардын сайн дурын морьт отряд оролцов¹.

Долоннуур, Жэхэгийн чиглэлийн хүч бүрэлдэхүүнд монголын талаас МАХЦ-ийн 5, 6, 7, 8 дугаар морьт дивиз, 9 дүгээр морьт тусгай хороо, танкийн 3 дугаар хороо, холбооны тусгай хороо зэрэг анги, нэгтгэл байв. Үүнээс гадна МАХЦ-ийн 11, 12 дугаар тусгай морьт хороод Завхан, Архангай аймгаас хөдөлж Байшинтын чигт хилийн ойролцоо хүч хуралдуулах үүрэг авсан байлаа. Хошууч генерал М.Зайсановын командалсан нисэх холимог дивиз дайсныг тагнах, холбоо барих, бөмбөгдөх байлдааны тушаал авчээ.

МАХЦ-ийн 5 дугаар морьт дивизийг хошууч генерал Ч.Доржпалам, улс төрийн орлогч бөгөөд улс төрийн хэлтсийн дарга, дэд хурандаа Лувсанлхүндэв, сургагч Андреев, штабын дарга нь хошууч Н.Дугаржав, 6 дугаар морьт дивизийг хурандаа М.Цэдэндаш, улс төрийн орлогч бөгөөд улс төрийн хэлтсийн дарга, дэд хурандаа Чадраавал, сургагч хурандаа Осин, штабын дарга нь хошууч Намсрай, 7 дугаар морьт дивизийг хурандаа Д.Дорж, улс төрийн орлогч бөгөөд улс төрийн хэлтсийн дарга, хурандаа Г.Вандан, сургагч хурандаа Фаварисов, штабын дарга нь хошууч Самбалхүндэв, 8 дугаар морьт дивизийг дэд хурандаа М.Одсүрэн, улс төрийн орлогч бөгөөд улс төрийн хэлтсийн дарга, дэд хурандаа Гомбодорж, сургагч хурандаа Пугаев, штабын дарга нь хошууч Янжив нар командлан байлджээ².

МАХЦ-ийн 5, 7 дугаар морьт дивиз, Фыннин, Жэхэ хот руу шууд давшилт хийв. Түүний зүүн гарыг дайсны дайралтаас халхлах үүрэгтэй Луньхуа хотыг чиглэн монголын 8 дугаар морьт дивиз давшин байлдав. МАХЦ-ийн 6 дугаар морьт дивиз Дунзыгоу тосгон хүртэл зүүн гарын маршрутаар давшиж, тэндээс Гозятунь тийш эргэж, 5, 7 дугаар дивизийн араас давшиж, замдаа японы 700 шахам цэргийг зэвсэг, хэрэглэлийн хамт буулган авчээ.

Энэ чиглэлийн давшилт аадар борооны үеэр тохиолдсон тул гол мөрөн эргээсээ халин, уулын ус хад чулууг нураан урсгаж эвдсэн нь манай анги, нэгтгэл, ялангуяа ууланд давших давшилтыг их хүнд байдалд оруулсаар байв. Гэвч гол хүчинд давшсан МАХЦ-ийн 7, 5 дугаар дивиз, зөвлөлтийн цэрэгтэй хамтран шуурхай давшихдаа 8 дугаар сарын 17-нд Фыннин, 20-нд Луаньпин хотыг эзлэн авч, группийн командлалаас өгсөн байлдааны үүргийг амжилттай биелүүлжээ.

МАХЦ-ийн 7, 8 дугаар дивиз 8 дугаар сарын 19-нд Жэхэ хот, түүний дүүрэгт хүрэлцэн очсон нь дайсны цэргийн гарнизоныг буулган авах явдлыг түргэсгэв³.

¹ Монгол ардын арми 50 жил УБ., 1971 т.200

² Монгол ардын арми 50 жил УБ., 1971 т.204-205

³ Монгол ардын арми 50 жил УБ., 1971 т.209

Монгол-Зөвлөлтийн цэрэг, Жэхэ хотыг эзлэн авч, түүний районд хяналтаа тогтоосноор Квантуны арми, хойт хятад дахь бэлтгэл хүчнээсээ таслагдаж, Өвөр байгалын фронтын гол хүч баруун жигүүрээсээ аюулгүй болсон юм. Жэхэ хотыг эзэлсний дараа группийн командлагчийн тушаалаар МАХЦ-ийн 5, 6 дугаар морьт дивиз давшилтын чигээ баруун өмнө зүгт эргүүлэн Бээжин хот тийш цохилт хийв.

МАХЦ-ийн 6 дугаар морьт дивизийн хошууч Ш.Дарамжавын командалсан 17 дугаар морьт хороо, 8 дугаар сарын 21-ний өглөө Аньзятунь хотыг дайран эзэлжээ. Энэ хотод байсан Японы 8 дугаар явган бригадын 250 офицер, цэрэг, 18 пулемёт, 4 миномёт, хэд хэдэн агуулахыг олзлон авав. Энэ тулалдааны дараа Аньзятунь хотоос зүүн тийш дайсны цэргийн нэг отряд байгаа мэдээ авч түүнийг байлдан тагнуулахаар 6 дугаар морьт дивизийн 17 дугаар хорооны тагнуулын салааг явуулжээ. Салааны дарга дэслэгч Ханан, дайсны ойролцоо очоод өөрийн салааны хүчийг задалж дайсны цэргийн ухрах, зугтах замыг хааж отуулаад, өөрөө морин жолоочийн хамтаар японы цэргийн отряд дээр очиж шаардлага тавьж, дайсны 100 гаруй цэрэг, дарга нарыг буулган авч зэвсгийг хураажээ.

5 дугаар морьт дивиз, үргэлжилсэн ширүүн бороон дундуур гүүр, гарамгүй, үерлэсэн гол мөрөн, намаг, шавар, уул хад, хөндий хавцал зэрэг газар орны саад бэрхшээлийг зоригтой даван туулж, 8 дугаар сарын 21-ний өдрийн 13 цагийн орчим Губейкоу хотод ойртон очив. МАХЦ-ийн 5, 6 дугаар морьт дивиз, гал, маневрын хүчийг чадмаг хослуулан хэрэглэж Губейкоу хотыг чөлөөлөв. Манай цэрэг, Губейкоу хотод байсан Японы 1300 гаруй цэрэг, офицер (тэдгээрийн дотор японы 8 дугаар корпусын штабын дарга, дэд хурандаа Очиг, 31 дүгээр отрядын дарга, хошууч Миядоо нар оролцжээ). 76 мм-ийн их бууны батарей, танк эсэргүүцэх 45 мм-ийн их бууны батарей, хүнд пулемёт 65, хөнгөн пулемёт 44, ротын миномёт 16, винтов 3700 гаруй, галт хэрэгслийн агуулах зэрэг цэргийн үлэмжхэн тооны зэр зэвсэг, эд хогшлыг олзлон авсан байна.

5 дугаар дивизийн 13 дугаар морьт хорооны дарга БНМАУ-ын баатар хурандаа Л.Дандарыг тус хотын комендантаар томилж, японы олзлогдсон цэргийг тусгай байрлуулж, харуул манаа гаргаж, олзолсон бүх зэвсэг, галт хэрэгсэл, эд аж ахуйн зүйлийг хамгаалуулжээ. Үүний дараа морьт механикжуулсан группийн командлагчийн тушаалаар монголын 5, 6 дугаар морьт дивиз бусад ангиудын хамтаар дайсны цэргийн үлэмжхэн хүч хуралдсан Миюнь хотыг эзлэн авахаар давшиж, үерлэсэн Чаохэ голыг гатлан 8 дугаар сарын 22-нд хотод хүрэлцэн очиж, тэндэхийн гарнизоныг бут цохин буулгах бэлтгэлд орсон боловч фронт командлагчийн тушаал хүлээн авч байлдааны ажиллагаагаа дуусгав¹.

Ийнхүү Тамсагбулагийн хэмээн нэрлэгдсэн 6 мд Чөлөөлөх дайнд командлалын тавьсан үүргийг амжилттай биелүүлж байлдааны ажиллагаагаа дуусгасан юм. Тус дивиз бусад ангиудын адил зуны аагим халуунд Цахарын элсэн цөлийг гаталж, аадар бороотойд Хянганы уулсыг давж, Японы цэргийг бутцохих үүргийг нэр төртэй биелүүлсэн байна.

¹Монгол ардын арми 50 жил УБ., 1971 т.209-210

Төр засгаас тус дивизийн олон арван дарга, цэргийг одон, медалиар шагнаж урамшуулсан нь тус дивизийн гүйцэтгэсэн үүргийг өндөр үнэлсний илэрхийлэл юм.

3.3. Монгол ардын хувьсгалт цэргийн 7 дугаар морьт дивиз Чөлөөлөх дайнд.

МАХЦ 1930-аад оноос шинэ бүтэц зохион байгуулалтанд шилжиж эхэлсэн холбогдуулан ЦЯЯ-ны сайд бөгөөд Бүх цэргийн жанжны 1932 оны 3 дугаар сарын 12-ны 41 тоот тушаалаар тус бүр 2 морьт дивиз бүхий морьт корпусуудыг байгуулсан юм. Улмаар 2 дугаар морьт корпусын бүрэлдэхүүнд нутгийн 3 дугаар хороог 7 дугаар морьт дивиз болгон өөрчилж 1932 онд Хэнтий аймгийн төвд байгуулсан түүхтэй.

Бүх цэргийн жанжны 1936 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн 9 дүгээр тушаалаар 7 дугаар морьт дивизийг хуягт хороогүйгээр 2 дугаар сарын 8-ны өдөр Өндөрхаанаас марш үйлдүүлэн мөн сарын 16-ны өдөр Чойрын хавьд суурьшуулахаар шийдвэр гаргасан боловч тухайн үед Монгол улсын дорнод хил хязгаарт дайны аюул занал бодит байдлаар нүүрэлсэнтэй холбогдуулан мөн оны 6 дугаар сарын 14-ний өдрийн БНМАУ-ын ЦЯЯ-ны сайд бөгөөд Бүх цэргийн жанжны 17 тоот нууц тушаалаар 7 дугаар морьт дивизийг 20 дугаар морьт хороогүйгээр Сүхбаатар аймгийн Баяндэлгэр (Хонгор) сумын нутаг Байшинт сүм хэмээх газар шилжин байрлуулжээ.

Тус дивиз нь 19, 20 дугаар морьт хороо, 7 дугаар моторт хороо, Холбооны суман гэсэн салбаруудаас бүрдэж байв. Хүн хүчний хувьд дарга 211, бага дарга, жагсаалын цэрэг 2167 (жагсаалын бус 192), нийт 2596¹ цэргийн алба хаагчтай, зэвсэглэл техникийн хувьд хөнгөн пулемёт 40, хүнд пулемёт 40, танк эсэргүүцэх их буу 4, 76 мм их буу 4, 11 АК станц, ТФТ-20 станц 1, Фаи 10, Баз 7, ачааны машин 34, Пикап 7, тусгай зориулалтын машин 5, зенитийн хоёр амтай пулемёт 5, агт морь 3100 байв².

Цэргийн явдлын Яамны сайд, Бүх цэргийн жанжны 1940 оны 6 дугаар сарын 22-ны 14 тоот тушаалаар 2 дугаар морьт хороог 7 дугаар морьт дивизэд шилжүүлсэнээр тус дивиз гурван морьт хороотой болсон байна.

МАХЦ-ийн 7 дугаар морьт дивизийн удирдлага дайнд бэлтгэх тухай нууц мэдээг 6 дугаар сарын 29-ны өдрийн 17:00 цагт хүлээн авсан бөгөөд ... тус дивизийн байлдааны нэгдсэн мэдээнд дивиз 28-ны өдрөөс эхлэн байлдаанд бэлэн болох талаар бүх бэлтгэл ажилд шилжин орж бэлэн болох³... заасны дагуу тус дивиз байлдааны бэлтгэл сургуулилтыг эрчимтэй явуулж эхэлжээ. Улмаар дивизийн штабаас гаргасан 1945 оны 7 дугаар сарын 11-ны өдрийн № .. тоот тушаалаар дивизийн бүх ангиуд орон тооны ба ар талын хангалтаар бүрэн хангагдаж тухайн өдрийн 17:00 цагт дайчилгааны төлөвлөгөөнд заасан эхлэх байранд гарч 12-ны 21:00 цагт Овоот хийдийн чиглэлд марш үйлдэн⁴ (дивиз гол

¹БХТА. Сх.1 д.1 хн.15 хуудас 18-19.

²Гомбосүрэн Д. "Монгол улсын зэвсэгт хүчний байгуулалтын түүх", УБ., 1998. Тал.195.

³БХТА.Сх.1 д.4 хн.139 Тал.4

⁴БХТА.Сх.1 д.4 хн.140 Тал.2

хүчний ангиудын аюулгүй байдлыг хангах үүрэгтэйгээр) 15-ны өдөр Овоотын районд ирж хүч хуралдуулав.

Энэ үед дивизийн морьт хороод Хонгор уулын сүм*, Онгон, Дарьганга сүм*, Молцог, Баянгол сумдад хориглолтын районуудыг зохион байгуулжээ¹.

Тухайн үед дивиз хүн хүчний хувьд захиран командлах ба улс төрийн тушаалтан дээд дарга 4, ахлах дарга 54, дунд дарга 178, захиргаа аж ахуй, хүн, малын эмнэлэг, техникийн тушаалтан ахлах дарга 18, дунд дарга 48, жинхэнэ хугацааны цэрэг бага дарга 383, адил эрхтэй 137, цэрэг 1624, түр цэрэг ажлын 25, мэргэжилтэн сурагч 23, хөлсний ажилтан 3, эмэгтэй цэрэг 21 бүгд 2518² хүний бүрэлдэхүүнтэй байснаас гадна 6 дугаар морьт дивизээс нөхөн хангалтаар 245 цэрэг³, 9 дүгээр морьт хорооноос 470⁴ хүн тус тус шилжин ирсэн бөгөөд байлдааны орон тоогоор агт морь 5256⁵ байв.

Тус дивиз цэргийн дээд удирдлагаас өгсөн байлдааны тушаалын дагуу 8 дугаар сарын 7-ны өдөр Байшинтын районоос Долнуур (Долоон нуур)*, Жэхэ (Чэндэ)* гэсэн чиглэлээр 950 км давшин байлдах үүрэг хүлээж 8 дугаар сарын 8-ны өдөр Овоотоос хөдлөн гарч хилийн районд хүчээ хуралдуулан 9-ны өдрийн 04:00 цагт улсын хилийг давж⁶ дайсныг гэнэдүүлэн цохих зорилгоор артиллер, авиацийн бэлтгэл хийлгүйгээр марш үйлдэн Хар нуур, Малин гол, Нэргүй нуураар дайран Сэнсрэг хийд (*Шеншингийн*)*-овооны районд хүрэлцэн очсон байна.

Сэнсрэгийн районоос 8 дугаар сарын 10-ны өдөр хөдөлж, Хашаат, 1255 тоот өндөрлөг, Хоёр нуур, Ар худгийн район (*Балуга-Айра*), 11-ний өдөр Богд уулын районуудад хүрэлцэн очив. Энэ үед ундны цэвэр усны хангалт дутмаг болж бие бүрэлдэхүүн, агт морьдоо хангах бололцоо багассан боловч өөрсдийн нөөц бололцоог ашиглан усны нөөцийг бүрдүүлж байжээ.

Дивизийн бие бүрэлдэхүүн марш үйлдэн 8 дугаар сарын 12-ны өдөр Нэргүй нуур, Хэрлэн гол (*Хибгин гол*), Ар цагаан нуурын районд хүрэлцэн очсон. Энэ үед 19 дүгээр морьт хороо, дивизийн толгойн (тэргүүний) ангид үүрэг гүйцэтгэж байв.

Тухайн үед Япончууд цэргийн гол хүчээ Манжуурьн гүнд татсан учраас хил орчмын бүсэд үлдсэн цөөн тооны нэгтгэл, ангиуд төдий л сүрхий эсэргүүцэл үзүүлээгүй юм. Тухайлбал: Авгын Богд уулын орчноос Японы цөөн тооны

* Анх 1762 онд Данзан гүүш да лам, олон ардын хамт 3600 лан мөнгөөр анх байгуулсан. Анх нэг дуган 50 ламтай байж байгаад хожим Агва, Чойр, Дүйнхор зэрэг арван сүм дуган нэмэн байгуулагдаж 1778 онд 154 ламтай болсон байна.

¹ БХТА.Сх.1 д.4 хн.128 х.2-4

² БХТА.Сх.1 д.1 хн.826 Тал.34

³ БХТА.Сх.1 д.1 хн.804 Тал.1-46

⁴ БХТА.Сх.1 д.1 хн.804 Тал 29-46

⁵ БХТА.Сх.1 д.4 хн.203 Тал 1

* Анх 1862 онд Хүү ноён гэгчийн үед 100 ламтай байгуулагдаж байсан бөгөөд Да лам Лодон гэгч 1500 лан мөнгөөр анхны дуган сүм болох Замилин хийдийг бариулж байжээ.

⁶ Пүрэвсүрэн. И "1945 оны дайнд оролцогчдын дуртгал" УБ., 1975. Тал.193-204

* "Монгол цэргийн түүхийн товчоо" номын 370 дугаар тал дээр дурдсан байдаг.

* Чэндэ хотыг тухайн үед Жэ-хэ хэмээн нэрэлдэг байсан. Одоо БНХАУ-ын ӨМӨЗО Хэбэй муж. Чэндэ хот.

*Одоогийн БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө Засах орон. Хэбэй муж. Нуурын гүн 1,237 м (4,058 фут)

морьт цэрэг хилийн ангиуддаа хүч нэмэгдүүлэх зорилготой марш үйлдэж яваад 19 дүгээр морьт хорооны бие бүрэлдэхүүнтэй тулгаран шууд бууж өгчээ.

Тэдгээр цэргийн алба хаагчдын зэвсгийг хураах, байцаан шалгаж, мэдээ олж авах, даалгаврыг тагнуул ангийн дарга Д.Шийдэр (Өвөрхангай. Дөлгөөн)¹, тусгай тасгийн дарга, хошууч Г.Дамдингаа, дивизийн хээрийн шүүхийн дарга, ахмад Р.Цуучил² нар биечлэн хариуцаж, олзлогсодыг бүлгийн штабт хүргүүлсэн байна.

Дивиз Янду сүмийн районоос 8 дугаар сарын 14-нд марш үйлдэн, Панцзян хотоос 7 км-т хүч хуралдуулж тус өдрийн 16:00 цагт Баян-Хүрээ нуурийн баруун хажуугаар хөдөлгөөн үйлдэн Сахай нуураас өмнөд хэсэг Нэргүй өндрийн районд, 8 дугаар сарын 15-ны өдрийн 16:00 цагт Их элстэйн районд 4 км-т³ мөн хүч хуралдуулж, улмаар 16-ны өдөр Шаргандайн өмнөх Нэргүй өндөрлөгийн районоос 160 км марш үйлдэн, бага амралт хийгээд 12:00 цагт Долнуур хотын зүүн талаар өнгөрөн Долнуурын зүүн хойд хэсэгт 3 км зайд дивиз дахин хүч хуралдуулав.

Энэ үед бүх дивизүүдийн 10 хувь нь гол хүчнээсээ хоцорч үлдсэн бөгөөд үүнд байлдааны гол зэвсэглэл болох их буунууд, хүнд пулемёт, миномёт болон бусад төрлийн хөнгөн тээврийн хэрэгслийн ихэнх салбарууд багтаж байсан.

Гэсэн хэдий боловч тус дивиз долоон өдрийн дотор 554 км давшин, 8 дугаар сарын 16-ны өдрийн 12:00 цагийн орчим Зөвлөлтийн 59 дүгээр морьт дивизийн тэргүүний ангиудын хамт Долнуур хотыг чөлөөлсөн юм. Долнуурын районоос Зөвлөлт-Монголын морьт механикжуулсан групп 2 чиглэлээр хүчээ хуваарилан цааш давшилтаа үргэлжлүүлсэн байна.

Үүнд: Баруун чиглэлд Иншан, Чунэлиний нурууны дундуур Зөвлөлтийн 59 мд, МАХЦ-ийн 5, 6, 7 мд Фыннин, Жэхэ хот руу шууд давшилтаа үргэлжлүүлсэн. Гол хүчинд давшсан МАХЦ-ийн 5, 7, 8 мд Зөвлөлтийн цэрэгтэй харилцан ажиллагааг сайтар зохион байгуулсны үр дүнд 8 дугаар сарын 17-ны өдөр Фыннин хотыг эзлэн авсан юм⁴.

Тус хотыг эзлэн авахад дивизийн бие бүрэлдэхүүн үүргээ амжилттай гүйцэтгэсэн бөгөөд баримт дурдвал: Тус дивизийн улс төрийн хэлтсийн орлогч, хошууч Д.Дагжид тухайн үед хотын хамгаалалтын ажлыг хариуцан ажиллах хугацаандаа 1 салаа цэргийн хүчээр дайсны жижиг бүлэгтэй тулгаран байлдаж 10 цэргийг устгаж, 3 цэргийг шархдуулж, 40 цэргийг олзлон авснаас гадна агт морь 60, винтов 50 орчим, хүнсний жижиг склад хоёр, 10000 орчим сум хураан авчээ⁵.

Тухайн өдрөөс эхлэн 7 дугаар морьт дивиз, Зөвлөлтийн 59 дүгээр дивизийн дараа 2 дугаар цувраанд тусгай үүрэг гүйцэтгэж эхэлсэн бөгөөд тус дивиз 8 дугаар сарын 18-ны өглөө хэд хэдэн суурин болох Цзяоцаехэ,

¹БХТА. *Морьт дивизүүдээс “Бид ялав медаль” шагнагдсан дарга, цэргүүдийн нэрийн бүртгэл (лавлагаа мэдээлэл, эрдэм шинжилгээний ажилд зориулав)* УБ., 2010. Тал.134

²БХТА.Р.Цуучилын хувийн хэрэг.№249

³“Российско-Монгольское военное сотрудничество” (1911-1946 167) сборник документов Часы-II Москва-Улан-Удэ 2008 Стр.167

⁴МУБХЯ-НЫ ЭШХ “Монгол цэргийн түүхийн товчоо” УБ., 1996. дэд дэвтэр Тал.371

⁵Пүрэвсүрэн.И “1945 оны дайнд оролцогчдын дуртгал” УБ., 1975. Тал.199

Вейцзыгоумынь, Гоцзятунийг эзлэж¹ ... цааш Луаньхэ голын өмнөд эрэг рүү хөдөлгөөн үйлдэн Луаньпин хотыг эзлэн авсан ... энэ үед газар орны байдал уулархаг, ус гол элбэг цаг агаарын байдал дулаан бөгөөд бороо ихтэй харилцан ажиллагааны талаар муу .. шавар ба даваа нуруу ихтэй учир уналга хөсөг явахад туйлын хүнд байв.

Гэвч байгалийн хүнд хэцүү нөхцөлд цэргийн дээд командлагчаас өгсөн тушаалыг гүйцэтгэсээр ... 1945 оны 8 дугаар сарын 18-ны өдөр Жэхэ хотод тус дивизээс 350 хүний бүрэлдэхүүнтэй морьт хороо орчим хүч хүрэлцэн очсон². ... 8 дугаар сарын 19-ны 23:00 цагт Жэхэ хотын баруун талд 3 км-т³ 7, 8 дугаар морьт дивизүүд хүч хуралдуулсан бөгөөд Жэхэ хотын урд талаас Зөвлөлтийн 59 дүгээр дивиз давшин удирдлагын байр, нисэх онгоцны буудал, төмөр зам, холбооны төв зангилгаа, хотын дотор байсан олон тооны янз бүрийн агуулах, үйлчилгээний байгууллага, авто бааз зэрэг онц чухал объектуудыг устгаж улмаар дайсны удирдах бүрэлдэхүүнд үг дуугүй бууж өгөхийг тулган шаардсанаар Япончууд хүчинд автагдан 8 дугаар сарын 20-нд бүрэн бүрэлдэхүүнээрээ бууж өгчээ.

... тус дивизийн бие бүрэлдэхүүн ар талд хоцорсон тээврийн хэрэгслүүдээ хүлээхийн зэрэгцээ олзлон авсан эд зүйлсийг эмхлэж журамлах ажлыг 18-25 өдрүүдэд хийж дуусгажээ. Улмаар 25-ны өдрөөс эхлэн байлдааны бэлтгэл сургуулийг хээрийн байрлалд үргэлжлүүлж эхэлсэн юм.

Давших байлдааны ажиллагааны явцад дивизийн хэмжээгээр фронтод, байлдааны үед улс төрийн сонсгол 200 гаруй удаа, ухуулагч нарын семинар 87 удаа, сонин уншлага 19 удаа, байлдааны хуудас 368 удаа, цахилгаан хуудас 116 удаа, идэвхтнүүдийн зөвөлгөөн, офицерүүдийн хурал, нам эвлэлийн хурал, элс давахад туслах зэрэг ажлууд явагдсан байна.

...намын байгууллага, гишүүдээс гүйцэтгэх үүргийн тухай, намын эгнээг өргөтгөх, намын гишүүдийн манлайлалыг дээшлүүлэх зэрэг асуудал хэлэлцэгдэж байсан. Намын хурлыг марш, давшилт, их, бага амралтын үед тун богино хугацаанд хийдэг байсан. Энэ хугацаанд дивизийн ангиудаас олон тооны цэргийн алба хаагчид байлдааны үүргээ нэр төртэй биелүүлэхээ илэрхийлж МАХН-д элсэхээр саналаа өгснөөс 351 хүн намын гишүүн болсон байна. Жишээ татвал: Дивизийн холбооны тусгай сумангийн намын үүр *дарга, бага дарга Н.Дэнзэн (Дундговь.Баянжаргалан)*⁴ бүх гишүүдийнхээ хурлын маршийн дундуур болон түр зогсолт, амралт, хоноглох үеийн аль бололцоотой цагийг чадамгай ашиглан намд 61 хүнийг элсүүлсэн байна. Мөн дивизийн МХЗЭ-ийн үүр байгууллага жинхэнэ, орлогчоор 348, эвлэлд 215 хүн элсүүлжээ.

Үүнээс байлдааны үүргийг амжилттай биелүүлээд нам, эвлэлд багтана гэсэн эх оронч өргөдлийг дээрх элсэгчдээс гаргаж байсан жишээнүүдийг дурьдвал: 2 дугаар морьт хорооны байлдагч Н.Минжүүрдорж (Мижиддорж)⁵-оос

¹ Плиев.И.А“Квантуны арми сөнөсөн нь” УБ.,1970. Тал.160

² БХТА.Сх.1 д.4 хн.141 Тал.3

³ “Российско-Монгольское военное сотрудничество” (1911-1946 167) сборник документов Часы-II Москва-Улан-Удэ 2008. Стр.167

⁴ БХТА. Морьт дивизүүдээс “Бид ялав медаль” шагнагдсан дарга, цэргүүдийн нэрийн бүртгэл (лавлагаа, мэдээлэл, эрдэм шинжилгээний ажилд зориулав) УБ., 2010. Тал.117

⁵ Мөн тэнд тал.32

“Би байлдааны хатуу тушаалыг биелүүлэхэд өөрийн амь биеийг өчүүхэн ч хайрлахгүй баатарлаг ялалтыг байгуулж, чадахыг намын өмнө батлана. Иймд намайг намын жагсаалтанд багтаан авна уу” гэж өргөдөл гаргаж байв¹. 7 дугаар морьт дивизийн улс төрийн дарга, дэд хурандаа Г.Вандан, улс төрийн хэлтсийн орлогч, хошууч Д.Дагжид нарын удирдсан нам, улс төрийн байгууллага 1945 оны байлдааны үед хороо, дивизионы дарга, цэргийн түргэн хурал цуглаан 15, онц хурал 8, суман, батарей, рот, салаа, тасаг, тоотын дайчдын хурал цуглаан 40 удаа тус тус хийж байлдааны үеийн цагийн байдал, дээд командын тушаал, өөрийн нэгтгэл, ангиудын үүргийг тайлбарлан танилцуулж байв.

Мөн дивизийн улс төрийн хэлтсээс «Байлдагчдад санамж», «Тагнуулчдад өгөх зөвлөлгөө», «Агт морьдыг хайрлая», «Зэвсгээ бүрэн эзэмшиж дайсныг сум тоолон сөнөөе» гэх зэрэг ухуулах хуудсыг хэвлэн гаргаж бага дарга, цэрэг нэг бүрт гардуулан өгч уншуулдаг байв. Түүнчлэн дивизийн хэмжээгээр байлдааны хуудсыг 380 удаа гаргаж, 496 хүнд баярын бичиг гардуулжээ. Эдгээр ухуулга нь офицер, түрүүч, байлдагчдын байлдах зоригийг улам бадраах, байлдааны арга туршлагыг дэлгэрүүлэх, дутагдлыг засахад чухал зэвсэг болж байсан юм.

Баримт дурьдвал: 7 дугаар морьт дивизийн 20 мх-ны 3 дугаар сумангийн ухуулагч, байлдагч З.Чүлтэм (Сүхбаатар.Баяндэрэм)² ухуулгыг үлгэртэй сайн зохиож байсан төдийгүй өөрөө нэг мориор байлдаан дуустал явсан учир хорооны даргын тушаалаар 8 удаа сайшаагдаж, баярын бичгээр шагнуулж байв.

7 дугаар дивизийн хэмжээгээр байлдаан эхлэхээс дуустал нэг мориор байлдааны үүрэг гүйцэтгээд ирсэн намын гишүүн 99, эвлэлийн гишүүн 101 байв. Энэ нь нам, эвлэлийн гишүүд зөвхөн ухуулагч байгаад зогсоогүй өөрсдийн биеэр амьд үлгэр жишээ болж байсны тод баримт юм. Дивизийн хэмжээгээр фронтод ажилласан ухуулагч 397 ажилласан бөгөөд давшилтын дундуур хороо дивизионы шуурхай хурал, цуглаан 15, хорооны дарга, цэргүүдийн хурал 8, суман батарейн хурал 40 удаа болжээ.

Тус дивизийн 19 дүгээр морьт хорооны тагнуулын салааны байлдагч, гишүүн бус П.Жамсран (Сүхбаатар.Түвшинширээ)³ байлдааны тушаал хүлээн аваад “Би энэ Чөлөөлөх дайнд онц гарамгай ажиллаж эх орныхоо өмнө гавьяа байгуулж чадна” гэж илэрхийлээд байлдааны бүх үед дарга нарынхаа өгсөн тушаалыг онц, сайн биелүүлж, Жэ-хэ хотыг эзлэн авахад тэргүүний эгнээнд давшин орж амжилт гарган засгийн дээд шагнал хүртсэн юм⁴.

Мөн дивизийн 20 дугаар морьт хорооны 1 дүгээр сумангийн салааны дарга, намын гишүүн Б.Чойжилсүрэн (Завхан.Шилүүстэй)⁵ салаагаараа тагнуулд гарах тушаал аваад «Би байлдааны тушаалыг онц, сайн биелүүлж «хэл» заавал барьж ирнэ » гэж амласан бөгөөд тэрээр өөрийн

¹ БХТА.Сх.1 д.4 хн.161 Тал.56

² БХТА. Морьт дивизүүдээс “Бид ялав медаль” шагнагдсан дарга, цэргүүдийн нэрийн бүртгэл (лавлагаа, мэдээлэл, эрдэм шинжилгээний ажилд зориулав) УБ., 2010. Тал.150

³ Мөн тэнд тал.72

⁴ Пүрэвсүрэн.И “1945 оны дайнд оролцогчдын дуртгал” УБ., 1975. Тал.194

⁵ БХТА. Морьт дивизүүдээс “Бид ялав медаль” шагнагдсан дарга, цэргүүдийн нэрийн бүртгэл (лавлагаа, мэдээлэл, эрдэм шинжилгээний ажилд зориулав) УБ., 2010. Тал.137

салааны нөхдийн хамт шөнийн 03:00 цагт БНМАУ-ын хилийг давж, хил орчмын Сэнсрэг хийдэд байрлаж байгаад цаашаа зугтсан Японы офицерын ул мөрийг илрүүлэн олж, улмаар түүнийг мөрдөн хөөж гүйцээд, бүслэн авч сумыг нь барагдтал хий буудуулж байгаад амьдаар нь барьж авчирч амласан үүргээ биелүүлсэн юм¹.

Энэ бүгд нь цэрэг дайчдын зориг хатуужил авхаалж самбаа эх оронч зүтгэлийн гэрч юм. Чөлөөлөх дайны үеэр 7 дугаар морьт дивизээс үрэгдсэн эд зүйлсийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт 3.1.

7 дугаар морьт дивизийн бэлэн буй хувцас хэрэглэл ба байлдаанд үрэгдсэн зүйлүүд²

№	Эд хогшлын нэр	Одоо бэлэн байгаа				
		1	2	3	4	Бүгд
1	Мухар малгай	15	112	1097	374	1598
2	Цэрэг шинель	452	736	1021	237	2446
3	Зуны гадуур цамц	546	533	1277	385	2741
4	Мөн өмд	492	483	1235	584	2794
5	Савхин гутал	235	333	1663	186	2417
6	Дотуур цамц	164	1244	2964	77	4449
7	Мөн өмд	333	1293	2674	646	4946
8	Дарины сав	2343	1262	2822	262	6688
9	Орны даавуу	420	309	1653	44	2426
10	Эсгий гудас	13	572	1056	131	1772
11	Гарын алчуур	2429	540	991	1851	5810
12	Хөлийн ороолт	1150	-	-	1724	2874
13	Суран бүс	166	472	1790	48	2476
14	Байлдааны хувин	431	604	1984	124	2643
15	Зүүдэг сав	100	933	1196	20	2249
16	Бууны оосор	98	548	1348	182	2176
17	Сэлэмний оосор	217	638	1092	156	2193
18	Брезенттэй дайз	93	467	1166	83	1809
19	Ширэн дайз	15	25	32	101	173
20	Цэмбэн хөнжил	170	403	1514	117	2804
21	Хасаг эмээл	231	377	1741	20	2489
22	Хойд богц	240	384	1567	221	2415
23	Урд богц	261	545	1393	124	2607
24	Суран шатар	1398	136	840	87	2461
25	Суран хазаар	267	1344	1617	204	3432
26	Овьёосны сав	133	70	138	-	1588
27	4 дугуйтай тэрэг	-	36	85	-	121
28	2 дугуйтай улаан тэрэг	-	-	88	-	88
29	Халуун тогоо	-	6	24	-	30

¹ МААУТГ “Монголын ардын арми 50 жил” УБ., 1971. Тал. 221

² БХТА. Сх. 1 д. 4 хн. 142 т. 5

30	Санитарын тэрэг	-	-	4	-	4
31	Аптекийн тэрэг	-	-	4	-	4
32	Хатуу тоног	107	110	364	27	608
33	Зөөлөн тоног	-	58	342	28	428
34	Тэмээний хөллөг	-	38	270	53	261
35	Купеттэй майхан	-	795	1500	-	2295
36	Дарга шар эмээл	-	-	8	-	8

Байлдааны ажиллагааны үеэр сөрөг муу зүйл ч гарч байв. Үүнд баримт сөхөөл: Тус дивизийн хуягт дивизионы зэвсгийн дарга, ахмад Дондов тайж Дамиранг буудан алсан, 2 дугаар морьт хорооны салааны дарга Яндаг дотоод Монголын нутагт дээрэм хийж ард иргэдийг айлган сүрдүүлсэн учир (буудуулсан), 2 мх-ны командын салаан дарга Баатаржав давших байлдааны үед ухарч өөрийгөө худал албан тушаалд мэхлэн тавьсан учир, 19 мх-ны цэрэг Лүндэг хөнгөн пулемётоо санаатайгаар хаясан тул шүүхэд тус тус шилжиж (10 жил хоригдох), дивизийн штабын дарга, дэд хурандаа Самбал-Лхүндэв, аж ахуйн орлогч хошууч Лувсан нар удаа дараа архидан согтуурсан учир (албан тушаал бууруулж), холбооны сумангийн салаан дарга, дэслэгч Нямжав буу алдаж бусдын бие мах бодид аюул учруулсан тул (албан тушаал бууруулан цэрэг)¹ (хүснэгт 4 үз.) ... давших байлдааны үед 2 мх-ны түр цэрэг Мандаа, 19 мх-ны шинэ цэрэг Сархад, Чулуун нарын 3 хүн оргож сураггүй алга болсон² ... олон цэргийн алба хаагчид өвчнөөр болон буу зэвсэгтэй харьцах үедээ буу алдаж харамсалтайгаар амь насаа алдах явдал нэлээд гарч байжээ.

Хүснэгт 3.2.

**7 дугаар морьт дивизийн ангиудаас
нас барсан хүмүүсийн бүртгэл³**

№	Овог нэр	Үндсэн захиргаа /аймаг, сум/	Албан тушаал	Тайлбар
1	Цогтын Балдорж	Завхан. Отгон сум 6-р баг	19 дүгээр морьт хорооны салаан дарга, ахлах дэслэгч	Өвчнөөр нас барсан.
2	Самын Нацаг	Хэнтий аймаг. Өмнөдэлгэр сум 3-р баг	19 дүгээр морьт хорооны цэрэг	
3	Норжмаагийн Жамбалдорж	Хэнтий аймаг. Мөрөн сум 1-р баг		
4	Дамдингийн Чинбат	Хэнтий аймаг. Дундбаян сумын 2-р баг		

¹ БХТА.Сх.1 д.4 хн.141 х.54

² БХТА.Сх.1 д.4 хн.161 х.54-55

³ БХТА.Сх.1 д.4 хн.138 х.84-85

5	Дүүрэнгийн Чүлтэм	Баянхонгор аймаг. Баян-Өндөр сум 7-р баг		
6	Баярын Бяхаржав	Сүхбаатар аймаг. Баяндэлгэр сум		
7	Хутагтын Дэмид	Сүхбаатар аймаг.		
8	Хонгорын Ганпүрэв	Хэнтий аймаг Дундбаян сум		
9	Цэенгийн Гончиг	Хэнтий аймаг. Мөрөн сум 2-р баг	2 дугаар морьт хорооны цэрэг	
10	Лувсангийн Ёндон	Хэнтий аймаг. Баянхутаг сум		
11	Бухын Жамбал	Сүхбаатар аймаг. Түвшинширээ сум 1-р баг		
12	Гончигийн Пүрэвжав	Төв аймаг. Бүрэн сум 5-р баг	Сургуулийн суманд тасгийн дарга	
13	Жамсрангийн Лодой	Сүхбаатар аймаг. Баянтэрэм сум 3-р баг	20 дугаар морьт хорооны цэрэг	
14	Очирын Гэндэнравжаа	Төв аймгийн Нялга сум 4-р баг		
15	Дугарын Чилхаасүрэн	Сүхбаатар аймаг. Уулбаян сумын 1-р баг		

Хүснэгт 3.3.

**7 дугаар морьт дивизийн ангиудаас буу алдсан ба шархдаж
нас барсан хүмүүсийн бүртгэл¹**

№	Овог нэр	Үндсэн захиргаа /аймаг, сум/	Албан тушаал	Тайлбар
1	Ноосойн Пүрэв	Ховд аймаг. Мөнххайрхан сум. 9-р баг	19 мх-ны цэрэг	Өөрөө буу алдаж нас барсан
2	Доржийн Даржаа	Хэнтий аймаг. Цэнхэрмандал сум. 2-р баг		Буу алдсаны улмаас шархдаж нас барсан.
3	Гочоогийн Нордов	Өвөрхангай аймаг. Сант сум.1-р баг	20 мх-ны цэрэг	
4	Рэнчингийн Гомбо	Хэнтий аймаг. Өмнөдэлгэр сум. 4-р баг	2 мх-ны цэрэг	
5	Дамдингийн Ширнэн	Говь-Алтай аймгийн харьяат	Авто суманд цэрэг	

¹ БХТА.Сх.1 д.4 хн.138 т.87

6	Доржлхагвын Жанцандорж	Баянхонгор аймаг. Баацагаан сум		
---	---------------------------	------------------------------------	--	--

Хүснэгт 3.4.

**7 дугаар морьт дивизийн ангиудаас хэргийн учир
шүүх таслах газар шилжигсэдийн бүртгэл¹**

№	Овог нэр	Үндсэн захиргаа (аймаг, сум)	Албан тушаал	Тайлбар
1	Жигжидийн Гүнтэв	Архангай. Чулуут. 1-р баг	Хуягтын дивизионд	Шүүхэд шилжиж буудуулсан.
2	Дэндэвийн Дугаржав	Ховдын харьяат 5-р хороо, 3-р хороо	20 мх-ны штабын туслах, ахлах дэслэгч	Шүүхэд шилжин хоригдон байсан.
3	Дарьжавын Мшиг	Баян-Өлгий. Цагаан-Нуур. 2-р баг	20 мх-ны салааны дарга, бага дэслэгч	
4	Доржийн Баатаржав	Увс. Малчин. 5-р баг	2 мх-ны салааны дарга, дэслэгч	
5	Лүндэвийн Яндахай	Дундговь. Сайнцагаан. 9-р баг	2 мх-ны салааны дарга, бага дэслэгч	
6	Ишгэний Дагвадорж	Архангай. Өндөрцогт. 1-р баг	2 мх-ны салааны дарга, дэслэгч	
7	Буучийн Лүнэров	Өмнөговь. Баяндалай. 3-р баг	19 мх-ны цэрэг	
8	Чүлтэмийн Осор	Хэнтий. Баянхутаг. 9-р баг		
9	Гүнсогийн Гомбожанц	Хэнтий. Баянадрага 1-р баг		
10	Санжийн Лувсандорж	Чойбалсан. Баянгол. 10-р баг	19 мх-ны бага дарга	
11	Содномрашийн Цэрэндэжид	Өвөрхангай.	19 мх-ны цэрэг	
12	Бундын Даваа	Увс. 2-р баг		
13	Даривийн Бат	Чойбалсан. Хөгнө. 5-р бага	2 мх-ны цэрэг	
14	Дамбын Лувсанжамц	Хэнтий. Баянхутаг. 4-р баг	Их бууны дивизионд цэрэг	
15	Наянтайн Пүрэв	Чойбалсан. Гурванзагал. 4-р баг	20 мх-ны цэрэг	

¹ БХТА. Сх. 1 д. 4 хн. 138 х. 80-81

Чөлөөлөх дайны явцад 7 дугаар морьт дивизийн Япон, Манж го-гийн талаас олзлон авсан хүн хүч, авто техник, эд хогшлыг нэгтгэн хүснэгтээр үзүүлэв:

Хүснэгт 3.5.

№	Олзлогдсон цэргийн алба хаагч	Тоо	Бүгд
1	Япон офицер	5	906
2	Монгол ноён	4	
3	Лам	13	
4	Япон цэрэг	292	
5	Хятад цэрэг	8	
6	Монгол цэрэг	142	
7	Бага офицер ба цэрэг	442	
Зэвсэглэлийн талаар			
1	Гар буу	48	
2	Маузер	46	
3	Винтов	780	
4	Шувууны буу	2	
5	Автомат	1	
6	Хөнгөн пулемёт	24	
7	Хүнд пулемёт	11	
8	Миномёт	14	
9	Сэлэм	1936	
10	Япон хутга	883	
Галт хэрэглэлийн талаар			
1	Хүнд пулемётын ленин	3280	
2	Жижиг бууны сум	42391	
3	Минийн толгой	368	
4	Мини	5937	
5	Миномётын мини	60	
6	Гранат	1937	
7	Хар дарь	10 авдар	
Цэргийн алба хаагчдын эд хэрэгсэл			
1	Дуран	1	
2	Компус	2	
3	Дарга цүнх	5	
4	Суран бүс	13	
5	Брезинтэн цув	350	
6	Байлдааны цув	400	
7	Баг	2700	
8	Эмээл	300	
9	Дуран	1	
Авто машин			
1	Суудлын	5	

2	Ачааны	9
3	Штабын автобус	2
Тэрэг		
1	2 дугуйтай тэрэг	50
2	2 дугуйтай тэрэг	10
3	Резинэн дугуйтай	6
4	2 дугуйтай тэрэг	130
5	Бүтээлэг	53
6	Татлага олс боодлоор	138
6	Нарийн олс	50

Хүснэгт 3.6.

**7 дугаар морьт дивизийн
Япончуудаас олзлон авсан эд зүйлс¹**

№	Эд хогшлын нэр	Шинэ эд хогшлын тоо	Хуучин эд хогшлын тоо	Бүгд
1	Япон зуны цамц	989	846	1835
2	Зуны өмд	150	773	923
3	Дотуур цамц	2319	1129	3448
4	Дотуур өмд	2159	2034	4193
5	Оймс	-	-	3680
6	Цагаан оймс	-	-	1580
7	Үстэй малгай	43	-	43
8	Хөвөнтэй дээл	713	-	713
9	Хөвөнтэй цамц	185	947	4763
10	Үстэй дээл	-	-	160
11	Үстэй бакель	-	-	100
12	Үстэй зах	-	-	720
13	Үстэй малгай	-	-	1950
14	Хөвөнтэй өмд	159	541	700
15	Хөвөнтэй өмд	-	-	2100
16	Цэмбэн цамц	100	500	600
17	Цэмбэн өмд	101	400	501
18	Цэмбэн хөнжил	280	150	430
19	Хөнжил			646
20	Үстэй дээл	15	-	15
21	Гарын цагаан бээлий	-	-	2438
22	Гарын ноосон бээлий	700	236	936
23	Хөвөнтэй бээлий	-	-	3763
24	Өвлийн шаахай	-	-	2930
25	Эсгий майхан	-	7	7
26	Япон шаахай	435	-	435

¹ БХТА.Сх.1 д.4 хн.142 т.4

27	Гранатын сав	112	-	112
28	Жижиг цагаан аяга	150	-	150
29	Овьёсны сав	122	-	122
30	Байлдааны хувин	36	-	36
31	Ажлын хүрз	34	-	34
32	Сумны дайз	284	-	284
33	Брезентэн ховоо	144	-	144
34	Даавуун майхан	-	2	2
35	Морины тоног	-	60	60
36	Усны хувин	4	-	4
37	Цонхны шил авдраар	30	-	30
38	Хадаас хэлээр	100	-	100
39	Хаалганы нугас ширхэгээр	32	-	32
40	Шалны хулдаас метрээр	35	-	35
41	Сандаг	-	20	20
42	Остоль	-	2	2
43	Нимгэн даавуу толгойгоор	-	-	113
44	Янз бүрийн даавуу метраар	-	-	10950
45	Буудай шуудайгаар	-	-	16
46	Барааны саван	-	-	1390
47	Хөнгөн аяга	-	-	4100
48	Пүү /хэл/	-	-	9

1945 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр 7 дугаар морьт дивиз дээр Бүх цэргийн жанжин, улсын хошой баатар, маршал Х.Чойбалсан хүрэлцэн ирж, давших байлдааны дүн ба хойшид хийх ажлын талаар үүрэг өгсний дагуу 1945 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 16:00 цагт Жэхэ хотоос 7 дугаар морьт дивизийн үндсэн гол хүч нутгийн зүг марш үйлдсэн бөгөөд дивизийн байлдааны журам нь дараах зохион байгуулалттай байв.

Үүнд: 2 дугаар морьт хороо, дивизийн тэргүүний ангид, нэгдүгээр эшелон (цувраа)-нд сэлэмт салбарууд, хоёрдугаар цувраанд дивизийн штаб, жижиг ангиуд, гуравдугаар цувраанд 19 дүгээр морьт хорооны 1 суман, дөрөвдүгээр цувраанд 20 дугаар морьт хороо, мөн хорооны 1 суман ар талд хоцорсон агт морьд, ачаа хөсгүүдийг хариуцан авч явснаас гадна¹ их амралтын үеэр хороонуудын байлдааны журмуудыг байнга өөрчлөж байсан бөгөөд тус дивизийн бие бүрэлдэхүүн Долнуур хот, Ар цагаан нуурт хүрэлцэн очиж агт морьдоо сэлбэн, эцэж тамирдсаныг нь армийн агтад шилжүүлэн байнгын

¹ БХТА.Сх.1 д.4 хн.141 х.38-39

байрлал болох Байшинтад 1945 оны 10 дугаар сарын 11-ны өдөр хүрэлцэн очсон юм¹.

... Жэхэ хотоос буцах марш үйлдэхээс өмнө 7 дугаар морьт дивизийн удирдлагад групп командлагчийн орлогч (дэслэгч генерал Ж.Лхагвасүрэн)-оос хотод байгаа олзлогдсон Япон цэргүүдийг Дорнод төмөр замаар дамжуулан Улаанбаатар хот руу хүргэх тушаал өгсөн бөгөөд энэхүү чухал даалгаврыг биелүүлэхэд 7 дугаар морьт дивизийн хошууч Ё.Нанзаддорж даргатай 19 дүгээр морьт хорооны ихэнх бүрэлдэхүүн, 2, 20 дугаар морьт хороодоос тус бүр 2 салаа орчим цэргийн алба хаагчид оролцсон юм.

Тус хорооны удирдлага олзлогдсон Япон цэргүүдийг жагсаалын цэрэг, дунд ахлах, дээд цолтон хэмээн ангилж, Солонгос, Хятад зэрэг орноос дайчлагдсан цэргүүдийг хэсэглэн хувааж захирах дарга, ахлагч нарыг томилон ажлын 5 батальон, 1 рот болгон зохион байгуулсан.

Үүнд:

- 1 дүгээр батальоны бие бүрэлдэхүүн 994 офицер 5, цэрэг 989
- 2 дугаар батальоны бие бүрэлдэхүүн 978 офицер 5, цэрэг 973
- 3 дугаар батальоны бие бүрэлдэхүүн 985 офицер 5, цэрэг 980
- 4 дүгээр батальоны бие бүрэлдэхүүн 981 офицер 5, цэрэг 976
- 5 дугаар батальоны бие бүрэлдэхүүн 261 офицер 5, цэрэг 257

Офицеруудын ротын бие бүрэлдэхүүн 301 (+25) офицер, цэрэг 4175² нийт 4500, цэргийн алба хаагчдыг 19 дүгээр морьт хорооноос цэрэг, дарга 318, 2 дугаар морьт хорооноос тасгийн дарга 6, цэрэг 61, салааны дарга 3, нийт 70, 20 дугаар морьт хорооноос 72 нийт 459³ цэргийн алба хаагчид 1945 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр Жэхэ хотоос олзлогдсон Япон цэргүүдийг ... 150 км явган марш үйлдүүлж, 3 хоногийн дотор төмөр замын өртөө болох Пинцюань (Бин-Цүн)-д⁴ хүргэсэн бөгөөд тухайн өртөөн дээрээс 865 хүнийг нэмэн авч тэндээс олзлогдсон цэргүүдийг вагонд ачиж, төмөр замын дагуух госпиталиуд болох Мүгдэнд 18, Харбинд 17, Сахалин 171, Манжуурт 58, Отфурнай 7, Благовещенск 29 гэх мэтээр нийт 300 цэргийн алба хаагчдыг цустай чацаг (цусан суулга) өвчний учир олзлогдсоодыг хүлээлгэх комиссын шийдвэрээр дээрх госпиталиудад шилжүүлсэн юм.

Олзлогдогсоодыг тээвэрлэн авч явах хугацаанд нэлээд тооны цэрэг оргохыг завдсан учир буудуулсан байна. Мөн өвчний улмаас 42 япон цэрэг нас барсныг Манжуурын төмөр замын дагуух буудлуудад оршуулсан байна.

Хошууч Ё.Нанзаддорж даргатай 19 дүгээр морьт хорооны бие бүрэлдэхүүн дээд удирдлагаас өгсөн үүргээ нэр төртэй биелүүлж, 1945 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Улаанбаатар хотод Дотоод яамны мэдэлд актаар Японы олзлогдсон 4,986 цэргийг шилжүүлэн өгчээ⁵.

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1945 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 79 дүгээр хурлын тогтоолоор байлдааны үүргээ нэр төртэй биелүүлсэн

¹ БХТА. Сх-1. д.4 хн.112 Тал.56-59

² БХТА.Сх.1 д.4 хн.117 Тал.45

³ БХТА.Сх.1 д.1 хн.804 Тал.47-56

⁴ Дашдаваа.Ч “Японы олзлогдогсод” УБ., 2013. Тал.27

* Ч.Дашдаваа судлаачийн номонд дурдсан хот.

⁵ БХТА.Сх.1 д.4 хн.117 Тал.41

дайчдыг төрийн дээд одон, медалиар шагнаан урамшуулсан бөгөөд тус дивизийн нийт бие бүрэлдэхүүнээс Улаан тугийн одон 16, Алтан гадас одон 20 (5 эмэгтэй цэргийн алба хаагч), Байлдааны хүндэт медаль 5, Хөдөлмөрийн хүндэт медаль 2, “Бид ялав” медалиар давхцсан тоогоор 3233 цэргийн алба хаагч шагнагдсан түүхтэй.

3.4. Монгол ардын хувьсгалт цэргийн 8 дугаар морьт дивиз Чөлөөлөх дайнд.

Дэлхийн хоёрдугаар дайны төгсгөлд БНМАУ-ын Засгийн газар Японы эсрэг дайнд оролцох бэлтгэлийг шуурхайлан хийж байв. БНМАУ-ын Засгийн газар, цэргийн дээд командлалаас МАХЦ-ийн нэгтгэл, ангиудыг байлдааны ажиллагаанд бэлтгэж, тэднийг орон тоо, байлдааны техник, зэвсгээр хангах, жигдрэлт, гар нийлсэн ажиллагааг хангах талаар олон чухал арга хэмжээ авав. МАХЦ-ийн хэмжээнд 1945 оны хавар, зун армийн нөхөн хангалт 69,0 хувь байсны дотор 8 мд-ийн морьт хороод 45 хувь, их буугийн дивизион 86 хувь, хуягт дивизион 100 хувь, холбооны тусган суман 70 хувь, бусад салбарууд 113 хувь, дивизийн хэмжээнд 60 хувь нөхөн хангагдсан байв.

МАХЦ-ийн дайнд оролцох нэгтгэл, ангиудыг 1945 оны 7 дугаар сарын 4-20-нд Сүхбаатар аймгийн Онгон, Молцог хийд, Хонгор сумын районд шилжүүлэн бүлэглэж хүч хуралдуулсны дотор 8 мд 7 дугаар сарын 8-20-нд Өндөрхаанаас хөдөлж 325 км марш үйлдэн Хонгор суманд ирж байрлав. Дивиз хүч хуралдуулах районд гарсан тухай штабын дарга Ч.Янжив дурдатгалдаа тэмдэглэсэнээр: “Байшинт, Овоотын чиглэлийн газар орны байдлыг судалж, марш хийхэд бэлтгэ гэсэн маршал Х.Чойбалсангийн гарын үсэгтэй маш нууц цахилгаан утсыг 7 дугаар сарын 2-нд хүлээн авав. Би энэ тушаалын ёсоор өөрийн сургагч хошууч Кирновын хамт Овоот, Баянгол хүртэл явж газар орны байдлыг судлан дивизийн явах зам, хоноглох, өнжих, амрах газар, булаг шанд, худаг усыг газрын зураг дээр тэмдэглэн авч маршаар хөдлөхөд бэлтгэв. Ингээд Бүх цэргийн жанжны тушаалаар 7 дугаар сарын 10-нд манай дивиз Байшинтын чиглэлд түргэн жагсаалаар хөдөллөө. 5 өдрийн марш хийж Сүхбаатар аймгийн Онгон сумаас урагш 25 км зайтай газар байрлаж улс төр, байлдааны бэлтгэл сургуулиа үргэлжлүүлэн байлдагчдыг хүлээн авч сургаж эхлэв... Бүлгийн штабын 1945 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн тушаал ёсоор манай дивиз Овоотын районд шилжин байрласан...”¹ гэж дурдсан байна.

8 мд-ийн байлдааны ажиллагааг дэд хурандаа Мядагийн Одсүрэн, улс төрийн орлогч хурандаа Дэндэвийн Гомбодорж, штабын дарга хошууч Чойжоогийн Янжив нар удирджээ. Тус дивизийн 22 мх-ны дарга Жавын Балдандорж, улс төрийн орлогч хошууч Минжүүрийн Дамжин, штабын дарга ахмад Луузангийн Бямбаа; 23 мх-ны дарга хошууч Чойн Дугаржав (хожим БНМАУ-ын баатар), улс төрийн орлогч ахмад Дамирангийн Халзхүү, штабын дарга хошууч Дарийн Бүтэмж; 34 мх-ны дарга хошууч Балжирын Сүрэнхорлоо, улс төрийн орлогч ахмад Тогтохын Дэндэв, штабын дарга ахмад Дарьжавын Мижид; 8 дугаар хуягт дивизионы дарга ахмад Бямбажавын Бухаа, улс төрийн орлогч хошууч Дашзэвэг, штабын дарга хошууч Дашдоржийн Цоож; 8 дугаар их

¹ “1945 оны дайнд оролцогчдын дуртгал”. Эмхэтгээсэн И.Пүрэвсүрэн. УБ., 1975.

бууны дивизионы дарга ахмад Дагвын Уламнэмэх, улс төрийн орлогч ахмад Мөнхийн Дамдин, штабын дарга ахмад Намсрайн Гэндэн нар тус тус ажиллажээ.

Бүлгийн командлагч генерал И.А.Плиев 8 дугаар сарын 7-ны өдөр дивизийн дарга, орлогч, штабын дарга, сургагч нарыг штабтаа дуудаж бүх анги, нэгтгэл Дарьгангын Нарангийн отрядаас урагш хил дээр байгаа Баянбулгийн районд хүч хуралдуулах тушаал өгчээ.

8 мд түгшүүрийн дохиогоор хөдлөн шөнийн марш хийж, 8-ны өглөө заасан газарт (эхлэх байранд) хүрэлцэн очив. Энд тус дивиз бүлгийн командлагчийн 1945 оны 8 дугаар сарын 8-ны № 002 тоот байлдааны тушаал хүлээж авав. Уг тушаалаас 8 мд-д холбогдох хэсгийг сийрүүлбэл: “8 мд бүлгийн резервт улсын хилийг “Ч+4” цагт давж Хар толгой уул, Хашаат, Шеншин овоо, Хасату, Балугагийн чиглэлд хөдөлгөөн үйлдэж, эхний өдрийн төгсгөлд Мелик гол, Хашаатын районд, хоёр дахь өдрийн төгсгөлд Шеншин овоо, Тайпу-усул; гурав дахь өдрийн төгсгөлд Балуга Айра (Бэй), Ар Хашаатын Районд гарсан бай” гэсэн үүрэг авсан байна.

МАХЦ-ийн ангиуд 7 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн Өвөр Байгалийн фронтоос (махнаас бусад) хангагдах болсон бөгөөд 8 мд улсын хил давах үедээ гурил 10, будаа 25, элсэн чихэр 15, мах 16, тос 9 хоногийн нөөцтэй болсон байв.

Дивизийн удирдлага дээрх тушаалыг биелүүлж 1945 оны 8 дугаар сарын 8-ны 20.00 цагт Дарьганга сумын нутаг Хар нуурт байрлаад маргааш нь 9-ний өглөө 4.00 цагт 1350 тоот өндөрлөгийн орчмоор улсын хил давсан байна. Энэ тухай жирийн байлдагчийн үгийг дурдъя. 8 мд-ийн 23 мх-ны байлдагч МХЗЭ-ийн үүрийн дарга Эрэнцэнгийн Лувсанбалдан хожим бичихдээ: “Бид Дарьганга нутгийн Богд уулын зүүн сугаар хил давах байсан юм. Би өөрөө Дарьганга хүн. Төрсөн нутаг Сүүжийн Ухаа Овоот хил дээрээс бараг бараа харагдах газар байгааг бодохоос дайсанд сөөм ч газар өгөхгүйн төлөө тулалдана гэдэг зориг эрмэлзэлтэй байж билээ. Би анх 1944 онд цэрэгт ирснээс хойш өнгөлөн далдлах, буудах, цавчихад шамдан суралцдаг байсан маань одоо хэрэг болох нь гэж бодож байлаа. Манай хороо дивизийн авангардад гарч хил давлаа”¹ гэсэн байдаг.

Улсын хилийг давахад Халхын голын байлдаанд гарамгай байлдаж, их туршлагажсан Ч.Дугаржавын удирдсан 23 мх тэргүүний ангид томилогдож, дивизийн гол хүчний ажиллагааг хангажээ. Тус дивиз байлдааны тушаалыг биелүүлж гол хүчээрээ өглөөний 04 цагт улсын хилийг давж 9-ний өдөр 60 км урагшлан Сэнсэнгийн хийд өнгөрч түр амралт хийжээ. Энэ үеэр японы харуулын 5 цэрэг тугаа нэг богцонд хийж зугтаж яваад төөрч дивизийн цуваанд орж ирэхэд нь олзлон авчээ.

Бүлгийн командлагч 1945 оны 8 дугаар сарын 10-ны өдөр №003 тоот байлдааны тушаал гаргаж нэгтгэл, ангиудын үүргийг тодотгосон байна. Энэ тушаалаар:

“8 мд Нуур (Балуга-Айраас зүүн тийш 5 км), Бохто уулын чиглэлд хөдөлгөөн үйлдэж, 1945 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн орой тэргүүний отрядаа Сүнит уулаас зүүн тийш 10 км-т буй Нуурын районд, гол хүчээрээ

¹ Монгол-Зөвлөлтийн ахмад дайчдын дуртгал. УБ., 1969

Балуга-Айраас зүүн тийш 2-5 км-т байгаа нуурын районд гарах; 08.12-ны өдрийн төгсгөлд тэргүүний отрядаа нуураас өмнө 1 км-т, гол хүчээ Бахта-Ула, түүнээс өмнүүрх районд хуралдуулсан бай” гэжээ.

Ийнхүү 8 мд 10-ны өдөр Хамба ламын хийдийг эзлэн авч түр амралт хийгээд Арцагаан нуурын чигт давшжээ. 12-ны өглөө Ар цагаан нуурын районыг эзлэн авч, түр зогсолт хийн нэмэгдэл шинэ цэрэг хүлээн авч анги, салбаруудад хуваарилан өгч, агт морь, буу зэвсгээр хангаж хүчээр зузаатгажээ. Арцагаан нуурт бүлгийн командлагч анги, нэгтгэлүүдийн маршийн дүнг гаргаад Цахарын цөлийг хэрхэн гатлах, Долоннуур хотыг авах байлдааны тушаал өгсөн байна. Энэ тушаалаар генерал Ю.Цэдэнбал, С.Равдан нар 8 мд-ийг заасан районд гаргах үүрэг авсан байна. Дивиз цааш давшиж Янду сүмийг 13-ны өдөр эзлэн авч, улмаар Бүлгийн командлалын шийдвэрээр 8 дугаар сарын 16-нд Долоннуур хотыг эзлэн авах тушаал авчээ.

Ийнхүү Хаалган-Долоннуурын давших операцийн II шат эхлэв.

Операцийн II шат 8 дугаар сарын 15-20 хүртэл үргэлжлэв. Энэ үеийн агуулга нь Квантуны армийн үндсэн хүчийг Манжуурын тэгш талд бут ниргээд улс төр, эдийн засгийн маш чухал төвүүдийг чөлөөлж, японы цэрэг үй олноор бууж өгөхийн эхлэл байсан юм.

МАХЦ-ийн Долоннуурын бүлэглэлийн гол хүч 300 км гаруй үргэлжилсэн Цахарын элсэн цөлийг туулж 8 дугаар сарын 17-нд Долоннуурыг эзлэн авсан явдал энэ чиглэлд хориглолтод шилжих гэсэн Японы командлалын оролдлогыг тасалдуулав.

8 мд-ийн байлдааны маршийн замд ихээхэн бэрхшээл тохиолдож байв. Жишээлбэл, улсын хилийг давахад 400 гаруй хүн эмээл хазаар, уналгагүйгээс болж явганаар гарсан бөгөөд Долоннуур хотод 140 гаруй хүн явган оржээ. Арцагаан нуураас дивиз маршрутын дагуу цуварч эхэлсэн бөгөөд агаарын машинууд бензин байхгүйгээс хоцорчээ. Бас их буу, миномёт, хүнд пулемётын хөсгийн морь, тэмээ явж чадахгүй болжээ. Их элсийг морьт анги штабын ганц автобустай туулж Долоннуурт хүрсэн байна. МАХЦ-ийн нэрт дарга Ж.Лхагвасүрэн: “Цахарын 70 км элсэн манханыг гатлахад армийн зүтгэх хүчин, автотехникт хүнд шалгалт болсон юм. Энэ нь тэр байлдаанд оролцож байсан хүн бүрийн санаанаас мартагдахгүй билээ. Энэ элсэн манхнаас эхлэн ар тал гол хүчнээс тасарч, цэрэг ангийг хангахад бэрхшээл тулгарсан юм. Бүх хүнс тэжээл ачсан машин техник элсэн манханд саатаж шатахуунаа дуусах, ангиа гүйцэхгүйд хүрсэн нь цэргүүдийг хангахад сүрхий бэрхшээл тулгарсан боловч цэргийн командлал бүхий л аргыг сүвэгчилж, түүний агаар, газраар нийлүүлэх шуурхай арга хэмжээ авч байлаа”¹ гэж онцлон тэмдэглэжээ.

“Өмнөд” бүлгийн командлал Жэхэ хотын чиглэлд давшилтыг яаралтай үргэлжлүүлэх шийдвэр гаргахдаа доорх хэдэн зүйлийг эш үндэс болгосон байна. Энэ нь:

Нэгдүгээрт, хур бороотой үед давшилтаа үргэлжүүлэх нь дайсныг гэнэт довтлох бололцоог хэвээр үлдээнэ. Японы командлал манай цэргийн үйл ажиллагааг өөрсдийн байр сууринаас үнэлж, Зөвлөлт-Монголын цэрэг идэвхтэй давшина гэж хэрхэвч санаанд нь орохгүй.

¹ Монгол-Зөвлөлтийн армийн ахмад дайчдын дуртгал. УБ., 1969. 253-254 дэх талд

Хоёрдугаарт, нэн даруй давшилтаа үргэлжлүүлэх явдал дайсны харилцан ажиллагаа алдагдаад байгаа үеэр нь атаклах бололцоо олгох ашигтай байв.

Гуравдугаарт, бороо хуртай үед дайсан нисэх хүчээ ашиглах бололцоогүй нь мэдэгдэж байв.

Ингээд 8 дугаар сарын 16-ны өглөөнөөс давшилтаа сэргээн Жэхэ тийш очих хоёр замын дагуу хийхээр төлөвлөжээ. Жэхэ хот бол Өвөр Байгалийн фронтын баруун жигүүрийн байлдааны ажиллагаанд нөлөө үзүүлэх чадал бүхий ойрын томоохон бүлэглэлтэй холбосон агаарын зам, төмөр замын гол шугам, засмал зам дайран гардаг стратегийн чухал түшиц газар байсан юм.

- 8.18-нд 5.00 цагт Дуньалечаод хүрэлцэн очиж тэргүүний районд явсан 34 мх тус хотын гарнизоныг буулган авч офицер 1, бага дарга 3, цэрэг 87, нийт 91 хүн, 98 винтов олзолжээ.

- 8.18-нд цааш хөдөлгөөнөө үргэлжлүүлэн Дуншинцзын районд хүрэлцэн очиход тэргүүний ангид 22 мх ажиллав. Тэнд 17.00 цагт дайсны явган батальоныг (12 ях-ны 13 яб), 22 мх, 34 мх бүслэн буулган авч офицер 7, бага дарга 5, цэрэг 160, нийт 172 хүнийг винтов 160, пулемёт 6, миномёт 8, хоёр дугуйтай ачааны тэрэг 10-ын хамт олзолжээ.

- 8.18-ны 13.00 цагт дайсны 2 дугаар холимог бригадын 22 ях-ны дарга хурандаа Ли овогт тэргүүтэй 500 гаруй дайсныг буулган авчээ.

- 8.18-ны 24.00 цагт Лунхуа хотын районд гарч Иматухэ голыг гатлах үеэр 3 цэрэг усанд унаж нас барсан байна.

- 8.19-нд 23 мх дайсны 257 цэрэг, офицерыг буулган авч винтов 242, маузер 62, пулемёт 6-г олзолжээ.

8 мд тагнуулыг сайтар зохион байгуулж чадсанаар бүх маршрутын дотор дайсны тусгай гарнизонуудыг илрүүлэн, тэднийг бүслэн буулган авч байсныг тэмдэглэх хэрэгтэй. Энэ талаар 22 мх-ны тагнуул ангийн дарга ахмад Батын Таяа дурдатгалдаа тодорхой өгүүлсэн байдаг. Тэрээр 8 дугаар сарын 20-ны шөнө Их Хянганы нүруу, Луаньхэ голын районд байсан дайсныг хэрхэн буулгаж авсан тухай бичихдээ: “Би 32 хүнтэй, хүн бүр хос морьтой, хоёр салаан дарга, таван бага дарга, хоёр хөнгөн пулемётчин, 15 онц буудагч бусад нөхдийн хамт тагнуулын үүрэг гүйцэтгэхээр... хөдөлж зүүн хойд Хятадын нутаг Луаньхэ тосгоны орчим японы ихээхэн хүч хориглож байсныг илрүүлэв. ...Бүх хүмүүсээ хориглуулаад салааны дарга О.Лувсанжамц, хөнгөн пулемётчин Дэмчиг, Гомбо, мэргэн буудагч Чойжамц, Дашзэвэг нарыг дагуулан японы ангийн штабт орж... Монгол-Зөвлөлтийн цэргийн ангиуд бүсэлж авсан. Та нар зэвсгээ хураалгаж үг дуугүй бууж өг” гэдэг шаардлага тавьсан байна. Тэгээд японы цэргийн дарга нар бууж өгөхөөр шийдвэрлэж цугларах бүрээ үлээхэд 700 гаруй цэрэг жагссаныг олзлон авчээ.

- 8.20-ны 17.00 цагт Луаньпин хотыг эзлэн авснаар дивизийн байлдааны ажиллагаа дуусаж, улмаар 22-ны өдөр хүртэл сэлэмт салбарууд хүчээ хуралдуулав. Харин их буут анги 8.28-30-нд очсон байна. Учир нь морьт дивизүүдийн хуягт дивизион, их буут ангиуд Цахарын элсний районд шатахуунгүй болж элсэн манханд суух зэргээр маршаас ихээхэн хоцорсон юм. 8

мд-ийн түүхэнд бичсэнээр “Толгойн анги Жэхэ хот хүрч байхад хоцорсон зарим анги, салбар нь дөнгөж Долнуур хүрч байв”¹.

Энэ аянд биеэр оролцсон түүхч Э.Лувсанбалдан хожим дурсахдаа: “Өдөр, шөнөгүй урагшилсаар Их Хянганы нурууг давахад морь, хүн аль аль нь нэлээд ядарч билээ. Алдар цуутай энэ нуруу нь мал идэх өвсгүй, намрын борооны манан буданг орой дээрээ суунаглуулсан шовх оргилууд олонтой. Тэр манан доошилж ирмэгц гэнэт гэнэт усан бороо асарна. Бид хувцасныхаа усыг гоожуулсаар урагшилж байв...”

Эгц давахын аргагүй давааг баруун, зүүн тийш нь хөрөөдсөөр яваа морьт цэргийн цувааны сүүлчийг харахад могой шиг мушгирсан аймаар ч юм шиг, сонин ч юм шиг үзэгддэгсэн. Хэрэв морь, хүний аль нэг нь үл ялих хазгай гишгэвэл уулын өндрөөс ёроолд нь хүртэл нисэх нь тэрээ”² гэж бичсэн байдаг.

Бүлгийн командлагч И.А.Плиев: “Бид цэргээ Долнуурт ч амруулах бололцоо байсангүй. Уулархаг нутгийн нөхцөл байдлаас болж хурдавчлан давших тэмцлийн гол хүнд нь улам бүр морьт цэрэгт оногдох боллоо”³ гэж онцлон тэмдэглэжээ.

МАХЦ-ийн “Өмнөд” бүлгийн дайчдын эрэлхэг гавъяаг ЗСБНХУ-ын Зэвсэгт хүчний ерөнхий дээд командлал өндөр үнэлж: “Зөвлөлт Холбоот Улсын маршал Малиновскийн командалсан Өвөр Байгалийн фронтын цэрэг, маршал Чойбалсангийн командалсан монгол армитай хавсарч Японы Манж-Далай нуур ба Халуун Рашааны бэхэлсэн районыг цөмлөн Их Хянганы нурууг даваад Монголын тал хээр газрыг гатлан 950 км урагш давшиж Чанчунь, Мугдэн, Цицигар, Жэхэ, Дайрэн, Порт-Артур хотуудыг эзлэв.

Алс Дорнодын байлдаанд МАХЦ-ийн хошууч генерал Доржпалам, хурандаа Цэдэндаш, хурандаа Дорж, дэд хурандаа Одсүрэнгийн морин цэргүүд, хурандаа Нянтайсүрэнгийн танкчид гарамгай байлдав.

Өнөөдөр 8 дугаар сарын 23-ны 22 цагт манай эх орны нийслэл Москва хот эх орныхоо өмнөөс... манай эрэлхэг Өвөр байгалийн ба Алс Дорнодын цэрэг, Номхон далайн флот, мөн маршал Чойбалсангийн монгол армид 324 их буугаар 24 удаа зэрэг буудаж ёслоё”⁴ гэж тэмдэглэжээ.

Дайнд оролцсон 8 мд их ялалтын баярыг 9 дүгээр сарын 3-нд Луаньпин хотод ёслон тэмдэглэхэд маршал Х.Чойбалсан тэргүүтэй цэргийн дээд командлал оролцож, энэ ажиллагаанд дивизээрээ ялалтын парадын жагсаал хийж ёслолын буудлага үйлдсэн байна. Х.Чойбалсан энд болсон ялалтын цуглаан дээр хэлсэн үгэндээ: “Та нар богино хугацааны дотор их амжилтын ялалтыг хийсэн байна. Ийм учраас н.Сталины тушаалаар манай армийг өндрөөр үнэлсэн билээ. Ийм их амжилтыг гаргасан боловч дутагдал байна. Зарим нэг хүмүүс Дотоод Монголын номхон шудрага ард түмний эд хөрөнгийг зүй бусаар дээрэмдсэн байна. Энэ бол манай армид туйлын жигшүүртэй хэрэг

¹ 1945 оны дайнд оролцогчдын дуртгал. Эмхтгэсэн И.Пүрэвсүрэн. УБ., 1975. 212-213 дахь талд

² Монгол-Зөвлөлтийн ахмад дайчдын дуртгал. УБ., 1969. 302 дахь талд.

³ Плиев И.А. Говь Хянганд тулалдсан нь УБ., 1966. 120 дахь талд.

⁴ Монгол-Зөвлөлтийн харилцаа. II боть. I хэсэг. УБ., 1981. 144 дэх талд.

мөн. Харин хойшид энэ муухай явдлыг миний чихэнд бүү дуулгаарай”¹ гэсэн байна.

Дайны дундуур орос, монгол цэргүүдээс Өвөр Монголын хүн амаас мал сүрэг, эд хөрөнгийг хууль бусаар булаан авах явдал гарч байжээ. Бүр дайны эхэнд бүлгийн командлагч И.Плиев, штабын дарга Никифоров нарын 197 тоот тушаал гарч “хоол хүнсний зүйлийг татан ирүүлэх ажиллагаа тасалдан саатах ахул анги, нэгтгэлүүдийн командлалаас орон нутгийн байгууллагуудаар дамжуулан юуны урьд баячууд ба сүм хийдийн малаас авч болохыг зөвшөөрсүгэй”² гэсэн заалт ч зохих нөлөө үзүүлсэн биз ээ.

Луаньпинд тус дивиз байрлан буцах маршид бэлтгэж байх үед байлдааны туг (шинэчилсэн загвар) гардуулах ёслол болжээ. ЦЯЯ-ны сайд Бүх цэргийн жанжны орлогч дэслэгч генерал Ж.Лхагвасүрэн 8 мд-ийн байлдааны тугийг 1945 оны 9 дүгээр сарын 9-нд дивизийн дарга дэд хурандаа М.Одсүрэнд гардуулжээ. Тэрээр дивизийн анги, салбаруудын төлөөлөгчдийн баярын цуглаан дээр хэлсэн үгэндээ Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн даалгавраар тус дивизэд Байлдааны тугийг гардуулж байгааг тэмдэглээд “... МАХЦ Улаан цэрэгтэй мөр зэрэгцэн явж Хойд Хятад ба Дотоод Монголын хэдэн сая ард түмнийг Японы фашистын дарлагдлаас бүрмөсөн чөлөөлсөн байна. Энэхүү чөлөөлөгч ариун дайнд 8 дугаар дивиз гарамгайгаар оролцсон явдал манай армийн байлдааны түүхэнд онцгой суурийг эзэлж байлаа. Нөхөд офицер, түрүүч, байлдагчид аа! Энэхүү байлдааны улаан тугийн дор ялалтаас ялалтад хүргэхийн төлөө урагшаа”³ гэжээ.

Энэ баяр ёслолын ажиллагаанд морьт хороо бүрээс морьт суман, нийтдээ 380 хүн жагсаж дивизийн штабын дарга хошууч Янжив командалсан байна. Цуглаанд 22 мх-ны дарга хошууч Балдандорж, 23 мх-ны дарга хошууч Дугаржав, морьт сумангийн дарга ахлах дэслэгч Лувсандорж, Дамбажамц, дэслэгч Юндэндорж, батарейн дарга ахлах дэслэгч Чулуунбаатар, салбарын улс төрийн орлогч дэслэгч Сүрэн, Дэндэв, салаан дарга бага дэслэгч Хажид, Гүр, Шарав, Дамдин, Чимэд зэрэг офицер оролцжээ. Байлдааны тугийн ассентад 22 мх-ны салааны дарга бага дэслэгч Янжив, 34 мх-ны салааны дарга бага дэслэгч Цогт, 22 мх-ны 1 дүгээр сумангийн салааны туслах ахлах түрүүч Лханаажав нар томилогдсон аж.

8 мд-ээс 1945 оны чөлөөлөх дайнд гэнэтийн осол, өвчин зэрэг байлдааны бус хохирол нь офицер 1, цэрэг 6, бүгд 7 хүн болжээ.

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн орлогч дарга Дашзэвэг 1945 оны 11 дүгээр сарын 16-нд 8 мд-д хүрэлцэн ирж дайчдад одон медаль гардуулжээ. Үүнд: шагналыг хоёр ээлж болгон олгосон бөгөөд М.Одсүрэн, Д.Гомбодорж, Ч.Янжив, Доржрэнцэн, Загд, Ч.Дугаржав нарын 62 хүнийг Байлдааны гавъяаны улаан тугийн одонгоор, Т.Дэндэв, М.Дамдин, Д.Халзхүү, Содном-Очир, Жамъяншарав, Сүндэв нарын 84 хүнийг “Алтан гадас” одонгоор, Банзрагч, Дашхүү, Цэрэн-надар нарын 150 гаруй хүнийг Байлдааны хүндэт медалиар, 15 хүнийг Хөдөлмөрийн хүндэт медалиар, нийтдээ дивизээс 314 хүн шагнагдсан

¹ ЗХТА. ф.1, т.3-1, хн. 475, хуудас 17-18.

² Мөн архив. Ф.3, д.1, хн.264, хуудас 39-40.

³ Мөн архив. Ф.1, т.3-1, хн. 475, хуудас 17

байна¹. Баярын бичгээр 1575, байлдааны хуудсанд 2467, цахилгаан хуудсаар 1275 хүнийг алдаршуулж, 1242 хүн сахилга журмын сайшаал хүртсэн байна.

ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн зарлигаар 8 мд-ийн дарга М.Одсүрэнг Байлдааны гавъяаны улаан тугийн одонгоор шагнасан юм.

1945 оны 8 дугаар сарын 22-ноос 9 дүгээр сарын 15 хүртэл хорь гаруй хоног буцах маршийн бэлтгэл хангав. Тухайлбал, цэргийн дээд командлалын шийдвэрээр буцах маршийн замд хүнсний бааз байгуулж, Долоннуурт байрласан 9 мх, цэргийн нөөц агтаас морьд сэлбэх, артиллери зэрэг хүнд зэвсгийг машинаар тээвэрлэх арга хэмжээг урьдчилан авсан байна. Энэ бүхэн нь буцах маршийг богино хугацаанд, зохион байгуулалттай, эмх дэгтэй үйлдэх бололцоо олгосон байна. Буцах маршийн хурдыг 30-35 км/ц-аар тогтоосон байна.

Маршийн бэлтгэлийг ийнхүү хангаад 1945 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 05.00 цагт армийн бусад ангиудын хамт 8 мд буцах маршаар нэгэн зэрэг хөдөлжээ. Энэ маршийг 20 гаруй хоног үйлдэж 1945 оны 10 дугаар сарын 8-нд Өндөрхаан хотод байнгын байрлалдаа эргэж ирсэн байна.

Хүснэгт 3.7

Дайны төгсгөлийн үеийн 8 мд-ийн хүч бүрэлдэхүүн (1945.09.11)

№	Бие бүрэлдэхүүн, зэвсэглэл	Орон тоо	Дансаар	Бэлэн буй	Замд яваа	Өвлийн байранд
1.		352	323	228	71	24
2.	Бага дарга	1200	587	397	138	52
3.	Цэрэг	2612	3575	2824	525	226
4.	Бүгд	4164	4485	3449	634	302
5.	Агт морь	4221	4351	3686	575	88
6.	Винтов	3044	2931	2107	402	422
7.	Танк эсэр. Буу	57	42	42	-	-
8.	ППШ (автомат)	323	358	348	8	2
9.	Хөнгөн П.	107	141	104	37	-
10.	Хүнд П.	36	36	36	-	-
11.	Том калибрийн	3	3	3	-	-
12.	Зенитийн	9	9	-	9	-
13.	50 мм-ийн	27	27	18	9	9
14.	120 мм-ийн	4	4	4	-	-
15.	45 мм-ийн	9	9	9	-	-
16.	76 мм-ийн	12	12	12	-	-
17.	Хөнгөн	10	8	-	8	-
18.	Дунд	10	12	-	12	-
19.	Автомашин	96	56	-	56	-
20.	Радиостанц	18	7	1	6	-

Дээрх хүснэгтээс үзэхэд 9 дүгээр сарын 11-ний өдөр гэхэд 63 хүн, хуягт дивизион, автомашинууд нь байнгын байрлалдаа хараахан ирж амжаагүй байв.

¹ ЗХТА. ф.1, т.3-1, хн.475, хуудас 18-19

Байнгын байрлалд хүрэлцэн ирсний дараа цэргийн байр сууцны засварыг яаралтай хийж, түлээ түлш бэлтгэх зэрэг өвлийн бэлтгэлийг хангах; орон даяар өрнөөд байсан тусгаар тогтнолын төлөө санал хураах ажлын зохион байгуулалтыг дуусгах явдал чухлаар тавигдав. БНМАУ-ын тусгаар тогтнолын төлөө 1945 оны 10 дугаар сарын 20-нд болсон санал хураалтад 8 мд-ийн бие бүрэлдэхүүн 4129 хүн гарын үсгээ зурав.

Бас хугацаат албаа дуусгасан ба дайчилгаагаар татагдан ирсэн түр цэрэг, бэлтгэл дарга нарыг цэргийн албанаас халагдуулах ажил чухал байв.

БНМАУ 1945 оны намар Японыг эсэргүүцсэн дайнд оролцсон нь тус улсын нэр хүндийг олон улсын тавцан дээр улам өргөж, төрийн тусгаар тогтнолоо дэлхийн том гүрнүүдээр зөвшөөрүүлэн хүлээлгэхэд чухал ач холбогдолтой болсон юм.

МАХН-ын Төв Хороо, Засгийн газар, цэргийн дээд командлалын шийдвэрээр дайн дуусмагц БНМАУ-ын зэвсэгт хүчнийг тайван цагийн байгуулалтанд шилжүүлж өөрчлөн байгуулав. ЦЯЯ-ны сайд бөгөөд Бүх цэргийн жанжны 1945 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн “МАХЦ-ийн зохион байгуулалтыг тайван цагийн журамд шилжүүлэн оруулах тухай” 00158 тоот тушаал гарч нийт анги, нэгтгэлүүд ба албан байгууллагуудыг тусгай төлөвлөгөөний дагуу 1946 оны 1 дүгээр сарын 1-нээс тайван цагийн орон тооны зохион байгуулалтын журамд шилжүүлжээ.

Энэ тушаал ёсоор МАХЦ-ийн Матадын 8 мд-ийг татан буулгасан юм. Матадын 8 мд-ийг татан буулгах ба 10 дугаар тусгай дивизионыг зохион байгуулах ажлыг хошууч генерал Г.Эрэндоо даргатай комисс гүйцэтгэсэн юм. 8 мд хугацааны ба дайчилгаагаар ирсэн цэрэг, бага дарга нарыг халсны дараа 1945 оны 12 дугаар сарын 20-нд хугацаат албаны 1918 хүнтэй байв. Дээрх бие бүрэлдэхүүнээс 7 мд-д 1191, артиллерийн тусгай хороо, шинээр байгуулсан зенитийн тусгай дивизион, авто жолоочийн сургууль, зэвсгийн курс, шугам ашиглалтын рот зэрэг анги, салбарт 494, Дотоод явдлын яаманд 233 хүнийг тус тус шилжүүлсэн байна¹.

Ийнхүү Дорнод Монголын Матад хан уулаар нэрлэгдэж 1945 оны дайнд оролцож байлдааны үүргээ нэр төртэй биелүүлсэн МАХЦ-ийн 8 мд Чөлөөлөх дайны ялалтад томоохон хувь нэмэр оруулсан байна.

3.5. Монгол ардын хувьсгалт цэргийн 9 дүгээр бэлтгэл морьт хороо Чөлөөлөх дайнд.

Есдүгээр морьт хорооны тухай материал Батлан хамгаалхын төв архивт байна. 1946 онд түүнийг бичжээ².

МАХЦ-ийн 9 дүгээр морьт хороо нь гадаад, дотоод нөхцөлийн улмаас анх байгуулагдсан түүхтэй юм. ЗХУ-д Гитлерийн герман довтолж, дэлхийн дайн өргөжин тэлэх нь гарцаагүй болжээ. Энэ үед БНМАУ “Бүхнийг фронтод” уриан дор бүх нийтээр хүчин чармайн ажиллаж байсны дээр эх орныхоо батлан хамгаалах хүчийг бэхжүүлэх арга чаргыг хайж байжээ. Тиймээс 1941 оны 8

¹ ЗХТА. ф.1, д.1, хн.813, хуудас 2.

² БХТА, сх.1. Д.3. хн 47.

дугаар сард 9 дүгээр морьт хороог байгуулсан нь 1945 оны 9 дүгээр сарын хооронд 4 жил үйл ажиллагаа явуулж байжээ.

Тус хороо нь 1941 оны 8 дугаар сарын 1-ээс “Морин хороо” хэмээн нэрлэгдэж байгаад 1943 оноос “Хот хамгаалах 9 дүгээр хороо” хэмээн нэрлэгдэх болжээ. Энэ хорооны анхны дарга нь хурандаа Дорж байжээ. Хороо нь 1, 2, 3, 4, 5, 6 дугаар сэлэмт суман, пулемёт, тээврийн бүгд 9 сумангаас бүрдэж, байлдааны бэлтгэл сургууль хийхийн хажуугаар бие бүрэлдүүн нь Сүхбаатарын кинонд тоглох үүрэг гүйцэтгэж байсан байна.

1943 онд хасгийн дээрэмчдийн халдлага идэвхижсэний улмаас тус хорооны бүрэлдүүнээс Ховдод шилжүүлж байсан байна.

1945 оны хавар хуучин цэргүүдээ зүүн аймгийн хязгаарын ангиудыг нөхөн хангахаар шилжүүлж, шинээр татагдсан цэргүүдийг хүлээн авч байлдааны бэлтгэл сургуульд жигдрүүлэх үүрэг хүлээжээ. Гэтэл долдугаар сарын эцсээр тус улсын өмнөд хязгаар руу марш үйлдэх тушаалыг гэнэт авчээ. Шинээр татагдан ирсэн цэргүүдээ дөнгөж дээлийг нь сольж, усанд оруулж амжаагүй цаг байв. Хоёр хоногийн дотор маршийн бэлтгэлийг хангаад долдугаар сарын 26-ны өдөр Улаанбаатараас хөдөлжээ. Энэ маршийн үед хорооны зохион байгуулалт нь:

- 1, 2, 3, 4 дүгээр сэлэмт суман
- Пулемёт суман
- Миномёт суман
- Ажил команд зэрэг салбараас бүрдэж 1000 гаруй хүнтэй байжээ.

Зэвсэглэлийн хувьд: Хүнд, хөнгөн пулемёт, морин цэргийн винтов, 1943 оны гранат, автомат, сэлэм, дуран зэрэг зэвсэглэлээр хангагдан хөдөлжээ.

Улсын хил давахын өмнө цэргийн дээд удирдлагаас 1000 гаруй хүн нэмж өгсөнөөр тус хороо 3000 шахам хүнтэй болж, улсын хил давж маршилсаар Долнуур хүрээд маршал Х.Чойбалсангийн тушаалаар зогсож, 4 дүгээр суманг Яндуу хийд дээр Авгын хошууг хамгаалуулав. Нэгдүгээр суманг Мянган хошууг хамгаалуулахаар явуулав.

Мөн оны 10 дугаар сарын 11-ний өдөр буцах марш үйлдэх тушаал авч 11 дүгээр сарын сүүлээр хагас хүчний хамтаар Улаанхуаранд ирж байрлажээ.

1945 оны 7 дугаар сарын 23-нд авч маршийн бэлтгэлийг ханган 26-ны өдөр эхлэх байранд гарахад генерал Лхагвасүрэн ирж маршийн бэлтгэлийг шалгажээ. Тэрээр бүх бие бүрэлдэхүүнд үүрэг тавьж хэлсэн үгэндээ:

- Танай ангийн марш нь армийн түүхэнд чухал ач холбогдолтой чухал үүрэг гүйцэтгэх болно. МАХЦ-ийн ангиуд Байшинтын районд хүч хуралдуулж байна. Үүнийг ойлгохдоо дайн болоод байгаа юмуу, өөр юу болох бол гэсэн эргэлзээ байж болохгүй. Командлалаас тавьсан үүргийг л биелүүлэх хэрэгтэй, танай дарга нар шинэ ургаж байгаа цэцэгсийг хүлээн авлаа. Хаана сахилгатай байвал тэнд амжилт гарах ба хаана сахилга боловсролгүй бол тэнд ялалт үл олдоно гэж байжээ. Тус морин хороо 7 дугаар сарын 28-аас 9 дүгээр сарын 4-ийг хүртэл марш үйлдэв. Тус хорооны гол үүрэг нь байлдаанд орсон морьт хороодыг тухай бүр нөхөн хангах үүрэгтэйг хорооны удирдлагууд сайтар ухаарч байжээ.

Тэр үед хороо нь сэлэмт суман 5, пулемёт, миномётын батарей, штаб, командын салаа бүхий салбаруудтай байсан ба бүгд 1046 хүнтэйгээр Улаанбаатараас гарч Өндөр хаан - Байшинт - Цагаан нуур - Долнуурын маршрутаар 2000 шахам км марш үйлджээ. Өдөр тутам 45-50 км явж, 1800 км газрыг 24 өдөр туулжээ. Маршийг нуур, худаг дагуу зохион байгуулсан боловч худаг нь хорооны ус ундыг хангаж чадахгүй байсан аж.

Хороо Цагаан нуурт хүрсэний дараа морин дивизүүдийг нөхөн хангах зорилгоор 1100 цэрэг офицер хүлээн авчээ. Элсний захад хүрэхэд армийн агтнаас 1500 агт хүлээн авсан боловч маршийг эмээлгүйгээр үргэлжлүүлэн 9 дүгээр сарын 4-ний өдөр Долнуурт очиж байрлажээ. Эмээлгүйгээр марш үйдсэнээс морьдын харцага ба нуруу авагдсан зэргээс 213 агтыг жагсаалаас гаргасан байна. Тэнд мужийн төв Яндуу сүм, Мянгат хошууг хамгаалах үүрэг хүлээсэн бөгөөд бас Дэ вангийн цэргийн үлдэгдлийг устгах үүрэг тавигдаж байжээ. Энэ үүргийн ёсоор нэгдүгээр суман Мянгат хошууны районд байсан үлдэгдлийг баривчлан авчээ: Үүнд:

- Манжуур -1

- Барга-3

- Хятад-3 -ыг баривчлан орон нутгийн захиргаанд шилжүүлэн өгчээ.

Хороо Долнуурт байх хугацаандаа Өвөр Монголоос 4000 агт бэлтгэж, тус хорооны хуучин агтнаас 2500 агтыг 5 болон 6 дугаар дивизид нөхөн хангалтаар өгчээ.

МАХЦ-ийн морьт дивизүүд Жэхэ хотоос буцах марш хийхэд 9 дүгээр морьт хороо нь тэдний арыг хамгаалах хийгээд хангалтыг хариуцах хүндхэн үүрэг хүлээсэн байна. Энэ үүргийн ёсоор бүх агтаа шилжүүлсэн учир хороо явган маршаар явжээ. 10 дугаар сарын 11-нд 3000 агт дайчилсан боловч тэр нь эмээл хазааргүй, эмнэг догшин даага, шүдлэн байсан учир байлдааны үүрэг гүйцэтгэх чадваргүй байжээ.

Буцах замдаа Байшинтад ирж, 7 дугаар дивизэд 1945 онд татагдсан 471 хүн, зарим зэвсэг, ачаа хөсгийн зүйлүүдийг шилжүүлэн өгөв. Өндөр хаан хүртэл түр цэргүүдийн хамт маршлаад тэндээс түр цэргүүдээ халж, кадрын цэрэг, офицерүүдтэйгээ Улаанбаатарт ирж, 12 дугаар морьт хороотой нэгджээ.

Усгүй цөл, халуун нарыг монгол цэрэг морьдын хатуужил тэсвэрээр л давсан. Удирдлагын офицеруудын мэргэжил дадлага сул, арын хангалт бэрхшээлтэйн учир цэргүүд өдөрт ганц хоолтой явах нь ерийн үзэгдэл байжээ. Маршийн замд худаг ус бэлтгээгүй буюу байлдааны театрыг огт бэлтгэлгүйгээр марш үйлдсэн нь хүнд хүнд бэрхшээлийг даван туулахад хүргэжээ. Хороонд холбооны техник хэрэгсэл ч байсангүй бөгөөд офицер 60, түрүүч 85, байлдагч 774 явсан гэдэг билээ.

- Өвөр монголын Вангийн хошууны Шилийн богдын /Энд эндүүрсэн бололтой. Шилийн Богд уул монголын нутагт буй/ районд хүрээд байхад 96 офицер, 943 түр цэргийг маршал Чойбалсангаас хошууч Зандраагаар толгойлуулан явуулснаар хороо 5 суман нэмж байгуулаад цааш явж, Долнуур орсны дараагаар 47 бэлтгэл ба 1 жинхэнэ офицерыг хүлээн авч офицер 211, цэрэг 943, хугацааны түрүүч, байлдагч 858, бүгд 2009 хүнтэй болжээ.

Шүүх таслах газар шилжин таслагдсан: офицер 1, цэрэг 2; Долнуураас оргосон цэрэг 1 байв.

Буцах замдаа тус хороо нь химийн баг 937, утаат гранат 250, цаасан нөмрөг 920 болон бусад хэрэглэл авч явсан ба баг 839, цаасан нөмрөг 783-ыг 7 дугаар дивиз, армийн эмнэлэг, Чойбалсан хотын засвар зэрэгт хүлээлгэн өгчээ.

Архивт байгаа 9 дүгээр морьт хорооны түүхэнд тэмдэглэсэн нь: “Агт мориор л бид үүргээ гүйцэтгэжээ. Мориор явсан хэмжээ 2300 гаруй км болно. Морины хүрэлцээ муу байсан учир жанжны тушаалаар морьд цуглуулж Улаанбаатараас гарахад 1150 агттай гарсан ба Хэнтийгээс нийлүүлсэн агт 500, Нарангийн отрядын районд 692, отрядаас шилжүүлэн авсан 260, Сант сүм буюу Ар цагаан нуурын районд армийн бэлтгэл агтнаас 530, буцах маршид Буян голоос авсан агт 485, Цахар чуулганаас 2800, бусдаас хураагдсан 723, бүгд 7140 байхаас жанжны тушаалаар 5 болон 6 дугаар дивизэд шилжүүлсэн агт 4718, эцэж хаягдсан ба хулгайд алдсан, эзэнгүй алдсан 147-г хасвал бүх адуу 3040 байна. Туранхай 1035 морь байна гэжээ.

Морьдын тухай: Нөхдийн дунд “Ширүүн хар” хэмээх байлдагч Цэрэндаш халтар, хээр хоёр морь 4 дугуйтай тэрэг хөллөж, Улаанбаатараас Долнуур хүрэхдээ ямар ч саатал гаргасангүй, Цэрэндаш мориныхоо хөл, нурууг ч авсангүй билээ.

Тэмээ, үхэр, хонины тухайд: Хороо Улаанбаатараас хөдлөхдөө тэмээгүй байсан. Өвөр монголын нутгаас хураасан тэмээ 235, бүх үхэр 1080-аас тугал 52 байжээ. Хонь 1469-өөс 259 гаруй хургатай, замын хоолонд хэрэглэсээр иржээ. Ямаа 429-өөс туранхай 150 байсан. Улаанбаатараас тууварлан явсан ямаанаас хөх зүсмийн ямаа Долнуур ороод буцаж нутагтаа иржээ.

Байлдааны үүргийг сайтар биелүүлсэн 400 хүнийг төрийн шагналд тодорхойлсоноос шагнагдсан 52, үүнээс байлдааны гавъяаны одонгоор 11, Алтан гадас 19, байлдааны медаль 22, бүгд 52 хэмээн хошууч Дашдорж, гишүүд дэслэгч Гүржав, Жамбаа нар бичиж үлдээсэн байна.

Архивын өөр нэгэн дансанд¹: Есдүгээр морьт хорооноос тодорхойлсон нь :

Байлдааны гавъяаны улаан тугийн одонд: 89

Алтан гадас одонд - 112

Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонд - 4

Байлдааны медальд - 179

Хөдөлмөрийн гавъяаны медальд - 16

Бүгд: 390 хүнийг тодорхойлсон архивын баримт байна.

9 морьт хороо хэдийгээр улсын хил даваад байлдааны ажиллагаанд оролцоогүй ч байлдаж нөхөн хангах үүргээ амжилттай биелүүлэн ялалтад өөрийн хувь нэмрээ оруулсан ажээ.

3.6. Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отряд Чөлөөлөх дайнд.

1942 он гэхэд Дэлхийн дайн эрч хүчээ улам бүр авч, дорно дахинд Японы милитаристуудын үйл ажиллагаа идэхжиж ирсэн үе байв. Хятадын хойд нутагт

¹ БХТА, сx1.Д.4.хн. 174

байрлаж асан Квантуны армийн үйл ажиллагаа БНМАУ-ын аюулгүй байдалд шууд заналхийлэх хэмжээнд хүрсэн, тухайлбал Монгол Улсын хилийн ойролцоо цэргийн их хүчийг хуримтлуулж, Хаалган, Рашаан, Жанчхүүгийн (Чжанцзя коу) даваанд удаан хугацааны бэхлэлтийн цогцолборуудыг байгуулж, цэрэг дайны хэрэгцээний төмөр зам, засмал зам, нисэх онгоцны буудал барьж, байлдааны бэлтгэлээ шуурхайлан базааж байлаа.

Цэрэг-улс төрийн цагийн байдал ийнхүү хүндэрч, улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдалд шууд заналхийлэл буй болсон учир батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлага тулгарав. Тиймээс засгийн эрхийг дангаар барьж байсан МАХН хийгээд БНМАУ-ын төр, засгийн удирдлагаас улс орноо батлан хамгаалах олон чухал арга хэмжээ авч хэрэгжүүлсний нэг нь эх орноо батлан хамгаалах үйл хэрэгт хүн амыг сурган бэлтгэх явдал байлаа. Энэ зорилгыг биелүүлэх үүднээс олон практик арга хэмжээ авч хэрэгжүүлснээс хамгийн үр дүнтэй нь “Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отряд”-уудыг (Чанагш АӨХСДМО гэнэ) үүсгэн байгуулсан явдал байлаа.

3.6.1. Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отрядын үүсэл, зохион байгуулалт, үйл ажиллагаа.

1940-өөд оныг хүртэл ард иргэдийг эх орноо батлан хамгаалах үйл хэрэгт сурган бэлтгэх, түүний дотор цэргийн хэрэгт сургах гол үүргийг МАХН-ын байгууллагууд удирдан чиглүүлж, Батлан хамгаалах эвлэлийн байгууллагууд хариуцан гүйцэтгэхээр намын дээд удирдлагаас чиглүүлэн заасан байв.

Гэтэл тэдгээр байгууллагын ажил ихээхэн доголдож, удирдлагын шийдвэр шаардлагын хэмжээнд хүртэл биелэгдэхгүй болсон байлаа. Энэ талаар МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгчдийн 1942 оны хоёрдугаар сарын 24-ний өдрийн 19 дүгээр хурлын тогтоолд “Олон улсын хоорондын байдал хүнд болсны улмаас тус улсын бүх ард түмнийг эх орноо идэвхтэйгээр хамгаалахад бэлтгэх ажлыг хүчтэй болгох явдал шаардагдаж буй атал улс орныг батлан хамгаалах ажил нь сүрхий дутагдалд орсон байна.

Намын олонх байгууллагууд нь тус улсын ард түмний дунд явуулах улс орныг батлан хамгаалах олон түмний ажлыг удирдах явдлаас салж хөндийрэн энэхүү ажлыг зөвхөн Батлан хамгаалах эвлэлийн байгууллагуудад найдсан байна.

Улсыг батлан хамгаалах эвлэлийн байгууллагуудын ажлын үндсэн дутагдлууд бол тэдгээр нь цэрэгжлийн сургуулийг зөвхөн зарим нэгэн дугуйлангуудад чиглүүлэн явуулж буй. Энэхүү дугуйлангуудад зөвхөн цөөн тооны гишүүдийг суралцуулах явдлаар хязгаарлагдан буй бөгөөд тэдгээр дугуйлангуудын ажил нь тогтмол бус, ямар ч эмх журамгүйгээр явагдаж байна” гэж онцлон тэмдэглээд “Эдүгээ үед улс орныг батлан хамгаалах, олон түмнийг аль болох олон тоогоор цэргийн эрдэм ба гартаа буу барьж эх орноо хамгаалж чадах болгон сургах зорилго мөн” хэмээгээд эл зорилгыг биелүүлэх үүднээс “Ардын өөрийгөө хамгаалах отряд”-уудыг өргөн олноор байгуулахыг даалгаж, тэдгээрийг Улсыг батлан хамгаалах зөвлөл ба Дотоод явдлын яаманд

харьяалуулахаар болгожээ¹. Ийнхүү нэгэн үе улс, эх орноо хамгаалахад ард нийтийг сурган бэлтгэх үйл хэрэгт түүхэн чухал үүрэг гүйцэтгэсэн өвөрмөц нэгэн байгууллага болох “Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отряд”-ууд үүсэн байгуулагджээ.

Дээрх хурлаас “Өөрийгөө батлан хамгаалах отрядуудыг зохион байгуулах ажилд идэвхтэйгээр оролцож, ард түмний сайн дурыг хатуу баримталж тэднийг эл ажилд оролцуулах явдлыг аймаг, хотын намын хороод ба намын үүрүүдэд үүрэг болгосон” нь уг ажлыг улс орон даяар эрчимтэй, далайцтай зохион байгуулах нэг нөхцөлийг бүрдүүлсэн бөгөөд отрядуудад цэргээс халагдсан хүмүүс, “улаан партизан” болон нам ба нам бус идэвхтэнүүдийг өргөнөөр оролцуулж эхэлжээ.

Дээр дурдсан тогтоол ёсоор отрядуудад хамрагдсан хүмүүсийг сургах, отрядуудыг зэвсэглэх ажлын удирдлагыг Батлан хамгаалах төв зөвлөл болон Дотоод явдлын яам хариуцах болсон бөгөөд сургалтын хөтөлбөр, арга хэлбэрийг Монгол ардын хувьсгалт цэргийн штаб ба Дотоод яам хамтран боловсруулж гүйцэтгэхээр болсон нь отрядуудыг цэргийн мэргэжлийн удирдлагаар тасралтгүй хангах, сургалтыг чанартай явуулах боломж олгожээ.

Мөн хурлаас өмнө нь Хэнтий аймгийн даргаар ажиллаж байсан Ч.Мижидийг Улсыг Батлан хамгаалах эвлэлийн Төв Зөвлөлийн дарга бөгөөд АӨХСДМО-уудыг удирдах даргаар, Дотоод яамны хязгаарын газрын ажилтан В.Даржааг АӨХСДМО-ын штабын даргаар, Батлан хамгаалах эвлэлийн Төв зөвлөлийн дарга асан А.Самбууг АӨХСДМО-ын комиссараар тус тус томилон ажиллуулжээ.

АӨХСДМО нь хагас цэргийн зохион байгуулалттай, тусгай дүрмээр ажилладаг цэрэгжсэн байгууллага байв.

Архивын сурвалж баримтуудад тулгуурлан судлаачдын тодорхойлсноор АӨХСДМО-ын Төв штаб нь нийт 40 гаруй хүний орон тоотойгоор, дор дурдсан зохион байгуулалт, бүтэцтэй ажиллаж байжээ. Үүнд:

1. Морьт отрядын төв удирдлага нь 3 хүний бүрэлдэхүүнтэй (отрядын жанжин, улс төрийн орлогч, төв штабын дарга);

2. Морьт отрядын байлдааны бэлтгэлийн хэлтэс нь 2 (хэлтсийн дарга, хэлтсийн мянгатын дарга);

3. Санхүүгийн хэлтэс нь 4 (санхүүгийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодох, туслах нягтлан бодох, санхүүгийн байцаагч) хүний орон тоотой байсан байна.

4. Морьт отрядын улс төрийн анги 1 (мянгатын улс төрийн дарга);

5. Морьт отрядын бичиг хэргийн анги 2 (жанжны нарийн бичгийн дарга, машины бичээч);

6. Морьт отрядын аж ахуйн анги 8 (аж ахуйн дарга комендат, аж ахуйн зарлага, аж ахуйн галч бөгөөд зааварлагч, аж ахуйн нэгдүгээр зэргийн жолооч, аж ахуйн хоёрдугаар зэргийн жолооч, аж ахуйн морин тэрэгний ажилчин, аж

¹ МАН-ын баримтын төв. ф1. т.9. хн 217

ахуйн манаач, аж ахуйн улс төрийн хэлтсийн дарга гэсэн орон тоо, бүтэц зохион байгуулалттай байжээ¹.

Аймаг бүрийн Улсыг батлан хамгаалах эвлэлийн зөвлөлийн дарга нарт тухай, тухайн аймгийн АӨХСДМО-ыг байгуулан удирдах ажлыг хариуцуулан аймгийн отрядын даргаар томилж, Улсыг батлан хамгаалах эвлэлийн төв ба аймаг, хотын зөвлөлүүдийн эрх баригчдын зохион байгуулалтыг төгөлдөржүүлэн сайжруулах арга хэмжээ авч, Улсыг батлан хамгаалах эвлэлийн доод шатны байгууллагуудын ажлыг сэргээн сайжруулахын тулд тус эвлэлийн үүрүүдийн тайлангийн хурал, сонгуулийн компани, аймгуудын бага хурлыг 1942 оны 3 дугаар сарын дотор багтаан зохион байгуулжээ. Тийнхүү Улсыг батлан хамгаалах эвлэлийн байгууллагад орж буй шинэчлэл, өөрчлөлтөд тохируулан тус эвлэлийн 1942 оны төсвийг шинэчлэн баталсан нь ажлыг эрчимтэй эхлүүлэх боломж олгожээ.

Мөн отрядуудыг зохион байгуулах ажлыг гардан гүйцэтгүүлэхийн тулд аймаг бүрт орон тооны ажилтан 1, бас аймгийн отрядуудын хэсэг тус бүрд орон тооны ажилтан 1 буюу аймаг бүрт 3 хүнийг томилж аймгийн хэмжээний отрядуудын удирдах даргын захиргаанд ажиллуулжээ.

АӨХСДМО нь эртний монгол цэргийн уламжлалт зохион байгуулалт болох аравтын тогтолцоонд тулгуурласан, тухайлбал аравт, зуут, мянгат, түмт гэсэн нэгжүүдтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байсан бөгөөд 16-45 насны эрэгтэй, эмэгтэй, сонгуулийн үнэмлэхтэй БНМАУ-ын харъяат хүмүүсийг гишүүнээр элсүүлэн авдаг байв.

МАХН, засгийн шийдвэрийг ард нийтээр дэмжиж, АӨХСДМО-д өргөнөөр элсэн орж, цэргийн хэрэгт суралцаж байсан бөгөөд энэ тухайд “морьт отрядын жагсаалд 15 насны багачууд хүртэл маш баяр баясгалантайгаар элсэн, 10 гаруй жил болсон Улсын батлан хамгаалах эвлэлийн өсөлтөөс морьт отрядын нэгэн жилийн өсөлт нь 7 дахин илүү нэмэгдсэн” гэж Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отрядын түүхэнд холбогдох дэвтэрт бичжээ².

Үнэхээр ч 1944 оны 1 дүгээр сарын 1-ний мэдээгээр Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын отрядуудад нийт 81448 хүн хамрагдсан байсан нь нийт хүн амын 20 хувь гаруй болж байсан бөгөөд харин тэр үед Улсыг батлан хамгаалах байгууллагууд бүгд 13602 гишүүнтэй байсан нь тус улсын хүн амын 10 орчим хувь болж байв.³

Энэ баримт нь тухайн үед ард нийтийг эх орноо хамгаалахад сурган бэлтгэх ажилд “АӨХСДМО”-ын хэлбэр хамгийн тохиромжтой, үндсэн арга хэлбэр болж байсныг илтгэн харуулж байна.

АӨХСДМО-ууд улсын бүх аймаг, сум, үйлдвэр, албан газарт байгуулагдаж хөдөлмөрчдийг тусгай хөтөлбөрөөр цэргийн эрдэмд сургаж байлаа.

АӨХСДМО-ын комиссараар ажиллаж байсан Анжилын Самбуу “Морьт отрядыг байгуулах тухай манай нам, засгаас зохих шийдвэр гарсны дараа ухуулга сурталчилгааны ажлыг энэ ажилд чиглүүлж нам, засгийн “Үнэн” сонин

¹ Болорчимэг П. Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отрядын түүхийн асуудалд. Магистрын дипломын ажил. УБ. 2016.

² БНМАУ-ын түүхийн төв архив. Ф-№20. Хн-№66. 24 дэх тал.

³ Мөнхөө Н. Домогт морьт отряд. УБ., 1985. 9 дэх тал

цэргийн төв хэвлэл “Улаан-Од” сонинд материал их бичигдэж байсан, бид ч аман ухуулгыг чадах чинээгээрээ хийдэг байсан юм. Манай нам, засгийн удирдагчид морьт отрядыг төв, орон нутагт байгуулах ажлыг биечлэн зохион байгуулж байсан. Жишээ нь 1942 оны гуравдугаар сард Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын 8 дугаар багийн ардуудыг хуралдуулан маршал Чойбалсан өөрийн биеэр ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отрядын нэгэн аравтыг байгуулсан юм. Отрядын гишүүнд элсэх, улс төр байлдааны бэлтгэл сургууль явуулахад хөдөлмөрчид их сонирхож маш дуртай халуун дотно угтан хүлээн авч, нам, засгийнхаа энэ бодлого шийдвэрийг хэрэгжүүлэхэд өөрийнхөө чадал чинээгээрээ тусалдаг байв. Отрядад эд аж ахуй, мөнгөн тусламжийг ардууд сайн дураараа бэлэглэх явдал олонтаа тохиолддог байсан. Отрядын гишүүдэд батлах өгч, татвар хураадаг байсны гадна, морьт отрядын гишүүдийг тэр үед ихэвчлэн отрядын “Байлдагч” гэж нэрлэж дуудах, албан баримт бичигт ингэж олонтаа бичдэг байсан” гэж дурсан өгүүлжээ.¹

АӨХСДМО-уудын удирдах бүрэлдэхүүний алдар цол. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1942 оны гуравдугаар сарын 7-ны өдрийн хурлын тогтоолоор АӨХСДМО-ын удирдах бүрэлдэхүүнд алдар цол олгох зааврыг баталжээ.

Заавар ёсоор Ч.Мижидэд “АӨХСДМО-ын жанжин” хэмээх алдар цол, комиссар А.Самбууд “АӨХСДМО-ын мянгатын комиссар”, штабын дарга В.Даржаад “АӨХСДМО-ын мянгатын дарга” гэдэг цол олгожээ².



АӨХСДМО-ын жанжин Ч.Мижид

АӨХСДМО-ын дарга, улс төр, аж ахуйн албан тушаалтанд дор дурдсан алдар цол олгож байжээ. Үүнд:

- Аравтын дарга;
- Тавьтын дарга;
- Тавьтын улс төрийн удирдагч;
- Тавьтын ахлах дарга;

¹ Мөнхөө Н. *Домогт морьт отряд*. УБ. 1985. 69 дэх тал

² *Батлан хамгаалахын төв архив*. Ф№3, хн №222. 18-19 дэх тал

- Тавьтын ахлах улс төрийн удирдагч;
- Зуутын дарга;
- Зуутын улс төрийн туслах;
- Зуутын ахлах дарга;
- Зуутын аж ахуйн дарга;
- Зуутын ахлах улс төрийн туслах;
- Мянгатын дарга;
- Мянгатын комиссар;
- Түмтийн дарга;
- Түмтийн комиссар.

Тэгэхдээ мянгатаас дээш алдар цолыг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс, аравтаас зуут хүртэлх алдар цолыг Улсыг батлан хамгаалах Төв зөвлөлийн даргаар уламжлуулан Дотоод Явдлын яамны сайдаас олгодог байв. Эдгээр алдар цолд дэвшүүлэх, олгох нь тодорхой хугацаатай байжээ. Үүнд: Аравт ба тавьтын дарга, улс төрийн удирдагч нарын алдар цолыг 2 жил, тавьт, зуутын алдар цолыг 3 жил, ахлах зуут ба мянгатын цолыг 4 жил, ахлах мянгатаас дээш алдар цолыг хугацаагүйгээр ажлын амжилт бүтээлийг тооцон дэвшүүлж байв. Морьт отрядын ажилд онцгой амжилт, бүтээл гаргасан дарга нарыг морьт отрядуудын жанжин ба түүний штабаас хянаж хугацаанаас өмнө алдар цол олгуулахаар нэр дэвшүүлэх эрхтэй байв.

Харин АӨХСДМО-ын алдар цолоор шагнагдсан дарга нараас сарын дотроос өөрийн хариуцсан ажилдаа ямар нэгэн шалтгаанаар тэнцэхгүй болох аваас түүний алдар цолыг өөрчлөх буюу бүрмөсөн хасч байсан ба мөн хэн нэгэн хүн муу ажилласан, дутагдал гаргасан, мөн ямар нэгэн хууль бус хэрэг үйлдэж хуулийн байгууллагад шилжвээс морьт отрядын жанжин, түүний штабаас өмнө нь түүнд олгосон алдар цолыг бууруулах юмуу уул алдар цол эдлэх эрхийг түр, эсвэл бүрмөсөн хасдаг байсан ажээ.


АӨХСДМО-уудын удирдах бүрэлдэхүүний дүрэмт хувцас, ялгах тэмдэг. АӨХСДМО-ын дарга, цэргүүд нь тусгай дүрэмт хувцас, онцгойлох тэмдгээрээ ялгагддаг байв. Үүнд, 1942 онд МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 24 дүгээр хурлын шийдвэрийн дагуу морьт отрядын туг далбаа, дарга, цэргийн хэрэглэх малгайн ба ханцуйн тэмдэг, захны петлицний хэлбэр маяг, дарга нарт олгох алдар цол, зүүх тэмдгийн тухай зааврыг маршал Х.Чойбалсангаар батлуулан гаргажээ.

Заавар ёсоор АӨХСДМО-ын аравтын даргад тусгай бэлтгэгдсэн дээл цамцны заханд тусгай петлицтэйгээр хадагдах цагаан металл тэмдэг 2-ыг, тавьтын даргад 3-ыг, зуутын даргад 4-ийг хэрэглүүлэх ба аравт, тавьт, зуутын дарга нарт баруун гарын ханцуй дээр зааврын дотор заагдсан гонзгой дөрвөлжин маягийн хөх цэнхэр өнгийн дэвсгэртэй, улаан эмжээртэй, дундаа тусгай давхар ба дан утсан тэмдэг болон нарийн улаан шугам мэт даавуугаар үйлдсэн тэмдгүүдийг хэрэглүүлжээ.


Мөн дээрх зааврын ёсоор мянгатын даргад шар металлаар хийсэн тэмдэг 3-ыг, түмтийн дарга нарт 4-ийг, мөн мянгат, түмтийн дарга ба комиссар нарт баруун гарын ханцуйд хадах, дээрх хэв маягийн хөх цэнхэр дэвсгэртэй, шар эмжээртэй цэмбээр үйлдсэн тэмдгийг хэрэглүүлж байв.

Харин алдар цолгүй дарга нар захандаа петлиц болон металл тэмдэггүй, зөвхөн зэрэг тушаалын хуваарь, баруун гарын ханцуй дээр хадах даавуу ба цэмбэн эдээр үйлдсэн тэмдгийг цэргээс эхлэн хэрэглэж байлаа.

Цэргээс зуутын дарга хүртэлх хүмүүст бор цэмбээр үйлдсэн, улаан эмжээртэй бөгөөд 1921 оны партизан цэргийнх шиг хийцтэй малгайг хэрэглүүлж байсан ба харин мянгатаас түмтийн дарга хүртэлх зэрэг зиндааны хүмүүст мөн бор цэмбээр хийсэн боловч шар эмжээртэй, дээр дурдсан хийц маягтай малгайг тус тус хэрэглэхээр заажээ¹.



13. Аравтын даргын ханцуйн тэмдгүүд;
14. Тавьтын даргын ханцуйн тэмдэг.



15. Зуутын дарга удирдагчийн ханцуйн тэмдэг;
16. Мянгат ба түмтийн дарга комиссарын ханцуйн тэмдэг.


АӨХСДМО-уудын туг. Мөнхүү зааварт АӨХСДМО-уудын туг нь ямар өнгө, хэлбэр хийцтэй байх, туган дээр ямар үг бичихийг зааж өгчээ. Үүнд: мөнгөн өнгөтэй, гилбэр маягийн зэвтэй, хар дэл, сүүлээр хийсэн манжлагатай улаан туг байсан бөгөөд тугийн голд улсын сүлдтэй, хоёр талд нь мөнгөн цагаан өнгөөр ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отряд (АӨХСДМО) гэж уйгаржин

¹ Мөнхөө Н. Домогт морьт отряд. УБ. 1985. 15-16 дахь тал

МОНГОЛ ҮСГЭЭР ТОВЧЛОН БИЧИЖ, СҮЛДИЙН ДООД ТАЛД НЬ АЛЬ АЙМГИЙН АРАВТ, ЗУУТ, МЯНГАТ, ТҮМТИЙН ТУГ БОЛОХЫГ ТОЛГОЙН ҮСГЭЭР ТОВЧЛОН ТЭМДЭГЛЭЖ БАЙЖЭЭ¹.



АӨХСДМО-ын туг



АӨХСДМО-ыг шинэчлэн зохион байгуулсан нь. МАХН, төр, засгийн шийдвэрийг Монголын ард түмэн нийтээр дэмжин АӨХСДМО-ад өргөнөөр элсэн орж, цэргийн хэрэгт суралцаж байсан тухай Ю.Цэдэнбал 1942 оны гуравдугаар сард хуралдсан цэргийн намын IX бага хурал дээр тавьсан илтгэлдээ... “Сайн дурын морьт отрядыг зохион байгуулах тухай нам, засгийн уриалгыг тус орны хөдөлмөрчид халуунаар угтан авч хурал цуглаан газар бүр болж өвгөчүүд,

¹ Мөнхөө Н. Домогт морьт отряд. УБ. 1985. 34 дэх тал

залуучууд, эмэгтэйчүүд хүртэл цөмөөр нэрсээ бичүүлэн эх оронч санал сэтгэлийн оргилсон хөдөлгөөн гаргаж байв” гэжээ¹.

Мөн МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооноос 1944 онд АӨХСДМО-ын жанжин Ч.Мижидийн илтгэлийг сонсож хэлэлцээд “1942 онд байгуулагдсан АӨХСДМО-ууд бол хөдөлмөрчин ард олныг эх орноо хамгаалах явдалд идэвхтэй ба өргөнөөр татан оролцуулах хэрэгт ихээхэн үүрэг гүйцэтгэжээ... АӨХСДМО-ууд нь сүүлийн жилүүдэд тус улсын ард түмнийг цэргийн эрдэмд өргөн олноор сурах үндсэн маяг нь болж ирсэн байна...” гэж цохон тэмдэглэсэн нь ард нийтийг эх орноо хамгаалах үйлсэд сурган боловсруулахад АӨХСДМО гол чухал үүрэг гүйцэтгэж байсны илэрхийлэл юм.

Гэвч МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны 1944 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаас гаргасан “Тус улсын ард түмний дотор явуулж буй улс орныг батлан хамгаалах ажлыг сайжруулах тухай” тогтоолд дурдсанаар “Сайн дурын отрядуудын ба Улсыг батлан хамгаалах эвлэлийн байгууллагуудын ажлын хооронд тодорхой ялгаварлах хязгааргүй болсон, тухайлбал АӨХСДМО-ын төв ба орон нутгийн штабууд нь Улсыг батлан хамгаалах эвлэлийн зөвлөлүүдийг хавсарч байсан учир тэдгээрийн ажил тарамдаж, АӨХСДМО-ын удирдлагыг сулруулсан” бөгөөд отрядууд цэргийн сургуулийн товч тодорхой төлөвлөгөө байхгүй, өөрийн мэдэлд байсан материал хэрэгсэл, зэр зэвсгийг ч сургалтанд ашиглаж чадахгүй байсан ба дарга нарын бэлтгэл сул, эрх үүрэг нь тодорхойгүй, отрядуудад олон түмнийг элсүүлэх ажил удаашран суларч эхэлсэн, сургууль хичээл чанар муутай явагддаг, аймаг, хотын Намын хороо, үүрүүдийн зүгээс морьт отрядуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийдэггүй, тусламж дэмжлэг үзүүлдэггүй байсан зэрэг дутагдал догодол газар авсан байлаа.

Улаанбаатар хотод л гэхэд “ард түмний оргилсон хөдөлгөөнийг тосон авч зохион байгуулалтыг хийж дуусгах ба нэгэнт үүссэн зохион байгуулалтыг маш журамтайгаар зохион байгуулж сургуулилах, хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулж гаргах, отрядын байлдагчдад дүрэмт хувцаа хэрэглүүлэх, зохион байгуулалтын дотоод эмх журмыг тогтоох зэрэг ажил удаан цалгар явагдаж байжээ. Улсыг батлан хамгаалах эвлэлийн хотын Зөвлөл байгуулагдаагүйгээс хотын тавьт, зуутуудын ажлыг биечлэн удирдах удирдлагагүй, ажил нь урсгалаар явагдаж байснаас зохион байгуулалтын анхны үүсвэрээс хэтэрч чадаагүй ба сайн дурын өөрийгөө хамгаалах отрядын улс төрийн ач холбогдлыг бүрэн дүүрэн тайлбарлаж таниулах явдал сул дутагдалтай байж, зарим газарт отрядад “Сайн дурын үндсэн дээр элсүүлэх зарчим” алдагдаж хүн бүрийг албадан элсүүлэх тохиолдол ч гарч байв.

Энэ мэтчилэн багагүй дутагдал оршиж байсантай уялдуулан Улаанбаатар хотын намын хорооны тэргүүлэгчдийн хурлаас Улаанбаатар хотын Батлан Хамгаалах Зөвлөл нь хотын доторх батлан хамгаалахын үүрүүд ба морьт отрядуудын ажлыг нэн даруй хүлээн авч аравт, тавьт, зуутын дарга нарыг бүртгэж шалган үзэж батлах болон алдар цол шагнах ажлыг нэн даруй хийж гүйцэтгэх, олон улсын хөдөлмөрчдийн эв санааны нэгдлийн өдөр-Майн 53

¹ Мөнхөө Н. Домогт морьт отряд. УБ., 1985. 9 дэх тал

жилийн ойн баярт морьт отрядуудыг зохион байгуулалттайгаар жагсаахын тулд бэлтгэл сургуулийг тусгайлан 2 удаа хийлгэх ба Майн баяраар тусгай зохион байгуулалттайгаар жагсаахын тулд хэд хэдэн зүйлийг гүйцэтгэхийг хотын Батлан Хамгаалах Зөвлөлд даалгаж хэрэгжүүлжээ. Үүнд:

1. Отрядын дотроос зуугаас доошгүй хүмүүсийг мориор жагсаах бэлтгэлийг хийх. Үүнд тэдгээрийн морин жадыг бэлтгэх, дүрэмт хувцасыг бүрэн бэлтгүүлэх, баярын наана жагсаал парадын сургуулийг зориуд 3 удаа хийлгэх.

2. 700-аас доошгүй хүмүүсийг дугуйгаар жагсаах, тэдгээрийн тэмдэг, хувцасыг бүрэн бэлдүүлж дугуйчдыг бүрэн буу зэвсэгтэйгээр жагсаах талаар арга хэмжээ авах, баярын наана 2-оос доошгүй удаа нэгдсэн бэлтгэлийг хийлгэх.

3. 500 эмэгтэйг эмнэлгийн тусламжийн групп болгон тусгай жагсаах талаар бэлтгэлийг хийлгэхээр тогтоосон байна .

Мөн отрядуудын сургуулилах хөтөлбөрийг тодорхой болгон хичээл сургуулийг заах хүмүүсийг шилэн сонгож сургуулийг чанартай явуулах ба хичээл сургуульд хэрэглэх үзүүлэн таниулах зүйлээр хангахыг хотын Батлан Хамгаалах Зөвлөлд, морьт отрядуудын зохион байгуулалтыг цааш өргөтгөх, ард түмэн ажилчин албан хаагчдын дотор ухуулга таниулгыг үргэлжлүүлэн зохиохыг хотын намын хорооны суртлын хэлтэст даалгаж байжээ.

Улаанбаатар хотоор жишээлэн дээр дурдсанчлан багагүй бэрхшээл тулгарч байсан ч эх орноо батлан хамгаалах тухай Үндсэн хуулийн заалтыг биелүүлэн МАХН-ын Төв Хороо, Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор 1942 оноос эхлэн сайн дурын морьт отрядуудыг хот, аймаг, сум, баг, сангийн аж ахуй, үйлдвэр, албан газар, сургуульд байгуулж ажиллуулах болсон байна.

Гэлээ ч ажлын дутагдал, доголдол үргэлжлэн гарсаар байсан тул МАХН, төр, засгийн удирдлага дүгнэлт хийж, олон түмнээс улс орноо хамгаалах ажлын зохион байгуулалтын хэлбэр маягийг өөрчлөн сайжруулах шийдвэртэйг 1944 онд гаргажээ. Тэгэхдээ Улсыг батлан хамгаалах эвлэлийн ач холбогдол, зохион байгуулалт нэгэнт хоцрогдож хуучирсан гэж үзэж тус эвлэлийг бүрмөсөн татан буулгаж, түүний бүх хөрөнгө, материалыг АӨХСДМО-ын штабт шилжүүлсэн нь дээр дурдсанчлан ажлын давхардал, цалгардлыг арилгахад чиглэсэн зөв зүйтэй шийдвэр байлаа.

АӨХСДМО-ын удирдлага, байлдааны бэлтгэл сургуулийг сайжруулахын тулд БНМАУ-ын Бүх цэргийн жанжны 1944 оны долдугаар сарын 8-ны өдрийн 54 тоот тушаалаар морьт отрядыг Цэргийн явдлын яаманд шилжүүлэн захируулсан байна. Тэгэхдээ урьдын адилаар “Ард түмнийг цэргийн эрдэмд өргөнөөр суралцуулах ажлыг АӨХСДМО-аар дамжуулан гүйцэтгэх”, отрядуудын зохион байгуулалтыг мөн урьдын адил аравт, зуут, мянгат, түмт гэсэн үндсэн нэгжтэйгээр байлгахаар тогтоожээ¹.

АӨХСДМО-ын ажлыг эрс сайжруулах шаардлагыг харгалзан МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооноос гаргасан тогтоолд отрядуудын бүх ажлыг АӨХСДМО-ын Төв штаб удирдахаар зааж, отрядуудыг зохион байгуулах, сургах, материал хэрэгсэл, зэр зэвсгээр хангах ажлыг шат шатны, тухайлбал зуут, мянгат, түмтийн штабууд болон Төв штаб гардан гүйцэтгэхээр даалгажээ.

¹ Мөнхөө Н. *Домогт морьт отряд. УБ., 1985. 10 дахь тал*

Түүнээс гадна МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны 1944 оны тавдугаар сарын 1-ний өдрийн 36 дугаар тогтоолоор отрядуудын удирдах боловсон хүчнийг тогтвор суурьшилтай байлгах, мэргэжлийн ур чадвартай хүмүүсээр хангаж бэхжүүлэх зорилгоор мянгатын даргыг оролцуулан түүнээс дээших бүх дарга нарыг цэргийн жинхэнэ албан хаагчдад тооцон, тэдэнд цэргийн цол олгох ба тэдгээрийг цэргийн дарга нарын адилаар, тэгэхдээ АӨХСДМО-ын Төв штабын хөрөнгө материалаар хангахаар шийдвэрлэжээ. Эл шийдвэрийг үндэслэн Ардын Сайд нарын Зөвлөлийн 1944 оны долдугаар сарын 8-ны өдрийн 73 дугаар тогтоолоор жанжин Ч.Мижидэд хошууч генерал цол олгожээ.

БНМАУ-ын Бүх цэргийн жанжнаас 1944 оны есдүгээр сарын 5-ны өдрийн 0120 тоот тушаалаар Улаанбаатар хотын түмтийн даргад ахлах дэслэгч Жигмэд, штабын даргад Дашийн Шарав, Булганы түмтийн даргад дэд хурандаа Цэен-Ойдов, штабын даргад бага дэслэгч Дорлиг нарын зэрэг Улаанбаатар хот, 18 аймгийн түмт ба ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отрядуудын түмтийн дарга, штабын дарга нарыг томилсон байна.

Мөн мянгатын дарга нараас дооших бүх шатны дарга нар болон бүх байлдагчдад тэднээс отрядын дотор гүйцэтгэж буй үүрэг тушаал, отрядад элсэж алба хаасан байдлыг нь тодорхойлон бичсэн цэргийн үнэмлэх бичиг олгож байх болгов.

АӨХСДМО-ын бүх эд хогшил ба хөсөг тээвэр, зэвсэг техник, галт хэрэгсэл, барилга, санхүүг тэдний мэдэлд хэвээр үлдээж, ардын сайн дурын морьт отрядын улс төр, байлдааны бэлтгэл сургуулиудыг ерөнхийлөн удирдах үүргийг дэслэгч генерал Ю.Цэдэнбал, Ж.Лхагвасүрэн нар хийгээд Бүх цэргийн жанжин штабын даргад хариуцуулсан ажээ. Мөн 1944 оны 7 дугаар сарын 4-ны дотор АӨХСДМО-ын орон тооны ажилчдад хувьсгалт цэргийн алдар цолыг олгох аттестатын хуудсууд ба зун цагийн сургуулийн төлөвлөгөөг боловсруулан батлуулах ба АӨХСДМО-ын дагаж шийтгүүлэх заавар ба цэргийн хүмүүжлийн ажлын талаар төлөвлөн хийх арга хэмжээнүүдийг авчээ.

Дээрх шийдвэр гарсантай холбогдуулан БНМАУ-ын Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1944 оны 4 дүгээр сарын 18-ны хурлын тогтоолоор өмнө нь мөрдөж байсан (1942 оны 3 сарын 7-ны өдөр баталсан) алдар цол олгох зааврыг хүчингүй болгосон байна.

АӨХСДМО-ын үйл ажиллагаа, сургалт, бэлэн байдал. Дэлхийн II дайны жилүүдэд АӨХСДМО-ын үйл ажиллагаанд, хөдөлмөрчдийг цэргийн мэдлэгтэй болгох ажил гол суурь эзэлж байлаа.

Төв орон нутгийн морьт отрядын анхан шатны нэгжүүдийн дарга байлдагчдад заах байлдааны бэлтгэл, улс төрийн сургуулийн хөтөлбөрийг 1942 оны 5, 6 дугаар сард маршал Чойбалсангаар батлуулан гаргаж мөрдүүлжээ.

АӨХСДМО-ын мянгат, зуут, тавьт, аравтуудын хичээл сургуулийг “Батлан хамгаалах эвлэлийн олон түмний дотор явуулах цэрэгжилтийн сургуулийн зохион байгуулалтын заавар”-т дурдсаны дагуу зохион байгуулж байв.

АӨХСДМО-ын үйл ажиллагааг нийтэд нь байлдааны бус болон байлдааны ажиллагааг дэмжих гэсэн үндсэн хоёр хэсэгт хувааж болно. Байлдааны бус

ажиллагаа нь сургалт, сурталчилгаа гэсэн хоёр хэсгээс бүрдэж байсан бөгөөд сургалтыг танхимын болон хээрийн бэлтгэл гэж ангилж болно.

АӨХСДМО-ын хичээл сургуулийг орон нутгийн харьяаллаар явуулж байсан бөгөөд тэгэхдээ ардуудыг өөрийн аж ахуйд хамгийн бага ажилтай байх цаг үеийг тохиолдуулан жилд 1-ээс доошгүй удаа, нэг удаад 5 юмуу 7 хоногоос дээшгүй хугацаагаар зохион байгуулж байв. Төв, орон нутгийн штабууд харьяа отрядуудынхаа хуралдаж, сургуулилаагүй завсарласан үед отрядуудын дарга, байлдагчдын нэрийн жагсаалтын дагуу үе үе шалгаж бүртгэж байсан ба тэгэхдээ тэднийг цуглуулахгүйгээр гүйцэтгэдэг байжээ. Отрядуудын албан ёсны цугларалт, сургуулиас гадуур орон нутагт цэргийн хичээл, сургалтыг явуулах бол зөвхөн оролцогчдын хүслээр, сайн дурын үндсэн дээр явуулдаг байв.

Албан ёсны цугларалт, сургуулийг явуулахдаа ганц ганцаар юмуу хэсэг хэсгээр нь тактикийн бэлтгэл хийлгэж, винтов, пулемёт, автомат буу болон гранат эзэмшүүлж, галын бэлтгэлийг байлдааны буудлага хийлгэж шалган дүгнэдэг.

Түмтүүдийн штабуудын офицерийн байлдааны бэлтгэлийг сайжруулахын тулд 1943, 1944 онд Төв штабын дэргэд түмтийн дарга, штабуудын дарга нарыг курсээр сурган бэлтгэжээ.

Отрядуудын бүх дарга нарын мэргэжил, бэлтгэлийг дээшлүүлэхийн тулд тэдэнд зориулсан тусгай хөтөлбөр боловсруулж, хичээл сургуулийг орон тооны дарга нартай байнга, тогтмол явуулж, нийт бие бүрэлдэхүүнийг отрядуудын сургууль хийхээр цугларуулахын өмнө бүх дарга нарыг хуралдуулж нэг долоо хоногийн давтан бэлтгэлийг хийлгэдэг байжээ.

Танхимын хичээл сургууль. Сургалт, бэлэн байдлын дорвитой арга хэмжээнд улс төр, байлдааны бэлтгэл сургууль болон хээрийн сургууль ордог. Тухайн үеийн байлдааны бэлтгэл сургуулийн хөтөлбөрт тусгагдсаны дагуу байлдааны бэлтгэлийг 5 хэсэг болгон хийлгэдэг байжээ. Үүнд:

1. Жинхэнэ орон тооны штабуудын бэлтгэл дугаар;
2. Жинхэнэ орон тооны нийт дарга нарын бэлтгэл;
3. Аймаг, хотуудын төв дэх орон тооны бус мянгат, зуут, тавьт, аравтын дарга нарын бэлтгэл;
4. Аймаг, сумын төв ба Улаанбаатар хотын доторх морьт-отрядын дарга цэргүүдийн бэлтгэл;
5. Хөдөө МАА дээрээ ажиллаж буй морьт отрядын дарга, цэргүүдийн бэлтгэл хэсгүүдээс бүрдэнэ.

Жинхэнэ орон тооны штабуудын бэлтгэлийг 7 хоногт 1 удаа 3 цагаар явуулж штабын хээрийн албаны дүрмээс зааж, улмаар штабуудын албаны дарга нарын тус тусын гүйцэтгэх үүрэг ба мөн бусад дарга нарын гүйцэтгэх үүргүүдийг солилцуулан судлах хийгээд ямар нэгэн цагт өөрийн харьяа ангиудыг байлдаанд бүрэн дүүрэн удирдаж чадах дадлагыг олгох, штабаас гаргах ямар нэгэн бичиг баримтын зүйлүүдийг зөв тодорхой бөгөөд товч, цэргийн хэллэгээр зохиож чадах дадлага чадвар болон газрын зураг дээрээс газар орны байдлыг шинжлэн судлах дадлыг олгох зэрэг сургуулилт хийлгэдэг байсан.

Жинхэнэ орон тооны нийт дарга нарын бэлтгэлийг 7 хоногт 1 удаа 8 цагаар 5 өдөр явуулж байв. Үүнд: Улс төр 10 цаг, тактикийн бэлтгэл 55 цаг, техникийн бэлтгэл 20 цаг, галын бэлтгэл 10 цаг, гардан байлдаан 15 цаг, дүрмүүдийн бэлтгэл 10 цаг гэх мэт тодорхой хуваарьтай байв.

Аймаг, хотуудын төв дэх орон тооны бус мянгат, зуут, тавьт, аравтын дарга нарын бэлтгэлийг 7 хоногт 1 удаа 3 цагаар явуулах дээрх хичээлүүд адил боловч нийт цаг 60 цаг. Үүнд: 1933 оны гар гранатын бүтэц, хүчин чадлын тухай, хөнгөн пулемётын бүтэц хийц, байлдааны хүчин чадлын тухай зэрэг хичээлийг багтааж байв.

Ийнхүү хот хөдөөгийн морьт отрядын бүхий л дарга цэргүүдэд заагдах улс төр, байлдааны бэлтгэл сургуулийн төлөвлөгөө хөтөлбөрийг Төв штабаас гаргаж өгөхийн дээр энэхүү ерөнхий хөтөлбөрийг баримтлан аймаг хотын түмтийн штабуудаас харьяа мянгат, зуут, тавьт нэг бүр дээр гаргасан хөтөлбөр, хичээлийн хуваарийг сар сараар гарган мөрдөж байв.

Отрядаас эрхлэн хийлгэх цэрэгжилтийн сургуулийг орон нутаг ба ажил төрлийн байдлыг харгалзан аймаг хотын төв, суурин газрууд, хөдөө орон нутгийн малчдын дунд гэж ялган хувааж, төв суурин газруудад цэрэгжилтийн бүлгэм дугуйланг ажлын бус цагаар нийт хүн амыг хамарч хичээллүүдэж байсан бөгөөд бүлгэм дугуйланд багшлах хүмүүсийг аймгийн төвд түр курсээр буюу 7-10 хоногийн хугацаатай семинараар бэлтгэн гаргаж байлаа.

Цэрэгжилтийн бүлгэм дугуйланг 30 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, хамрагдах хүмүүсийг цэрэгт явсан, яваагүйгээр нь ялган дээд, доод дугуйланд хуваарилж, жинхэнэ болон туслах багш, бүртгэгчдийг намын үүрийн товчоогоор батлан томилж, цэргийн дүрмийн дагуу хатуу чанд сахилга бат, зохион байгуулалттайгаар хичээллүүлдэг журамтай байжээ.

Цэрэгжилтийн дугуйлан нь дотроо химийн аюулаас хамгаалах арга хэрэгсэл судлах, буудлагын онол, хүнд хөнгөн пулемёт, винтовын задаргаа, буудах арга ажиллагаа, морин цэргийн тактик, цэргийн дүрэм, нисэх онгоц ба түүний байлдааны зарим асуудал, техникийн бүлгэм дугуйлан зэрэг хуваариар хичээллэж байв.

Цэрэгжилтийн сургуулийг төв, хөдөөгийн мянгат, зуут, тавьт, аравтын дарга нар аймгийн түмтийн штабаас гаргасан улс төр, байлдааны бэлтгэл сургуулиудын хөтөлбөр, цагийн хуваарь ёсоор явуулдаг байсан бөгөөд байлдагчдын дунд аймгийн төв, суурин газруудад цэрэгжилтийн сургуулийг 7 хоногт 1 удаа тус бүр 2 цагаар, хөдөөгийн малчдад тавьт, аравтуудаар сард 1-2 удаа тус бүр 1 цаг 30 минут хийж байлаа. Тэгэхдээ хөдөөгийн байлдагчдын сургуулийг явуулахдаа богино хугацаатай хурал зөвлөлгөөний үеэр, түүний өмнө буюу дараа нь, мөн хамтарч чоно авлах, тариа тарих, өвс хадах, малын ноос, хөөвөр авах үеийг ашиглан зохиодог байв.

Шаардлагатай зарим үед малчид, морьт отрядын гишүүд, байлдагчид, хөдөөгийн сумдад намын байгууллагын шууд удирдлагаар захиргаа, олон нийтийн байгууллагатай хамтран 3 сард нэг бүтэн долоо хоногийн сургуулиар буюу цэргийн насны идэрчүүдийг албан ёсоор татан сургуулилах журмаар хичээллүүлэхийн хамт газ эсэргүүцэгчтэйгээр тогтоосон зайд тусгай марш,

буудлагын тэмцээн зохиох ажлыг тусгай график, төлөвлөгөөтэйгээр явуулдаг байжээ.

БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлөөс 1944 оны 9 дүгээр сард дунд сургууль, техникумуудын сурагчдыг “Цэргийн бэлтгэлтэй болгох тухай” тогтоол гаргасан¹ ба тогтоолын дагуу дунд сургуулийн 5-10 дугаар анги, техникумын сурагчдын анхан шатны ба цэрэгт татагдахын өмнөх бэлтгэлийн тухай дүрмийг батлан гаргаж, сурагчдыг цэргийн бэлтгэлтэй болгох тухай энэ шийдвэрийг 1944 онд баталсан “Ард нийтээс цэргийн албыг хаах үүрийн тухай” хуулинд нарийвчлан тусгажээ. Уг хуулинд 5-7 дугаар ангийн сурагчдыг цэргийн анхан шатны мэдлэгтэй болгохын тулд цэргийн сургуулийг 7 хоногт 2-3 цаг явуулах, дунд сургуулийн 8-10 дугаар анги, техникум, их, дээд сургуулийн оюутан сурагчдад 7 хоногт 3-4 цаг, бусад залуучуудад цэрэгт татагдахын нь өмнө 80 цагийн сургууль явуулахаар заасан байна.

Отрядад байлдааны бэлтгэлийг сайжруулах зорилгоор ардуудын ажил багатай цагт 5-7 хоногоор, жилд 1-ээс доошгүй удаа хичээл сургуулийг зохион байгуулж байх, отрядууд байлдагчидтай сургуулилахдаа нэг бүрчлэн ба хэсэг бүлгээр нь тактикийн бэлтгэлтэй болгох, винтов, пулемёт, автомат, гранатыг эзэмшиж сургах, галын бэлтгэлийг дүгнэхдээ байлдааны буудлагаар шалгаж дүгнэх, сургуулийн төгсгөлд хээрийн сургууль хийж сурлагыг дүгнэж байх зэрэг журам тогтоосон байлаа.

Хээрийн дадлага сургууль. Отрядын байлдагчдад цэргийн хэргийн дадлага олгох томоохон ажлын нэг нь хээрийн маневрийн сургууль байлаа. Өвөл, хавар, зун, намрын аль ч улиралд цаг агаар, газар орны хүндрүүлсэн нөхцөлд АӨХСДМО алс хол газар марш үйлдэж, морьт цэргийн олон отрядыг оролцуулан тусгай хөтөлбөр, төлөвлөгөөгөөр хээрийн дадлага, сургуулийг олон хоногоор явуулдаг байв.

МАХН-ын Төв Хороо, Засгийн газар, морьт отрядын төв штабын шийдвэрээр 1942 оны дөрөвдүгээр сард Төв аймгийн Зорголхайрхан уулын хавьд, 1942 оны есдүгээр сард Төв аймгийн Баянбараат сумын нутаг Буурхайрханы булаг, 1943 оны 9 дүгээр сард Хэнтий аймгийн Баянмөнх сумын Баянбулаг, 1942 оны 3 дугаар сард Дорнод аймгийн Очирбаянмөнх, 1944 оны 9 дүгээр сарын 15, 20-нд Булган аймгийн Могод сум, 1944 оны Есдүгээр сарын 30-нд Дундговь аймгийн Өлзийт сумдад болсон хээрийн сургуульд дээрх аймгуудын төв, сумдын олон мянган хүн хамрагджээ.

АӨХСДМО-уудын хээрийн сургуулиар цэргийн марш үйлдэх, давших, хориглох байлдаан хийх сургалтыг зохион байгуулж, тэгэхдээ анги хуваагдаж хэд хэдэн тавьт хоорондоо харилцан “байлдах” сургууль хийх юмуу зэргэлдээ сум, тавьт, зуутуудыг хооронд нь нэгтгэн нийлүүлж байлдааны бэлтгэл, дадлагыг хийлгэж байв. МАХН, Засгийн удирдагчид хээрийн сургалт дадлагад ихээхэн ач холбогдол өгч, заримд нь биечлэн оролцдог байжээ.

Төв аймгийн Зорголхайрхан болон Хэрлэн голын баруун эрэгт болсон том хэмжээний хээрийн сургуулийн үйл ажиллагаанд маршал Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал нар биечлэн оролцож, удирдан зохион байгуулж байсан ба тэр

¹ Монгол цэргийн түүхийн товчоон. Дэд дэвтэр. УБ., 1996. 347 пахь тал

хээрийн сургуульд 1500-3000 хүртэл хүн оролцож 3-5 хоногийн сургууль хийсэн байна.

Улаанбаатар хотын жишээгээр аваад үзэхэд морьт отрядуудын дарга нарын нэгдсэн хээрийн сургуульд явах нэг мянгатын байгуулалт ба түүний зуут, тавьтуудад тусгай дугаар ногдуулдаг байв. Үүнд:

Давших мянгатын дугаар-20

- 35 дугаар зуут, түүний харъяа тавьтад 18 ба 19 дүгээр;
- 35 дугаар зуут, түүний харъяа хоёр тавьтад 28 ба 29 дүгээр;
- 69 дүгээр зуут, түүний харъяа хоёр тавьтад 37 ба 38 дугаар;
- 45 дугаар зуут, түүний харъяа хоёр тавьтад 5 ба 8 дугаар;
- 43 дугаар зуут, түүний харъяа хоёр тавьтад 6 ба 7 гэсэн дугааруудыг ногдуулах бөгөөд аравтын дугаарыг зуут, тавьтуудаас түүгээрээ өгч гүйцэтгэдэг байжээ.

Хориглох зуут, тавьтуудад

- Яармагын зуутад 85 дугаар, түүний харъяа хоёр тавьтад 10-12 дугаар;
- Майхан толгойн тавьтад 85 дугаар;
- Улаан хавцлын тавьтад 69 дүгээр;
- Туул голын эргийн тавьтад 68 дугаар гэсэн дугааруудыг тус тус олгож нэрлэдэг байсан байна¹.

Ийнхүү тусгай дугаар өгдөг нь цэргийн нууцыг хадгалах шаардлагын улмаас үүдсэн бөгөөд хээрийн сургуулийг цэргийн жинхэнэ анги, салбаруудын жишгээр, байгаль цаг уур, байлдааны цагийн хүндрүүлсэн нөхцөл байдалд аль болохоор ойртуулан явуулахыг эрмэлздэг байсан нь сургалтын чанарыг дээшлүүлэхэд нааштай нөлөө үзүүлдэг байжээ.

Улс төр соёл хүмүүжлийн ажил. Морьт отрядын гишүүдийн дотор зохиох улс төр соёл хүмүүжлийн ажлыг аравт, тавьт, зуут, мянгат, түмтээр зохион байгуулж, тэдгээрийн комиссар улс төрийн туслах нар энэ ажлыг биечлэн зохион явуулах үүрэг бүхий байгууллага, хүмүүс удирдан явуулдаг байсан бөгөөд морьт отрядын аймгуудын түмтийн комиссарын үүргийг аймгийн намын хорооны суртал ухуулгын хэлтсийн дарга нар хавсарган гүйцэтгэдэг байв.

Тавьт, зуутын улс төрийн удирдагчаар мэдлэг боловсролоор илүү сайн хүмүүсийг шилж сонгон авч, мянгат түмтийн даргын тушаалаар томилох ба суртал ухуулгын ажлыг баг, сумын хэмжээнд намын үүрийн нарийн бичгийн дарга, багийн дарга, ухуулагчид хамтран гүйцэтгэдэг байжээ. Морьт отрядын дарга, цэргүүдийн дотор зохиох улс төрийн ажлыг хамрах хүрээгээр нь 3 хэсэгт хуваадаг. Үүнд:

1. Үйлдвэр, албан газар, хөдөөгийн малчин ардуудын дунд зохиох суртал ухуулгын ажлууд;
2. Аймаг, хотын түмтүүд ба морьт отрядын төв штабын офицер, ажилчдын дунд зохиох болон бусад хэлбэрийн ажил;
3. Морьт отрядуудын дарга цэргүүдийн сургууль, хээрийн дадлага цугларалтын үед зохиох ажил гэж хуваарилан ажиллаж байсан бөгөөд зааврыг

¹ Болорчимэг П. Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отрядын түүхийн асуудалд. Магистрын дипломын ажил. УБ. 2016.

МАХН-ын Төв Хорооны суртал ухуулгын хэлтсээр батлуулан морьт отрядын улс төрийн ажилтнуудад гарын авлага болгон хүргүүлж хэрэгжүүлдэг байв.

Мөн морьт отрядын гишүүдийн дунд зохиох улс төрийн сургуулийг байлдааны цагийн байдалд улам ойртуулах зорилгоор

- нам, улс төрийн ажлын ерөнхий байдал;
- марш ба тулгаран байлдах үеийн нам, улс төрийн ажил;
- амралтын үед зохиох ажил;
- хориглолтын үед зохиох ажил;

- дайсны ар талд хийх ажил гэсэн таван үндсэн чиглэлээр судлуулж, хээрийн сургуулийн үед дадлагажуулж байжээ.

Сургалт, бэлтгэлийг дээшлүүлэхэд чиглэсэн бусад ажлууд. Сайн дурын морьт отрядын дарга, улс төрийн ажилтан, гишүүдийн цэргийн хэргийн мэдлэгийг нэмэгдүүлэхэд тус дэм болох үүднээс “Үнэн”, “Улаан-Од” зэрэг тогтмол хэвлэлүүдэд олон материал нийтэлж байсны гадна 1942-1948 онд АӨХСДМО-оос эрхлэн сурах бичиг, гарын авлага материал хэвлэн гаргаж аравт, тавьт, мянгат, түмтүүдэд хуваарилан хүргэж судлуулж байжээ. Байлдааны бэлтгэл сургуулийн амжилт, тэргүүн туршлагыг сурталчлахад “Улаан-Од” сонин их үүрэг гүйцэтгэж байв.

Түмтүүдийн штабын офицеруудын байлдааны бэлтгэлийг сайжруулахын тулд 1943, 1944 онд Төв штабын дэргэд түмтийн дарга, түүний штабуудын дарга нарын курс байгуулж сурган бэлтгэж байсан ба мөн Зөвлөлт эх орны дайны явцад гарсан Зөвлөлтийн улаан армийн туршлага болох морьт отрядын байлдагчдын байлдааны бэлтгэлийг нэмэгдүүлэх арга ажиллагаа, гар гранатыг хэрхэн ашиглах, танк эсэргүүцэх, шатаах шилийн тухай, агаарын десантыг эсэргүүцэхэд хөнгөн пулемётыг хэрхэн бэлтгэж ажиллуулах, техникийн ба тактик, маршийн үед цэрэг нэг бүрийн ажиллагаа ямар байх тухай зэрэг цэргийн бэлтгэлийн холбогдолтой тохимолуудыг тус тус 10 мянган хувиар хэвлэн гаргаж, бас гранат, хөнгөн пулемёт, винтов, морин сургууль, сэлэм ашиглах тухай 7 төрлийн үзүүлэн таниулах зургууд тус бүр 40 мянган хувийг хэвлэн тараасан байна.

Отрядууд цугларч сургуулилаагүй үед орон нутгийн штабуудаас клуб, улаан булан зэрэг газарт цэргийн асуудлаар лекц, илтгэл, яриа таниулга хийж, буудлагын газарт буудлага хийлгэх, цэргийн мэргэжлийг судлах дугуйлангуудад ард иргэдийг хамруулан оролцуулах зэргээр олон түмний дунд сурталчилгаа, сургалт явуулж байлаа.

Дугуйлангуудыг хот суурин бүрд ажилчин, албан хаагчдыг оролцуулан зохион байгуулж байсан бөгөөд тэгэхдээ дугуйланг сард 1 удаа, лекц, яриа, буудлагыг мөн сард 1 удаа хийлгэж, хөдөөд лекц яриа, үзүүлэн таниулах зүйл, үзэсгэлэн, буудлага зэргийг нүүдлийн журмаар зохион байгуулж байжээ.

Эдгээр арга хэмжээ нь морьт отрядын дарга, цэргүүдээс байлдааны бэлтгэлийг богино хугацаанд амжилттай эзэмшиж сурахад чухал нөлөө үзүүлж байсан бөгөөд АӨХСДМын дарга цэргүүдийн байлдааны бэлтгэлийн сурлагын

дүн 1943 онд 73 хувийн амжилттай байсан бол 1945 онд 82 хувь болон өссөний дотор буудлагын сургуульд 100 хувийн дүн үзүүлж байжээ¹.

АӨХСДМО-ын бэлэн байдлын төлөвлөгөөний тухайд. АӨХСДМО нь анх 1942 онд байгуулагдахдаа л эх орноо батлан хамгаалах хүчийг бэхжүүлэх, нийт ард түмнийг цэргийн анхан шатны мэдлэгтэй болгох, мөн Чөлөөлөх дайнд байлдааны үүрэг гүйцэтгэх зорилготой байгуулагдсан учир гэнэтийн халдлага дайралт тохиолдвол эх орноо хэрхэн хамгаалах талаар АӨХСДМО-ын жанжин хошууч генерал Ч.Мижид байлдааны үед морьт отрядуудын Төв штабаас ажиллах ажилчдын ерөнхий төлөвлөгөөг боловсруулан гаргаж, төлөвлөгөөний дагуу байнгын бэлтгэл сургуулилт хийж, бэлэн байдлыг өндөр түвшинд байлгадаг.

Байлдааны үед морьт отрядуудын Төв штабаас ажиллах төлөвлөгөө нь:

1. Морьт отрядын байлдагч, дарга цэргүүдийг цуглуулах;
2. Сайн дурын отрядыг зэвсэглэх;
3. Морьт отрядыг байлдаанд оруулж удирдах;
4. Морьт отрядын аж ахуй, хоол хүнсийг бэлтгэн нийлүүлэх;
5. Морьт отрядын хорогдлыг нөхөх ба хүчнийг нэмэгдүүлэн олшруулах зэрэг таван талт хэсгээс бүрддэг байна.

АӨХСДМО-ын байлдагч, дарга цэргүүдийн цугларалтын тухайд. Зэвсэгт хүчний жанжин, маршал Чойбалсан аль аймгуудын түмтүүдийг хэзээ хаана бэлэн байлгах тухай шийдвэр гаргаж тушаал өгөх ба бэлтгэх аймгийн түмтүүдийн даргад нууц тушаалыг цахилгаан шипрээр яаралтай өгч, Төв штабаас хариуцлагатай нэг хүнийг маршалын гарын үсэгтэй үнэмлэхтэй явуулж дарга, цэргүүдийг цуглуулахад туслуулан бүх хүмүүсийг бэлэн байлгах явдлыг аймгийн дунд шууд хариуцуулах ба МАХН-ын Төв Хороо, засгийн газраас аймгийн намын хороо, захиргааны дарга нарт сайн дурын отрядын байлдагч дарга, цэргүүдийг цуглуулахад тусламж үзүүлэх тухай цахилгааныг бэлтгэн явуулж, цугларах, зохион байгуулах газрыг маш нууцаар зураг дээр тэмдэглэн төвөөс явах хүнд бариулан явуулахаар заасан байдаг байв.

Харин бэлтгэх хүмүүст хүн малын эмч нараас бусдад дан эрчүүдийг оролцуулах ба зуутуудад сумын эмч нарыг бэлэн байлгаж эдгээр эмч нар нь өөрт буй эм, эмчилгээний хэрэглэлийг авч ирэхээр төлөвлөгөөнд тусгасан байлаа.

Сайн дурын отрядыг зэвсэглэх талаар. Зэвсэгт хүчний жанжны тушаалаар отрядууд өөрт хадгалагдаж буй герман винтов, сумаар хангаад зогсохгүй автомат, гранат хэрэглэж болох ба морьт отрядуудын цугларсан газарт олон буу зэвсгийг төвөөс тээвэрлэн хүргүүлж, шаардлагатай унаа хөсөг, авто машиныг Зэвсэгт хүчний жанжны орлогч нарын тушаалаар гаргуулан авч, отрядын бүрэлдэхүүнийг улс төрийн талаар хянан шалгасны дараа зэвсэг хэрэглэлийг олгон байлдаанд оруулах журамтай байжээ.

Байлдагч, дарга цэргүүдийн сум хэрэглэлийг тасалдуулахгүй хангах явдлыг отрядын жанжин ба штабын дарга нараас зөвшөөрөл авч хүргэх ажлыг явуулах ба хэрвээ олон анги, газар аймаг, аймгаар цугларах хэрэг тохиолдвол дундыг

¹ Мөнхөө Н. Домогт морьт отряд. УБ., 1985. 46 дахь тал

баримталсан нэг тоочиг газарт тээвэрлэн очуулж тараан олгох зэрэг арга хэмжээнүүдийг авна.

Сайн дурын морьт отрядын ар талын хангалт. Ар талын хангалт, түүний дотор хүнсний хангалтыг орон нутгийн ардуудаас сайн дурын морьт отрядын хөрөнгө мөнгөөр худалдан авч бэлтгэх зорилгоор нэг сая төгрөгийн тусгай фонд байгуулсан байсан ба хэрвээ ардуудаас авч бэлтгэх бололцоогүй байвал орон нутагт бэлэн байгаа цэргийн хоол хүнсэнд бэлтгэсэн зүйлээс авч хэрэглэхээр төлөвлөсөн байлаа. Сайн дурын морьт отрядын аравт, тавьтууд нь хувиараа майхан, тогоо шанага, хөсөг уналгатай байх ба түмт, мянгатын штаб, Төв штаб нь өөрийн байгууллагын нөөцөлсөн хэрэгслийг ашигладаг байв.

Сайн дурын морьт отрядын хорогдлыг нөхөн дүүргэх ба хүчнийг нэмэгдүүлэн олшруулах талаар. Хорогдлыг нөхөх ба амьд хүчийг нэмэгдүүлэх зорилгоор хамгийн ойролцоо байгаа аймгаас буюу зарим үед төвөөс юмуу өөр холын аймгуудаас жинхэнэ ажиллах бүх хүчний гуравны хоёр хувиас доошгүй тооны хүмүүсүүдийг бэлтгэн татах ба байлдаан бүхий районаас 200 километрийн дотор бэлтгэн ирүүлэх зэрэг нарийн төлөвлөгөөтэй байжээ.

Дээрхээс харахад АӨХСДМО-ын удирдлага, зохион байгуулалт өндөр түвшинд байжээ гэж дүгнэж болохоор байна.

3.6.2. Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отряд чөлөөлөх дайнд

Төр, засгаас авч хэрэгжүүлсэн олон талт арга хэмжээний үр дүнд Эх орноо зэвсэг барин батлан хамгаалах үйл хэрэгт хүн амыг сурган боловсруулах, цэргийн анхан шатны бэлтгэлийн гол уурхай нь АӨХСДМО-ууд болсон бөгөөд 1945 оны японыг эсэргүүцсэн дайны үе гэхэд тэдгээрт нийт 74556 хүн хамрагдаж байсан бөгөөд тэдний дотроос дайнд 1186 хүн биечлэн үүрэг гүйцэтгэж, ар талд буюу нөөцөнд 1170 хүн бэлэн байдалтай байв¹.

Нэг. Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отрядуудаас Чөлөөлөх дайнд биечлэн оролцсон бүрэлдэхүүн 1945 оны Чөлөөлөх дайнд морьт отрядуудын дайчдаас бүрдсэн 3 отряд үүрэг гүйцэтгэн оролцсон байна². Үүнд:

1. АӨХСДМО-ын жанжин, хошууч генерал Ч.Мижидийн удирдсан отряд. Сүхбаатар аймгийн Уулбаян, Онгон, Хонгор, Дарьганга, Асгат, Баяндэлгэр, Төвшинширээ, Халзан, Сүхбаатар, Дарханхан, Зотол, Бүрэн, Баянтэрэм, Хэнтий аймгийн Баянхутаг, Баян, Мандал, Биндэр, Галшар, Буянт, Идэрмэг, Мөрөн, Өмнөдэлгэр, Баянмөнх, Батноров сумын морьт отрядуудын цэргээс бүрдсэн. Таван зуутын зохион байгуулалттай. Нийт 588 хүнтэй;

2. МАХН-ын Төв хорооны Н.Лхамсүрэнгийн удирдсан отряд. Дорнод аймгийн Хотын захиргаа, Дашбалбар, Аравжаргалант, Булган, Хөгнө, Баян-Уул, Чойбалсан, Цагаан-Овоо, Хунт, Баяндун, Түмэндэлгэр, Сүхбаатар аймгийн Дарханхан, Зотол, Урт, Баяндэлгэр, Дорнод аймагт суурьшсан Төв, Хөвсгөл, Архангай, Өвөрхангай аймгийн харъяат хүмүүсээс бүрдсэн. Нэг зуутын зохион байгуулалттай. Нийт 91 хүнтэй;

¹ Батлан хамгаалахын Төв архив. Сан 103, данс-9, хадгаламжийн нэгж 14, хуудас-25.

² Батлан хамгаалахын Төв архив. Хөмрөг-103, данс-9, хадгаламжийн нэгж-19, хуудас-1-71.

3. АӨХСДМО-ын Төв штабын дарга, дэд хурандаа В.Даржаагийн удирдсан отряд. Дорноговь аймгийн 14 сумын морьт отрядын дайчдаас бүрдсэн. Таван зуутын зохион байгуулалттай. Нийт нь 508 хүнтэй.

Дайны дараа АӨХСДМО-ын Төв штабаас Гадаад яамны орлогч сайд Н.Лхамсүрэнд явуулсан мэдээгээр:

- Хошууч генерал Ч.Мижид, дэд хурандаа В.Даржаа нарын удирдсан отрядууд нь таван зуут, нэг мянгатын, Н.Лхамсүрэнгийн отряд нь нэг зуутын зохион байгуулалттайгаар зохион байгуулагдсан. Морьт отрядуудын үйл ажиллагаатай холбоотой баримтуудыг судлан үзэхэд Ч.Мижид, Н.Лхамсүрэн нарын отрядын бүрэлдэхүүний талаар тодорхой баримт одоогоор олдоогүй байна.

Харин В.Даржаагийн отрядын дарга, цэргүүд нь байлдааны чадварын хувьд орон нутгийн албан хаагчид 39, цэргийн алба хаасан 53, түр цэргийн сургууль үйлдсэн 48, цэрэгт огт яваагүй 361 хүн байжээ¹. Насны хувьд 16-58 нас хүртэлх хүмүүсээс бүрдсэн, үүнд 16 настай Эрдэнэ сумын Гэлэгбалсан, Дэлгэрхэт сумын Шархүү, Бадрах сумын Панди зэрэг хүмүүс өөрийн сайн дураар явж байжээ².

Хоёр. Байлдааны ажиллагаа АӨХСДМО-уудыг дайнд оролцуулах талаар гаргасан ямар нэгэн тушаал, шийдвэр архивт байхгүй байна.

Харин морьт отрядуудын Төв штабын дарга, дэд хурандаа В.Даржаагийн илтгэлд дурдсанаас үзвэл ЦЯЯ-ны сайд, Бүх цэргийн жанжин Маршал Х.Чойбалсангаас өгсөн үүргийн дагуу отрядуудыг бүрдүүлж, хошууч генерал Ч.Мижидийн удирдсан отряд Долнуурын чиглэлд, дэд хурандаа В.Даржаагийн удирдсан отряд Чуулалт хаалга, Жанчхүүгийн чиглэлд үүрэг гүйцэтгэсэн байна. Гэхдээ Н.Лхамсүрэнгийн удирдсан отряд аль чиглэлд, ямар үүрэг гүйцэтгэсэн талаарх баримт одоогоор олдоогүй байна.

Хошууч генерал Ч.Мижидийн удирдсан отряд нь ЦЯЯ-ны сайд, Бүх цэргийн жанжны тушаалаар 1945 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр МАХН-ын Төв Хорооны даалгавраар тусгай үүрэг гүйцэтгэхээр томилогдсон Н.Ламжавын мэдэлд шилжин үүрэг гүйцэтгэсэн³ бөгөөд дээрх отрядуудын байлдааны ажиллагаанд холбогдох баримт архивт шилжиж ирээгүй учир чухам ямар үүрэг гүйцэтгэн ажилласныг тодорхойлох боломжгүй байна.

Тиймээс одоогоор мэдэгдэж байгаа Чуулалт хаалга, Жанчхүүгийн чиглэлд үүрэг гүйцэтгэсэн отрядын байлдааны ажиллагааны талаарх мэдээ, баримтыг дор нэгтгэн сийрүүлэв.

¹ Батлан хамгаалахын Төв архив. Сан 103, данс-9, хадгаламжийн нэгж 14, хуудас-16-23

² Энэ баримт Дорноговь аймгийн сайн дурын морьт отрядын хээрийн мянгатын орлогч Сүрэнжавын илтгэлд бий.

³ Хошууч генерал Ч.Мижидийг отрядын хамт Н.Ламжавын мэдэлд шилжихийг тушаасан Маршал. Х.Чойбалсангийн цахилгаан: "1945 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр. Сайн дурын морьт отрядын жанжин, хошууч генерал Мижидэд. Би чамтай Баруун Сөнөд дээр уулзана гэж бодсон, чи байгаагүй тул уулзсангүй. Гэвч бусад нөхөдтэй би энд уулзав. Иймд чиний бие өөрийнхөө отрядын хамтаар нөхөр Ламжавын мэдэлд бүрэн шилжихийг чамд тушаасугай. Хэзээ, хэрхэн буцах тухай миний тусгай тушаалыг очтол гэдрэг буцаж болохгүй. Надтай харилцахдаа Долнуураар дамжиж харилцаж байсугай. Харин өөрийнхөө отрядыг Долнуурт аваачиж болохгүйг мэдэгдье. Чойбалсан".

Сайн дурын морьт отрядуудын Төв штабын дарга дэд хурандаа В.Даржаагийн удирдсан отряд дан ганц Дорноговь аймгийн морьт отрядын дайчдаас бүрдэж, Чуулалт хаалга, Жанчхүүгийн чиглэлд үүрэг гүйцэтгэжээ.

АӨХСДМО-уудын жанжин хошууч генерал Ч.Мижид, морьт отрядуудын Төв штабын дарга, дэд хурандаа В.Даржаа нар 1945 оны 8 дугаар сарын 17-ны өдөр Улаанбаатар хотоос гарч, 18-ны өдөр Дорноговь аймагт хүрэлцэн очиж аймгийн удирдлагуудтай уулзан маршал Чойбалсангаас өгсөн үүргийг танилцуулж, аймгийн яам, намын хорооны хавсарсан тэргүүлэгчдийн хурлыг хийж, тус аймгийн баруун урдаас эхлэн зүүн зах нутаг бөгөөд гол төлөв хязгаарын болох Мандах, Сайхандулаан, Хөвсгөл, Агруут, Хатанбулаг, Улаанбадрах, Эрдэнэ, Дэлгэрэх, Дэлгэрхэт, Алтанширээ, Баянмөнх, Айлбаян, Өргөн зэрэг 13 сум, аймгийн төв, нийт 14 газраас морьт отрядын дарга, байлдагчид 786, отрядын бус энгийн ард ажилчид 178 хүн, бүгд 904 хүнийг тус бүр өөрсдийн бололцоо байдлаар 1 юмуу 2 морьтой, долоо хоногийн хоол хүнстэй, сэрүүний ба дулааны хувцастай, 5 хүн тутам 1 майхантай ба гал тогооны хэрэглэлтэй, хүн бүр дэвсгэр, хучлага зэргийг өөрсдийнхөө амин хувиас хэрэглэн явах, гагцхүү майхан ба усны ган сав зэргийг сумдын захиргаад, гар үйлдвэр, худалдааны байгууллагуудаас бололцоогоор нь туслалцуулан гаргуулахын дээр огт уналга морьгүй хүмүүст сумдуудад хадгалагдан буй алдуул адуунаас хэрэглүүлэн гаргаж 8 дугаар сарын 27-ны өдөр Эрдэнэ ба Улаанбадрах сумдад хоёр хэсэг цэг дээр цугларах, 28, 29-ний өдрүүдэд нэр бүхий хоёр цэг дээр цугларсан ангиуд Замын-Үүдийн Эрдэнэ овооноос баруун урагш 5 километр зайтай Жавагийн худаг хэмээх газар цугларах тогтоолыг гаргасан байна.

Үүнтэй холбогдуулан аймгийн түмтийн штабаас тушаалуудыг сумдын зуутын штабуудад хүргэж, аймгийн яам, МАХН-ын хороо, түмтийн штабаас нэр бүхий 13 сум нэг бүрд бие төлөөлөгчдийг 19-ний өдөр явуулж, 26-ны өдөр Төв штабаас явуулсан буу сумыг авч, 27-ны өдөр Замын-Үүдийн 12 дугаар отряд дээр байрлуулжээ. Дээрх хоёр цэг дээр дээр 1945 оны 8 дугаар сарын 29-ний оройны байдлаар нийт 818 хүмүүс хүрэлцэн ирсэн байв.

ЦЯЯ-ны сайд, Бүх цэргийн жанжнаас “500-гаас илүү хүн битгий авч яв!” гэж тушаасан учир түмтийн штабаас аймгийн МАХН-ын хорооны дарга Чойжамц, Дотоод яамны харъяа хэлтсийн дарга Цэдэн нартай зөвлөлдөн хүрэлцэн ирсэн хүмүүсийн дотроос ар гэртээ хүн бүл муутай ба бие өвчтэй, нас хөгшин болсон зэрэг хүмүүсийг чөлөөлөн, 510 хүнийг сонгон авч, аймгийн түмтээс штабын дарга ба мянгатын дарга 1, Дотоод яамны хэлтсээс хэсгийн төлөөлөгч 2, аймгийн МАХН-ын хорооны суртал ухуулгын хэлтсийн зааварлагч 1, аймгаас хүний бага эмч 1-ийг тус тус томилон отрядыг бүрдүүлсэн байна.

Морьт отрядын хээрийн штабаас 1945 оны 8 дугаар сарын 29-ний өдөр “Жинхэнэ байлдааны байгуулагдах нэг мянгатын зохион байгуулалтын дарга ажилчдыг томилох тухай” 1 тоот тушаалыг гаргаж, мянгатын даргад бага дэслэгч Санжид, орлогчид Сүрэнжав, штабын даргад Базаржав, аж ахуйн даргад Ням, хүнсний ба аж ахуйн эрхлэгчид Дашдорж, бичиг хэргийн эрхлэгчид Гэлэгбалсанг болон зуут, тавьтын удирдлагуудыг тус тус томилосон байна. Мөн тушаалд мянгатын даргаас аравтын дарга нарыг томилохыг тушааж,

томилогдсон дарга нар нь өөр өөрийн ажилдаа онц шийдвэр зоригтой, жинхэнэ байлдааны журмаар бүх ажлаа зохион байгуулж, мянгат ба хээрийн штабаас гаргасан ямар нэгэн байлдааны ба тайван цагийн тушаалыг ямар ч дутагдалгүй цаг тухайд нь жинхэнэ цэргийн ёс журмаар гүйцэтгэж байхыг тушаасан байна.

Зэвсэглэлийн хувьд Төв штабаас герман винтов 400, сум 30000 гаруй ирснийг тарааж, дутуу хүмүүст хязгаарын 12 дугаар отрядаас эвдэрхий голдуу япон буу 83, мөн сум 8700-г тус тус авч олгон, нийтдээ уналгын морь 813, ачилгын тэмээ 72, майхан 22, хоол хүнсэнд зориулж бэлтгэсэн хонь 50-тайгаар 1945 оны 8 дугаар сарын 30-ны орой 17 цагт Замын-Үүдээс байлдааны үүрэг гүйцэтгэхээр хөдөлжээ.

Марш үйлдэхийн өмнө отрядын бүх дайчдад аймгийн МАХН-ын хорооны дарга Чойжамц, 12 дугаар отрядын дарга хошууч Сонжав нараас яриа хийж, сануулгыг өгсөн байна.

Отряд нь Бүх цэргийн жанжнаас өгсөн үүргийн дагуу аяны маршаар явж 9 дүгээр сарын 2-ны өдрийн 10 цагт улсын хил давж Эрээн давс хэмээх газарт амралтыг зохион байгуулж, хүн, морьдыг амрааж, 6-ны өдөр Баруун Сөнөд вангийн хошууны төвд очиж, тэнд байсан 12 дугаар отрядын сумангаас хоол хүнсний зүйл болон зэвсэг, галт хэрэгслийг сэлбэн авч, 10-ны өдөр Завсар хотоос урагш 15 километрт Чонын гол хэмээх газар хуягт бригадын ар талын ангиудтай нэгдэн байрлажээ.

Отряд явсан чиглэлийнхээ дагуу тусгай жижиг салбар бүлгүүдийг үлдээж явсан, үүнд Эрээн давсанд Ламжав даргатай 10 хүнийг 9 дүгээр сарын 5-ны өдөр, Хоолтын сумын районд Жамбал даргатай 20 хүнийг 9 дүгээр сарын 5-ны өдөр, Банж хэмээх жижиг тосгонд Буяндэлгэр даргатай 20 хүнийг, Төмөрийн Шандуй хэмээх хотын районд түмтийн штабын дарга Балдан, зуутын дарга Ухнаа даргатай 52 хүнийг 9 дүгээр сарын 8-ны өдөр үлдээсэн бөгөөд эдгээр салбарууд нь тухайн газар орны ард олонд ухуулан таниулах ажлыг хийж, амгалан тайван байдлыг хангах ажлыг зохион байгуулж байлаа.

Отрядын штаб Завсар хотод байрлаж байх үед буюу 9 дүгээр сарын 14-ний өдөр Адуучин хошууны нутаг Модон Шандуй хэмээх тосгонд хятадын дээрэмчид энгийн хүмүүсийн эд зүйлийг дээрэмдэн алж байгаа мэдээ ирсэн учир хэсгийн төлөөлөгч Цэрэндэжид, зуутын дарга Рэнцэндорж нараар удирдуулсан нэг зуутыг явуулс бөгөөд тэд уг тосгоны ойролцоо дээрэмчидтэй тулгаран буудалцаж, 2 хүнийг алж, 7 бууг олзлон авсан ба зуут тэндээ байрлаж байгаад 9 дүгээр сарын 18-ны өдөр үндсэн отрядыг буцахад эгэн очиж нэгджээ. Отряд тийнхүү буцаж 9 дүгээр сарын 20-ны өдөр Баруун Сөнөдийн төвөөс зүүн тийш 6 километр газарт байрлаж байхад Дотоод яамны сайд, хошууч генерал Б.Шагдаржаваас тушаал өгөхдөө отрядаас нэг зуутыг гаргаж, Өвөр Монголын олзлогдсон 7, 9 дүгээр дивизүүдийн цэргийг Замын-Үүд хүргэх үүрэг өгсөн тул түмтийн штабын дарга Балдан, зуутын дарга Ухнаа даргатай зуутыг 22-ны өдөр явуулжээ. Мөн сайдаас нэг зуутаар хошууны оргодол айлуудыг хөөн нүүлгэж Монголын нутагт оруулах тушаалыг өгсөнд түмтийн дарга Данзан, зуутын дарга Догсом, хэсгийн төлөөлөгч Цэрэндэжид нарын удирдсан зуутыг 9 дүгээр сарын 23-ны өдөр, мөн Монголын цэргээс удаа, дараа оргож гарсан оргодол 9 хүнийг

Замын-Үүдэд хүргэх 10 хүнийг тус тус томилон явуулж үүрэг гүйцэтгүүлсэн байна.

Отряд нь Баруун Сөнөд хүрээд Бүх цэргийн жанжны тушаалыг хүлээн 10 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл байрласан ба тэгэхдээ өдөр бүр 3-6 цагийн байлдааны бэлтгэл сургуулийг хийж байв.

Отрядын даргаас Бүх цэргийн жанжнаас буцах тухай тушаалыг хүлээн аваад 2-ны өдөр Баруун Сөнөдөөс хөдлөн 7-ны өдөр Замын-Үүдийн 12 дугаар отрядын байрлалд ирж, 8-ны өдөр зэвсэг, галт хэрэгслэлийг тус 12 дугаар отрядад түр хадгалуулаад, дарга, цэргүүдийг сумдад нь зохион байгуулалттайгаар тарааснаар тус морьт отрядын байлдааны ажиллагаа дуусжээ.

Отряд нь Замын-Үүд-Эрээн давс-Хулдын сүм-Хоолтын сүм-Баруун Сөнөдийн тамгын газар-Завсар хот-Чоно гол гэсэн нэр бүхий газруудаар ирж, буцахын нийт 1656 километрийн марш үйлдсэн байна.

Гурав. Дайнд биечлэн оролцсон бүрэлдэхүүний байлдааны үеийн зардал, хохирол, шийтгэл, сайшаал шагнал:

Байлдааны үеийн зардал. Морьт отрядуудын Төв штабаас дайны дараа гаргасан мэдээгээр 2 чиглэлд биеэр явсан бүх хүмүүсийн хоол хүнсний зардалд 1186 хүн нь 60 хоногоор тооцож, нэг хүн өдөр бүр 30 төгрөгийн зардлаар бодож, бүгд 2134800 төгрөг, хүн нэг бүрийн хувцас ба бусад хэрэглэлийн зардалд 800 төгрөг зарснаар бодож бүгд 1186 хүний зардалд 948800 төгрөг, хүн нэг бүр 2 морьтой явсан тул морь нэг бүр нь нэг мянган төгрөг, бүгд 2372 морины 2372000 төгрөг, ачилга хөсгийн тэмээ нэг бүрийг 1500 төгрөгөөр бүгд 200 тэмээний 300000 төгрөг, морь ба хөсгийн үнэ бүгд 2672000 төгрөг, винтов буу 1186, нэг бүрийг 3500 төгрөгөөр бодож, бүх бууны үнэ 4151000 төгрөг, мөн винтов бууны сум нэг бүрийг 60 мөнгөөр бодож, бүгд 426960 ширхэг сумны үнэ 256176 төгрөг, буу зэвсгийн бүх зардалд 4407176 төгрөгийг тус тус зарцуулсан ба нийт байлдааны зардал нь 10162776 төгрөг болжээ.

Байлдааны үеийн хохирол. Морьт отрядуудын Төв штабаас гаргасан мэдээгээр байлдааны ажиллагааны үед морьт отрядуудаас 2 хүн амь үрэгдэж, 4 хүн шархадсан ажээ. Үүнд:

Амь үрэгдсэн 2 хүний нэг болох Лувсандоржийн Гомбо нь Дорноговь аймгийн Алтанширээ сумын 1 дүгээр багийн харьяат бөгөөд тавьтын даргаар үүрэг гүйцэтгэж явсан. Хэний цэрэг нь үл мэдэгдэх оргодол цэрэгт буудуулж амь үрэгдсэн.

Хоёр дахь нь мөн аймаг, сум, багийн харьяат Борын Мятав. 1945 оны 9 дүгээр сарын 21-нд цус харваж нас барсан.

Харин шархдагсдын тухайд бол Дорноговь аймгийн Айлбаян сумын 3 дугаар багийн харьяат байлдагч Цэдэвийн Жамц хөдөө хээрээс дэлбэрэх зүйл олж байрандаа оролдож байтал тэр нь дэлбэрсний улмаас өөрөө болон хажууд нь байсан Адьяагийн Дарьсүрэн, Эрэгдэлийн Балдандорж, Дондогийн Рэнцэнсамба нар шархадсан ажээ¹.

¹ Гантулга Ж. Чөлөөлөх дайнд Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отрядуудын гүйцэтгэсэн үүрэг//”Чөлөөлөх дайн 70 жил: түүх, сургаамж” эмхэтгэл. УБ. 2016 он. 47 дахь тал

Шийтгэл. Байлдааны үүрэг гүйцэтгэх явцад харуул манааны үүргийг сулаар биелүүлсэн, хариуцлагагүй, удирдлагын тушаалыг биелүүлдэггүй, өөрийн эзэмшсэн буу зэвсэг, агт морийг хамгаалах талаар сул байсан зэрэг дутагдал гарч байжээ. Үүнд зарим нэг дарга, байлдагчдаас хариуцсан пост газрыг эзэнгүй хаях юмуу унтах, Өвөр Монголын ард түмэнтэй хувийн худалдаа, наймаа хийх зэрэг дутагдлыг гаргаж, тэр тухайд нь удирдлагын зүгээс шаардлага тавихад дутагдлаа хүлээхгүй сөргөцөлддөг гэх мэт явдлыг гаргаж байсан учраас холбогдох хүмүүсийг сануулах, донгодох, 1-2 хоногийн манаанд ээлж бусаар томилох болон гянданд 1-2 хоног хорих зэрэг шийтгэлийг оноож байжээ. Мөн цэргийн дунд үлгэргүй байдлыг гаргаж, хариуцлага алдсан тавьтын дарга Цэрэндоржийг шүүхэд шилжүүлсэн байна.

Сайшаал шагнал. Сайн дурын морьт отрядын дайчдаас дайнд үүргээ сайн гүйцэтгэсэн 179 хүнийг Төрийн дээд, одон медалиар шагнасан бөгөөд үүнд “Улаан туг”-ийн одонгоор 6, “Хөдөлмөрийн гавъяа”-ны одонгоор 7, “Алтан гадас” одонгоор 32, “Байлдааны медаль”-иар 119, “Хөдөлмөрийн медаль”-иар 23 хүнийг тус тус шагнажээ.

Дайнд үүргээ сайн биелүүлсэн дарга, цэргүүдийг Ардын сайн дурын морьт отрядуудын Төв штабаас үнэ бүхий зүйлээр /монгол гутал, савхин гутал, шаазан аяга зэрэг/ шагнаж байжээ.

Мөн отрядын бүрэлдэхүүнээс олон арван дарга, цэргүүд сахилга батын талаар цэргийн ёс журмыг хатуу баримталж, түүний шаардлагыг биелүүлэхийн төлөө өөрийн биеийн хүчийг бүрэн зориулж, эцсийн амьсгал, цусны дуслыг дуустал зүтгэнэ гэдгээ илэрхийлж байсан байна.

Дүгнэлт: Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отрядуудын дарга, цэргүүд нь төр засгаас өгсөн байлдааны үүргийг байнгын бэлтгэл сургуулилттай байсан МАХЦ-ийн анги, салбаруудын нэгэн адил амжилттай биелүүлж, дайны ялалтад зохих хувь нэмэр оруулжээ.

АӨХСДМО-уудын байлдааны ажиллагааг ЦЯЯ-ны сайд, Бүх Зэвсэгт хүчний жанжин, Улсын хошой баатар, маршал Чойбалсангаас Завсар хотод болсон цэргийн ёслолын жагсаал дээр онцгойлон тэмдэглэж дүгнэн өгүүлэхдээ:

“Нөхөд өө! Морьт отрядын олон байлдагч та нар энэ жил анхны удаа их туршлагатай ажлыг хийж байна. Хэдий өөрийн биеэр, ангиараа жинхэнэ байлдаанд ороогүй боловч жинхэнэ байлдаанд орсон ангитай адил их туршлагатай сургууль ажлыг хийлээ.

Манай сайн дурын отрядын олон байлдагчид нь цөмөөрөө энэ янзаар хэрэгтэй цагт хөдөлнө гэдгийг манай нам засгаас хатуу итгэж байна.

Саяхан морьт отрыдаас хоёр томоохон анги хөдөлсөн юм. Түүний нэг нь та нар юм. Та бүгд 600 илүү километр газар байлдагчилсан их маршийг сайнаар хийсэн нь их амжилт юм.

Бид өөрийн ялсан цэргийн нэгэн адил, та бүгдийн ялалттай давшилтыг үнэлэн үзнэ.

Та бүгд, манай морьт отрядын олон байлдагчид нам засгаас даалгасан цагт үүнтэй адил ямагт бэлхэн байж ажиллахыг уриалмой” гэсэн нь АӨХСДМО-уудын үйл ажиллагааг тэр үеийн улс орон, цэргийн удирдлага хэрхэн үнэлж байсны баримт юм.

3.6.3. Дайны дараах үеийн ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отряд

Дэлхийн хоёрдугаар дайн дуусч энх цагийн бүтээн байгуулалтанд шилжсэн нөхцөлийг харгалзан нам засгаас ардын хувьсгалт цэргийн тоог хорогдуулан батлан хамгаалах төсвөө багасгах арга хэмжээ авахын хамт Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отрядчуудын хүч хэрэгслийг ч хорогдуулах арга хэмжээ авч иржээ. Гэвч дэлхий дахинд капиталист, социалист хоёр лагерь үүсч, тэдгээрийн зөрчил хурцдах хандлагатай байсан тул ард нийтийг эх орноо батлан хамгаалахад бэлтгэх асуудал тулгамдсан зүйлийн нэг хэвээр байв. Тиймээс АӨХСДМО-ын үйл ажиллагааг урьдын адил эрчимтэй биш ч гэлээ хэвээр үргэлжлүүлэн хадгалсаар байлаа.

АӨХСДМО-ууд 1949 он гэхэд эгнээндээ “459 зуут, 1485 тавьт, 5574 аравтыг нэгтгэсэн...нийт 70 мянга гаруй хүмүүсийг хамарсан олон нийтийн сайн дурын томоохон байгууллага болж үйл ажиллагаа нь улам өргөжин бэхжсэн байлаа. Отрядад хамрагдагсдын бэлтгэл сургалт улам сайжирч, буудлага, техникийн спортын чиглэлээр багагүй ажил гүйцэтгэх болов. Тухайлбал биеийн тамир, спортыг нийтийн хүртээл болгох, сонирхогчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор биеийн тамир, спортын байгууллагуудтай хамтарч хөдөлмөрчдийн дунд үндэсний сур харвах, нийтийн гимнастик, гүйлт, харайлтын тэмцээн зохиох, отрядын дайчид залуучууд, хөдөлмөрчдийн дунд жагсаалын сургууль заах зэрэг олон төрлийн ажил зохион байгуулж байлаа.

БНМАУ Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1946 оны нэгдүгээр сарын 28-ны өдрийн 6 дугаар хурлын тогтоолоор маршал Х. Чойбалсангийн мэргэн буудагч алдар цол, тэмдгийг олгох зааврыг баталжээ.

Энэ зааврыг үндэслэн АӨХСДМО-ын дарга, байлдагчдаар тусгай тогтоосон нормативын дагуу буудлага хийлгэж, шалгарагсдад дээрх алдар цол, тэмдгийг АӨХСДМО-ын жанжны тушаалаар олгож байв¹.

Чойбалсангийн мэргэн буудагч алдар цол, тэмдэг горилогсод нь дор дурдсан нормативыг биелүүлэх ёстой байв. Үүнд:

1. бага калибрийн винтовын буудлагыг 500 метр газраас 4 минутын дотор давшин гүйж, тусгай бэлтгэсэн галт байрнаас 25 метр газар 5 дахин багасгасан 9 дүгээр очковтой байнд бэлтгэх ба сумлах ажиллагааг оролцуулан 50 секундэд 3 сумаар хэвтээ, гар дээрээс буудаж 25-30 очков онц буудсанаар үнэлэлтийг өгнө;

2. байлдааны винтовоор нэг бүрийн буудлагыг хэвтээ гар дээрээс 100 метр газар 11 дүгээр очковтой байнд бэлтгэх ба сумлах ажиллагааг оролцуулан 40 секундэд гурван сумыг буудаж биеийн дүрсэнд 3 сумаар оновол онц буудсан үнэлэлтийг өгнө;

3. Автомат буугаар нэг бүрийн буудлагыг хэвтээ гар дээрээс 100 метр газар 12 дугаар цээжин биед сумлах ба бэлтгэх ажиллагааг оролцуулан нэг, нэг сумаар 35 секундэд гурван сумыг буудаж биеийн дүрсэнд 3 сумаар оновол онц буудсан үнэлэлтийг өгнө.

¹ Рийзэн Д. Дэлхийн II дайны жилүүдэд МАХН-аас улсыг батлан хамгаалах талаар авсан зарим арга хэмжээ болон МАХЦ-ийн дотор зохиож байсан нам улс төрийн ажил.УБ., 1976. 61 дэх тал

Энэхүү 3 төрлийн буудлагын үүргийг онц үзүүлэлтээр гүйцэтгэгчдэд Х.Чойбалсангийн мэргэн буудагчийн алдар цол, тэмдгийг олгоно¹ гэж тодорхойлон заасан байлаа.

Энэ мэт арга хэмжээ нь морьт отрядын дайчдын урам зоригийг сэргээж, ажилд түлхэц өгсөн чухал хөшүүрэг болж байжээ.

АӨХСДМО-ууд дээр дурдсанчлан цэргийн сургууль, бэлтгэл хийхээс гадна Улс ардын аж ахуйг сэргээн босгоход чиглэсэн онцлог үүргүүдийг ч биелүүлдэг байв. Жишээ нь,

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс 1945 онд тарваганы арьс бэлтгэх, сугалаа гаргах журам гарган АӨХСДМО-ад хариуцуулсан ба Тээврийн яам, Хоршоодын төв холбооны морин тээврийг сайн дурын морьт отрядад шилжүүлэх тухай тогтоол гаргаж, морин тээврийг бүх зүтгэх хүчин, тэрэг хэрэгсэл, бусад хөдлөх, үл хөдлөх хөрөнгө, малын тэжээл хүнсний тариа будаа тарьдаг тариалангийн газрын хамтаар тус байгууллагад шилжүүлсэнээр² морьт отрядууд аж ахуйн хувьд бүрэн бэхжиж, энх цагийн бүтээн байгуулалтад идэвхтэй оролцох болжээ.

АӨХСДМО ард түмний дунд нэр хүндтэй томоохон байгууллага болсон байсан бөгөөд Майн нэгэн, Октябрийн баяр, улсын баяр наадмаар Ардын цэргийн дайчдын нэгэн адил баярын жагсаалд оролцдог байсан нь тэдний нэр хүнд ямархуу өндөрт байсны нэгээхэн илрэл гэж болно. 1946 онд л гэхэд улсын баяр, наадмаар Сүхбаатар, Хэнтий, Дорноговь, Дундговь, Булган, Сэлэнгэ, Төв зэрэг аймгуудаас морьт отрядын 2000 гаруй дайчин баярын парадад оролцож, амжилт бүтээлээ ард түмэндээ илтгэж байжээ³.

АӨХСДМО татан буугдсан нь. Дайны дараах жилүүдэд БНМАУ хөрш зэргэлдээ хоёр социалист улсын дунд орших болж, тэдэнтэй “Ах дүүгийн найрсаг харилцаа” тогтоосноор улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдалд шууд заналхийлэх дайн, түрэмгийллийн аюул холдсон тул урьдын адил бүх нийтийг хамарсан цэргийн бэлтгэлийг өндөржүүлсэн хэлбэрээр хийх шаардлагагүй болжээ. Тиймээс төр, засгаас Ардын цэргийг анги, салбаруудыг цомхотгохын хамт АӨХСДМО өөрийн үүргийг биелүүлсэн гэж үзэж БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл, МАХН-ын Төв Хорооны 1949 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн хамтарсан хурлын 113/25 дугаар тогтоолоор⁴ АӨХСДМО-ыг татан буулгаж, түүний гүйцэтгэж байсан үүргийг Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэл, биеийн тамирын байгууллагуудаар гүйцэтгүүлэх болжээ.

АӨХСДМО-ыг татан буулгах комиссын даргад Н.Майдар, комиссын орлогч даргад Ч.Мижид, гишүүдэд Батлан хамгаалах яамны Жанжин штабын дарга Б.Цог, Хязгаарын газрын штабын дарга Б.Цэдэн-Иш, морьт отрядын Төв штабын дарга Довчин, байлдааны бэлтгэл хэлтсийн дарга Самдан, Санхүүгийн хэлтсийн дарга Гомбо нарыг томилсон ба аймгийн комиссыг аймгийн Бага Хурлын Тэргүүлэгчдийн дарга, цэргийн хэлтсийн дарга, аймгийн түмтийн дарга, Дотоод яамны хэлтсийн дарга нарын бүрэлдэхүүнтэйгээр томилжээ.

¹ Мөнхөө Н. *Домогт морьт отряд*. УБ., 1985. 14 дэх тал

² Мөнхөө Н. *Домогт морьт отряд*. УБ., 1985. т. 53

³ Даржаа В. “Иргэнийхээ үүргийг биелүүлж явсан минь” Мөнхөө Н. *Домогт морьт отряд*. УБ., 1985. 64 дэх тал

⁴ УТА. *МАН-ын баримтын төв*. ХМ-4.Д-16. ХН-3

АӨХСДМО-ыг татан буулгах Төв ба аймгийн комиссууд аймаг дахь морьт отрядын адуу мал, орон сууц, эд хөрөнгийг улсын морин өртөөдийг байгуулахад хэрэглүүлэхээр аймгийн Бага Хурлын Тэргүүлэгчдэд актаар шилжүүлэн өгч, бүх аймаг хотын түмтийн байлдааны болон ангийн буу зэвсгийг тус тусын аймаг дахь Дотоод яамны хэлтэст мөн актаар шилжүүлж, сугалаа ба лото гаргахад зориулан бэлтгэсэн бүх бараа материалыг аймгуудын Хоршоодын холбоонд өөрийн үнээр нь шилжүүлэн түүнээс орсон мөнгийг улсын орлого болгож, морьт отрядын Төв штаб болон аймгуудын морьт отрядын мэдэлд байгаа бүх мөнгөн хөрөнгийг мөн улсын орлого болгожээ.

Отрядын байгууллагуудын бусдаас авбал зохих ер авлагатай холбогдсон хэргүүдийг сайтар магадлан хянаад хуулийн байгуулгад шилжүүлэн авах төдийгүй нэхэмжлэн авсан хөрөнгийг улсын орлогод шилжүүлж, отрядын төв ба орон нутгийн байгууллагуудын улс, олон нийт, хоршооллын байгууллагууд ба энгийн хүмүүст төлвөл зохих өрийг 1949 оны 6 дугаар сарын 15-ны наана төлж дуусган, морьт отрядын Төв ба орон нутгийн байгууллагуудаас гаргаж байсан хонжворт сугалаа, лотоны бүх ажиллагааг мөн оны 6 дугаар сарын 15-наас эхлэн зогсоохоор үүрэг болгожээ.

Хошууч генерал Ч.Мижидэд морьт отрядын дарга, цэргүүдийн бүртгэл жагсаалтыг 2 хувь үйлдэж нэгэн хувийг аймгийн Бага Хурлын Тэргүүлэгчдэд, нөгөө хувийг Улсыг батлан хамгаалах яаманд тус тус шилжүүлэхийг үүрэг болгож, отрядын түүхэнд холбогдолтой материал, дүрэм, заавар, баримт бичгийг Улсын архивт хадгалуулахаар аймгийн Бага Хурлын Тэргүүлэгчдэд шилжүүлэн өгөхийг үүрэг болгожээ.

Тэрээр удирдлагаас өгсөн үүргийн дагуу морьт отрядын байгууллагуудыг татан буулгаж, өөрийн ажил ба аймгуудын комиссын бүх ажлыг 1949 оны 6 дугаар сарын 30-ны наана дуусгаж, сайн дурын морьт отрядуудыг татан буулгасны дүнгийн илтгэлийг энэ оны 7 дугаар сарын 1-ний наана Сайд нарын Зөвлөлд өргөн барьснаар Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отряд¹ хэмээх олон нийтийн байгууллага түүх болон мөнхөрчээ.

1942 байгуулагдсан Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отряд татан буугдах хүртлээ ард нийтийг улс орноо батлан хамгаалах хэрэгт сурган бэлтгэх үндсэн хэрэгсэл болж байсан ажээ. Тухайлбал:

Ард иргэдийг цэргийн эрдэмд боловсруулан сургах зорилго бүхий Ардын сайн дурын морьт отрядууд улсын бүх аймаг, сум, үйлдвэр, албан газарт байгуулагдсан байсан бөгөөд морьт отрядад 18-45 насны, сонгуулийн эрх бүхий эрэгтэй, эмэгтэй, БНМАУ-ын харъяат иргэдийг сайн дурын үндсэн дээр гишүүнээр элсүүлэн авч байв.

Сайн дурын морьт отрядыг монгол цэргийн уламжлалт бүтцийг хадгалсан аравт, тавьт, зуут, мянгат, түмтийн зохион байгуулалттайгаар байгуулсан ба Улаанбаатар, 18 аймагт сайн дурын морьт отрядын түмтүүдийг байгуулсан байна. Сайн дурын морьт отрядуудыг жанжин удирдаж, комиссар, штабын дарга нар ахлан, дээрх шат дараалсан нэгжүүдийн дарга нар үйл ажиллагааг нь удирдан явуулж байв.

¹ УТА. МАН-ын баримтын төв. ХМ-4.Д-16. ХН-3

Сайн дурын отряд нь анх Улсыг батлан хамгаалах эвлэлийн харьяанд байгуулагдсан бөгөөд морьт отрядуудын төв, орон нутгийн штаб нь Батлан хамгаалах эвлэлийн зөвлөлийг хавсарч байсан нь зохимжгүй байснаас үүдэн Бүх цэргийн жанжны тушаалаар 1944 оны долдугаар сарын 8-нд Цэргийн Явдлын Яамнаа шилжүүлэн захируулжээ. 1944 оны байдлаар сайн дурын отрядад 81448 хүн хамрагдсан нь БНМАУ-ын нийт хүн амын 10,7 хувь болж байна.

Ардын сайн дурын отрядууд нь хөдөлмөрчдийг тусгай хөтөлбөрөөр буудлага, гранат, жагсаал, биеийн тамир, зэвсэг техникийн хичээл дадлагыг зааж цэргийн эрдэмд сургаж байв. Цэрэгжилтийн сургуулийг хот суурин, хөдөө орон нутаг гэх ялгавартайгаар тогтмол явуулж байв.

Отрядын байлдагчдад цэргийн хээрийн дадлага олгох томоохон ажлын нэг нь хээрийн сургууль байв. Жилийн дөрвөн улиралд цаг агаар, газар орны хүндрүүлсэн нөхцөлд морин марш, хээрийн сургуулийг явуулж, галын ба тактикийн бэлтгэлийг дүгнэж бэлэн байдлыг шалгадаг байжээ. 1942-1944 онд МАХН-ын Төв Хороо, Засгийн газар, Морьт отрядын Төв штабын шийдвэрээр Төв, Хэнтий, Дорнод, Булган, Дундговь аймгийн нутагт хээрийн сургууль болж байв.

Маршал Х.Чойбалсангийн тушаалаар АӨХСДМО Японы эсрэг Чөлөөлөх дайнд оролцож хоёр чиглэлээр 1600 гаруй километр зам туулж байлдааны үүргээ амжилттай гүйцэтгэж, дайсныг дарахад тодорхой хувь нэмрээ оруулжээ.

Дайн дууссаны дараа энх цагийн байгуулалтанд шилжих болсонтой уялдан 1949 онд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл, МАХН-ын Төв Хорооны 113/25 дугаар хурлын тогтоолоор Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отрядыг татан буулгажээ.

Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отряд нь Монголын ард нийтийг цэргийн эрдэм мэдлэгт сургах, эх орноо батлан хамгаалах, нийтийн дайсныг даран сөнөөх үйл хэрэгт өөрийн хувь нэмрээ оруулж тавьсан зорилго, үүргээ нэр төртэйгээр биелүүлжээ.

3.7. Дэлхийн II дайнаар Монгол Улсад учирсан хохирлын тухайд. Монголчууд ХХ зуунд тухайн үеийн ЗХУ-ын дайчидтай мөр зэрэгцэн дэлхийн II дайны эхлэл, төгсгөл болсон хоёр дайнд орсон билээ. Түүний нэг нь 1939 оны Халхын голын, нөгөө нь 1945 оны Чөлөөлөх дайн юм. Аливаа дайны хохирлыг тооцон тогтоох нь төвөгтэй, маргаантай ажил байсаар иржээ. Хүний амийг юугаар тооцох вэ? гээд л төвөгтэй асуудал тулгардаг аж.Тиймээс ямагт барагцаалсан тооцоо гарч ирсэн байх юм. Энд би 1939, 1945 оны дайнд ядаж монгол улс ямар хохирол хүлээж вэ, бас Япон улс ямар хохирол хүлээж вэ гэдгийг өөрт олдсон сурвалж, судалгааны зохиолуудад түшиглэн барагцаалахыг оролдов.

Дайн, байлдааны хохирол гэж юуг хэлэх нь ч нэлээд төвөгтэй асуудал юм. Нэвтэрхий болон тайлбар толиудыг сөхөж үзвэл:

“**Дайны хохирол**-Дайн цэргийн мөргөлдөөний улмаас дайтагч талуудын амсаж буй гарз хохирол. Дайны хохиролд дайн, зэвсэгт мөргөлдөөний фронтод болон ар талд гарах хүн хүч, зэвсэг, техник, эд хөрөнгийн гарз, экологийн

тэнцвэрт байдлын алдагдлаас үүсэх гамшгийн хор уршиг хамаарна. Байлдааны төрөл бүрийн зэвсгийн хөгжилтэй холбоотой хохирлыг шууд хохирол гэх ба дайны нөхцөл байдлын улмаас гарах бусад хохирлыг дам хохирол гэнэ¹”.

“**Цэргийн хохирол-Фронт**, ар талын хүн хүчний хохирол, улс орны материалын хохирол дэмжлэгийг хэлнэ. Цэргийн хохирлыг шууд ба дам гэж хуваана. Шууд хохирол гэж байлдааны хохирлыг хэлнэ. Дам хохирол гэж зэвсэг, техникийн шууд үйл ажиллагаатай холбоогүй гарз зардлыг хэлнэ²”.

“Байлдааны хохирлыг:

1. Бие бүрэлдүүний /хүн хүч/
2. Зэвсэглэлийн
3. Техник ба эд материалын гэж хуваан үзнэ. Бас:

А. Буцалтгүй хохирол

Б. Сэргээх хохирол гэж хуваана. Буцалтгүй хохиролд:

1. Алагдсан, сураггүй алга болсон, олзлогдсон, шархнаас үхсэн, тахир дутуу болж цэргээс халагдсан хүмүүс,
2. Эргэж ашиглах аргагүй болсон зэвсэг, цэргийн техник, материал хэрэглэл орно.

Сэргээх хохиролд:

1. Шарх нь эмчлэгдээд эргэж жагсаалдаа орсон цэргийн алба хаагч
2. Засвар үйлчилгээ хийсний дараа ашиглах боломж олсон зэвсэглэл, цэргийн техник, материал хэрэгсэл тус тус харъяалагдах аж³”.

А. Халхын голын дайны хохирол:

Монголын талын хохирлын талаар судалгааны зохиолуудад дурдсан нь:

- 5 дугаар сарын 11-ний байлдаанд байлдагч Бат-Очир, Ичинноров нар амь үрэгдсэн⁴;

- “Монгол-Зөвлөлтийн цэрэг 1939 оны 5 дугаар сарын 28, 29-ний хоёр өдрийн ширүүн тулалдаанд бага бус хохирол үзжээ. 6 мд-ийн дарга хошууч Ч.Шаарийбуу, жанжин штабын орлогч дарга бөгөөд оперативын хэлтсийн дарга хурандаа Рэнчин, их бууны батареены улс төрийн удирдагч Л.Гэлэгбаатар, сумангийн улс төрийн удирдагч Ж.Жамбалжамц, Б.Шагдар, хөнгөн пулемётчин З.Самдан, хуягт машины дарга Хонгор, хуягтын жолооч Аюушжав, сумлагч Самбуу нарын дайчид дайсны эсрэг зориг баатарлаг тулалдаж, амь алдсан байна⁵”.

- Зургадугаар сарын 20-нд Хамар давааг японы 120 онгоц бөмбөгдөхөд Монгол-Зөвлөлтийн 95 онгоц тосон тулалдаж, манай талаас 12 онгоц сүйджээ.

- Наймдугаар сарын 20-30-нд болсон агаарын тулалдаанд манай тал бага бус гарз хохирол үзжээ. Монгол-Зөвлөлтийн талаас алагдсан, шархадсан цэрэг, дарга 10000 шахам болжээ⁶”.

¹Цэргийн нэр томъёоны тайлбар толь. УБ., т.135-136.

²Советская военная энциклопедия. М., 1978. с.477.

³Советская военная энциклопедия. М., 1976. с.541.

⁴Монголын ардын армийн 50 жил. УБ., 1971.т.139.

⁵Мөн тэнд. т.143.

⁶Мөн тэнд.т.153.

- ЗХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн 1939 оны 8, 11 дүгээр сарын зарлигаар 70 хүнд ЗХУ-ын баатар цол олгосны 21 нь Халхын голын тулалдаанд эрэлхгээр амь үрэгджээ¹” гэх зэргээр тэмдэглэгдсэн байдаг билээ.

Японы талын хохиролын талаар тэмдэглэгдсэн нь:

- Тавдугаар сарын 28-29-ний байлдаанд 6 дугаар морьт дивизийн дайчид “Японы цэргийн тагнуулын отряд, мөн моторжуулсан салааг бараг бүхлээр нь устгажээ²”.

- 1939 оны 5 дугаар сарын 11-ээс мөн сарын 29-ний хооронд “Япон-Манжго-ийн цэргийн нэг явган хороо, хоёр морин хороо, танк болон моторжуулсан тус бүр нэг отряд Номон хаан, Бүрд овоо, Хайлаастайн голын дагуу довтолсон боловч Монгол-Зөвлөлтийн цэргийн түрүүч ангид цохигдон 400 гаруй цэрэг, офицероо устгуулж, зэр зэвсгийн ихээхэн хохирол хүлээж, үлдсэн нь хилийн чанадад хөөгджээ³”.

- 1939 оны 6 дугаар сарын 20-нд Хамар давааг японы 120 онгоц бөмбөгдөхөд дайсны 31 онгоцыг сөнөөж, 6 дугаар сарын 24-нд японы 60 гаруй онгоц дахин дайралт хийсэн боловч 25 онгоцоо устгуулан ... 6 дугаар сарын 22-26-нд агаарын тулалдаанд дайсан 64 нисэх онгоцоо алджээ⁴”.

- “Баянцагааны орчинд 7 дугаар сарын эхээр 5 өдрийн турш болсон ширүүн байлдаанаар япончууд 2000 гаруй цэрэг, офицероо устгуулж, 3500 гаруй хүнээ шархдуулж, олзлуулах зэргээр хохирчээ. Мөн энэ тулалдаанаар дайсны танк 50, их буу 8, олон мянган их, бага бууны сум, винтов, жад, сэлэм зэрэг байлдааны зэвсэг, техникээр хохирч, Халхын голын зүүн эрэгт хөөгдөн гарав.

- Монгол-Зөвлөлтийн нисгэгчид Баянцагааны районд болсон энэ хэдэн өдрийн агаарын байлдаанд японы 45 нисэх онгоц, түүний дотор шумбагч бөмбөгдөгч 20 онгоцыг сөнөөжээ⁵”.

- “Долдугаар сарын 23-аас 8 дугаар сарын 4-ний хооронд дайсан 116 онгоцоо алдсан байна⁶”.

- Наймдугаар сарын 24-30-нд Монгол-Зөвлөлтийн цэрэг их давшилт хийж, ялалтаар төгсгөв. Дайсан амьд хүч, зэвсэг техникийн маш их хохирол үзжээ. “Зөвхөн 7,8 дугаар сарын тулалдаанд Япон 19 мянга шахам хүнээ устгуулж, 25 мянга орчим хүнээ шархдуулсан ба 1939 оны 5 дугаар сараас 9 дүгээр сар хүртэл хугацаанд дайсан нийтдээ 52-55 мянган цэрэг, офицерээ алдаж хохирсоны дотроос 25 мянга илүү хүнээ устгуулжээ. Наймдугаар сарын давшилтын цохилтоор дайсан их буу 175, түүний дотор хүнд их буу 30, пулемёт 340, винтов 12 мянга, их бууны сум 42 мянга, винтовын сум 2 сая, авто машин, хуягт, танк, хувцас хэрэглэл зэрэг цэргийн бусад үлэмжхэн эд хогшлыг олзлуулжээ. Дайсан энэ хугацаанд 200 гаруй их буу, 660-аад нисэх онгоцоо алдсаны дотор 200 орчим нь наймдугаар сарын 20-30-нд болсон агаарын тулалдаанд устгагдсан байна⁷”.

¹ Мөн тэнд. т. 160.

² Мөн тэнд. т. 141.

³ Мөн тэнд. т. 141.

⁴ Мөн тэнд. т. 145.

⁵ Мөн тэнд. т. 149.

⁶ Мөн тэнд. т. 150

⁷ Мөн тэнд. т. 153

Хоёр талын хохирлын талаар: ОХУ-ын Гадаад харилцааны яамны Москва дахь олон улсын харилцааны их сургуулийн профессор С.В.Чугров өгүүлэх нь: Халхын голын дайнд ялагдсаны дараа Японы олон нийт 23 дугаар явган дивизийг оруулан нийт 18000 хүн, Зөвлөлт-Монголын дайчид 9284 хүн буюу Японы талын хохирол 50%-тай гэж итгэж байв. Гэтэл ЗХУ-ын задралын өмнө, ил тодын үед Зөвлөлтийн мэргэжилтнүүд 1991 оны тавдугаар сарын 22-23-нд Токиод болсон бага хурал дээр 1960 онд бүх нийтэд зарлагдсан 9284 хүн алагдсан тоо нь хэт багасгасан тоо гэдгийг хүлээн зөвшөөрсөн билээ. Ил тодын үед тодорхой болсон эх сурвалж дээр үндэслэн гаргасан судалгаагаар 19380 амь үрэгдэгсэд байгаагийн ихэнх нь Японы талын хохирол гэсэн шинэ тоо гарч иржээ¹ гэх мэтийн тэмдэглэл судалгааны зохиолуудад үзэгдэнэ.

Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Түүх судлалын төвийн дарга доктор, профессор С.Ганболд “Халхын голын дайн: Түүхэн үнэний эрэлд. УБ., 1995” гэсэн эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлийн 106-111 дүгээр талд судалгаагаа дэлгэсэн байна. Үүнд:

Манай эрдэмтэн судлаачид Халхын голын дайн дууссаны дараа 1939 оны сүүлчээс эхлэн дайны нийт хохирол, түүний дотор хүн хүчний хохирлыг тогтоох анхны оролдлогыг хийж эхэлжээ. МАХЦ-ийн Жанжин штабаас гаргасан нэгэн мэдээнд 1939 оны 5-9 дүгээр сард МАХЦ-т учирсан хүн хүчний хохирлыг 771 хүн гэж анх гаргажээ². Мөн 731 хүн гэсэн тоо ч бас байдаг.

Тэрчлэн 1939 оны 12 дугаар сард МАХЦ-ийн хүн эмнэлгийн газрын сургагч Бородин 1939 оны 5-9 дүгээр сард МАХЦ-ийн хохирлыг 566 хүн алагдаж, шархадсан гэж гаргасан ч буй³.

Халхын голын дайны хохирлыг тогтоох явдал 1940 оноос нэлээд эрчимжиж 1946 онд гаргасан мэдээгээр МАХЦ-ийн хүн хүчний хохирлыг 1131 хүн гэж тогтоожээ. Гэтэл энэхүү тоог бодитой бус, Японоос дайны төлбөр гаргахын тулд өсгөж гаргасан тоо гэж үзэх нь буй.

Хохирлын мэдээг тогтоохдоо 1939 оны 5 дугаар сарын 11-ээс 9 дүгээр сарын 16-аар хязгаарлаж байна. Энэ судалгааны үр дүнд Халхын голын дайнд МАХЦ-ээс 895 хүн алагдаж, шархдан, сураггүй болсоныг тогтоогоод байна. Нийт хохирлын 26,5 хувь буюу 237 хүн нь амь үрэгдэгсэд, 69,9 хувь буюу 626 хүн нь шархдагсад, 3,6 хувь буюу 32 хүн нь сураггүй алга бологсод байна. Эдгээрийг албан тушаалаар нь ангилан үзвэл:

1. Салааны дарга, түүнээс дээшхи албан тушаалын захиран командлах болон улс төр, ар тал, техникийн албан тушаалтан дарга нар 97 хүн буюу нийт хохиролын 10,8 хувь;

2. Бага дарга болон түүнтэй адилтгах албан тушаалтнууд 131 хүн буюу 14,6 хувь;

3. Жинхэнэ хугацааны болон түр цэрэг 667 хүн буюу 74,5 хувь болж байна.

Дээрхи 97 даргын 71 нь буюу 73,2 хувь нь командлан захирах албан тушаалтнууд: Үүнд:

¹ Халхын голын дайн: түүх, орчин үе. УБ., 2009. т.124.

² БХТА. ф.16. Д.4. хн.20

³ Халхын гол: Хагас зууны тэртээг шинээр харахад. УБ., 1989.

- Салааны дарга - 41;
- Сумангийн дарга -10;
- Дивиз, хорооны штабын ажилтан – 17.

Дивизийн дарга, түүнээс дээшхи албан тушаалтан 3 /19,6%/ нь буюу 19 хувь нь улс төрийн албан тушаалтнууд: Үүнд:

- Хорооны комиссар - 3;
- Клубийн дарга - 2;
- Сумангийн улс төрийн удирдагч - 7;
- Номын багш - 7;

/7,2 хувь нь буюу 7 хүн нь ар тал, техникийн албан тушаалтнууд: Үүнд: Эмнэлгийн албаны дарга, эмч 5, техникийн ажилтан 2 байгаа юм/.

Мөн бага дарга 131 хүний 73 нь буюу 55,7 хувь нь тасгийн дарга, 23 хүн буюу 17,6 хувь нь салааны туслах, 3 хүн буюу 2,3 хувь нь жагсаалын дарга, 32 хүн буюу 24,4 хувь нь эдгээртэй адилтгах албан тушаалтнууд байна.

Хохирлын дийлэнх хувийг эзэлж байгаа шархдагсдаас эдгээрэд жагсаалд эргэн орсон хүний талаар баримт ховор байх ба 1939 оны 9 дүгээр сарын 15-ны нэгэн мэдээнд шархнаас эдгэрсэн хүн 93 гэснийг үндэслэн нийт шархдагсдын 14,8 хувь нь эргэж жагсаалдаа оржээ гэж үзэж болох юм.

Хүн хүчний хохирлыг тухайн үеийн нэгтгэл ангийн бие бүрэлдүүнтэй харьцуулан үзвэл 1939 оны 9 дүгээр сарын эхээр фронтод байсан нийт даргалах бүрэлдүүний 15,2 хувь, бага дарга нарын 17,8 хувь, хугацааны болон түр цэргийн 12,2 хувь нь болж байх бөгөөд дайнд оролцсон нийт бие бүрэлдүүний 10,4 хувь нь хохирол үзжээ.

Энд ангийн оршин суугчид, цэргийн шүүхэд шилжсэн, хэлмэгдсэн хүмүүсийн тоог оруулаагүй. Харин хязгаарын цэргээс 43 хүн амь үрэгдэж, 52 хүн шархадсан гэх бөгөөд энэ 95 хүнийг МАХЦ-ийн хохиролтой нийлүүлж тооцвол Монголын талын хүн хүчний хохирол 990 хүн болох юм.

Халхын голын дайны үеэр сураггүй алга болсон гэх 30 гаруй хүн байх бөгөөд тэдгээрийн хувь заяаны талаар тодорхой баримт байхгүй юм.

Дайны үед өөрийн талын их бууны сум, бөмбөгт өртөх явдал гарч байжээ. Тухайлбал, 8 дугаар морьт дивизийн хохирлын 31,4 хувийг өөрийн талын суманд өртөгсөд эзлэх аж. Буу зэвсэгтэйгээ буруу харьцсанаас осолдох явдал ч цөөнгүй гарч байжээ.

Халхын голын дайнд үрэгдэгсдийн дурсгалыг жил бүрийн 9 дүгээр сарын 16-нд орон даяар хүндэтгэн тэмдэглэж байвал залуу хойч үеийг цэрэг, эх оронч үзлээр хүмүүжүүлэхэд чухал хувь нэмэр болох болно хэмээн өгүүлсэн байна.

Б. Чөлөөлөх дайнд учирсан хохирлын талаар судалгааны зохиолд:

Монголын талын хохирлын талаар:

- “Японы империализмыг дарахын төлөө явуулсан дайнд БНМАУ өөрийн зэвсэгт хүчнийг оролцуулж, 950 км давшиж, тулалдахдаа амьд хүч, эдийн засгийн талаар ихээхэн зүйлээр хохирсон юм. Монгол цэрэг нь энэхүү дайнд хүн хүч ба эд материалын хохирлыг хүлээсэн юм. Монголын цэргийн ангиуд 2039

цэрэг, офицерээ алдаж, 205 сая төгрөгийн эд материалын үлэмжхэн хохирлыг хүлээв” гэж Ю.Цэдэнбал бичиж байжээ¹”.

- 1945 оны чөлөөлөх дайнд Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отрядуудын гүйцэтгэсэн үүрэг судлаачдын анхааралд ховор туссан байдаг билээ.

Судлаач Ж.Гантулга өгүүлсэн нь: Морьт отрядуудын төв штабаас дайны дараа гаргасан мэдээгээр дайнд морьт отрядуудаас 3 хүн амь үрэгдэж, 2 чиглэлд биеэр явсан бүх хүмүүсийн хоол хүнсний зардалд 1186 хүн нь 60 хоног явахад нэг хүн өдөр бүр 30 төгрөгийн зардлаар бодож, бүгд 21334800 төгрөгний, хүн нэг бүрийн хувцас ба бусад хэрэглэлийн зардалд 800 төгрөг зарсанаар бодож бүгд 1186 хүний зардалд 948800 төгрөгний, хүн нэг бүр хоёр морьтой явсан, морь нэг бүр нь нэг мянган төгрөг, бүгд 2372 морины 2372000 төгрөгний, ачилга хөсгийн тэмээ нэг бүрийг 1500 төгрөгөөр бүгд 200 тэмээний 300000 төгрөгний, морь ба хөсгийн үнэ бүгд 2672000 төгрөгний, винтов буу 1186, нэг бүрийг 3500 төгрөгөөр бодож, бүх бууны үнэ 4151000 төгрөг, мөн винтов бууны сум нэг бүрийг 60 мөнгөөр бодож, бүгд 426960 ширхэг сумны үнэ 256176 төгрөг, буу зэвсгийн бүх зардалд 4407176 төгрөгийг тус тус зарцуулж, нийт байлдааны зардал нь 10162776 төгрөг болсон байна²” хэмээн өгүүлжээ.

Японы талын хохирлын талаар:

- Долнуур, Жэхэ-ийн чиглэлд 6 мд Японы 700 шахам цэргийг зэвсэг хэрэглэлийн хамт булган авав³”.

- 34 дүгээр морьт хороо 90 шахам цэрэг, офицериийг нь буулган авав... 34 дүгээр морьт хороо, 22 дугаар морьт хороо 8 дугаар сарын 19-нд манжго-ийн 172 офицер, цэрэг, 8 миномёт, 6 пулемёт, 160 винтов, цэргийн төрөл бүрийн хэрэглэл бүхий ачаа хөсөг 10-ын хамт олзлов... 22 болон 34 дүгэр морьт хороо хамтран давшиж, 500 гаруй цэрэг, офицерыг хурандаа Ли-ийн хамт олзлов... Линьхуа хотод дайсны 275 офицер, цэргийг буулган авав⁴”.

- Долнуур чиглэлд давшсан МАХЦ-ийн ангиуд зөвхөн Жэхэ, Анъзятун, Губейку хотоос Япон, Манжго-ийн 8650 гаруй цэрэг, офицериийг буулган авч, зэр зэвсэг, хүнс хэрэглэлийн хамт олзлон авав.

- Чуулалт хаалган чиглэлд давшсан Зөвлөлт-Монголын цэрэг мөн ялгуусан давшилт хийж, 8 дугаар сарын 14-нд л гэхэд Завсар хотын ойролцоо байрлаж байсан Өвөр монголын 7 дугаар морьт дивизийг бүх бүрэлдүүнээр буулган авав.

- 1945 оны 8 дугаар сарын 9-өөс 23-ныг дуустал хугацаанд Японы цэргийг бутцохин ялалт байгуулав. “Энэ байлдааны ялалтаар Монгол-Зөвлөлтийн зэвсэгт хүчин японы 677 мянган цэрэг, офицериийг хохируулсаны дотор 84737 хүн байлдааны талбарт алагджээ. Монгол-Зөвлөлтийн цэрэг дайснаас 3700 гаруй их буу, миномёт, 600 танк, 861 онгоц, 12 мянга орчим пулемёт, 2129 автомашин, 13 мянга орчим морь, цэргийн эд хэрэглэлийн янз бүрийн агуулах

¹ МАА-ийн 50 жил. УБ., 1971. т.227

² Чөлөөлөх дайн 70 жил: Түүх, сургаамж. УБ., 2016. т.45.

³ МАА-ийн 50 жил. УБ., 1971. т.207.

⁴ Мөн тэнд. т. 208.

679 зэрэг үлэмжхэн хэмжээний цэрэг, зэвсэг, хүнс тэжээл, эд хогшлын зүйл олзолжээ¹” гэх хэсэг бусад мэдээ байх юм.

Чөлөөлөх дайнаар монголчуудын хүлээсэн хүн хүчний хохирлын талаар доктор, профессор С.Ганболд судалж өгүүлэл нийтлүүлсэн байна. Түүний өгүүлсэн нь:

“Аливаа дайн, байлдааны хохирол, түүний дотор хүн хүчний хохирлыг тооцож гаргах нь тухайн дайны шинж чанар, цар хврээ, дайтагч талуудын цэргийн байлдах чадвар, цэргийн жанжнуудын авъяас, чадварыг илэрхийлэх нэгэн чухал үзүүлэлт болдог билээ.

Чөлөөлөх дайнд ЗХУ болон Японы талын үзсэн хүн хүчний хохирол түүх бичлэгт нэгэнт тодорхой тусгагдсан байдаг бол монгол цэргийн үзсэн хохирол өнөө болтол нэг мөр болж чадаагүй байна.

Зөвлөлтийн улаан армийн 1 сая 669.500 хүнээс 36.456 хүн амь үрэгдэж, шархадсан бол Японы Квантуны армийн 1 сая гаруй хүнээс 83.7 мянган хүн алагдаж, шархдан, 640.1 мянган хүн олзлогджээ.

Эдгээр хохирлыг бие бүрэлдэхүүний тоотой нь харьцуулбал Зөвлөлтийн улаан арми 2.18 хувь, Японы Квантуны арми 72.3 хувийн хохирол үзсэн байна.

Дайны хохирлыг хүн хүчний болон эд материалын гэж ангилдаг бөгөөд энэ удаад чөлөөлөх дайнд оролцсон Монгол ардын хувьсгалт цэргийн хүн хүчний хохирлын талаархи судалгааны талаар өгүүлье.

Чөлөөлөх дайны дараа БНМАУ-ын Цэргийн явдлын яамны сайдын зөвлөх бөгөөд МАХЦ-ийн Жанжин штабын дарга дэслэгч генерал Рубины бичсэн нэгэн илтгэл Батлан хамгаалахын төв архивт байна. Тэрээр энэхүү илтгэлдээ дайнд оролцсон МАХЦ-ийн нэгтгэл, ангиудын байлдааны ажиллагааны талаар дүн шинжилгээ хийж, ололт дутагдлыг тэмдэглэхийн зэрэгцээ уг дайнаар үзсэн хүн хүчний хохирлыг нэгтгэн гаргасан байх ажээ. Үүнийг дор хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 3.8.

Хохирол	5 мд	6 мд	7 мд	8 мд	7 хбр	Бүгд
Бүх өвчилсөн хүний тоо	588	420	250	702	219	2179
Үүнээс госпитальд байгаа хүний тоо	460	218	175	451	154	1458
Өвчний учир нас барсан	10	19	14	26	10	79
Байлдаанд амь үрэгдсэн					10	10
Байлдаанд шархадсан					20	20
Буу зэвсэг осолдож нас барсан	4	10	3	5	3	24
Буу зэвсэг осолдож шархадсан	13	10	1	19		46

¹ Мөн тэнд. т.224

Дээрхээс үзвэл байлдааны ажиллагааны явцад 113 хүн амь насаа алдаж, 66 хүн шархадсан гэж хэлж болохоор байна. Хүн хүчний нийт хохирол **179** болж байна. Харин энд ор сураггүй болсон хүний тоог тусгаагүй байна. Харин 47 хүн шүүхэд шилжиж таслуулжээ. Үүнийг нэмж тооцвол **226** хүн болох ажээ.

Дайнд оролцсон нэгтгэл, ангийн дарга нар дайны дараа өөрийн ангийн байлдааны ажиллагааны дүнгийн тухай илтгэл бичиж, түүнд хүн хүчний хохирлын дүнг товч өгүүлсэн байх ажээ.

Эдгээрийг нэгтгэж үзвэл ямар нэг байдлаар амь насаа алдсан хүн 59, шархадсан 5, сураггүй болсон 17, бүгд **81** хвн болж байна. Мөн 5 дугаар морьт дивизийн даргын илтгэлд дурдсан маршийн үеэр тиф өвчнөөр нас барсан 44 хүнийг нэмж тооцвол нийт хохирол **125** хүн болох ажээ.

Түүнчлэн Жанжин штабаас гаргаж нэгтгэсэн зарим мэдээг авч үзье. 1945 оны 10 дугаар сард гаргасан нэгэн мэдээнд:

- Байлдаанд алагдсан -11
- Усанд унаж нас барсан - 4
- Зэрлэг суманд оногдсон -3
- Буу алдаж нас барсан -16
- Гэнэтийн ослоор нас барсан - 5
- Өвчнөөр нас барсан - 49
- Сураггүй алга болсон -21

Бүгд -**109** хвн гэжээ.

Морьт механикжуулсан бүлгийн штабаас гаргасан илтгэлд бүлгийн хохирлыг байлдааны хохирол: амь үрэгдсэн 57, шархадсан 137, маршийн хохирол 9 хүн гэсэн байх бөгөөд үүнийг нэгтгэвэл **203** хүн болж байна.

Мөн тус бүлгийн штабаас хөтөлж байсан байлдааны журналд тэмдэглэн үлдээсэн хүн хүчний хохирол нь **312** хүн болох бөгөөд МАХЦ-ийн ангиудын хохирол бүрэн бус байх ажээ. МАХЦ-ийн Улс төрийн газрын дарга дэслэгч генерал Ю.Цэдэнбал нэгтгэл, ангиудын улс төрийн хэлтсийн дарга нарын зөвлөлгөөнд тавьсан илтгэлдээ хүн хүчний хохирлыг:

- Байлдаанд нас барсан -10
- Гэнэтийн аюулаар нас барсан -16
- Өвчнөөр нас барсан - 10
- Усанд амь үрэгдсэн - 8
- Шархадсан -36
- Ор сураггүй болсон - 32

Бүгд - **122** хүн гэж гаргасан байна.

Чөлөөлөх дайны хүн хүчний хохирлыг тооцоолох гэсэн оролдлогууд удаа дараа хийж байсны нэг жишээ нь цэргийн хүн эмнэлгийн байгууллагын тvvх юм. Түүнд дайнд оролцсон армийн бүх бүрэлдэхүүний 3.6 хувь нь хохирол үзсэн гээд амь үрэгдсэн бага дарга 111, цэрэг 500 гэжээ. Дээр дурдсан хохирлын **611** гэсэн тоог харьцуулж үзвэл дайнд МАХЦ-ээс 16.972 хүн оролцсон болж байна.

Энэ нь ОХУ-ын судлаачдын сүүлийн үед гаргасан зарим баримтад уг дайнд оролцсон МАХЦ-ийн бие бүрэлдэхүүнийг 16.000 гэсэнтэй ойролцоо бөгөөд энэ тоонд зөвхөн дөрвөн морьт дивиз, 7 дугаар хуягт бригадын цэргийн тоог оруулсан ажээ. ОХУ-ын судлаачдын 1993 онд гаргасан тооцоогоор МАХЦ-ийн

бие бүрэлдэхүүнээс буцалтгүй хохирол 72, эмнэлгийн хохирлыг 125, бүгд **197** хвний хохирол үзсэн гэжээ.

Манай улс дайн дууссаны дараа Японоос дайны төлбөр нэхэмжлэх зорилгоор хүн хүчний хохирлоо тооцож гаргасан байна. Японоос дайны хохирол нэхэмжилсэн тооцоог хэд хэдэн хувилбараар гаргасан байдаг бөгөөд 1946 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр маршал Х.Чойбалсанд гаргаж өгсөн нэгэн илтгэлд 1945 оны чөлөөлөх дайны хүн хүчний хохирлыг **124** хүн гэж гаргасан байх ажээ¹.

Түүнчлэн өөр нэгэн баримтад дурдсаныг үзвэл 1945 оны чөлөөлөх дайнаар амь үрэгдсэн 141, шархадсан 360, сураггүй алга болсон 23, бүгд **524** хүний хохирол үзсэн² гэх нь ч бий. Үүнийг зарим судлаач дайны хохирол нэхэх зорилгоор хэт өсгөсөн тоо гэсэн байр суурь баримталдаг ажээ.

Дайнаар учирсан хүн хүчний хохирлыг баттай тооцоолж гаргахад дайнд амь үрэгдсэн, шархадсан хүмүүсийн бүртгэл нэн чухал ач холбогдолтой билээ. Гэвч харамсалтай нь Монгол Улсын архивуудад эдгээр бүртгэл бүрэн бус байгаа нь дайны хохирлыг тооцоолж, эцсийн үнэн тоог гаргахад бэрхшээл учруулж байгаа юм. Иймээс дээр дурдсан олон янзын тоо бүртгэлээс аль нэгийг нь үнэнд ойрхон тоо гэж үзэхээс өөр аргагүй болж байна.

Өнөөгийн байдлаар бидэнд мэдэгдэж буй баримтуудаар чөлөөлөх дайнд МАХЦ-ийн үзсэн хүн хүчний хохирол нь 109, 122, 124, 125, 197, 226, 524, 611 гэсэн өөр хоорондоо эрс зөрөөтэй тоо баримт байгаа нь хохирлыг эцэслэн тогтооход бэрхшээл учруулж байна. Гэсэн ч судлаач миний бие дээрх олон тоо баримтуудаас дайнд оролцсон нэгтгэл, ангийн дарга нарын бичсэн илтгэлд дурдсан 125, маршал Х.Чойбалсанд бичсэн илтгэлд дурдсан 124, Улс төрийн газрын дарга дэслэгч генерал Ю.Цэдэнбалын илтгэлд буй 122 гэсэн тоонууд нь ойролцоо байгаа тул монгол цэргийн үзсэн хүн хүчний хохирлыг 122-125 хүн гэж үзэх нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлж байна.

Түүнчлэн дайны хохирлыг эцэслэн тогтооход Монгол Улсын архивуудад байгаа баримтыг нэг бүрчлэн үзэж нягтлах шаардлагатай байна. Иймээс энэ чиглэлийн судалгааг гүнзгийрүүлж, Монгол Улсын төдийгүй ОХУ-ын архивуудын баримтыг нарийвчлан үзэх шаардлага тулгарч байгааг хэлэхийг хүсэж байна гэж доктор С.Ганболд бичиж байна.

Одоо 1935-1945 онд учирсан дайны хохирлын талаархи Батлан хамгаалахын төв архивын баримтыг сөхөж үзье³:

1946 оны 4 дүгээр сарын 8-наа Бүх цэргийн жанжин, улсын шалгарсан хошой баатар маршал танаа хэмээн хаягласан генерал Равдан тэргүүтэй тусгай бүлгийн бичсэн илтгэл байна. Үүнд:

1935 оноос 1945 он хүртэлх хугацаанаа Японы эзэрхэг түрэмгий нараас БНМАУ-д учруулсан цэргийн хохирлуудын тухай илтгэл:

Япон 1935 оноос БНМАУ-ын хилд заналхийлэх болсоноос Монгол улс ихээхэн зардал гаргах болсон. Нэг. Япон заналхийлсэнээс БНМАУ дараах арга хэмжээ авахад хүргэв. Үүнд:

¹ РГАСПИ. Ф.644. Оп.2. д.514.д.39. Подлинник-// Российско-Монгольское военное сотрудничество (1911-1946). Сборник документов. Часть 2. М-Улан-Удэ., 2008. с.147.

² Российско-Монгольское военное сотрудничество (1911-1946). Сборник документов. Часть 2. Москва-Улан-Удэ., 2008. с.147-148.

³ Ф1. Д.4. хн.205.

1. 1935 оноос цэргээ байлдааны цагийн орон тоонд хүргэх болсон.
2. Цэрэг халахыг зогсоосноос цэргийн зардлыг нэмэгдүүлсэн.
3. МАХЦ-ийн ангиудыг өргөтгөх ба шинээр байгуулсан, үүний зардлыг ардын аж ахуйгаас гаргасан.

Тиймээс Японоос манайд учруулсан хохирлыг бодохдоо: 1/ Цэргийн тоог тайван цагаас байлдааны цагийн орон тоонд шилжүүлсэн бүх зардал;

2/. Удаа дараагийн байлдааны хохирлыг бодож гаргав /зөвхөн цэргийн хохирол/:

- 1935 он ба 1938,1944 онуудын ханшаар бодвол 268 058 383 төг, 83 мөнгө болохоос гадна японтой хийсэн удаа дараагийн байлдаанд хохирсон хүн 1888, үүнээс алагдсан 610, шархадсан 1206, олзлогдсон 18, сураггүй болсон 53 болмой.

Японоос манайд учруулсан хохирлыг гаргахдаа:

1. 1935 оноос 1938 онд манай хилийг зөрчсөний улмаас гарсан хохирол;
2. 1939 оны Халхын голын балдааны сүйтгэл;
3. 1945 оны хэмээн 3 үед ангилан үзэв.

1935-1938 онд үзүүлсэн хохирол:

А/ 1935 он: 1935 оны нэгдүгээр сарын 24-ний өглөө 16 дугаар хорооны штабын дарга Дондов, монгол загасны харуулын дарга Лхамсүрэн нар дөрвөн цэргийн хамтаар Халхын сүмийн районд хил эргэж явахад японы зэвсэг бүхий 15 цэрэг тохиолдож тэд гал нээсэн учир штабын дарга Дондов, цэрэг Янжив нар амь үрэгджээ. Мөн 1935 оны нэгдүгээр сарын 28-нд Баян хоолойн харуулын дэргэд байсан 20 шахам ардууд дээр япон-манжийн хэсэг хүмүүс ирж буу тулган, цэргийн байр хүчийг асууж байгаад эцэст нь тэдгээр ардыг хоёр хоёроор нь хүлж орхиод дараа нь тайж Цэндийн 22 үхэр, есөн морийг дээрэмдэн явжээ.

- 1935 оны 12 дугаар сарын 18-нд Улаан худгийн харуулд довтолж, мөн 19-ний өглөөний 6 цагт Булан дэрсэний харуулд суман хүчтэй цэргээр дайрч, хэд хэдэн хүний амийг сүйтгэжээ. Иймээс хилээ хамгаалах арга хэмжээ авч ихээхэн зардал сүйтгэл гаргаж байв.

Б/ 1936 онд: 1936 оны 1 дүгээр сарын 31-нд японы батальон, 12 танк нисэх онгоцны дэмжлэгтэйгээр Халхын сүм, монгол загасны харуулыг эзлэн 20 хүнийг алж, 37 хүн шархадсан ба 40 морь үрэгджээ.

- 1936 оны 3 дугаар сарын 15. Японы цэрэг Булан дэрсээр давшиж, манай 15 хүн алагдаж, 30 хүн шархдаж, 43 морь үрэгджээ.
- 1936 оны 3 дугаар сарын 30. Японы 2 нисэх онгоц Тамсаг булагийн цэргийн объектийг эвдэв.15 хүн шархдаж, 30 морь үрэгджээ. Бас төмөр утасны шугамыг эвджээ. Мөн 1936 оны 3 дугаар сарын 31-нд Адаг дулаанаар япончууд довтолж, төмөр утасны бүх шугамыг эвдэлсэн бөгөөд 17 хүн алагдаж, 30 хүн шархаджээ.
- 1936 оны 4 дүгээр сарын 1-нд Баянцагаан дахь МАХЦ-ийн ангийг 15 онгоцоор бөмбөгдөхөд 12 хүн алагдаж, 20 хүн шархдаж,100 морь үрэгджээ. Бас төмөр утасны шугамыг эвджээ. Түүнчлэн 1936 оны дөрөвдүгээр сарын 2-нд японы 7 онгоц Матадын объектыг бөмбөгдөж, склад 2, казарм 2, офицеруудын байр 1-ийг эвджээ.

- 1936 оны турш япон заналхийлсэн учир 6 дугаар морьт дивизийг Тамсагаас хилд очуулж, 8 дугаар морьт дивизийг шинээр байгуулжээ.

1935-1936 онд Японоос учруулсан хохиролыг тооцвол:

Бүх хохирсон хүн 233, үүнээс дарга нар 15, бага дарга 52, цэрэг 166. Эдгээрээс алагдсан нь 78, шархадсан 137, олзлогдсон 18 байв.

Эд материалын хохирол:

1. Их буу - 404444 төг
2. Нисэх хүчин - 610700 төг
3. Авто, хуягт танк -142100 төг
4. Шатах, тослох -156800 төг
5. Агт морьд, эм хэрэглэл - 51660 төг
6. Тээвэр - 542539 төг
7. Хүнс хэрэглэл - 1189167 төг, 35 мөнгө
8. Холбооны техник хэрэглэл - 6015983 төг, 90 мөнгө
9. Хувцас хэрэглэл - 1713870 төг, 56 мөнгө
10. Орон сууцны талаар - 38625 төг
11. Хүн эмнэлгийн талаар - 5000 төг
12. Цэргийн санхүүгийн талаар - 518220 төг
13. Цэргийн хилийн хэрэглэл - 1140 төг
ДҮН - 11390249 төг

Дээр дурдсан хохирлыг үндэс болгосон зарим баримтыг дурдвас:

1. Халхын сүм, Булан дэрс, Адаг дулааны байлдаанд бүрмөсөн эвдэрсэн онгоц-4, бензин- 7432 кило, масло 376 кило, агаарын бөмбөг 6400 кг-ыг зарцуулсаны үнэ 610.700 төгрөг
2. Их буу ба галт хэрэглэлийн талаар: төрөл бүрийн винтов 81, хөнгөн пулемёт 50, гар гранат 2070, их бууны сум 850, 45 мм-ийн их бууны сум 5000 гарзадсаны сүйтгэл 404441 төгрөг
3. Хилийн будлианд хөнгөн хуягт 2, суудлын машин 1, ачааны машин 66, хуягт машин 18, бүрмөсөн жагсаалаас гарсан сүйтгэл 142. 100 төг, бензин, маслын бүгд 75 тонн- ыг зарцуулсаны үнэ-156800 төгрөг
4. Агт 213, тэмээ 12, 6 дугаар морьт дивизийн мал эмнэлэг бүрэн сүйдсэн-51.660 төгрөг
5. 1935-36 онд японы бөмбөгдсөн утасны шугамыг сэргээн босгосны сүйтгэл
6. Япон довтолсоны улмаас цэрэгт илүү зарцуулсан хоол, орон сууц, хувцас хэрэглэл гаргасны бүх зардалыг бодсон болой.

Хоёрдугаар үе. 1939 оны Халхын голын дайнд учирсан цэргийн хохирлын баримт:

- 1939 оны нэгдүгээр сараас 1939 оны 5 дугаар сарын 11-ний өдөр буюу Халх голын байлдаан эхлэх хүртэл япончууд манай хилийг зөрчсөөр байв: Жишээ нь: 1939 оны нэгдүгээр сард япон-манжийн 3-аас 60 тооны цэрэг Хайлаастын голоор хилийг 8 удаа зөрчсөн ба мөн оны 2 дугаар сарын 8-аас 16-ыг хүртэл салаа ба суман хүчтэй цэргээр хилд халдсаар байв.

- Япончууд 1939 оны 5 дугаар сарын 11-ний өдөр томоохон отряд манай хилийг зөрчиж, Халхын голын дайныг эхлүүлсэн бөгөөд 30 хүн алагдаж, 80 хүн шархаджээ.
- 1939 оны 6 дугаар сард Халхын голын зүүн эрэгт байсан МАХЦ-ийн ангиуд руу японы явган дивиз давшиж, энэ байлдаанд 90 хүн алагдаж, 160 хүн шархаджээ.
- Наймдугаар сард японы түрэмгийлэл идэвхижсэн бөгөөд 250 хүн алагдаж, 150 хүн шархдаж, 30 хүн сураггүй болжээ.
- 1939 оны 8 дугаар сард японы онгоц Тамсагийн штабын 2 казарм, Чойбалсангийн 1 казарм, дарга нарын сууцыг бүрмөсөн сүйтгэж, 21 хүн алагдаж, 20 хүн шархаджээ.

Халхын голын дайнд манай командлалаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээнд:

- 6 ба 8 дугаар морьт дивизийн 14 дүгээр хороо, хуягт бригадын зарим анги, нисэх хүчний хагасыг байлдаанд оруулж, 5 дугаар дивизийн үлдэгдэл анги, моторт бригадын гол хүчийг Тамсаг ба Буйрын районд татан авсан байна.
- Байлдааны цагийн орон тоонд шилжүүлж зардал нэмэгдсэн.

1939 оноос манайд учруулсан хохирлыг тооцвоос:

1939 оны байлдааны хүн хүчний хохирол: МАХЦ-т 1131 хүний хохирол гарсан бөгөөд үүнээс, дарга 119, бага дарга 350, цэрэг 672-ээс алагдсан 391, шархадсан 710, ор сураггүй болсон 30.

Эд материалын хохирол:

1. Их буу - 7597416 төг
 2. Нисэх хүчин - 2936094 төг
 3. Авто, хуягт техник - 802.100 төг
 4. Шатах, тослох материал - 798600 төг
 5. Агт морьд, эм хэрэглэл - 1.102119 төг
 6. Тээврийн зардал - 827557 төг
 7. Хүнс - 10882257 төг
 8. Холбооны техник хэрэгсэл - 172584 төг 90 мөнгө
 9. Хувцас хэрэглэл - 26435228 төг 98 мөнгө
 10. Орон сууц - 4137000 төг
 11. Хүн эмнэлэг - 34300 төг
 12. Инжинерийн багаж хэрэглэл - 50438 төг 82 мөнгө
 13. Цэргийн санхүү - 4079163 төг 20 мөнгө
 14. Гэгээрлийн эд хохирол - 796960 төг
 15. Цэргийн химийн хэрэгсэл - 80378 төг 95 мөнгө
- БҮГД: 60732197 төг 85 мөнгө

Халхын голд гарсан эдгээр хохирлыг бодож гаргахдаа үндэс болгосон зарим баримт:

1. Агаарын бензин 157 тн 820 кг, масло 7 тн 900 кило, нисэх онгоцны 15, агаарын бөмбөг 45 тн, ачааны машин 8, авто бензин 105 тн, масло 5 тн 500 кг, БҮГД -2 сая, 936 мянга, 094 төгрөг.
2. Их буу ба зэвсэг, галт хэрэглэлийн талаар:

Винтов 250, төрөл бүрийн пулемёт 70, 45-ийн танк эсэргүүцэх буу 11, хорооны их буу 6, их бууны сум ба бусад зүй бусын сум зэргийг бүгд нийлүүлж -7597416 төг

3. Хуягт танк хийгээд шатах тослох материал:

Хөнгөн хуягт 13, ачааны болон суудлын машин 114, бензин тос 500 тн, бүгд нийлж 1.600700 төг

4. Агт 4436, тэмээ 193, үхэр 132, тэдгээрийн үнэ бүгд 1077320 төг.

Гуравдугаар үе: 1945 оны чөлөөлөх дайны хохирлуудын баримт:

Фашист германыг ялсны дараа ЗХУ тэргүүтэй холбоотон гүрнүүдийн тэргүүнүүд Японд дайн зарлан дайтах, түүнд МАХЦ-ийг оруулах тохироонд хүрсэн ёсоор БНМАУ-ын Засгийн газар 1945 оны 8 дугаар сарын 10-нд Японд дайн зарласнаар 1945 оны Чөлөөлөх дайн эхлэсэн билээ. Энэ дайнд БНМАУ эртнээс бэлтгэж байсан байна. Тухайлбал, БНМАУ цэргийн тоогоо ихээр нэмсэн ба шинэ шинэ техник /онгоц, танк, их буу/ нэмсэн, үлэмж тээврийн хэрэгсэл, шатах тослох материал зарцуулсан аж. Үүнд:

Хүн хүчний хохирол: 524, үүнээс алагдсан 141, шархадсан 360, сураггүй болсон үгүй. Эдгээрээс дарга 23, бага дарга 111, цэрэг 490 байв.

Эд материалын хохирол:

1. Их буу, зэвсэг - 6360590 төг
2. Нисэх хүчин - 6288905 төг
3. Авто хуягт танк - 6108000 төг
4. Шатах тослох материал - 3621200 төг
5. Агт морьд, эм хэрэглэл - 3532522 төг
6. Тээврийн зардал - 1149733 төг 80 мөнгө
7. Хүнс хэрэглэл – 31846671 төг 80 мөнгө
8. Холбооны техник хэрэглэл - 918 979 төг 27 мөнгө
9. Хувцас хэрэглэл - 96065584 төг 06 мөнгө
10. Орон сууц - 6304317 төг
11. Хүн эмнэлэг - 419000 төг
12. Инженерийн хэрэгсэл - 104821 төг 22 мөнгө
13. Санхүүгийн талаар - 32722416 төг
14. Гэгээрлийн эд хогшил - 418 512 төг
15. Цэргийн хилийн хэрэглэл - 74684 төг 82 мөнгө

БҮГД: 195 935 936 төг 17 мөнгө

Тайлбар: Хуягт машиныг дайны дараа актлагдсаныг оруулав.

Дээрхи хохирлыг гаргахад үндэс болгосон зарим томоохон баримтаас дурдвал:

1. Нисэх хүчнээс бүрэн жагсаалаас гарсан 3, агаарын бензин 360 тн, авто масло 16 тн, бүгд үнэ 6288905 төг.
2. Төрөл бүрийн винтов 553, автомат 7, зенитийн пулемёт 5, дуран 59, хүнд пулемёт 2, винтовын сум 1041956, төрөл бүрийн бага калибрын бууны сум 118 3108, 45 мм-ийн танк эсэргүүцэх бууны сум 650, 76 мм-ийн их бууны сум 2319, төрөл бүрийн миномётын мина 4422, эдгээрийн бүх үнэ- 6360590 төг

3. Хөнгөн хуягт 19, дунд хуягт 30, хөнгөн танк 3, ачааны машин 237, суудлын машин 32, мотоцикл 7, бүгд 328, машины бензин 170 тн, масло 130 тн, эдгээрийн бүгд үнэ 9729 .200 төг.
4. Агт 13113, тэмээ 1245 , үхэр 307, бүгд үнэ 3490310 төг гэх зэргээр бодож гаргасан болно.

1939-1945 оныг дуустал учирсан хохирол:

а/ Амьд хүч: Хүмүүсийн албан тушаалын ялгавар: Алагдсан: Дарга нар-35, бага дарга - 170, цэрэг - 405. Бүгд - 610.

Шархадсан: Дарга - 111, бага дарга - 313, цэрэг – 783. Бүгд: 1207

Олзлогдсон: Дарга - 1, цэрэг – 17. Бүгд: 18. Мэдээ сураггүй болсон: Бага дарга - 30, цэрэг – 23. Бүгд: 53.

Бүгд: Дарга:147, бага дарга-513, цэрэг-1328, Бүгд:5.1888

б/ Эд материалын хохирол:

1. Их бууны зэвсэглэл-14362450 төгрөг
 2. Нисэх хүчин-9 835699 төг
 3. Авто хуягт танк-7052200 төг
 4. Шатах тослох хэрэгсэл-4576600 төг
 5. Агт, эмнэлгийн хэрэгсэл-4686301 төг
 6. Тээврийн зардал-2519829 төг
 7. Хүн ба агт морьдын хүнс хэрэглэл-43918096 төг
 8. Холбооны хэрэгсэл-7107548 төг
 9. Хувцас, хүнс-124214683 төг
 10. Орон сууц-10479942 төг
 11. Эмнэлгийн хэрэглэл-458300 төг
 12. Сапёрын хэрэглэл-155260 төг
 13. Мөнгөн хөрөнгө- 37319799 төг
 14. Улс төр, гэгээрлийн талаар-1215472 төг
 15. Химийн хэрэглэл-156203 төг
- БҮГД: 26805383 төг 83 мөнгө

Ерөнхий дүгнэлт

1. 1935,1945 онд японоос учруулсан цэргийн талын бүх хохирол-268558383 төг 83 мөнгө.

2. Энэ хохирлыг гаргахдаа дээр дурдсан зүйлүүд дээр нэмж, эрхбиш анхаарах чухал гэж үзэв: Үүнд:

- 1935-1945 оныг дуустал 10 жилд манай арми 400 гаруй хувиар нэмэгдсэн буюу 169 мянга 501 хүнийг улс ардын аж ахуйгаас салгасан нь улсын хөгжилд ихээхэн саад учруулсан. Энэхүү аж ахуйгаас салсан хүн нэг бүрийн хөдөлмөрийн үнийг тус тусын оны ханшаар барагцаалан бодвол: 1367397 000 төгрөгийн хохирол учруулжээ.
- Удаа дараа дайчилсан цэргийг тээвэрлэх морьдын тоо 143906 байсан нь нэг морь нэг өдөрт ардын аж ахуйд оруулах үнийг нэг төгрөгөөр улсын тогтоосон үнээр авч үзвэл, аж ахуйгаас салсан хугацааны дотор хохирсон үнийг тус бүрийн морьдын тоогоор үржүүлэн гаргаваас

энэхүү хугацааны дотор үнэ нь 198 86 800 төгрөгийн хохирол учруулжээ.

- Удаа дараагийн цэрэг дайчилгаагаар татсан машины тоо 3001 болох нь дундыг баримталж тус бүрийн явсан хэмжээ 1000 км хэмээгээд хүн\км-ийг 15 мөнгөөр бодож, Бүгд: 13094550 төгрөгийн хохирол учруулжээ хэмээн архивын баримт өгүүлж байна.

Өмнө өгүүлсэн бүхнийг шүүн тунгааж, дараахи хэдэн дүгнэлтийг хийж болмоор байна. Үүнд:

Нэгд: Өмнө өгүүлснээр, сурвалж судалгааны зохиолуудад Халхын голын дайнд МАХЦ-ийн хүн хүчний хохирлын талаар: 731, 566, 1131 (алагдсан, шархадсан, сураггүй болсон) гэсэн тоо баримт дурдагдав. Доктор С.Ганболд судалгаандаа буцалтгүй хохирол бүгд 895 (алагдсан-237, шархадсан-626, сураггүй болсон-32) хэмээснийг дээр өгүүлсэн билээ. Үүнээс алагдсан гэх 237 хүний 225 хүний нь нэрс, товч тодорхойлолт “Х.Шагдар, Ж.Гантулга. “Эх орныхоо төлөө өргөсөн алтан амь”. УБ., 2014 хэмээх эмхэтгэлд бүртгэгдсэн байх бөгөөд сураггүй болсон - 32 гэдэг нь генерал С.Равдангаас маршал Х.Чойбалсанд өргөсөн илтгэлд 30 хүн гэсэнтэй дүйж байгаа тул тулхтай, итгэмжтэй судалгаа болсон нь харагдаж байна.

С.Ганболд судалгаандаа хязгаарын цэргээс амь үрэгдсэн 43, шархадсан 52 хүнийг нэмвэл монгол цэргийн хохирол 990 (895 + 95) болно гэж үзжээ. Гэтэл энд дурдсан Х.Шагдар нарын эмхэтгэлд хязгаарын цэргээс зүүн хилд амь үрэгдсэн 57 хүн бүртгэгджээ. Тиймээс энэ зөрөөг (14 хүн) нэмж тооцоод Халхын голын дайнаар 1004 монгол цэрэг, даргын буцалтгүй хохирол үзжээ гэж тооцов.

Хоёрт: Халхын голын дайнд Зөвлөлтийн цэргийн бие бүрэлдүүний хохирол¹:

Хүснэгт 3.9.

1. Буцалтгүй хохирол:

	Дарга	Бага дарга	Байлдагч	Бүгд
Алагдсан, эмнэлэгт нас барсан	1063	1313	4455	6831
Сураггүй болсон	71	120	952	1146
БҮГД:	1134	1433	5407	7954

2. Эмнэлгийн асрамжид:

	Дарга	Бага дарга	Байлдагч	Бүгд
Шархадсан, бэртсэн, түлэгдсэн	1335	2123	11793	15251
Өвдөж эмчлүүлсэн	85	127	489	701
БҮГД:	1420	2250	12282	15925

Буцалтгүй ба эмнэлгийн Бүгд: 7954 + 15925 = 23879 хүн

¹Гриф секретности снят. М., 1993. т.78-79-оос үзвэл

Гуравт: Оросын судлаачид 1993 онд архивын нууц баримтуудыг дэлгэж, Эх орны дайны хохирлоор шинэ тооцоо хийсэн байна. Тэр судалгааны номд “Монгол, ЗХУ, Японы нийт амь үрэгдэгсэд 19380 бөгөөд ихэнх нь японы хохирол гэсэн нь анхаарал татаж байна¹”.

Энэ баримтад итгэвэл зөвхөн амь үрэгдэгсэд, буцалтгүй хохирлын хувьд: Зөвлөлт 7954 + Монгол 1004 = 8958 хүн. Гурван улсын хохирол 19380 - 8958 = 10422 нь Японы хохирол болж байна. Энэ нь Оросын судлаачдын өмнө өгүүлсэн ихэнх нь японы хохирол (8958: 10422) болж таарч байна. Энэ хохиролд хоёр талаас ялагдсан, ялсан талын хооронд 1000-аад хүний зөрөө л байна. Дайны хохирол иймэрхүү л байдгийн жишээ байж болох юм.

Халхын голын дайны туршид Япон 61 мянган хүнээ алуулж, шархдуулж, олзлуулсанаас 45 мянга орчим хүнээ 7-8 дугаар сарын байлдаанд алджээ² гэдэг нь арай даваадуулсан тоо байх гэж бодогдоно. Нөгөө талаар Квантуны армийн 1,5 сая хүний 61 мянгыг устгасан нь нийт бие бүрэлдүүний гуравны нэг нь юм. Гурван хүний нэг нь алагдвал нөгөө хоёр нь байлдах чадвараа алддаг “номлолоор” бодвол японы цэрэг зугтсан, ялагдсан нь, илүү хохирол хүлээсэн нь үнэн гэх дүгнэлтэд хүргэнэ.

Дөрөвт: Хохирлын баримтуудаас ажвал дайн, байлдаанд үлэмж хохирдог нь тэргүүн шугамд хориглох буюу давшиж яваа жирийн цэрэг, бага дарга, салаа болон ротын дарга байдаг аж.

Тавд: Өмнө дурдсан архивын баримт, судалгааны бүтээлүүдэд дурдагдсан 1945 оны чөлөөлөх дайны хүн хүчний буюу буцалтгүй хохирлын тухайд: 124, 179, 197, 122-125 гэсэн тооцоонууд тун ойролцоо байгаа нь 1946 онд маршал Х.Чойбалсанд гаргаж өгсөн илтгэл нэн бодитой байсныг илтгэнэ. Тиймээс тус илтгэлд дурдсанаар 1945 оны хүн хүчний хохирол 124 гэж тогтоох нь зүйтэй гэж үзлээ.

Зургаад: Батлан хамгаалахын төв архивт байгаа данснуудыг судлаач Ж. Гантулга шүүн нэгтгэж 1945 онд ямар нэгэн шалтгаанаар амь үрэгдсэн 73 хүний нэрийг товч тодорхойлолтын хамт жагсаан бүртгэсэн байна³. Энэ бол хөдөлгөөнгүй бодитой баримт юм.

Долоод: Зөвлөлтийн улаан армиас Чөлөөлөх дайнд алагдсан, шархадсан 36456 хүн, Японы талаас алагдсан, шархадсан 83700, олзлогдсон 640100 гэдэг нь бодит үндэстэй тооцоонууд гэж үзэж байна. Зөвлөлтийн улаан арми бие бүрэлдүүний 2,18 хувь, Япон 72,3 хувийн хохирол авсан гэдэг нь ч маргах аргагүй баримт биз. Үүнээс харвал дайтагч талуудын хохирлын зөрөөг харьцуулж зүйрлэшгүй бөгөөд Гитлерийн германыг ялсан улаан армийн сүр хүч, Хиросима, Нагасака дээр хаясан хоёр атомын бөмбөгний нүргээнд японы армийн сүнс зайлж, байлдах чадваргүй болсон байсан нь илт байна

¹Мөн тэнд

²Гриф. т.78.

³Х.Шагдар, Ж.Гантулга. Эх орныхоо төлөө өргөсөн алтан амь. УБ., 2014.

Наймд: 1935-1945 оны хооронд БНМАУ-д учирсан хохирлыг нэгтгэсэн баримт бичгийн тухайд:

Энэ баримтад 1935-1945 онд Японоос учруулсан цэргийн хохирлыг :

1. 1935-1938 он. Хүн хүчний нийт хохирол, Бүгд:233. Үүнээс алагдсан 78, шархадсан 137, олзлогдсон 18.
2. 1939 он. Хүн хүчний нийт хохирол. Бүгд: 1131. Үүнээс алагдсан 391, шархадсан 710, сураггүй болсон 30.
3. 1939-1945 он. Хүн хүчний нийт хохирол. Бүгд: 524. Үүнээс алагдсан 141, шархадсан 360 хэмээн гурав ангилан тооцсон байна.

Эдгээрийг нэгтгэвэл: 1935-1945 онд Монголын зэвсэгт хүчнээс алагдсан 610, шархадсан 1207, олзлогдсон 18, сураггүй болсон 30 (Үүнийг тус баримтад 53 гэж тооцсон буй), Бүгд: 1888 хүн гэсэн тооцоо гарч байна.

Есд: Мөн дээрхи архивын дансанд Японоос БНМАУ-ын Зэвсэгт хүчинд учруулсан зэвсэг, техник, эд материалын хохирлыг тооцоолон жагсаасан байна. Тэдгээрийн нэгдсэн дүнг гаргавал:

1/ Их буу, 2/ Нисэх хүчин, 3/ Авто, хуягт танк, 4/ Шатах тослох материал, 5/ Агт морьд, эм хэрэглэл, 6/ Тээвэр, 7/ Хүнс хэрэглэл, 8/ Холбооны техник хэрэглэл, 9/ Хувцас хэрэглэл, 10/ Орон сууц, 11/ Хүн эмнэлгийн талаар, 12/ Цэргийн санхүүгийн талаар, 13/ Цэргийн хилийн хэрэглэл гэсэн ангиллаар тооцоолсон байна. Үүнд:

1. 1935-1936 онд: Дүн:113 902 49 төг.
2. 1939 онд дээрхи эхний 11 ангилал дээр 12/ Инжинерийн багаж хэрэглэл, 13/ Цэргийн санхүү, 14/ Цэргийн химийн хэрэглэлийн хохирлыг нэмээд Бүгд: 607.321.97 төг.85 мөнгө

Аравт: 1945 онд дээрхи 15 ангиллаар: Бүгд: 195.935.936 төг 17 мөнгө.

Дээрхи хохирлуудын нийлбэрийг багцлан үзвэл, 1935-1945 оны хохирол буюу 1939 оны Халхын голын болон 1945 оны Чөлөөлөх дайнд гарсан Монголын талын хохирол: Бүгд: 268 сая 058 мянга 382 төгрөг болжээ.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Монгол Улс дэлхийн II дайны жилүүдэд 1936 онд ЗХУ-тай байгуулсан протокол гэрээний дагуу зөвлөлтийн ард түмний талд эх орны дайн эхэлсэн өдрөөс эхлэн тууштай зогсож, бүхий л талын тусламж, дэмжлэгийг үзүүлж ирснийг архивын баримт, судалгааны бүтээлүүд нотлон харуулдаг билээ. Энэ талаар Монголын түүх бичлэгт өргөн хэмжээтэй тусгасан байх ажээ.

Энэхүү төслийн ажлын тайланд дайны жилүүдэд Монгол Улсын гүйцэтгэсэн үүргийг нэг бүрчлэн авч үзэлгүй зөвхөн зарим төрлөөр нь төлөөлүүлэн авч үзсэн болно. Тухайлбал, Монголын ард түмнээс Зөвлөлтийн ард түмэнд зориулсан бэлэглэлийн талаар түүх бичлэгт дэлгэрэнгүй авч үзсэн байх бөгөөд харин түүх бичлэгт төдийлөн дэлгэрэнгүй тусаагүй сэдвүүдийг энэ тайланд сонгон авч оруулав.

ОХУ-тай хамтарсан төслийн ажлын үр дүнд хоёр орны эрдэмтэд “Монголия во второй мировой войне (1939-1945 гг)” хэмээх нэгэн сэдэвт бүтээл туурвисан нь манай цэргийн түүхчдийн хувьд гадаадын эрдэмтэдтэй хамтарсан анхны бүтээл гэж хэлж болно. Уг бүтээлд Монгол, Оросын түүх бичлэгт Монгол Улсаас дэлхийн II дайны жилүүдэд гүйцэтгэсэн үүрэг, түүний дотор Зөвлөлтийн улаан армид үзүүлсэн тусламжийн талаар зарим бүтээлээр төлөөлүүлэн авч үзсэний дээр бэлэг гардуулахаар очсон Монголын төлөөлөгчдийн фронт дээрх үйл ажиллагааг дэлгэрэнгүй судлан гаргав. Монголын ард түмний сэтгэл шингэсэн бэлгийг Зөвлөлтийн улаан армийн дайчдад гардуулж байсан нь тэдний сэтгэл санааг өндөрт өргөж, ялалтад зоригжуулж байсныг түүхэн баримтууд нотлон харуулж байна.

Энэхүү тайланд Монгол Улсаас дэлхийн II дайны жилүүдэд гүйцэтгэсэн үүргээс зөвхөн цэргийн буюу 1939, 1945 оны дайнд оролцсон МАХЦ-ийн, түүний дотор зөвхөн морьт цэргийн оролцоо, гүйцэтгэсэн үүрэг, ялалтад оруулсан хувь нэмэр, тохиолдож байсан саад бэрхшээл, сургамжийн талаар авч үзсэн бөгөөд энэ нь монголын морьт цэргийн XX зуунд гүйцэтгэсэн үүргийг тусгайлан судалсан судалгаа болов.

1939 оны Халхын голын дайнд морьт цэргийн гүйцэтгэсэн үүргийг бүхэлд нь эерэгээр үнэлж болохоор байна. Учир нь тухайн үед МАХЦ-ийн үндсэн бүрэлдэхүүн нь морьт дивизүүд байсан ба дайнд 5, 6, 8 мд оролцож гол үүргийг гүйцэтгэжээ. Энэ дайнд МАХЦ-ийн ангиуд Зөвлөлтийн улаан армитай хамтран байлдааны үүрэг биелүүлж, нэг удирдлагад захирагдаж байв. Монгол, Зөвлөлтийн цэргийг нэгтгэн удирдсан Армийн 1 дүгээр бүлгийн командлагч Г.К.Жуков Халхын голын дайнд монголын морьт цэргийг фронтын хоёр жигүүрт байлдааны үүрэг гүйцэтгүүлсэн нь цэргийн урлагийн үүднээс маш зөв шийдвэр байв. Учир нь японы тал фронтын төв хэсэгтээ явган болон механикжсан анги, их бууны ангиудаа, хоёр жигүүртээ Хянганы морьт хороодыг байрлуулсан тул тэрхүү морьт цэргийн эсрэг монголын морьт цэргийг сэргүүлэн тавьсан нь зүй ёсны хэрэг байжээ.

Монголын морьт цэрэг дайн эхэлсэн эхний өдрөөс эхлэн сайтаг сургагдсан японы цэрэгтэй нүүр тулж эрэлхэг зоригтой байлдаж иржээ. Энэ дайнд монгол цэргүүд зөвлөлтийн улаан армийн байлдах арга ухаанаас суралцаж, байлдааны багагүй туршлага хуримтлуулсан нь дайнд ялалт

байгуулахад чухал нөлөө үзүүлжээ. Ялангуяа наймдугаар сарын ерөнхий давшилтаар японы цэргийг Халхын гол, улсын хилийн хооронд бүслэн авахад 6 болон 8 мд фронтын хоёр жигүүрийг халхалж, хамгийн түрүүнд улсын хилд хүрснээр японы цэргийг бүрэн бүслэн авч, улмаар бутцохих таатай боломжийг олгосон байна. Энэ нь танк, хуягт тэр бүр явах боломжгүй элс, намагтай газар орон дээр морьт цэрэг хурдан шалмаг маневрлаж, байлдааны үүрэг биелүүлэх чадвартай цэрэг гэдгээ харуулсан хэрэг байв.

1945 оны Чөлөөлөх дайнд Өвөр Байгалийн фронтын баруун жигүүрийг халхлах үүрэг хүлээсэн И.А.Плиевийн командалсан Монгол, Зөвлөлтийн морьт механикжуулсан бүлэг хүнд нөхцөл байдлын дунд байлдааны үүрэг биелүүлснийг архивын баримтууд гэрчилж байна. Энэхүү бүлгийн бүрэлдэхүүнд МАХЦ-ийн 5, 6, 7, 8 мд, 9 дүгээр бэлтгэл морьт хороо, Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отряд багтаж байв.

Бүлгийн командлагч хүч хэрэгслээ хоёр чиглэлд хувааж давших шийдвэр гаргасны зүүн чиглэл буюу Долнуур-Жэхэгийн чиглэлд монголын морьт цэрэг үүрэг гүйцэтгэх болсон байна. Энэ чиглэлд 300 орчим км үргэлжлэх Цахарын элсэн цөл, Хянганы өндөр уулс орших бөгөөд түүнийг морьт цэргээс өөр нэгтгэл, анги туулж гарах боломжгүй байсан юм. Энэхүү шийдвэр нь тухайн үеийн байлдааны цагийн байдалтай уялдсан бөгөөд үүнээс өөр сонголт морьт механикжуулсан бүлгийн командлалд байгаагүй ажээ.

Байгаль, цаг уурын маш хүнд нөхцөлийн дунд монголын морьт цэрэг тавигдсан байлдааны үүргийг биелүүлэхийн тулд асар их бэрхшээлийг туулж, тэрхүү саадыг давж гарсан нь монгол цэрэг, монгол морины тэсвэр хатуужлыг харуулсан хэрэг байв.

Энэ нь морьт цэрэг байгаль, цаг уурын хүнд нөхцөлд байлдааны үүрэг биелүүлэх чадвартай гэдгийг харуулсан нотолгоо болсон байна.

Судалгааны ажлын үр дүнгээс харахад байлдаанд морьт цэргийн гүйцэтгэх үүрэг нь тодорхой хэмжээгээр хязгаарлагдмал байх бөгөөд зөвхөн явган болон морьт цэргийн эсрэг байлдааны ажиллагаа явуулах боломжтой нь харагдав.

Механикжсан болон хуягт, танкийн цэргийн эсрэг морьт цэрэг байлдааны ажиллагаа явуулах боломжгүй байсан нь Халхын гол, Чөлөөлөх дайны туршлага харуулж байна.

Үүний хамт өнгөрсөн дайнуудад монголын морьт цэргийн байлдааны ажиллагаануудад сургамж болохуйц цөөнгүй зүйл тохиолдож байсныг дурдах нь зүйтэй.

Монгол оронд өрнөсөн улс төрийн хэлмэгдүүлэлт МАХЦ-ийн байлдах чадвар, байлдааны бэлэн байдалд ихээхэн сөрөг нөлөө үзүүлснийг харуулав. Ялангуяа даргалах бүрэлдэхүүний чанар, мэдлэг боловсрол, ажлын дадлага туршлага, байлдааны ажиллагааг удирдан зохион байгуулах чадвар ихэд доод түвшинд байв.

Тэр ч хэмжээгээр бага дарга, цэргүүдийн бэлтгэл төдий л сайн байсангүй. Халхын голын дайн дууссаны хойно ч дарга, цэргүүдийн бэлтгэлд төдий л ахиц гараагүй нь дайны туршлага, сургамжийг амьдралд хэрэгжүүлэх талаар анхаарал тавиагүйн шинж мөн.

Аливаа байлдааны ажиллагаанд оролцох цэргийг, түүний дотор даргалах бүрэлдэхүүнийг бүх талаар урьдчилан бэлдсэн байх шаардлагатай нь харагдав.

Түүнчлэн нутгийн аль болзошгүй чиглэлийн газар орон, байлдааны ажиллагааны театрыг урьдчилан судалсан байх, даргалах бүрэлдэхүүнтэй цэргийн тоглоом явуулах хэрэгтэйг харуулав. 1939 оны эхнээс л Японы зүгээс удаа дараагийн өдөөн хатгалга үйлдэж байхад тухайн газар орныг тагнан судлаагүй, байлдааны ажиллагаа өргөжиж болзошгүй гэдгийг хайхраагүйгээс огт таньж мэдэхгүй газар оронд байлдааны ажиллагаа өрнөжээ. Гэтэл Японы тал тус газар нутгийг эртнээс нямбайлан судалсан байв. Тавдугаар сарын байлдаан нь үнэн хэрэгтээ МАХЦ-ийн хувьд гэнэтийн байлдаан болсон байна.

Төрөл, мэргэжлийн цэргийн харилцан ажиллагааг зохион байгуулж чадахгүй байснаас өөрийн цэрэгт багагүй хохирол учруулжээ.

Цэргүүдийг байлдааны ажиллагаанд, түүний дотор дор хаяж нэг бүрийн зэвсэгтэйгээ харьцаж, эзэмшиж чаддаг болгон сургаагүйгээс багагүй хохирол амссан байна.

Дайчилгаагаар болон шинээр татагдсан цэргүүдийг тодорхой хугацаанд сургаж бэлтгэхгүйгээр байлдаанд оруулах нь ихээхэн сөрөг үр дагавартай гэдгийг харуулав.

Чөлөөлөх дайнд Монголын морьт дивизүүд ар тал үгүй, дээд командлал болоод дивиз хоорондын холбоо харилцаагүйгээр давшилтад орсон байна.

Газрын зураг дээрхи газар усны нэр зөрж, түүний улмаас баримжаа алдаж байв.

Ар цагаан нуураас Цахарын их элс эхлэхэд л хуягт, их буу, ар талын ангиуд, галт хэрэглэл, зарим салбар анги хоцорсон байна. Үүнээс шалтгаалж морьт цэргүүд ар талын хангалтаасаа бүрэн тасарчээ.

МАХЦ-ийн зэвсэглэл, техникийн байлдааны бэлэн байдал тухайн үеийн дайны шаардлагыг хангахгүй болсон байжээ. Дайныг эхлүүлэх нууцлал, цаг хугацааны тулгамдлаас үүдэн зэвсэг, техникийн засвар, шинэчлэл хийж чадалгүйгээр дайнд оржээ. МАХЦ дайнд орж хил давсанаас үндсэндээ 2 хоногийн дараагаар хоол хүнс, шатахуунаар тус тус тасарч, хүнд зэвсэг, техникээ орхиж, морьт цэрэг болон анги, салбарын үлдэгдэл шатахуунаа шавхаж цэнэглэсэн цөөн зэвсэг техникээр урагшилжээ.

Газрын зургийн тодорхойгүй байдлаас, үл мэдэх газарт баримжаалах чадвараас шалтгаалан хил даваад морьт дивизүүд зам төөрөн маршрутаасаа хазайж байв.

Энэ мэтчилэн цөөнгүй зүйлийг сургамж болгон дурдаж болохоор бөгөөд даргалах бүрэлдэхүүний мэдлэг, боловсрол тухайн цагт тавигдаж буй шаардлагыг хангаж чадахгүй байсныг онцлон тэмдэглэх нь зүйтэй юм.

Монгол, Зөвлөлтийн цэрэг богино хугацаанд японы Квантуны армийг бутцохиж, ялалт байгуулсны дараа МАХЦ-ийг 1945 оноос эхэлж удаа дараа цомхотгож, олон тооны нэгтгэл, ангийг татан буулгажээ. Энэ цомхотголд морьт дивизүүд бүгд хамрагдаж үндсэндээ морьт цэргийг татан буулгасан гэж хэлж болно. 1953 онд морьт цэргийн сүүлчийн ангийг татан буулгаснаар монголын морьт цэргийн XX зууны түүх төгссөн байна.

Тавиад оны сүүлч, жараад оны дунд үеэс буудлагын, улмаар мотобуудлагын ангиудыг шинээр байгуулж эхэлжээ. Энэ цаг үед морьт цэргийн ангиудыг сэргээн байгуулаагүй нь дэлхийн цэргийн хэрэгт гарсан цэргийн хэргийн хувьсал, өөрчлөлттэй холбоотой бөгөөд мотобуудлагын болон бусад шинэ төрөл, мэргэжлийн цэрэг бий болж, зэвсэг техникийн хувьд эрс шинэчлэгдсэн нь морьт цэргийн хэрэгцээ шаардлагагүй болсныг харуулсан хэрэг байв.

Дээр өгүүлснийг нэгтгэн үзвэл ХХ зууны түүхэн дэх хоёр дайнд монголын морьт цэрэг оролцож, эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолыг хамгаалахад үнэтэй хувь нэмэр оруулжээ.

Цэргийн хэрэгт гарсан хувьсал, өөрчлөлтийн дагуу морьт цэрэг татан буугдсан бөгөөд морьт цэрэг түүхэн үүргээ биелүүлж, шинэ төрлийн цэрэгт халаагаа өгчээ.

ЭШ ТАТСАН СУРВАЛЖ, СУДАЛГААНЫ ЗОХИОЛ

а. Архивын баримт материал

1. БХТА. сх-1, д-4, хн-109
2. БХТА, сх-1, д-5, хн-46
3. БХТА. сх-1 д-4 хн-203
4. БХТА. Ф-1, д-4, хн -123
5. БХТА. сх-1, д-3, хн. 462. х. 4
6. БХТА. сх-1, д-3, хн. 462. х. 8-9
7. БХТА, сх.16, д.4, хн.109. х.16
8. БХТА, сх.16, д.4,хн.40, х. 3-8
9. БХТА, сх.16, д.4,хн.24, х.36
10. БХТА, сх.16, д.4,хн.97. х.21-22
11. БХТА, сх. 1. хн 920. Х.1-11
12. БХТА.Сх.1 д.1 хн.826
13. БХТА.Сх.1 д.1 хн.804
14. БХТА.Сх.1 д.4 хн.139
15. БХТА.Сх.1 д.4 хн.140
16. БХТА.Сх.1 д.4 хн.128
17. БХТА.Сх.1 д.4 хн.203
18. БХТА.Сх.1 д.4 хн.141
19. БХТА. Сх-1. д.4 хн.112
20. БХТА.Сх.1 д.4 хн.117
21. БХТА.Сх.1 д.4 хн.138
22. БХТА.Сх.1 д.4 хн.142
23. БХЯ-ны ЭШХ-ийн фондод буй ахмад дайчдын дурдатгалууд
24. БХТА, сх.1, д.1, хн.299.
25. БХТА, сх.1, д.1, хн.300.
26. БХТА, сх.1, д.15, хн.15а.
27. БХТА, сх.1, д.3, хн.462.
28. БХТА, сх.1, д.3,хн.475.
29. БХТА, сх.2, д.34,хн.6.
30. БХТА, сх.4, д.2,хн.27.
31. БХТА, сх.4, д.2 хн.29.
32. БХТА, сх.4, д.2, хн.32.
33. БХТА, сх.4, д.2, хн.39.
34. БХТА, сх.16, д.4,хн.2.
35. БХТА, сх.16, д.4, хн.3.
36. БХТА, сх.16, д.4, хн.12.
37. БХТА, сх.16, д.4, хн.18.
38. БХТА, сх.16, д.4, хн.20.
39. БХТА, сх.16, д.4, хн.24.
40. БХТА, сх.16, д.4, хн.26.
41. БХТА, сх.16, д.4, хн.27.
42. БХТА, сх.16, д.4, хн.28.
43. БХТА, сх.16, д.4, хн.29.
44. БХТА, сх.16, д.4, хн.30.

45. БХТА, сх.16, д.4, хн.36.
46. БХТА, сх.16, д.4, хн.37.
47. БХТА, сх.16, д.4, хн.39.
48. БХТА, сх.16, д.4, хн.40.
49. БХТА, сх.16, д.4, хн.41.
50. БХТА, сх.16, д.4, хн.44.
51. БХТА, сх.16, д.4, хн.61.
52. БХТА, сх.16, д.4, хн.62.
53. БХТА, сх.16, д.4, хн.64.
54. БХТА, сх.16, д.4, хн.65.
55. БХТА, сх.16, д.4, хн.66.
56. БХТА, сх.16, д.4, хн.68.
57. БХТА, сх.16, д.4, хн.85.
58. БХТА, сх.16, д.4, хн.97.
59. БХТА, сх.16, д.4, хн.98.
60. БХТА, сх.16, д.4, хн.101.
61. БХТА, сх.16, д.4, хн.108.
62. БХТА, сх.16, д.4, хн.109.
63. БХТА, сх.16, д.4, хн.111.
64. Российской Государственной Военной Архив /РГВА/.ф.32113, оп.1, ед.хр.3.
65. РГВА ф.32113, оп.1, ед.хр.229.
66. РГВА, ф.32113, оп.1, д.232.
67. РГВА, ф.32113, оп.1, д.259.
68. РГВА, ф.32113, оп.1, д.281.
69. РГВА, ф.32113, оп.1, д.672.
70. Улсыг Аюулаас Хамгаалах Байгууллагын Төв Архив. ф.1, хн.477 /IV/.
71. БХТА.Улаан-одон” сонин 1942-1943 оны дугаарууд

б. Судалгааны зохиол, тогтмол хэвлэл

1. Ардын хувьсгалт цэргийн 20 жил. УБ., 1941.
2. БХЯ-ны ЭШХ-ийн фондод буй “Халх гол-хагас зуунтэртээг шинээр харахад” /баримт бичгийн эмхтгэл/номын эх. УБ., 1989.
3. БНМАУ-ынморьтулаанцэргийнбайлдааныдүрэм. УБ.,1935. I, III анги.
4. Даваасүрэн Б. МАХН-аас цэргийн боловсон хүчин бэлтгэх талаар явуулсан бодлого, үйлажиллагаа. УБ.,1990.
5. Дайчиннөхөрлөл. УБ., 1985.
6. Дамдиндорж Да. Хар хэргийн амьд гэрч. УБ., 1990.
7. Доржсүрэн Б. Түүхэнялалтынугсурвалж, ачхолбогдол.УБ., 1989.
8. Жамсранжав Ш. Мөнх найрамдлын их ялалт. УБ., 1969.
9. История второй мировой войны. 1939-1945. т-2. М.,1974.
10. Лхагвасүрэн Ж. Халх гол. УБ., 1979.
11. Монголын Ардын Армийн 50 жил. УБ., 1971.
12. МАХН-ын тогтоол, шийдвэр, баримт бичгүүд. II боть.1929-1940.УБ., 1984.
13. Новиков В.М. Победа на Халхин голе. М.,1971.
14. Одонт ангиуд. УБ., 1986.Жуков Г.К. Дурдатгал, бодол. 1 боть. УБ., 1977.
- 15.
16. Самдангэлэг Ц. Зөвлөлт, Монголын армиуд Халх голд Японы түрэмгийлэгчдийг бут цохисон нь. УБ., 1981.

17. Халх голын байлдаанд Монголын армийн төрөл мэргэжлийн цэргүүд. УБ., 1965.
18. Халх голын байлдаанд оролцсон ахмад дайчдын дурдатгал. УБ., 1981.
19. Халх гол: түүхэн үнэний эрэлд. УБ., 1993.
20. Халх голын байлдаан. Баримт бичгүүд. УБ., 1970.
21. Цэдэн-Иш Б. Дархан хилийн домогт сургамж. УБ., 1979.
22. Эрдэм шинжилгээний өгүүлэл №3. БХЯ-ны Цэргийн эрдэм шинжилгээний институт. УБ., 1985.
23. Улаан одон. 1939.08.10.№92.
24. Улаан од. 1964.08.20.№100.
25. Эх орны төлөө. 1939.07.16.№21.
26. Эх орны төлөө. 1939.07.18.№23 .
27. Эх орны төлөө. 1939.07.20.№24.
28. Эх орны төлөө. 1939.08.13.№40.
29. Эх орны төлөө. 1939.08.16.№42.
30. Эх орны төлөө. 1939.08.24.№48.
31. Эх орны төлөө. 1939.09.15.№62.
32. Банзрагч.Ч Сайнхүү.Б “Монголын хүрээ хийдийн түүх” УБ., 2004.
33. Дашдаваа.Ч “Японы олзлогдогсод” УБ., 2013.
34. Пүрэвсүрэн.И “1945 оны дайнд оролцогчдын дуртгал” УБ., 1975.
35. Плиев.И.А“Квантуны арми сөнөсөн нь” УБ.,1970.
36. “Монгол Зөвлөлтийн армийн ахмад дайчдын дуртгал” УБ., 1969.
37. “Монгол цэргийн түүхийн товчоо” УБ., 1996. дэд дэвтэр
38. “Российско-Монгольское военное сотрудничество” (1911-1946 167) сборник документов Часть-II Москва-Улан-Удэ 2008.
39. “Чөлөөлөх дайны 70 жил: Түүх сургамж” УБ., 2016.
40. Монгол Ардын армийн 50 жил. УБ., 1971
41. МАХЦ-ийн түүхэнд холбогдох баримт бичгүүд. 1921-1945 он. УБ., 1974
42. 1945 оны дайнд оролцогчдын дуртгал. УБ., 1975.
43. Монгол цэргийн түүхийн товчоон. II дэвтэр.УБ., 1996
44. Ганболд С. 5 дугаар морьт дивиз Чөлөөлөх дайнд “Соёмбо” сонин. 2005. VII. 1-7. №27
45. Ганболд С. МАХЦ Чөлөөлөх дайнд оролцсон нь “Монгол ба Орос Дэлхийн хоёрдугаар дайны жилүүдэд” Эрдэм шинжилгээний өгүүллийн эмхэтгэл. УБ., 2011
46. Зэвсэгт хүчнийхээ түүхийг 80 жил бичилцсэн алдарт нэгтгэл. УБ., 2001.
47. Российско-Монгольское военное сотрудничество (1911-1946). Сборник документов Часть II. Москва-Улан-Удэ., 2008.
48. Улаан одон. 1939.08.10.№92.
49. Ганболд С. Наймдугаар морьт дивиз Халхын голын дайнд. УБ., 1995. т.15
50. Гомбосүрэн Д. Монгол улсын Зэвсэгт хүчний байгуулалтын түүх (ХХзуун) Судалгааны бүтээл. Нэмж засварласан хоёр дахь удаагийн хэвлэл. УБ., 2012. т. 141-142
51. Жамсранжав Ш. Мөнх найрамдлын их ялалт. УБ., 1969. т.151-153,
52. Халх голын байлдаанд оролцсон ахмад дайчдын дурдатгал. УБ., 1981, т.33-40,
53. Эх орны төлөө. 1939.07.16.№21.
54. Улаан одон. 1939.08.10.№92

ТӨСЛИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД МОНГОЛЫН ТАЛЫН ГҮЙЦЭТГЭГЧДИЙН БИЧИЖ НИЙТЛҮҮЛСЭН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ, ИЛТГЭЛҮҮД

Эрдэм шинжилгээний өгүүлэл: 9

Тоо гадаад: 3

Дотоод: 6

1. С.Ганболд. “Mongolian messenger” сэтгүүлд “Монголын ард түмнээс Зөвлөлтийн улаан армид үзүүлсэн тусламж” өгүүлэл англи хэлээр. 2015.05.
2. С.Ганболд. “Новости Монголии” сонинд “Монголын ард түмэн эх орны дайны жилүүдэд” өгүүлэл оросхэлээр. 2015.05.
3. Ж.Базарсүрэн. “1945 оны чөлөөлөх дайны цэргийн урлагийн зарим асуудалд”. (Соёмбо БХИС. 2015 оны IX сарын 5-12. №36 (10454) буюу “Соёмбо” сонин. 2015-IX сарын 5-12. №36 (10454).
4. Ж.Базарсүрэн. “1945 оны чөлөөлөх дайны цэргийн урлагийн зарим асуудалд”. “Дэлхийн дайны ялалт ба БНМАУ-ын тусгаар тогтнол” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ.,2016. 83-89 дэх тал.
5. Ж.Базарсүрэн. “1945 оны чөлөөлөх дайны цэргийн урлагийн зарим асуудалд”. Монгол Улсын баатар Д.Данзанваанчиг агсны мэндэлсний 100 жилийн ойд зориулсан “Шуурган галын дундуур” эмхэтгэл. УБ.,2018. 31-36 дахт тал.
6. С.Ганболд. “Mongolia made an important contribution to international peace by taking part in the War of Liberation”. “The Mongolian observer” сэтгүүл. 2017.03.29. №3.
7. Т.Уранчимэг. “Тавдугаар морьт дивиз 1939 оны Халхын голын дайнд”. “Цэргийн шинэчлэл” сэтгүүл. 2018 № 1. Тал 51-55.
8. Т.Уранчимэг. “Тавдугаар морьт дивиз Чөлөөлөх дайнд”. Цац” сэтгүүл. 2017 № 10. Тал 119-127.
9. Н.Хүдэрбат. “Дайны жилүүдэд Монгол Улсын баатар Чойн Дугаржавын гүйцэтгэсэн үүрэг”. Цэргийн шинэчлэл сэтгүүл. 2016 он. №1 (61)

Эрдэм шинжилгээний хурлын илтгэл:

Тоо гадаад: 7


Дотоод: 22

1. С.Ганболд. Маршал Х.Чойбалсангийн мэндэлсний 120 жилийн ойд зориулж 2015 оны 2 дугаар сарын 6, 9-нд болсон эрдэм шинжилгээний хуралд “Цэргийн явдлын яамны сайд маршал Х.Чойбалсан” сэдвээр 2 илтгэл хэлэлцүүлэв.
2. С.Ганболд. ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын дарга С.Е.Нарышкиний санаачлагаар зохион байгуулсан “Монгол, Оросын харилцааны түүх, уран зохиол” сэдэвт дугуй ширээний ярилцлагад “Монголо-Российское военные отношения и сотрудничество” илтгэл. 2015.02.16.
3. С.Ганболд. “Некоторые исторические проблемы войны на Халхин голе”. Доклад международной научно-практической конференции, посвященной 70 летию победы во второй мировой войны и в великой отечественной войны. 20-23 апреля 2015 года. Горно-Алтайск. В сборнике “История и культура народов юго-западной Сибири и сопредельных регионов (Казахстан, Монголия, Китай). Горно-Алтайск.,2015. С 52-55.
4. С.Ганболд. Монголын нисэх хүчний 90 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хуралд “Цэргийн нисэх хүчний үүсэл, хөгжилт” илтгэл 5 дугаар сарын 15-нд.
5. С.Ганболд. ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгээс 5 дугаар сарын 6-нд зохион байгуулсан эрдэм шинжилгээний хуралд “Монголын ард түмнээс улаан армид үзүүлсэн тусламжид МАХЦ-ийн оруулсан хувь нэмэр” сэдэвт илтгэлийг хошууч Н.Хүдэрбатын хамт.
6. С.Ганболд. Цэргийн түүхч, дипломатч Л.Тойвын мэндэлсний 100 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хуралд “Цэргийн түүх судлалд Л.Тойвын оруулсан хувь нэмэр” сэдвээр илтгэл тавьсан.
7. С.Ганболд. ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, төвөд, будда судлалын хүрээлэнтэй хамтарсан “Монгол Улс дэлхийн II дайнд” хэмээх олон улсын төслийн хүрээнд 6 сарын 9-нд хийсэн дугуй ширээний ярилцлагад “Монгол Улсын тусгаар тогтнол ба дэлхийн II дайн” илтгэл.


8. С.Ганболд. МУИС, ОХУ-ын Горно-Алтайн БНУ-ын “Вестник Горно-Алтайска” сонин, БХЭШ-ийн хамтран зохион байгуулсан эрдэм шинжилгээний хуралд “Чөлөөлөх дайны ялалт ба түүний түүхэн ач холбогдол” сэдэвт илтгэл. 2015.08.27.
9. С.Ганболд. Чөлөөлөх дайны ялалтын 70 жилийн ойд зориулсан “Чөлөөлөх дайн 70 жил: Түүх, сургамж” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд “Чөлөөлөх дайны түүхэн ач холбогдол” сэдэвт үндсэн илтгэл. 2015.09.02.
10. С.Ганболд. Х.Шагдар.Чөлөөлөх дайны ялалтын 70 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хуралд “Монгол-Зөвлөлтийн морьт механикжуулсан бүлгийн командлагч И.А.Плиев” илтгэл. 2015.09.02.
11. С.Ганболд. Х.Шагдар.Орос улсын эрдэмтдийн дугуй ширээний ярилцлагад “МАХЦ дайнд оролцсон нь” илтгэл. 2015.06.09.
12. С.Ганболд. Ж.Базарсүрэн. Чөлөөлөх дайны 70 жилийн ойд зориулсан ОХУ, Монголын судлаачдын дугуй ширээний ярилцлагад “Чөлөөлөх дайны цэргийн урлаг” илтгэл.2015.06.09.
13. Ж.Базарсүрэн. Манжуурын стратегийн давших операц-цэргийн урлаг. Чөлөөлөх дайны 70 жилийн ойд зориулсан ОХУ, Монголын судлаачдын дугуй ширээний ярилцлага. БХЭШХ. 2015-05-06.
14. Ж.Базарсүрэн. 1945 оны чөлөөлөх дайны цэргийн урлагийн зарим асуудалд. Чөлөөлөх дайны 70 жилийн ойд зориулж БХЯ, БХЭШХ-ээс зохиосон ЭШХ. ГХЯ-ны хурлын танхим. 2015-09-02.
15. С.Ганболд. “Уроки войны на реке Халхин гол и железная дорога”. (Б.Очирсүрэнгийн хамт). 2016 оны 9 дүгээр сард ОХУ-ын Чита хотод болсон олон улсын эрдэм шинжилгээний хуралд эчнээгээр хэлэлцүүлсэн илтгэл.
16. Х.Шагдар. “Халхин-гол главная стажировка Советских военных журналистов” (Г.Нямдоржийн хамт). 2016 оны 9 дүгээр сард ОХУ-ын Чита хотод болсон олон улсын эрдэм шинжилгээний хуралд эчнээгээр хэлэлцүүлсэн илтгэл.
17. С.Ганболд. “Цэргийн хөгжмийн удирдаач Г.Бирваа” (хошууч Н.Хүдэрбатын хамт). 2016.10 сар.
18. С.Ганболд. “Улс орны батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэх зорилт ба маршал Ю.Цэдэнбал” (Ц.Бямба-Эрдэнийн хамт). 2016.12 сар.
19. С.Ганболд. “Улс төрийн хэлмэгдүүлэлтэд МАХЦ-ийн бие бүрэлдэхүүн өртсөн нь”. Улс төрийн хэлмэгдүүлэлт: шалтгаан, үр дагавар,сургамж сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал. 2017.09.07. Улаанбаатар.
20. Ж.Базарсүрэн (доктор Л.Баярын хамт). “Монгол Улсын цэргийн удирдлагын тогтолцооны уламжлал, сургамж”. 2017.03.10.
21. Х.Шагдар, Ж.Базарсүрэн. “Дальневосточная операция: Заключительный этап Второй мировой войны”. Улаан-Үд хотод болсон “Мир Центральной Азии”-IV” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл. 2017.10.04-07. “Мир Центральной Азии”-IV”: сб.науч. ст.Иркутск:2017. с 186-188.
22. С.Ганболд. “Улс төрийн хэлмэгдүүлэлтэд МАХЦ-ийн бие бүрэлдэхүүн өртсөн нь”. Улс төрийн хэлмэгдүүлэлт: шалтгаан, үр дагавар,сургамж сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал. 2017.09.07. Улаанбаатар.
23. С.Ганболд, Б.Очирсүрэн. “Роль СССР в подготовке военных кадров Монголии (1939-1945)”. Улаан-Үд хотод болсон “Мир Центральной Азии”-IV” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал. 2017.10.04-07. “Мир Центральной Азии”-IV”: сб.науч. ст.Иркутск:2017. с 186-188.
24. С.Ганболд. “Залуу жанжин Ж.Лхагвасүрэн Халхын голын дайнд”. Жанжин Ж.Лхагвасүрэнгийн мэндэлсний 105 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал. Булган аймаг. 2017.11.09.
25. Ж.Базарсүрэн (доктор Л.Баярын хамт). “Монгол Улсын цэргийн удирдлагын тогтолцооны уламжлал, сургамж”. 2017.03.10.
26. Ж.Базарсүрэн. “БНМАУ-ын БХЯ-ны сайд Ж.Лхагвасүрэн”. Жанжин Ж.Лхагвасүрэнгийн мэндэлсний 105 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал. Булган аймаг. 2017.11.09.
27. Х.Шагдар. “Жанжин Ж.Лхагвасүрэн 1945 оны Чөлөөлөх дайнд”. Жанжин Ж.Лхагвасүрэнгийн мэндэлсний 105 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал. Булган аймаг. 2017.11.09.

28. Х.Шагдар. “Д.Гомбосүрэн: 22 дугаар морьт хорооны мөрөөр...”. Д.Гомбосүрэнгийн мэндэлсний 80 жилийн ойд зориулсан “Монголын төр, цэргийн түүхийн тулгамдсан асуудлууд” сэдэвт эрдэм шинжилгээний хурал. 2017.05.15.
29. Н.Хүдэрбат. “Монгол ардын хувьсгалт цэргийн Байшинтын 7 дугаар морьт дивизээс улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн цэргийн алба хаагчдын судалгаа”. Улс төрийн хэлмэгдүүлэлт: шалтгаан, үр дагавар, сургамж сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал. 2017.09.07. Улаанбаатар.


1939 ОНЫ ХАЛХЫН ГОЛЫН ДАЙН, 1945 ОНЫ ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНТАЙ ХОЛБОГДОХ БҮДҮҮВЧ ЗУРАГНУУД




Халхын голын дайны бүтэц (Б.Шагдарын ангилал)




Япон - Манжийн цэргийн өдөөн хатгалга (1935-1936 он)




Хайлаастын голын байлдаан (1939.05.28-30)




Баянцагааны байлдаан (1939.07.02-07.05)



Нөмрөг-Мана уулын байлдаан (тойм зураг)




организации Конно-Механизированной
группы войск МНРА



III Схема М


Движения частей и соединений из постоянных районов дислокации до июля 1945 г. в новые районы сосредоточения по приказу командующего Забаронтом.




СХЕМА

4

Положение главных сил группы на
Доломорском направлении в исходном
положении, занятого в ночь на 9 авг. 1945 г.






13


СХЕМА

положения войск группы на участке Долоннор - Губэйкоу



САЛМА

положения войск группы на участке оз. Арчаган-
нур - Долоннор



1: 500 000